ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

Хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгаа, практикийн улирал тутмын сэтгүүл

2019 он, Цуврал 1 (71)

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.ki.gov.mn

Улаанбаатар хот
2019 он

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

Сэтгүүлд нийтлэсэн бүтээл нь Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

© Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээлийн зохиогчийн эрх Сэтгүүлийн редакц болон зохиогчид хадгалагдана.

Хэвлэсэн газар: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хэвлэх үйлдвэр

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Ж.Амарсанаа	*Академич, гавьяат хуульч*
Ц.Сарантуяа	*Хууль зүйн шинжлэх ухааны доктор, гавьяат хуульч*
Б.Баярсайхан	*Хууль зүйн доктор*
Д.Гангабаатар	*Хууль зүйн доктор*
Д.Зүмбэрэллхам	*Хууль зүйн доктор*
Ж.Оюунтунгалаг	*Хууль зүйн доктор*
Д.Сүнжид	*Хууль зүйн доктор*
П.Амаржаргал	*Хууль зүйн доктор*
З.Сүхбаатар	*Бизнесийн удирдлагын доктор*
Ц.Цогт	*Хууль зүйн доктор*

Эрхлэгч
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал
С.Энхцэцэг

Нарийн бичгийн дарга
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан
Ж.Булгансүрэн

Хэвлэлийн эхийг
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эх бэлтгэгч, дизайнер
Д.Мөнхжаргал

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

Улсын бүртгэлийн дугаар: 279 ISSN:2226-9185 Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс эрхлэн гаргав. Жилд 5 дугаар гарна.	Хаяг: Улаанбаатар–46, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу /15160/, Хуульчдын гудамж 1, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн байр Утас: +(976)-11-315735 Факс: 315735 Вэб хуудас: www.nli.gov.mn Цахим хаяг: lawjournal@legalinstitute.mn

EDITORIAL BOARD

J.Amarsanaa	*Academician, Merited Lawyer of Mongolia*
Ts.Sarantuya	*(Sc.D), Merited Lawyer of Mongolia*
B.Bayarsaikhan	*(Ph.D)*
D.Gangabaatar	*(LL.D)*
D.Zumberellkham	*(Ph.D)*
J.Oyuntungalag	*(LL.D)*
D.Sunjid	*(Dr.jur)*
P.Amarjargal	*(Ph.D)*
Z.Sukhbaatar	*(Ph.D)*
Ts.Tsogt	*(LL.D)*

Executive Editor–in-Chief
Director, The National Legal Institute
S.Enkhtsetseg

Acting Assistant Editor
Researcher, The National Legal Institute
J.Bulgansuren

Designed by
Designer, The National Legal Institute
D.Munkhjargal

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nli.gov.mn

State Registration Number:279
ISSN: 2226-9185
The National Legal Institute publishes this law review five times per year.

Address: 4th Khoroo, Chingeltei District, Lawyer's Street-1, Ulaanbaatar-15160, Mongolia
Phone:+(976)-11-315735
Fax: 315735
Website: www.nli.gov.mn
E-mail: lawjournal@legalinstitute.mn

АГУУЛГА

ХУУЛЬ ТӨРӨХИЙН ӨМНӨ /ОНЦЛОХ ӨГҮҮЛЭЛ, ЯРИЛЦЛАГА/

Гэм хорын эрх зүйн зорилго: Эрх зүй, эдийн засгийн хандлага **9**
Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, хууль зүйн доктор Ж.Оюунтунгалаг

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны "оролцогч биш" оролцогч буюу "сэжигтний" талаарх зохицуулалтыг Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн /stpo/ зохицуулалттай харьцуулах нь **17**
УЕПГ-ын Сургалт, судалгааны төвийн дэргэдэх гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах хүрээлэнгийн захирал, хууль зүйн доктор Б.Өнөрмаа

Эрх зүйт, ардчилсан төрд хуульчийн гүйцэтгэх үүрэг **22**
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн хүндэт доктор Юрген Харбих (Герман хэлээр бичсэн үндсэн бичвэрийг оруулав.)

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны процессыг маргааны төрлөөс хамааран ялгамжтай зохицуулах нь: /Цэцийн шийдвэрийн хууль зүйн үр нөлөөг дээшлүүлэх боломж/ **33**
Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын референт Д.Амарбаясгалан

ЭРХ ЗҮЙН СЭТГЭЛГЭЭ: ҮЗЭЛ БОДОЛ, ЭРГЭЦҮҮЛЭЛ

Гэмт хэргийн ангилал түүний нийгмийн хор аюулын шинж, хэр хэмжээнээс хамаарах нь **41**
Баян-Өлгий аймгийн прокурорын газрын Ерөнхий прокурор Т.Батсүх, Баян-Өлгий аймгийн прокурорын газрын хяналтын прокурор, хууль цаазын ахлах зөвлөх М.Фарида

Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан "хулгайлах"гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн үр нөлөөнд татгалзуулах онол (deterrence theory)-ын үүднээс хийсэн дүн шинжилгээ **47**
Сонгинохайрхан дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор, хууль цаазын ахлах зөвлөх Д.Нямбат

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны асуудлыг хүний эрхийн үүднээс авч үзэх нь **54**
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ахлах ажилтан Г.Халиунаа, Эрдэм шинжилгээний ажилтан Б.Ариунжаргал

Монгол Улсад сонгуулийн тогтолцоог тодорхойлох эрх зүйн асуудал **62**
МУИС–ийн Хууль зүйн сургуулийн докторант С.Номынбаясгалан

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨ

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 72.3 дахь зохицуулалтын онолын тайлбар, практик хэрэглээ **74**
"Жунсон констракшн" ХХК-ийн хуульч А.Түвшинтөгс

Шүүх эрх мэдэл-шүүгчийн хараат бус байдалд авлига нөлөөлөх нь **82**
Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын ахлах мэргэжилтэн Н.Онударь

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад иргэний нэхэмжлэл гаргах үндэслэл **91**
Хууль сахиулах их сургуулийн докторант М.Ванчигмаа

Хууль ба Улс төрийн шүтэлцээ **100**
ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарын Эрдэм шинжилгээний дэд ажилтан М.Долгорсүрэн

ЭРХ ЗҮЙН СУДАЛГАА, ТОЙМ , ҮР ДҮН

Анагаахын салбар шинжлэх ухааны оюутнуудын эмнэлгийн эрх зүйн мэдлэгийн түвшинг үнэлсэн судалгаа **111**
Анагаах ухааны доктор, дэд профессор М.Цэрэнбат

"Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан" **114**

Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хэсэгчлэн хийсэн үнэлгээний тайлан **125**

ХУУЛЬ ЗҮЙН НЭР ТОМЬЁОНЫ БУЛАН **137**
Академич, гавьяат хуульч Ж.Амарсанаа

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГЭЭС 2018 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН СУДАЛГААНЫ ЖАГСААЛТ **139**

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

CONTENT

BEFORE CREATING A LAW /UNDERLINE ARTICLE AND INTERVIEW/

Purpose of Delict Law: Law and Economics Approach 9
Oyuntungalag.J, LL.D., Chief Judge of the Capital City Courts of Civil Appeals

A Comparative Study on Regulation of Criminal Procedure Participant as a Suspect or Non- Participant and Stpo Regulation of Criminal Procedure of Gfr 17
Unurmaa. B, Ph.D., Director of Research center for studying causes and conditions of the crime at Training and Research center, General Prosecutor's Office

Lawyer's Responsibility in the State of Law and Democracy 22
Jurgen Harbaugh, Professor Emeritus at School of Law, National University of Mongolia

Diverse Arrangements of the Constitutional Court Procedure of the Constitutional Court of Mongolia Regarding to Dispute Types 33
Amarbayasgalan. D, Referent and Legal analyst of the Constitutional Court

LEGAL THINKING: VIEWS AND REFLECTIONS

Crime Classification by the Consequences of the Nature and Extend of its Social Harm 41
Batsukh. T, Prosecutor general at Prosecutor's office of Bayan-Ulgii aimag
Parida. M, Supervisor Prosecutor, Senior Legal Council Bayan-Ulgii aimag

Analyzing for Result of Penalties Imposed on theft Crime in the Criminal Code of Mongolia Based on the Deterrence Theory 47
Nyambat. D, Supervision Prosecutor, Senior Legal Council at Prosecutor office of Songino-Khairkhan district

Human Rights Perspective on Statute of Limitations for Crime 54
Khaliunaa. G, Senior Researcher at the National Legal Institute
Ariunjargal. B, Researcher at the National Legal Institute

ХУУЛЬ ЗУЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

Legal Issues on the Definition of Electoral System in Mongolia 62
Nomynbayasgalan S, Ph.D candidate, School of Law, National University of Mongolia

IMPLEMENTATION OF EFFICIENCY AND LAW

Issues of Teleological Interpretation, Practical Usage for Provisional Regulation of Article 72.3 of Civil Procedural Code of Mongolia 74
Tuvshintugs. A, Lawyer, "JUNSON construction" LLC

Corruption Effects on the Judicial Independence 82
Onudari N. Senior specialist of Secretariat of the Constitutional Court of Mongolia

Grounds for Claimants Bringing a Civil Suit in a Criminal Case 91
Vanchigmaa. M, Ph.D candidate, Law Enforcement University of Mongolia

Legal and Political Relevance 100
M. Dolgorsuren MAS, Institute of Philosophy, Forum and Economy section, Scientific sub researcher

LEGAL RESEARCH OVERVIEW

Research evaluating level of Medical law education of the Students of medical science 111
Tserenbat. M, DMSc, Associate Professor

Research Report on Evaluate Consequences of the Implementation of Law on the Resolution of Petition and Complaints Lodged by Citizens to the State Organizations and the Public Official 114

Partial evaluation research report on implementation outcomes of Criminal Code 125

LEGAL TERMS 137
Amarsanaa. J

A LIST OF RESEARCH CARRIED OUT BY THE NATIONAL LEGAL INSTITUTE IN 2018 139

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ГЭМ ХОРЫН ЭРХ ЗҮЙН ЗОРИЛГО: ЭРХ ЗҮЙ, ЭДИЙН ЗАСГИЙН ХАНДЛАГА

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, хууль зүйн доктор Ж.Оюунтунгалаг

Энэ өгүүллийг хуульчид төдийгүй эдийн засагч, хуулийн мөн чанарыг сонирхдог хүмүүсийн сонорт хүргэх зорилгоор бичиж байгаа учраас гэм хор учруулснаас үүрэг үүсэх учир шалтгааны талаар аль болох энгийнээр тайлбарлахыг хичээлээ. Хүмүүс эд баялагтай холбоотой харилцаанд орох үед нөгөө талд нь давуу байдал, ашиг орлого бий болох, эсхүл өөрт нь илүү зардал гарах буюу алдагдал үүсэх тохиолдол байдаг. Харин ийнхүү алдагдалд орсон явдалд нь өөр хүмүүсийн нөлөө орсон, эсхүл өөр хүмүүс үүний улмаас үндэслэлгүй ашиг олсон гэж үзвэл тухайн этгээд хохирсон хэмээн маргаан үүсгэх, улмаар шүүхэд хандан гомдол, нэхэмжлэл гаргана.

Энэхүү алдагдал, хохирол нь хүмүүсийн эд баялаг холилдон нийлэх, шилжих, хуулиар эсхүл гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчих, бусдын эд хөрөнгийг засан сайжруулах зэрэг олон шалтгаанаар үүсч болдог. Үүнийг гэрээний эрх зүйн зөрчил, үндэслэлгүй хөрөнгөжих, эдийн баялгийн буюу өмч хөрөнгөтэй холбоотой гэм хорыг арилгах зэрэг олон төрлийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд авч үзэж, хохирлоо арилгуулах боломж, үндэслэлийг хуулиар тодорхойлсон байдаг[1]. Эдгээр хохирол арилгахтай холбоотой хуулийн зохицуулалтыг хэрэглэх үндэслэл, нөхцөл өөр өөр байх[2] бөгөөд энэ өгүүллийн хүрээнд зөвхөн бусдын эрх зөрчсөн үйлдэл /эс үйлдэл/ буюу "зөрчлийн" эсхүл гэм хорын улмаас үүссэн хохирлыг арилгах үндэслэлийг авч үзнэ.

Аливаа эрх зүйн хэм хэмжээ буюу хууль[3] нь тухайн нийгмийн гишүүдийн хоорондын харилцаанд баримталбал зохих стандарт, түүнийг зөрчсөнөөс үүсэх үр дагаврыг тогтоох замаар хүний үндсэн буюу амьд явах, эрүүл байх, өмч хөрөнгөтэй байх эрхийг хамгаалахад чиглэгдсэн байдаг. Үүний нэгэн адил зөрчлөөс үүсэх үүргийн эрх зүй нь хүний үндсэн эрхийг зөрчсөнөөс учирсан хохирлыг арилгах хууль зүйн боломжийг олгодог юм. Тодруулбал, бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө зэрэгт хууль бус үйлдэл, эс үйлдэхүйгээр хохирол учруулсан байвал иргэний эрх зүйд "гэм хор" учруулсан хэмээн үзэж, үүнээс үүсэх үр дагаврыг тэрхүү буруутай хүнээр нь арилгуулахыг "гэм хороос үүсэх үүрэг" гэж нэрлэдэг[4]. Шүүхийн статистик тоо мэдээнээс үзэхэд гэм хор учруулснаас үүссэн хохирлыг арилгуулах тухай нэхэмжлэлтэй иргэний хэрэг 2015 онд 1193, 2016 онд

[1] Иргэний хуульд нийт 41 удаа "хохирол" гэсэн үг орсон байдаг.

[2] Иргэний хуулийн 119.3, 120.2, 219.1, 227.1, улмаар гэрээний үүргийн төрөл тус бүрийн хувьд Иргэний хуулийн 497-510, 493.5, 493.7, 495 болон бусад зүйлд хохирол төлөх ерөнхий болон тусгай үндэслэлийг заасан байдаг.

[3] Хуульч бус, энгийн иргэдийн хувьд хууль, эрх зүй гэсэн ойлголтыг ялгаж үзэх шаардлагагүй байдаг тул эрх зүй гэдгийг хялбарчлан "хууль" гэсэн үгээр томьёолов. Харин хуульчид, философчидын хувьд хууль, эрх зүй хэмээх ухагдахууныг маш олон арга зүй, үзэл баримтлалаар тайлбарлан мэтгэлцдэг. Жишээлбэл, Х.Кельзен, Хэм хэмжээний тухай ерөнхий онол, 2013, (орчуулга) х.20, Р.Дворкин, Хуулийн эзэнт гүрэн, 2015 (орчуулга), Д.Баярсайхан, Эрх зүй онол, 2010 он, 5-51 дэх тал, Ч.Нямсүрэн, Эрх зүй ерөнхий онол, 89-90 дэх тал.

[4] Иргэний хуулийн 497.1 дэх хэсэг нь гэм хорын үүрэг үүсэх гэм буруугийн зарчмыг тогтоосон, Шварц Вандт, Хуульд зааснаар үүсэх үүргийн эрх зүй: зөрчлийн улмаас үүсэх үүрэг буюу гэм хорын эрх зүй" гэх номны орчуулгад "зөрчлийн эрх зүй" гэж мөн томьёолжээ. 1 дэх тал.

1212, 2017 онд 1124 шийдвэрлэгдсэн байна[5]. Энэ нь иргэний хэрэг маргааны нийт тоон дүнтэй харьцуулахад тийм их биш боловч гэрээний бус үүрэгтэй холбоотой маргааны хувьд дийлэнх хэсгийг эзэлдэг. Тухайлбал, гэрээний бус үүрэгтэй холбоотой 2015 онд 1291, 2016 онд 1423, 2017 онд 1390 хэрэг шийдвэрлэсэн байна.

Энэхүү иргэний эрх зүй дэх гэм хор хэмээх ойлголтыг эрүүгийн гэмт хэргээс ялгах гол шинж нь буруутай этгээдийн үйлдэл /эс үйлдэхүй/ нь тодорхой этгээдэд хохирол учруулсан болохоос нийт нийгэмд аюултай, хор хөнөөлтэй шинжийг агуулсан байх шаардлагагүй юм[6]. Харин гэмт хэрэг бол нийт нийгэмд хор аюултай гэсэн утгаараа төрийн зүгээс цээрлүүлбэл зохих буруу үйлдэл /эс үйлдэхүй/ юм. Иймд иргэний эрх зүйн энэхүү хариуцлагын төрлийг цаашид "гэм хороос үүсэх үүрэг" гэж, ийм үүрэг үүсэхтэй холбоотой зохицуулалтыг "гэм хорын эрх зүй" гэж энэхүү өгүүллийн хүрээнд товчлон бичлээ.

Хууль зүйн ухааны судлаачид гэм хорын эрх зүйн зорилго, чиг үүргийг хувь хүний ашиг сонирхол, эрх чөлөөг хамгаалах зарчим, үндэслэлгүй хөрөнгөжилтийн эсрэг онол, үзэл санаа, солилцооны болон залруулах[7] зүй ёсны зарчим зэрэгт үндэслэн тайлбарладаг[8]. Тодруулбал, аливаа зөрчлийн улмаас хохирол амссан этгээдэд үүссэн алдагдал, нэмэлт зардал буюу хохирлыг тухайн зөрчлийг гаргасан хүнээр нөхөн төлүүлэх үндэслэлийг гэм хорын эрх зүйгээр тогтоодог болно.

Энэхүү эрх зүйн зохицуулалт юуны түрүүнд "хохирлыг арилгах"-д чиглэсэн буюу нөхөн төлбөрийн зорилготой гэж үздэг[9]. Тодруулбал, бусдад гэм хор учруулсан буруутай этгээдээр учруулсан хохирлыг нь нөхөн төлүүлэх замаар хохирогчид үүссэн сөрөг үр дагавар буюу зардлыг хохиролд шилжүүлэх нь шударга ёсонд нийцнэ гэж үздэг[10]. Иймд хууль тогтоогч, эрх зүй бүтээгчдийн шийдвэрлэвэл зохих гол асуудал нь гэм хорын хохирлыг нөхөн төлүүлэх ерөнхий болон тусгай дүрэм, хуулиар хамгаалах ашиг сонирхлын хүрээ буюу ямар төрлийн хохирлыг нөхөн төлүүлэх зэрэг байдаг. Жишээлбэл, эд хөрөнгийн хохирлоос гадна эдийн бус хохирол буюу амь нас, эрүүл мэнд, сэтгэл санаанд үүссэн сөрөг үр дагавар /өвдөлт, гутрал, ганцаардал гэх мэт мөнгөөр үнэлж болохгүй алдагдал/, эсхүл цаашдын эдийн засгийн боломжоо алдсан зэрэгтэй холбоотой хохирлыг арилгуулах нь гэм хорын эрх зүйн хүрээнд зохицуулагддаг байна[11].

Гэм хороос үүсэх үүргийг хуулиар тодорхойлох дараагийн нэг зорилго бол цаашид зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх гэж мөн хууль зүйн ухаанд тайлбарладаг[12]. Гэвч энэхүү онолын тайлбарын талаар иргэний эрх зүйчдийн дунд маргаантай хэвээр байна. Учир нь хувь этгээдүүдийн хоорондын хохирол, алдагдалтай холбоотой маргааныг хэрхэн зохицуулах нь бусад хүмүүст болон нийт нийгэмд ач холбогдолгүй. Иймд зөрчил буюу гэм хороос "урьдчилан сэргийлэх" нь хувийн эрх зүйн хэм хэмжээний зорилго

[5] Шүүхийн ерөнхий зөвлөлийн Судалгааны хүрээлэнгээс авсан тоо, мэдээ, Уб., 2019 он, 1 дүгээр сар.

[6] D.H.Cole, Peter Z.Grossman, Principles of Law and Economics, 2nd ed., 2011, p.260

[7] "Солилцооны зүй ёс" commutative Justice "залруулах зүй ёс "corrective justice" гэж монгол хэлэнд буулгав.

[8] Ж.Оюунтунгалаг, Харьцуулсан иргэний эрх зүй, Уб., 2013 он, 95 дах тал, D.H.Cole& P.Z.Grossman, Principles of Law and Economics, 2nd.ed., 2011, p.269

[9] Т.Мөнхжаргал, Монгол Улсын Иргэний эрх зүй, 2015 он, 213 дахь тал, Х.Доржпалам, Гэм хор учруулснаас үүсэх үүргийн эрх зүй, 2015 он, 11 дэх тал, Б.Баттөмөр, Монгол Улсын Иргэний эрх зүйн зарим асуудал, 2005 он, 155 дахь тал, Д.Буянхишиг, Иргэний эрх зүй: Тусгай анги Уб., 2015 он.

[10] Гражданское право: учебник/под.ред.М.В.Карпичева м 2010, с 601, Гражданское право, учебник/под. рад.С.А.Степанова 2017, С 559

[11] J.Gordley, Foundations of Private Law: Property, tort, contract, unjust enrichment, 2007,

[12] Weinrib E.J, The Idea of Private Law, 1995, 36-38, H.Schaefer C.Ott, The Economic Analysisd Civil Law, (2007) p.38-40.

байх боломжгүй гэж үздэг юм[13]. Үүнийг няцаасан тайлбарыг зөвхөн эрх зүй судлалд үндэслэн гаргахад харьцангуй хүндрэлтэй болно. Харин "гэм хор" хэмээх эрх зүйн ойлголтыг эрх зүй, эдийн засгийн хандлагаар авч үзвэл уг эрх зүйн зохицуулалтын нийгмийн ач холбогдол илүү тодорхой харагдах юм[14].

Эрх зүйн асуудлыг эдийн засгийн үүднээс авч үзэх шаардлага байгаа гэдгийг манай улс дэлхий нийтийн жишгээр хүлээн зөвшөөрч эхэлсэн. Үүний нэг том жишээ бол аливаа хууль тогтоомж, дүрэм журмыг "хэрэгжүүлэх"-д шаардлагатай зардлыг тооцох ажлыг хийж эхлэн, хууль тогтоомждоо тусгасан явдал юм[15]. Гэвч зардлыг тооцох энэхүү аргачлал нь хуулийн хэм хэмжээг баталснаар төр, иргэдэд гарч болох зардалд илүү төвлөрсөн буюу эдийн засгийн шинжилгээний шинж харьцангуй багатай. Тухайлбал, тодорхой гэрээ хэлцэл хийхэд нэмэлт зөвшөөрөл, бичиг баримт шаардсан хуулийн зохицуулалтын улмаас иргэнд, төрийн байгууллагад ямар хэмжээний ачаалал, зардал гарах тухай асуудал уг зардлын тооцооны зүйл болно.[16]

Харин хуулийн зохицуулалт хүмүүсийн зан авир буюу үйл хөдлөлд /үйлдэл, эс үйлдэл/ хэрхэн нөлөөлөх асуудлыг тэр бүр чухалчлан авч үзэх хандлага хараахан тогтоогүй байна. Энэ талаар манай хуульч, эдийн засагч, судлаачид болон иргэдийн дунд ердийн ухамсрын түвшний таамаг, яриа байдаг боловч эдийн засгийн ухааны арга хэрэгслийг ашиглан хэлэлцсэн, санал дэвшүүлсэн зүйл бараг байхгүй байна.

Хязгаарлагдмал баялгаар хязгааргүй хэрэгцээг хангах асуудлыг авч үздэг эдийн засгийн ухааны хандлагаар[17] гэм хор хэмээх үзэгдлийг авч үзвэл үүсч буй сөрөг үр дагавар, зардлыг багасгах буюу хамгийн бага түвшинд байлгах асуудал тавигдах юм. Үүнийг тогтоохын тулд юуны түрүүнд "гэм хор" гэх үзэгдлийн шалтгааныг тодорхойлох хэрэгтэй болж байна. Гэм хор нь тухайн нэг бүрчилсэн тохиолдол бүрт янз бүрийн шалтгаанаар үүсдэг боловч эдийн засгийн ухаанд 3 үндсэн шалтгаантай гэж үзжээ. Нэгдүгээрт, хүмүүс өөрсдийнх нь үйл хөдлөлийн /үйлдэл, эс үйлдэхүй/ улмаас үүсэх эрсдэлийн тухай бүрэн дүүрэн мэдээлэлгүй; хоёрдугаарт, эрсдэл байгааг мэдсэн боловч уг эрсдэлийг зөв тооцох чадваргүй; гуравдугаарт, эрсдэлийг зөв тооцох боловч үүсэх зардлыг өөр этгээдэд хариуцуулах буюу өөрөөсөө зайлуулах боломжтой гэж үзсэний улмаас хохирлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаггүй байна[18].

Гэвч гэм хор үүсэх эрсдэлийг огт байхгүй болгох нь хуулийн зорилго байх боломжгүй. Учир нь бүх эрсдэлийг байхгүй болгох оролдлого нь ямар ч үр ашиггүй, хэт их зардалтай байж болно. Жишээлбэл, зам тээврийн осол эрсдэлийг байхгүй болгохын тулд тээврийн хэрэгсэл ашиглахыг хориглох шаардлагатай болж болох юм. Гэтэл орчин үеийн нийгэм, эдийн засгийн амьдралд энэ нь туйлын ухаалаг бус, эдийн засгийн маш их алдагдал авчрах шийдвэр болно. Ийм учраас тухайн эрсдэлийг хуулийн хэллэгээр бол "зохистой" түвшинд, эдийн засгийн хэллэгээр бол "үр ашигтай" түвшинд байлгах сэдлийг хүмүүст бий болгоход хууль чиглэх ёстой болно[19].

Бусад этгээдийн зүгээс өөрт нь санаатай эсхүл болгоомжгүйгээр гэм хор учруулах эрсдэл хүний нийгэмд амьдарч байгаа ямар ч хүнд байсаар л байдаг. Харин энэхүү "гэм хор" буюу

[13] K.Zweigert& H.Koetz, Comparative law: Volume II, The Insitutions of Private Law (1977) p.310

[14] R.Posner, Economic Analysis of Law, 2006

[15] Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйл

[16] ХЗДХЯ, Хууль, хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал, Уб., 2013 он.

[17] Микро экономиксийн үндэс, Уб., 2014 он , 19 дэх тал / МУИС, Эдийн засгийн тэнхим/

[18] D.H.Cole, Peter Z.Grossman, Principles of Law and Economics, 2nded., 2011, p.267

19 R.Cooter & T.Ulen, Law& Economics, 6th ed, p.199-200

Хуульчдын мэдээлэл www.nlegov.mn

зөрчлөөс үүсэх нэмэлт зардлыг хэнд, ямар хэмжээгээр хариуцуулах буюу эрсдэлийг хуваарилахад эрх зүйн зохицуулалт чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ тохиолдолд гэм хор учруулсан этгээдээр үүссэн зардлыг нөхөн төлүүлэх нь уг эрсдэлийг багасгахад чиглэсэн үйл хөдлөл хийх сэдэлтийг нэмэгдүүлэх тул гэм хорын улмаас нийгэмд гарч буй үр ашиггүй зардлыг бууруулах боломжтой болох юм.

Эдийн засгийн арга зүйг ашиглан гэм хороос үүсэх үүргийн зорилгыг тайлбарласан анхны бүтээл бол Гуйдо Галабрисигийн "Ослын зардал" хэмээх бүтээл /1972 он/ билээ. Энэхүү бүтээл гарснаас хойш эрх зүй, эдийн засгийн олон ном, сурах бичгүүдэд гэм хорын асуудлыг тухайлан авч үзэхдээ судлаачид өөр өөрсдийн арга барилаар хандсан[20] байх боловч үндсэндээ дээрх бүтээлд анхлан хөндөгдсөн тэрхүү "эдийн засгийн үр ашиг" хэмээх ойлголтод тулгуурласаар байна.

Гэм хорын улмаас үүсэх зардал гэдгийг эдийн засгийн ухаанд хохирсон этгээдүүдэд үүсэх эрүүл мэнд, эд хөрөнгө, орлого, цаг хугацаа болон өвдөлт, зовлон шаналал зэрэг олон төрлийн алдагдлаас гадна уг зөрчилтэй холбоотойгоор нийгмийн бусад гишүүд, байгууллагуудад гарч буй зардал юм. Тухайлбал, осол гэмтлийг шалгах, маргаан шийдвэрлэх байгууллагын зардал зэрэг олон төрлийн зардлыг мөн оруулж тооцдог. Үүнийг эрх зүй, эдийн засгийн ухаанд "ослын зардал" гэсэн үгээр илэрхийлжээ. Жишээлбэл, шүүхээр шийдвэрлэгдэж буй гэм хорын маргааны түгээмэл хэлбэр болох зам тээврийн ослын хувьд нэхэмжлэгчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлоос[21] гадна уг ослыг шалган тогтоохтой холбоотой цаг хугацаа, техник хэрэгсэл, хүн хүчний зардал, шүүхийн үйл ажиллагаатай холбоотой зардал зэрэг нь "ослын зардал" болох юм.

Нөгөө талаас, гэм хороос урьдчилан сэргийлэхэд гэм хор учруулагч этгээдээс болон хохирч болзошгүй этгээдийн аль алины зүгээс анхаарал, болгоомжтой байх шаардлагатай. Жишээлбэл, замын хөдөлгөөний дүрмийг чандлан сахих, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах, эргэн тойрноо анхааран хөдөлгөөнд оролцох, насанд хүрээгүй хүүхдийг ганцааранг нь явуулахгүй байх, замын цагдаа, сургуулийн "цагдаа" зэрэг хүмүүсийг зам дээр зогсоож зохицуулах, олон тооны камер байршуулах зэрэгт тодорхой хэмжээний цаг хугацаа, энерги, мөнгөн зардал гарна. Үүний тулд хүмүүс мөн л цаг хугацаа, мөнгө, тав тух зэргээ зориулах тул энэ нь урьдчилан сэргийлэх зардалд орж тооцогдох бөгөөд эрх зүй, эдийн засгийн ухаанд "анхаарал болгоомжийн зардал" гэнэ[22].

Ослоос үүдэн гарах зардал болон анхаарал болгоомжтой байх зардал хоёрын нийлбэр нь ослын улмаас нийгэмд үүсэх нийт зардал юм. Өөрөөр хэлбэл, дээрх "ослын зардал", "анхаарал болгоомжийн зардал"-ыг нийлүүлээд "гэм хорын нийгмийн зардал" гэж үзэж болно. Энэхүү гэм хорын нийгмийн зардлыг хамгийн бага хэмжээнд байлгахад эрх зүйн зохицуулалт чиглэж байвал тухайн зохицуулалтыг "үр ашигтай" гэж үзэх юм.

Санаатайгаар бусдад хохирол учруулсан гэмт үйлдлээс бусад ихэнх тохиолдлын гэм хорын хувьд хүний анхаарал болгоомжгүй байдал нөлөөлдөг. Тухайлбал, зам тээврийн ослын "анхаарал болгоомж" нэмэгдэх хэрээр "осол гарах магадлал" буурах урвуу хамааралтай болох юм. Үүнээс

[20] R.A.Posner& Guido Galabresi`s " The Costs of Accidents": Areassessment, 64.Haryland Law Rewiew 12 (2005)

[21] Жишээлбэл, Манай улсын хувьд 2017 оны байдлаар зам тээврийн ослоос иргэн, аж ахуй нэгж, байгууллагад нийт 6 195 085 942 хохирол учирдаг гэсэн тоо мэдээ байна. Монгол Улс дахь Зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхтгэл, Уб., 2018 он, 30 дахь тал.

[22] R.Cooter & T.Ulen, Law& Economics, 6th ed,2011 p.199-200

үзвэл, ослын тоог бууруулах, үүсэх хохирлын хэмжээг багасгахын тулд ослоос сэргийлэхэд нийгмийн гишүүд буюу хүмүүсийн хүлээх үүрэг буюу “анхаарал болгоомжтой байх үүрэг”-ийг хуульчлан тогтоох шаардлага үүсэх юм.

Манай улсын Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсэгт “бусдын эд хөрөнгөд санаатай эсхүл болгоомжгүй үйлдэл, эс үйлдлээр гэм хор учруулсан бол уг гэм хорыг хариуцан арилгах” талаар заасан. Энэхүү гэм хор учруулснаас үүсэх ерөнхий үүргийг тогтоосон хуулийн заалт нь “болгоомжгүй” буюу анхаарал, болгоомж алдсан байхыг гэм буруутай гэж тооцох нэг нөхцөл болгон тусгасан байна. Жишээлбэл, зам тээврийн ослоос үүссэн хохирлыг арилгуулахын тулд ихэнх тохиолдолд тухайн этгээд “болгоомжгүй”-н буруутай гэх нөхцөл байдал тогтоогдсон байх ёстой.

Тэгвэл “болгоомжгүй” гэж үзэхийн тулд тодорхой стандарт буюу хэмжүүр байх ёстой болж байна. Зам тээврийн ослын хувьд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн дүрэм, журмын ихэнх зохицуулалт нь замын хөдөлгөөнд оролцогчдын баримталбал зохих стандарт буюу “анхаарал болгоомж”-ийн хэмжээг тогтоодог. Өнгөц харахад замын хөдөлгөөний дүрмийг биелүүлэхэд зардал шаардлагагүй мэт харагдах боловч хөдөлгөөний хурдаа хянах, эсхүл согтуугаар автомашин жолоодохын оронд дуудлагын жолооч хөлслөх зэрэг сонголт байна. Үүнд мөнгөний болон тав тух, цаг хугацаа тодорхой хэмжээнд зарцуулах учраас “анхаарал болгоомжтой байх” нь өөрөө ямар ч зардалгүй буюу үнэ цэнэгүй зүйл биш юм. Жишээлбэл, сургуулийн хүүхдийн цүнхэнд гэрэлтүүлэгчтэй уут хийлгэх, “сургуулийн цагдаа” буюу “school police” хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг нь зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэхэд чиглэж буй үйл ажиллагаа боловч эцэг, эхчүүдээс гарах зардал нэмэгдэнэ.

Ийм учраас зам тээврийн ослын нийгмийн нийт зардлыг бууруулахад ямар зохицуулалт, дүрэм журам хэрэгтэй болохыг эдийн засгийн шинжилгээний аргыг ашиглан тандах боломжтой. Замын хөдөлгөөнд оролцох моторт тээврийн хэрэгслийн тоо нэмэгдэх хэрээр осол гарах магадлал өндөр байдаг. Монгол Улсын Замын цагдаагийн газрын статистик тоо мэдээнээс үзэхэд 1998-2016 оны хооронд тээврийн хэрэгслийн тоо 71490-766019 болж өссөн[23], зам тээврийн ослын тоо 4108-46715 болж өссөн байна. Харин 2017 онд автомашины тоо 48 990-ээр нэмэгдсэн байхад ослын тоо 10121-ээр буурсан байна. Ийнхүү ослын тоо буурахад ямар хүчин зүйл, ямар арга хэмжээ нөлөөлсөн гэдэг нь сонирхол татаж байв. Түүнчлэн “анхаарал болгоомж”-ийн хэмжээ нь осол гарах магадлалд нөлөөлж байгааг илтгэх өөр нэг тоон үзүүлэлт бол “тээврийн хэрэгсэл жолоодсон туршлага” буюу хугацаанаас хамаарч байна. Тодруулбал, осол гаргасан 9821 нийт жолоочийн 34 хувь нь 0-5 жил, 28 хувь нь 6-10 жил, 25 хувь нь 11-15, 11 хувь нь 16-20, 1.2 хувь нь 21-ээс дээш жил тээврийн хэрэгсэл жолоодсон туршлагатай байсан байна[24].

Дээрхээс арай илүү тодорхой жишээ авч үзвэл үйлдвэрлэлийн ослоос ажилтанд учирсан хохирлыг ажил олгогчоор нөхөн төлүүлэх зохицуулалт[25] манай улсын болон бусад улс орны хуульд байдаг. Хүн чанар зэрэг ёс зүйн асуудал энд хөндөгдөх нь эргэлзээгүй боловч эдийн засгийн ашиг орлогын төлөө үйлдвэрлэл явуулж байгаа этгээдийн хувьд уг үйл ажиллагаанд зарцуулж буй зардал, түүнээс бий болох орлого, эсхүл хэмнэгдэх зардлыг тооцоолон шийдвэр гаргадаг. Жишээлбэл, үйлдвэр дээр осол гарч болох эрсдэлийг ажил

[23] Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт, Уб., 2018 он, №7 205 дахь тал.

[24] Замын хөдөлгөөний статистик №7 69 дэх тал.

[25] Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйл.

олгогчид хүлээлгэн, хамгаалалтын хэрэгсэл, технологи нэвтрүүлэх, тусгай ажилтан ажиллуулах, хяналт, сургалт зохион байгуулах зэрэг ослоос сэргийлэх арга хэмжээ авах үүргийг ажил олгогчид хүлээлгэдэг[26]. Энэ нь анхаарал болгоомжийн стандартыг хуулиар тогтоож буй явдал юм. Эдгээр дүрэм, журмыг дагаж мөрдөхийн тулд ажил олгогч тодорхой нэмэлт зардал гаргаж байгааг "анхаарал болгоомжийн зардал" гэж үзэж болно. Анхаарал болгоомжтой байх стандартыг сахих буюу анхаарал болгоомжийн хэмжээ нэмэгдэх хэрээр ослын магадлал зохих хэмжээгээр буурах, үүнтэй холбоотой ослоос үүдэн гарах зардлын хэмжээ буурч болно[27]. Осол гарах магадлал 100 хувьтай бол үүнээс үүсэх хохирол, зардлыг 100 нэгж байх хамаарлын хүрээнд ослоос гарах зардлыг ослын магадлалтай уялдуулан тодорхойлж болно. Жишээлбэл, үйлдвэрлэлийн ослоос сэргийлэх тухай ямар ч дүрэм, журам тогтоогоогүй тохиолдолд осол гарах магадлал 30 хувь гэж үзвэл урьдчилан сэргийлэх зардал байхгүй, харин ослоос үүсэх зардал 30 нэгж болно. Тэгвэл, үйлдвэрлэлийн ослоос сэргийлэхийн тулд аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх үүргийг хуулиар ажил олгогчид ногдуулжээ. Энэхүү үүргийг биелүүлэхийн тулд ажил олгогчид 2 нэгж зардал гарах боловч осол гарах магадлал 20 хувь болж буурна гэж үзвэл үйлдвэрлэлийн ослын нийгмийн нийт зардал 22 нэгж болох юм. Энэ мэтчилэн шинэ дүрэм, журам тогтоон хэрэгжүүлэх замаар анхаарал болгоомжийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ бүрийг эхний баганад 0-7 гэсэн тоон үзүүлэлтээр илэрхийлж, харгалзан гарах анхаарал болгоомжийн зардал тус бүр 2 нэгжээр нэмэгдэхэд ослын магадлал 30 хувиас 11 хувь хүртэл харилцан адилгүй буурна гэж үзье.

Эдгээр анхаарал болгоомжийн хэмжээ, түүнд шаардагдах "зардал", "ослын магадлал", "ослын зардал" зэргийн харилцан хамаарлаас нийгмийн нийт зардал хамгийн бага байх хэмжээг тодорхойлох аргачлалыг хүснэгтээс харж болох юм. Анхаарал болгоомжийн хэмжээ 3 гэсэн илэрхийлэл дээр байхад ослын нийт зардал хамгийн бага байхаар байна. Дараагийн анхаарах асуудал бол 6, 7 гэсэн илэрхийлэлд буй анхаарал болгоомжийн зардал 12, 14 байгаа нь ослоос гарах зардалтай тэнцүү болон илүү байна. Энэ тохиолдолд анхаарал болгоомжтой байхад шаардлагатай арга хэмжээг авах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй болж байна.

Анхаарал болгоомжийг нэмэгдүүлэх арга хэмжээ	Анхаарал болгоомжийн зардал	Ослын магадлал	Ослоос гарах зардал	Нийт зардал
0	0	30%	30	30
1	2	25%	25	27
2	4	20%	20	24
3	**6**	**15%**	**15**	**21**
4	8	14%	14	22
5	10	13%	13	23
6	12	12%	12	24
7	14	11%	11	28

Өөрөөр хэлбэл, олон дүрэм журам, стандартыг сахих үүргийг биелүүлэхийн тулд гарах цаг хугацаа, мөнгөн зардал нэмэгдэх тул үүнтэй уялдан ослын магадлал, түүнтэй холбоотой зардал хэрхэн буурах вэ гэдгийг анхаарч үзэх нь нийгмийн ач холбогдолтой юм. Энэхүү зүй тогтол алдагдсанаас үүдэн иргэд хуулийг биелүүлэхгүй байх, тогтоосон хууль тогтоомж, дүрэм журмыг амьдралд нийцэхгүй байна гэсэн шүүмжлэл гарч болох юм.

Шүүхэд хэрэг шийдвэрлэх үед анхаарал болгоомжтой байх үүргээ

[26] ХНХЯ, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн эмхэтгэл, 2018. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүд ахуйн тухай хууль, Б,ХБЯ, Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм, 2006, Барилга угсралтын үйл ажиллагаанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангах асуудлыг зохицуулах нийтлэг журам, Уб., 2013 он.

[27] R.Cooter & T.Ulen, Law& Economics, 6th ed,2011, p.200

зөрчсөн эсэхийг тогтоохын тулд гэм хор үүссэн нөхцөл байдлыг хариуцагч арилгах, сэргийлэх бодит боломжтой байсан эсэх нь ач холбогдолтой нөхцөл байдал болдог.[28] Эдгээр төрлийн зардлыг тооцох мэдээлэл өөрөө их үнэтэй байдаг учир шүүхэд ийм тооцооллыг нарийвчлан хийх боломжтой эсэх нь эргэлзээтэй[29]. Жишээлбэл, нийтийн зориулалттай орон сууцны барилгын гаражийн гарцын хэсэгт цас байснаас болж өглөө үүрээр машин шарван осол гарчээ. Машины өмчлөгч СӨХ-өөс цасыг арилгаагүй байснаас осол гарсан гэж хохирол нэхэмжилсэн тохиолдолд хэр удаан хугацаанд цастай байсан, тухайн байгууллагын хувьд цасыг арилгах боломжтой байсан зэрэг нөхцөл байдал ач холбогдолтой байж болно. Шүүхээс машины өмчлөгчид учирсан хохирлын нөхөн төлбөрийг гаргуулснаар уг СӨХ-ийн хувьд цаашид үүднийхээ цасыг арилгах талаар анхаарал тавих сэдэлтийг нэмэгдүүлж болох боловч тэр нь ямар хэмжээтэй, ямар өртөгтэй байх вэ гэдэг нь "чухал биш асуудал" биш юм. Үүнээс шалтгаалан жолоочийн хувьд мөн анхаарал, болгоомж алдсан эсэх асуудал хөндөгдөж болно. Хүний бүхий л үйл хөдлөлд баримтлах стандартыг хуульчлан тогтоох боломжгүй, түүнчлэн хуулийн зохицуулалтыг нэг бүрчилсэн тохиолдолд хэрэглэхэд "анхаарал болгоомж"-той байх үүрэг зөрчигдсөн эсэхийг шүүхээс тогтоох, дүгнэлт хийхэд энэхүү эрх зүй, эдийн засгийн шинжилгээний аргыг анхаарч болох юм.

ДҮГНЭЛТ

Хүний нийгэмд амьдарч буй хүн бусдад гэм хор учруулахгүй байхын тулд зохих хэмжээнд анхаарал болгоомжтой байх нь мэдээжийн зүйл мэт боловч зайлшгүй шаардлагатай "анхаарал болгоомж"-ийн хэмжээ, стандартыг тухайн нийгмийн гишүүдийн зөвшилцлийн үр дүнд бий болсон хууль тогтоомжоор мөн тогтоодог. Өөрөөр хэлбэл, гэм хор учруулснаас үүрэг үүсэх буюу хохирол төлүүлэх үндэслэлийг тодорхойлж буй дүрэм, журмууд цаашид үүсэх хор, хохирлыг багасгахад чиглэсэн байж болно. Өөрөөр хэлбэл, хүмүүсийн баримтлах стандарт буюу "анхаарал болгоомжийн хэмжээ"-г тогтоох замаар цаашид үүсч болзошгүй аюул ослыг багасгахад гэм хорын эрх зүй, түүний хүрээнд хэрэглэгдэх дүрэм, журмууд чиглэж байна.

Анхаарал болгоомж нэмэгдэх хэрээр ослын магадлал буурах боловч энэ нь нийгмийн нийт зардалд хэрхэн нөлөөлөхийг эрх зүй, эдийн засгийн хандлагаар авч үзэх нь хууль тогтоомж амьдралд хэрэгжих боломжтой, "ухаалаг" байх нэг нөхцөл болох юм. Учир нь ослоос сэргийлэхэд шаардагдах зардал нь ослоос үүсэх зардлаас бага бус, эсхүл нийгмийн нийт зардлыг бууруулж чадахааргүй байгаа тохиолдолд ослоос сэргийлэхэд чиглэсэн дүрэм, журмууд бодитой хэрэгжих эсэх нь эргэлзээтэй. Иймд "анхаарал болгоомжийн хэмжээ"-г тогтоосон аливаа дүрэм журам нь сэргийлж, хамгаалах гэж буй тухайн зорилготойгоо уялдаж буй эсэхийг хууль тогтоогчид, тэдгээрт зөвлөгөө өгдөг эрхэм хуульчдын анхаарах нэн чухал асуудлын нэг болжээ.

Эрх зүй, эдийн засгийн арга зүй нь зөвхөн хууль тогтоогчид төдийгүй шүүхийн практикт ач холбогдолтой байж болно. Аливаа этгээдийг "анхаарал болгоомжтой байх үүргээ зөрчсөн" гэж үзэх буюу "болгоомжгүйн гэм буруу"-тай гэж тооцохын тулд ямар дүрэм, журам,

[28] R.Cooter & T.Ulen, Law& Economics, 6th ed, p.196-197

[29] D.H.Cole, Peter Z.Grossman, Principles of Law and Economics, 2nded., 2011, p.273

хууль зөрчсөн гэдгийг анхаарахаас гадна, үүнд хэр хэмжээний зардал гаргах, улмаар үүсч болзошгүй ослыг хэр хэмжээнд зайлуулах боломжтой байсан бэ гэдгийг эргэцүүлэн тунгаахад тус дэмтэй билээ. Энэхүү өгүүллийн хүрээнд гэм хорын эрх зүйн нийгэмд гүйцэтгэх үүрэг, “болгоомжгүйн” гэм буруутай гэж үзэх асуудлыг эрх зүй, эдийн засгийн арга зүйг ашиглан тайлбарлахыг зорьсон бөгөөд, анхаарал болгоомжтой байх үүргийн хуваарилалт, гэм хорын үүргийн төрөл зэрэг асуудлыг эрх зүй, эдийн засгийн ухаанд хэрхэн авч үзэж байгааг дараа, дараагийн өгүүлэлд танилцуулах болно.

---o0o---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ “ОРОЛЦОГЧ БИШ” ОРОЛЦОГЧ БУЮУ “СЭЖИГТЭН”-ИЙ ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТЫГ ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН /STPO/ ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛАХ НЬ

УЕПГ-ын Сургалт, судалгааны төвийн дэргэдэх гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах хүрээлэнгийн захирал, хууль зүйн доктор Б.Өнөрмаа

ТҮЛХҮҮР ҮГ:

Хүний эрх, сэжигтэн, хуулийн хийдэл, өөрийгөө хамгаалах эрх, сэжиглэх үндэслэл, дотоод итгэл, нотлох баримт, халдашгүй байдал, мэдүүлэг өгөх эрх, гэм буруугүйгээ нотлох.

ТОВЧЛОЛ:

Монгол Улсын ЭХХШтХ-д сэжигтнийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч гэж хуульчилсан атлаа сэжигтнээс мэдүүлэг авах ажиллагаа зохицуулагдаагүй бөгөөд хэрэгт сэрдэгдэж буй хүнээс гэрчийн мэдүүлэг авах нь түүний үндсэн эрхийг ноцтой зөрчиж **“сэжигтэн”**-ий статус, эрх үүргийг тодорхойлоогүй нь Монгол Улсын Үндсэн хуульд харшилж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гол оролцогч атлаа эрх, үүрэг нь тодорхой бус оролцогч “сэжигтэн”-ий эрх зүйн байдлыг тодорхойлох маргаан нь мөрдөгч, прокурор сэжигтнээр тогтоох эсхүл тооцох тогтоол гаргах эсэх процессын асуудал биш бөгөөд харин сэжигтэн нь дээрх ажиллагааны гол оролцогчийн хувьд гэрчийн мэдүүлэг өгч байгаа нь гэм буруугүйгээ өөрөө нотлох хүлээж буй үйлдэл юм. Энэ нь Монгол Улсын ЭХХШтХ-ийн 1.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Шүүх, прокурор, мөрдөгч нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс гэм буруугүй болохыг өөрөөр нь нотлуулахаар шаардахыг хориглоно” гэж заасантай зөрчилдөж байна.

УДИРТГАЛ:

Хүний эрхэд суурилсан түүнийг хамгаалсан эсхүл зөрчигдсөн эрхийг сэргээх нийтлэг чиг хандлагыг тодорхойлсон олон улсад жишиг болон мөрдөгдөж буй эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны суурь зарчмуудыг хэрэгжүүлэхэд манай улсад уламжлагдан тогтож ирсэн энэ чиглэлийн онол, үзэл баримтлал үүнээс улбаалсан гэмт хэрэгтэй тэмцэх, түүнийг илрүүлэх, гэмт этгээдийг олж тогтоох, түүнд шударга ял шийтгэл оногдуулахад чиглэсэн тогтолцоо, байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын чиг үүргийн хуваарилалтыг өөрчлөх шаардлага бий болсны дагуу Монгол Улс 2015 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг батлан, мөрдөгдөж эхлээд жил гаран болж байна.[1]

Гэмт хэрэгтэй тэмцэхэд чиглэсэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь улс орон бүрт өөр өөрийн онцлогт тохирсон эрх зүйн тогтолцооны уламжлалынхаа хүрээнд бүрэлдэн бий болсон байдаг хэдий ч онолын болон практик хэрэглээний хүрээнд Эх газрын буюу Ром - Германы,

[1] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан тайлан, Уб., 2016 он.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Нийтийн эрх зүй буюу Англо - Саксоны гэсэн бүлүүдэд хуваагдан хөгжиж ирсэн бөгөөд эрх зүйн тогтолцооны энэ хоёр бүл харилцан тус тусын давуу байдлыг хуваалцан, орхих зүйлээ орхин зэрэгцэн хөгжиж ирсэн юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдын эдлэх эрх, хүлээх үүргийг хуулиар зохицуулдаг бөгөөд тодорхой бус нөхцөл байдал нь хуулийн хийдэл үүсгэх цаашлаад хүний эрх зөрчигдөх нөхцөл үүсгэдэг. Шинээр мөрдөгдөж буй ЭХХШтХ-д эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг оролцогч болох сэжигтнээс хэрхэн мэдүүлэг авахыг хуулиар зохицуулаагүй нь өнөөдөр маргаан дагуулж байна.

ҮНДСЭН ХЭСЭГ

Хүнийг гэмт хэрэгт сэрдэж эхэлсэн үеэс, цаашилбал эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах тогтоол үйлдэхийн өмнө гэмт хэрэгт холбогдсон хүнээс хэрхэн мэдүүлэг авах нь процессын хувьд ч тухайн субъектийн хувьд ч ойлгомжгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арванургадугаар зүйлд[2] хүний халдашгүй байдал болон өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх үндсэн эрхийг баталгаажуулсан байдаг. Гэтэл өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ЭХХШтХ-д сэжигтнээр тооцох, сэжигтнээс мэдүүлэг авах ажиллагаа зохицуулагдаагүй бөгөөд хэрэгт сэрдэгдэж буй хүнээс гэрчийн мэдүүлэг авах нь түүний үндсэн эрхийг ноцтой зөрчиж буй үйлдэл болж байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогчдын эрх үүргийг хуульчилсан атлаа **"сэжигтэн"**-ий статус, эрх үүргийг тодорхойлоогүй нь Үндсэн хуульд харшилж байна.

Монгол Улсын ЭХХШтХ-д "сэжигтэн"-г эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч байхаар уг хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.13 дахь заалтад тодорхойлсон байдаг бөгөөд гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй гэж хуульд заасан үндэслэлээр сэрдэгдсэн, хууль ёсны эрх ашиг, сонирхлоо хамгаалуулах, хууль зүйн туслалцаа авах эрхтэй субъект юм.

Хууль заасан үндэслэлээр сэрдэгдэнэ гэдэг нь мөн хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.23 дахь заалтад заасан "үндэслэл бүхий сэжиг" гэж энэ хуульд заасан тодорхой ажиллагаа явуулах нөхцөл үүссэн, эсхүл үйлдэгдэж болзошгүй гэмт хэргийн талаарх мэдээлэл, хэргийн нөхцөл байдалд тулгуурласан мөрдөгч, прокурор, шүүгчийн дотоод итгэлийг хэлнэ гэжээ.

Шүүгч, прокурор, мөрдөгчийн дотоод итгэл гэдэг нь хувь хүний асуудалд хандах сэтгэл зүйн хандлага ч биш хувийн итгэл үнэмшил ч биш бөгөөд аливаа хэрэг, маргааныг шийдвэрлэхэд ач холбогдолтой баримтын хүрээг зөв тодорхойлж эх сурвалжийг тогтоосон, тэдгээр нь хөдөлбөргүй нотлогдсон талаар мэргэжлийн ур чадварт тулгуурласан итгэл үнэмшил бөгөөд уг итгэл үнэмшилдээ хуульд нийцүүлж гаргасан шийдвэрээр баталгаажуулж байдаг.[3]

Эрх бүхий албан тушаалтан хуулиар бусдыг гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй гэж сэжиглэх үндэслэл буюу эрхийг баталгаажуулснаар хүний эрхэнд халдах боломж, нөхцөл бүрдэж байгаа бол нөгөө талдаа сэжиглэгдэж буй хүнд өөрийгөө хамгаалах эрх буюу боломж нь давхар үүсч байх ёстой.

ХБНГУ-ын эрүүгийн эрх зүйд гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй сэрдэгдэж буй хүн /Verdächtiger/, сэжигтэн, /*Beschuldigter*/, яллагдагч /Angeschuldigte/ гэсэн нэр томьёо байдаг бөгөөд Verdächtiger[4]

[2] Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно.

[3] Б.Өнөрмаа, "Шүүгчийн дотоод итгэл буюу нотлох баримтыг үнэлэх ажиллагаа", 2018 он, Дэлгэрэнгүй http://www.prokuror.mn/a/2174, https://www.mglbar.mn/?action=content&view=article&id=2640 үзнэ үү.

[4] https://de.wikipedia.org/wiki/Beschuldigter#cite_note-1

хуульзүйнцэнхэр www.nlr.gov.mn

буюу сэрдэгдэж буй хүн нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч биш тул хуульд тухайн субъектийн талаар зохицуулалт байдаггүй.

Харин сэжигтэн /*Beschuldigter*/ гэсэн нэр томьёо нь прокурор, мөрдөгчийн дотоод итгэлээр гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй гэсэн хангалттай үндэслэлээр хүнээс мэдүүлэг авсан тэр цаг мөчөөс тухайн хүн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч болж ирдэг. Сэжигтнээр тооцох эсхүл тогтоох гэсэн шийдвэр гардаггүй бөгөөд мэдүүлэг авахдаа эрх үүргийг нь шууд тайлбарлан өгдөг.

ХБНГУ-ын ЭХХШтХ-ийн /STPO/ 133 дугаар зүйлд сэжигтнийг мэдүүлэг авахаар бичгээр дуудан ирүүлэх ажиллагааг, 134 дүгээр зүйлд түүнийг баривчлах хангалттай үндэслэл байгаа тохиолдолд шууд албадан ирүүлэх ажиллагааг зохицуулсан байдаг.[5]

Прокурор сэжигтнийг ирэх тухай бичгээр мэдэгдсэн тохиолдолд дуудагдсан хүн заавал ирэх үүрэгтэй бөгөөд ирээгүй тохиолдолд албадан ирүүлэх эсхүл баривчлан ирүүлэх ажиллагаа хийгддэг. Дуудагдсан сэжигтэн түүнийг дуудсан нь үндэслэлгүй гэж үзвэл гомдол гаргах эрхтэй боловч гомдол гаргасан нь түүнийг хүрэлцэн ирэхэд саад болох үндэслэлгүй бөгөөд заавал ирэх үүрэг хүлээдэг.

Сэжигтнээр мэдүүлэг авах ажиллагааг мөн хуулийн 136 дугаар зүйлд дараах байдлаар нарийвчлан зохицуулжээ.

1. Түүнийг ямар хэрэгт буруутгаж байгааг эхэлж тайлбарлахдаа мөрдөгч, прокурор түүнийг холбогдуулан шалгаж байгаа хэргийн талаар тодорхой тайлбарлах үүрэгтэй бөгөөд ингэхдээ тодорхой бус, битүүлэг эсхүл үл ойлгогдох байдлаар илэрхийлж болохгүй.

2. Сэжигтэнд буруутгагдаж байгаа хэргийн талаар мэдүүлэг өгөхгүй байх, эсхүл сайн дурааараа мэдүүлэгч өгөх, мэдүүлэг өгөхөөсөө өмнө өөрийн сонгож авсан өмгөөлөгчөөсөө зөвлөгөө авах эрхтэйг тайлбарлана.

3. Өөрийг нь буруутгаж буй үндэслэлийг няцаах нотлох баримтыг нэгбүрчлэн шалгуулах хүсэлт гаргах эрхтэйг тайлбарлаж өгнө.

4. Мэдүүлэг өгөхийг зөвшөөрсөн тохиолдолд сэжигтэн хохирогчийн нэгэн адил бичгээр мэдүүлгээ өгч болохыг тайлбарлана. Сэжигтэн үйлдсэн хэргийн талаар үнэн зөв мэдүүлсэн тохиолдолд түүнд оногдуулах ял шийтгэл хөнгөрөх боломжтойг тайлбарлаж өгнө.

Сэжигтэн өөрийн буруугүйгээ нотлохын тулд худлаа ярих эрхтэй ч өөрийгөө зөвтгөсөн мэдүүлэг нь гэмт хэргийг нууж төөрөгдүүлэхгүй байх, /Vortäuschung einer Straftat § 145d StGB/, бусдыг гэмт хэрэгт гүтгэх эсхүл хуурамч сэжиг таамаг бий болгохгүй байх /die falsche Verdächtigung (§ 164 StGB), бусдыг гүтгэхгүй байх / Beleidigungsdelikt §§ 185 ff. StGB /-ыг сануулдаг бөгөөд энэ нь эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг болохыг сануулдаг. Тодруулбал, сэжигтний худлаа ярих эрх нь хууль сахиулагч болон албан тушаалтныг тухайн шалгаж байгаа хэргээс нь холдуулах зорилготой эсхүл зохиомол эрүүгийн хэрэг бий болгох, бусдыг гэмт хэрэгт буруутгах үндэслэл болохын бол зөвхөн энэ үйлдлийнхээ төлөө эрүүгийн хариуцлага хүлээнэ гэдгийг сануулдаг.

Гэтэл Монгол Улсын ЭХХШтХ-д сэжигтнийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч гэж хуульчилсан атлаа сэжигтнээс мэдүүлэг авах ажиллагаа зохицуулагдаагүй бөгөөд хэрэгт сэрдэгдэж буй хүнээс гэрчийн мэдүүлэг авах нь түүний үндсэн эрхийг ноцтой зөрчиж **“сэжигтэн”**-ий статус, эрх үүргийг тодорхойлоогүй нь Үндсэн хуульд харшилж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гол оролцогч атлаа эрх үүрэг нь тодорхой бус оролцогч “сэжигтэн”-ий эрх зүйн байдлыг тодорхойлох маргаан нь мөрдөгч, прокурор сэжигтнээр тогтоох эсхүл тооцох тогтоол гаргах эсэх процессын асуудал биш бөгөөд харин сэжигтэн нь

[5] https://www.justiz.nrw.de/Gerichte_Behoerden/Staatsanwaltschaften/Ermittlungsverfahren_Beteiligte/Beschuldigter/index.php, StP§ 133, 134, 135, 136

дээрх ажиллагааны гол оролцогчийн хувьд гэрчийн мэдүүлэг өгч байгаа нь гэм буруугүйгээ өөрөө нотлох хүлээж буй үйлдэл юм. Монгол Улсын ЭХХШтХ-ийн 1.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Шүүх, прокурор, мөрдөгч нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс гэм буруугүй болохыг өөрөөр нь нотлуулахаар шаардахыг хориглоно" гэж заасантай зөрчилдөж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүнийг гэрч гэх бөгөөд гэрч нь хэргийн талаар өөрийн мэдэх зүйлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан, мэдүүлэг өгөхөөс санаатайгаар зайлсхийсэн, эсхүл худал мэдүүлэг өгсөн бол түүнд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.[6]

Сэжигтэн "гэрч" нь хуульд заасан агуулгаараа өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй, гэм буруугүйгээ нотлох үүрэггүй боловч гэрчээр мэдүүлэг өгсөн тохиолдолд тухайн хэргийн талаар үнэн зөвөөр мэдүүлэх үүрэгтэй. Тухайн сэжигтэнд холбогдох хэрэг нотлогдсон, "гэрч" сэжигтэн худлаа мэдүүлэг өгсөн нь нотлогдсон тохиолдолд түүнд гэрчийн хувьд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үү гэдэг асуудал хөндөгдөнө.

2015 оны ЭХХШтХ-ийн 31.6 дугаар зүйлд зөвхөн баривчлагдсан сэжигтэнд эрхийг нь тайлбарлах тухай зохицуулсан байгаа нь гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй үндэслэлээр сэжиглэгдэж буй бусад сэжигтэнд хамаарахгүй зохицуулалт юм.

ДҮГНЭЛТ

Шинэ хуулиар эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын эрх ашгийг хангах, яллах, өмгөөлөх талын эрх тэгш мэтгэлцээний үндсэн дээр явагдах зарчим бүрэн хэрэгжих нөхцөл энэ тохиолдолд хангагдаагүй бөгөөд сэжигтний эрх, үүргийг хуулиар тодорхойлоогүй нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан эрхийг зөрчиж ЭХХШтХ-ийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хууль ёсны байх мөн хэргийн бодит байдлыг тогтоох зарчим алдагдаж байна.

Шүүгч, прокурор, мөрдөгчийн дотоод итгэл гэдэг нь хувь хүний асуудалд хандах сэтгэл зүйн хандлага ч биш хувийн итгэл үнэмшил ч биш бөгөөд аливаа хэрэг, маргааныг шийдвэрлэхэд ач холбогдолтой баримтын хүрээг зөв тодорхойлж эх сурвалжийг тогтоосон, тэдгээр нь хөдөлбөргүй нотлогдсон талаар мэргэжлийн ур чадварт тулгуурласан итгэл үнэмшил бөгөөд энэ нь бусдыг гэмт хэрэг үйлдсэн сэжиг, таамаг дэвшүүлэхэд тулгуур нь болох ёстой. Энэ нь ЭХХШтХ-ийн 1.4 дүгээр зүйлийн 1.23 дахь заалтад заасан "үндэслэл бүхий сэжиг" гэж энэ хуульд заасан тодорхой ажиллагаа явуулах нөхцөл үүссэн, эсхүл үйлдэгдэж болзошгүй гэмт хэргийн талаарх мэдээлэл, хэргийн нөхцөл байдалд тулгуурласан мөрдөгч, прокурор, шүүгчийн дотоод итгэлийг хэлнэ гэжээ.

Эрх бүхий албан тушаалтан хуулиар бусдыг гэм хэрэг үйлдсэн байж болзошгүй гэж сэжиглэх үндэслэл буюу эрхийг баталгаажуулснаар хүний эрхэнд халдах боломж, нөхцөл бүрдэж байгаа бол нөгөө талдаа сэжиглэгдэж буй хүнд өөрийгөө хамгаалах эрх буюу боломж нь давхар үүсч байх ёстой.

Баривчлагдсанаас бусад тохиолдолд гэмт хэрэгт сэжиглэгдэж буй хүнд дээрх эрх, боломж нь 2015 оны ЭХХШтХ-аар олгогдоогүй бөгөөд гэрчийн мэдүүлэг өгч явсаар шууд яллагдагчаар татагдах нөхцөл бий болоод байгаа бөгөөд тодруулбал, сэжигтнээр үйлдсэн хэргийг нь нотлуулах хэмжээний хийдэл хуульд бий болсон нь эрх бүхий субъектүүдийн "дотоод итгэл, нотлох баримт"-аар хэргийг шийдвэрлэх чиг үүрэгтэй нь харшилдаж байна.

САНАЛ

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гол оролцогч атлаа эрх үүрэг нь тодорхой бус оролцогч "сэжигтэн"-ий эрх зүйн байдлыг тодорхойлох. Тухайлбал, сэжигтэн нь дээрх ажиллагааны гол

[6] ЭХХШтХ-ийн 9.6 дугаар зүйл.

оролцогчийн хувьд гэрчийн мэдүүлэг өгч байгаа нь гэм буруугүйгээ өөрөө нотлох хүлээж буй хуулийн хийдлийг арилгах зохицуулалт хийх буюу сэжигтнээс мэдүүлэг авах, эрх үүргийг нь танилцуулах тодорхой заалтыг хуульд тусгаж өгөх. Баривчлагдсанаас бусад тохиолдолд гэмт хэрэгт сэжиглэгдэн дуудагдан ирсэн, мэдүүлэг өгч буй хүнд сэжиглэгдэж буй үндэслэл, түүний эрх, үүргийг нь шууд тайлбарлан өгдөг зохицуулалтыг хуульд тусгах.

Сэжигтний үүргийг тодорхой болгохдоо өөрийн гэм буруугүйг батлахын тулд бусдыг гэмт хэрэгт гүтгэх боломжийг хааж энэ тохиолдолд харин эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг сануулж болох юм.

2. Сэжигтнээр тооцох, тогтоох тухай процесс шаардлагагүй гэж үзэж байна. Учир нь ЭХХШтХ-ийн 1.4 дүгээр зүйлийн 1.23 дахь хэсэгт заасан "үндэслэл бүхий сэжиг" гэж энэ хуульд заасан тодорхой ажиллагаа явуулах нөхцөл үүссэн, эсхүл үйлдэгдэж болзошгүй гэмт хэргийн талаарх мэдээлэл, хэргийн нөхцөл байдалд тулгуурласан мөрдөгч, прокурор, шүүгчийн дотоод итгэлийг хэлнэ гэж тодорхойлсон нь сэрдэгдэж буй хүнээс мэдүүлэг авах нөхцөлийг бүрдүүлж байгаа болно. Гэрчээр тооцох, тогтоох процесс байдаггүйтэй ижил нөхцөл юм.

ЭХ СУРВАЛЖ

1. Монгол Улсын Үндсэн хууль

2. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

3. ХБНГУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /STPO/

4. Б.Өнөрмаа, "Шүүгчийн дотоод итгэл буюу нотлох баримтыг үнэлэх ажиллагаа", Уб., 2018 он.

5.https://www.justiz.nrw.de/Gerichte_Behoerden/Staatsanwaltschaften/Ermittlungsverfahren_Beteiligte/Beschuldigter/index.php, StP§ 133, 134, 135, 136

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

---o0o---

ЭРХ ЗҮЙТ, АРДЧИЛСАН ТӨРД ХУУЛЬЧИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн хүндэт доктор, Юрген Харбих

Монгол Улсын иргэд германчууд бидний нэгэн адил ардчилал, эрх мэдлийн хуваарилалт, хүний үндсэн эрхийг гол зарчмаа болгон тунхагласан улс орны иргэд билээ. Бид ардчилсан эрх зүйт төрд, орчин үеийн үндсэн хуульт оронд оршин амьдарч байна. Монголын хувьд ч манай улсын хувьд ч үргэлж ийм байсангүй. Герман улсаас үүсэлтэй ардчилсан эрх зүйт төрийн үнэт зүйлийг уландаа гишгэсэн үйл явдал 20 дугаар зуунд болж өнгөрсөн нь манай улсын төдийгүй, дэлхийн бусад улсын түүхэнд гашуун сургамж болон үлдсэн юм. Ардчилал, эрх зүйт ёс тэнгэрээс унаж ирдэг хишиг биш, харин ихээхэн хүчин чармайлт шаардсан үнэ цэнтэй зүйл байна гэдгийг бид бүхэн мэднэ. Энэ үнэ цэнтэй зүйл маань үргэлжийн мөнхөд байна гэсэн баталгаа бас үгүй.

Гагцхүү бүх хүчээ дайчлан зүтгэж байж л энэхүү ардчилсан эрх зүйт төрийн үр шимийг хүртэнэ. Түүний үр шим нь юу вэ? гэдгийг эргэн саная:

Тэр нь Үндсэн хуульдаа бидний тунхагласан хүний эрх, хуулийн өмнө хүн бүр тэгш байх явдал, ялангуяа хүйсийн тэгш эрх, шашин шүтэх эрх чөлөө, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, шинжлэх ухааны эрх чөлөө, ардчилсан сонгох сонгогдох эрх, эрх мэдлийн хуваарилалт, захиргаа хуульд захирагдах ёс, дур зоргоор авирлахыг хориглох, эрх зүйг шүүх эрх мэдлээр хамгаалах ёс, шүүгчийн хараат бус байдал, эцэст нь дурдалгүй өнгөрч үл болох зүйл бол эрх зүйт төрийн титэм болсон Үндсэн хуулийн шүүх эрх мэдэл юм. Энэ бүгд үнэ цэнтэй зүйлс гэдэг нь маргаангүй.

Харин эдгээр үнэт зүйлсийн төлөө бүх хүчин чармайлтаа дайчлан ажиллах нь эрэгтэй, эмэгтэй нэгэн адил хүн бүрийн үүрэг хариуцлага юм. Юуны өмнө төрийн эрх мэдлийн гурван салаа руу товч анхаарал хандуулъя:

I. ПАРЛАМЕНТ

Ард түмнээс сонгогдсон Парламент нь хууль баталж, улсын эрх зүй, эдийн засаг, нийгмийн бодлогыг тодорхойлж, шинэчилж тогтвортой байлгах чиг үүрэгтэй. Хуулиар хувь хүн, хувийн эрх зүйн болон төрийн бус байгууллага (ТББ), аж ахуйн болон гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагааны хүрээ хязгаарыг тогтоодог. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэм хэмжээг ч мөн хуулиар тогтоосон байдаг.

Парламент нь хууль батлахдаа шийдвэр гаргах өөрийн гэсэн орон зайтай байдаг бөгөөд улс төрийн намууд тэрхүү орон зайн хүрээнд өөрсдийн бодлогыг хэрэгжүүлдэг. Гагцхүү хуулийн хүрээнд баталсан хууль л хууль ёсны хэмээн тооцогддог. Өөрөөр хэлбэл, парламент ч гэсэн чиг үүргээ эрх зүйн хүрээнд, тодруулбал Үндсэн хуулийн хүрээнд хэрэгжүүлэх ёстой.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Түүний үйл ажиллагаа, шийдвэрийнх нь агуулгыг Үндсэн хуулиар хязгаарласан байдаг. Парламент дахь цөөнхийн эрхийг хүндэтгэж, хүний үндсэн эрхийг хамгаалж, дур зоргоор шийдвэр гаргахыг таслан зогсоох нь Үндсэн хуулийн тэрхүү хязгаар билээ. Аль ч улсад шийдвэр гаргагчид заримдаа эдгээр зарчмыг хараанаасаа гээх тохиолдол байдгийг бид бүхэн мэднэ. Иймд бид сонор соргог байгтун хэмээн сануулах учиртай. Үүнээс болж гарцаагүй зөрчилдөөн үүсэх нь олонтаа тохиолдоно. Хэдийгээр аливаа байгууллагын гишүүн дотогш болон гадагш чиглэсэн харилцаандаа байгууллагынхаа эрх ашигт үнэнч байх үүрэг хүлээдэг боловч хуулиас давж алхсан мөчөөс тэрхүү байгууллага гишүүдээсээ үнэнчээр зүтгэхийг шаардах эрхээ алддаг. Үндсэн хуулийн зарчим мөрдөгдөж, ардчилал, эрх чөлөө, тэгш эрх иргэн бүрийн амьдралд мэдрэгдэхүйц өөрчлөлт авчирч буй эсэхэд анхаарал хандуулж үүний төлөө тэмцэх нь парламентын гишүүн нэг бүрийн үүрэг гэдгийг гүнээ ухамсарлах шаардлагатай. Ялангуяа парламентад сууж буй хуульч эрх баригч нам, эсвэл сөрөг хүчинд харьяалагдаж байгаагаас үл хамаарч энэ үүргээ илүү өндөр түвшинд ухамсарлаж хэрэгжүүлэх ёстой. Хуульч хүний ёс зүй нь ямар ч өндөр дээд албан тушаалтны эсрэг зогсож тэмцэхийг шаарддаг.

Манай Европын Холбоонд өнөөдөр эрх зүйт төрийн тухай эрчимтэй маргаан мэтгэлцээн өрнөж байна. Тус Холбооны нэг бус гишүүн орны парламентын олонх нь Үндсэн хуулиар тогтоосон хүрээ хязгаарыг давж, нийгмийн бүх оролцогчдоос бат тогтвортой суурь хэмээн хүлээн зөвшөөрөгдөж ирсэн эрх зүйт төрийн суурь зарчмыг зөрчиж байгааг бид нэлээд хэдэн жилийн өмнөөс харж байна. Тэрхүү хууль бус алхмыг зохион байгуулагчдын ариаг сонсоход өөрсдийгөө ард түмний ихэнх хувийн саналыг авч сонгогдсон парламентын олонх гэдгээр зөвтгөхийг оролдох нь элбэг байдаг. Ийм үндэслэлд цаг тухайд нь дорвитой няцаалт өгч байх шаардлагатай. Орчин үеийн үндсэн хуульт төрийн үндсэн хэв шинж нь гагцхүү ардчиллын суурь зарчмаар тодорхойлогдохгүй. Хараат бус шүүх, хүний эрхийг эрхэмлэн дээдлэх зэрэг эрх зүйт төрийн чухал элемент түүний хэв шинжийг мөн тодорхойлж өгдөг. Эрх зүйт төр нь төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж буй бүхий л шатны байгууллага, тэр дундаа юуны түрүүнд парламент хууль, болон эрх зүйг ямарваа ялгаварлалгүйгээр дээдлэн сахихыг шаардаж байдаг.

II. ГҮЙЦЭТГЭХ ЭРХ МЭДЭЛ

Гүйцэтгэх эрх мэдэл, өөрөөр хэлбэл Засгийн газар болон түүний харьяаны байгууллагуудад та бүхний анхаарлыг хандуулъя.

Засгийн газар нь хэрэгжүүлэхээр баталсан мөрийн хөтөлбөртэй. Бүрэн эрхийнхээ хугацааг дуусах мөчид гаргасан амжилттай байж сонгогчдын саналыг дахин авах нь түүний ашиг сонирхол байдаг. Эрх зүйт төр төлөвшсөн орнуудад ч Засгийн газар нь мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлж байхдаа эрх зүйн хүрээ хязгаарыг хараанаасаа алдах тохиолдол гардаг. Энэ нь үргэлж зориуд санаатай үйлдэл байдаггүй. Аль ч тохиолдолд хуульч хүн сонор соргог байх ёстой. Засгийн газарт ажилладаг хуульч, сайдын хуулийн зөвлөх гэх мэт аль ч шатанд ажилладаг бай хуульч хүн ямагт идэвх санаачилгатай байж үгээ хэлж байх ёстой. Хэдийгээр эрх зүйг төлөвшүүлж хөгжүүлэх, өөрчлөх нь улс төрлийнхний үүрэг мөн боловч энэ процесс нь эрх зүйн хүрээ хязгаараас гадна явагддаггүй. Хэмжээгүй эрхт хаант засаг болон дарангуйллын тогтолцооноос ялгаатай нь орчин үеийн үндсэн хуульт төртэй улсад улс төрийн хүчин нь эрх зүйн хүлээсэнд оршдог. Энэ нь эрх зүйн хөгжилд

Хүний эрхийн үндэсний комисс www.nhrc.gov.mn

гарсан томоохон дэвшил юм. Төрөөс тогтоосон хуульд захирагдах үүргийг гүйцэтгэх эрх мэдлийн тэргүүнээс эхлээд хамгийн доод шатны захиргааны байгууллага хүртэл хүлээдэг. Энэ бол онолын хувьд мэдээжийн зүйл. Гэвч практикт ямар бэрхшээл тулгардгийг бид бүгд мэднэ. Аль ч эрх зүйн тогтолцоонд нэгэн вирус байдаг нь хуулийн эмхэтгэлд нийтлэгдсэн хууль хэрэгжих шатандаа очоод замхардаг явдал юм. Эрх зүйт төр бүхий улсад ч бид доод албан тушаалтнаасаа хууль зөрчсөн үйлдэл хийхийг хүлээдэг, шаарддаг удирдлагатай. Мэдээж хэрэг дээд албан тушаалтан нь ажилтандаа заавар, чиглэл өгөх эрхтэй. Харин тэрхүү заавар, чиглэлийг доод шатны ажилтан хууль бус гэж үзвэл хэрхэх вэ? Энэ тохиолдлыг улсууд Төрийн албаны тухай хуульдаа янз бүрээр л зохицуулсан байдаг байх. Германы хуулиар төрийн албан хаагч нь удирдлагаас өгсөн заавар, чиглэлийг сохроор дагах үүрэг хүлээдэггүй. Тэрээр аливаа заавар, чиглэл хууль зөрчсөн гэж үзвэл энэ талаар дээд албан тушаалтандаа байр сууриа илэрхийлэх үүргийг хуулиар хүлээсэн байдаг. Энэ нь зөрчилдөөнд хүргэх байлаа ч төрийн албан хаагч түүнээс зайлсхийх эрхгүй. Хэрэв “тэмцэлгүйгээр” тулааны талбарыг орхивол, өөрөөр хэлбэл, хэлэлцүүлэг, харилцан яриа, хариу няцаалтгүйгээр ажлаа үргэлжлүүлбэл тэр нэг дор хоёр ялагдлын хариуцлага хүлээх юм. Нэгд, эрх зүйн ялагдал, хоёрт, хувь хүний ялагдал. Эхний ялагдлыг буцаан засч болох боловч хоёр дахь ялагдлыг залруулахад хэцүү, эсвэл огт боломжгүй юм. Төрийн албан хаагч нэгэнтээ буруу зүйлтэй эвлэрсэн бол цаашид ч эвлэрсээр байх болно. Удирдлага нь түүнтэй тоглоомын бөмбөг мэт харилцаж эрх зүйт төр зовлонд унана. Германы төрийн албан хаагч удирдлагатайгаа зөрчилдсөн тохиолдолд ажлаасаа халагдахаас эмээх шаардлагагүй. Учир нь түүнийг хугацаагүй томилдог. Төрийн албан хаагчийн эрхлэх албыг өөрчилж болно. Гэхдээ үүнд аль ч төрийн албан хаагч бэлтгэлтэй байж хүлээн зөвшөөрөх үүрэгтэй. Эс зөвшөөрвөл анхнаасаа төрийн албанд орох эрх үүсдэггүй. Төрийн албан хаагчийн байр суурь сул байж удирдлагатайгаа зөрчилдсөнөөс болж ажлаасаа халагдах айдас дунд ажлаа хийж буй тохиолдолд улс төр, хэвлэл мэдээлэл, шинжлэх ухааны салбарынхан ийм тогтолцоог өөрчлөхийн төлөө тэмцэх ёстой. Энэ нь төрийн албан хаагчийн төлөө биш, эрх зүйт төрийн байр суурийг бэхжүүлэхийн төлөө юм. Хэдий төрийн албан хаагчийн эрх зүйн байдал сул байлаа ч хүчтэй удирдагч доод албан тушаалын хүмүүстээ үзэл бодлоо зоригтой илэрхийлж “би үүн дээр өөр байр суурьтай байна” гэж өөдөөс нь зоригтой дуугарах боломжийг олгодог. Ажилдаа эрүүл саруул ухаанаар ханддаг дарга өөрийнх нь удирдлагад ажиллаж буй хүмүүсийн саналыг сонсож тэдний дэвшүүлсэн үндэслэлийг анхааралтай дүгнэж цэгнэж шийдвэрээ гаргадаг. Төрийн албанд ажиллаж буй хуульч ийнхүү үзэл бодлоо чөлөөтэй нээн ярилцдаг соёлыг дэлгэрүүлж чадна. Төрөл бүрийн сургалтаар ийм соёлыг дэмжих боломжтой.

III. ШҮҮХ ЭРХ МЭДЭЛ

Эрх зүйт төр бол тэнгэрийн хишиг биш, түүнийг хичээл зүтгэл гаргаж тэмцэж олдог, оршин тогтноход нь хүчин чармайлт шаардлагатай гэдгийг бид ямагт санаж ухамсарлаж байх нь зүйтэй. Монгол Улс Үндсэн хуулиараа (49 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг) ХБНГУ-ын Үндсэн хуулийн нэгэн адилаар (97 дугаар зүйлийн 1 дэх хэсэг) шүүгчийн хараат бус байдлыг баталгаажуулсан. Энэ нь эрх зүйт төрийн хөгжлийн тулгуур чулуу бөгөөд үндсэн хуулийн шүүх эрх мэдэл нь эрх зүйт төрийн титэм хэмээн ойлгож болно.

Шүүх эрх мэдэл гүйцэтгэх эрх мэдлээс юугаараа ялгардгийг эргэн санацгаая. Гүйцэтгэх эрх мэдэл өмнөө тодорхой зорилго тавьж түүнийгээ хэрэгжүүлдэг, жишээ нь: улсын хөгжлийг дэмжих, дэд бүтцийг сайжруулах, агаарыг цэвэр байлгах, ерөнхий боловсролыг сайжруулах, их сургуулийн сургалт, судалгааг эрчимжүүлэх г.м. Энэ бүхэн гагцхүү хуулийн хүрээнд хэрэгжиж байж л хууль ёсны болно. Гүйцэтгэх эрх мэдэл зорилгоо хэрэгжүүлэхдээ зарим тохиолдолд эрх зүйн хүрээ хязгаарыг хараанаасаа гээх үе байдаг нь нууц биш. Эрх зүйд харш аливаа үйлдлийг эрх зүйт төрийн шалгуураар залруулах нь зайлшгүй юм. Орчин үеийн үндсэн хуульт төрд ийнхүү залруулах үүргийг хараат бус шүүх эрх мэдэл хэрэгжүүлдэг. Гүйцэтгэх эрх мэдлээс ялгаатай нь шүүх тодорхой мөрийн хөтөлбөрийн хүрээнд ажилладаггүй. Шүүн таслах ажиллагаанаас ямар үр дүн гарах нь түүнд сонин биш. Нэхэмжлэгч, хариуцагч талын алиных нь талд хэрэг шийдвэрлэх вэ гэдэгт анхаарал хандуулах эрхгүй. Анхан шатны шүүхээс эхлээд Үндсэн хуулийн цэц хүртэлх бүхий л шүүх төвийг сахисан байгууллагын хувьд цорын ганц эрх ашигт үйлчилнэ. Энэ нь шүүн таслах ажиллагааг хуулийн дагуу, шударга явуулж хуульд нийцсэн шийдвэр гаргах явдал юм. Энэ чиг үүргээ шүүх гагцхүү хараат бус ажиллаж чадах нөхцөлд л биелүүлэх боломжтой юм.

Харамсалтай нь эрх зүйт төрийн үндсэн хуулийн байгууллагууд үндсэн хуулийн хэм хэмжээнээс давж гишгэх тохиолдол цөөн ч гэсэн гардаг. Ийм үед Үндсэн хуулийн шүүх нь тэдгээр байгууллагыг эргүүлэн Үндсэн хуульд заасан хэм хэмжээний хүрээнд авчрах үүрэгтэй. Германд ийм тохиолдол үе үе гардаг. Үндсэн хуулийн шүүхээс гаргасан ийм шийдвэрийг ялангуяа төрийн болон нийгмийн бүхий л хүчин хүлээн зөвшөөрөх ёстой. Үндсэн хуулийн шүүхгүй үндсэн хууль бол шүдгүй арслан лугаа адил хэмээх зүйрлэлийг эргэн сануулахыг хүсч байна. Ямар ч субъект, тэр дундаа ялангуяа төрийн байгууллага, мөн түүнчлэн нийгмийн хүчнүүд шүүгчийн хараат бус байдлыг хүндэтгэн үзэх ёстой. Энэхүү хараат бус байдалд халдах нь эрх зүйт төрд халдаж буй хэрэг юм. Европын нэгэн улсын ерөнхийлөгч эрүүгийн хэрэгт буруутгагдаж буй нэгэн шүүгдэгчийг хүнд ял авах ёстой хэмээн телевизээр мэдэгдэж байхыг бид 21 дүгээр зуунд харлаа. Түүнийг тухайн улсад хэн ч шүүмжлээгүйгээр барахгүй шүүгчид нь хүлээлтэд нь нийцсэн шийдвэр гаргасан. Энэ улсад эрх чөлөөний дутмагшил хэр түвшинд хүрснийг тодорхойлоход тийм ч хэцүү биш байна.

Одоогоос 2000 гаруй жилийн өмнө буюу эртний Грекийн иргэд шүүгчийн хараат бус байдлыг өөрсдийнхөө эрх, эрх чөлөөний чухал баталгаа хэмээн үздэг байжээ. Өнөөдөр ч гэсэн ялгаагүй.

Шүүгчийн хараат бус байдал нь шүүгчид өөрт нь зориулагдаагүй. Шүүгчийн хувь хүнд нь олгож буй давуу эрх биш. Тэрээр шүүхийн хэвийн ажиллагааг хангах зориулалттай. Шүүгчийг сүрдүүлэх, хүсэлтийг нь үл харгалзан өөр шүүхэд шилжүүлэх зэрэг хараат бус байдалд нь халдсан аливаа үйлдэл нь германы нийгэмд томоохон эсэргүүцэлтэй тулгарах болно. Ийм тохиолдлыг олж мэдсэн иргэн бүр, тэр дундаа хуульчид дуугүй өнгөрч болохгүй. Түүнийг дөнгөж эхлэх үе дээр нь таслан зогсоовол зохистой юм.

Захиргааны хэргийн шүүх нь онцгой чухал үүрэгтэй. Тэрээр захиргааны актаар иргэний эрх зөрчигдөхөөс хамгаалдаг. Захиргааны хэргийн шүүх гүйцэтгэх эрх мэдлийн шийдвэрийг засч залруулдаг нь ардчилсан эрх зүйт төрд байдаг ердийн л зүйл. Мэдээжээр эрх зүйн маргаантай асуудлыг тодруулах шаардлага үе үе тулгарна. Гэвч зарим тохиолдолд

захиргааны хэргийн шүүх гүйцэтгэх эрх мэдлийн хууль зөрчсөн үйлдлийг илрүүлж, арилгах шаардлагатай болно. Хэрэв гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага сонсох ажиллагаа явуулах үүргээ хэрэгжүүлээгүй, гаргасан шийдвэрийнхээ үндэслэлийг тайлбарлах үүргээ биелүүлээгүй байвал захиргааны хэргийн шүүх тэдэнд өршөөнгүй хандах эрхгүй. Учир нь үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд явуулахаас өөр сонголт захиргаанд байх ёсгүй. Германд захиргааны хэргийн шүүхийг мөн сурган хүмүүжүүлэх үүрэгтэй гэж ярьдаг. Хэрэв захиргааны албан тушаалтан сөрөг үйлчлэл бүхий захиргааны акт гаргахаасаа халширч, түүнийг гаргах урьдач нөхцөл хангагдсан эсэхийг дахин дахин шалгаж байвал үүнийг эрх зүйт төрийн хөгжилд гарсан томоохон дэвшил гэж үзэж болно.

Шүүх эрх мэдэл нь мэдээж хэрэг төрийн нэгэн чухал бүтэц бүрэлдэхүүн юм. Хүчтэй шүүх эрх мэдэл, хүчтэй Үндсэн хуулийн шүүх ямар ч улсад хор хохирол учруулж байсан удаагүй. Харин ч эсрэгээр, хяналтгүй эрх мэдэл улс оронд гай тарих нь хамгийн элбэг байдаг.

Германы шүүгчид төр болон нийгмийн өмнө ихээхэн нэр хүндтэй байдаг. Үүнд олон шалтгаан байгаа байх. Тухайлбал дундад зууны үеэс шүүгчийг “Бурхны эрх мэдлийг газар дэлхий дээр хэрэгжүүлэгч” хэмээн дээдэлж ирсэн уламжлалт сэтгэхүйн нөлөө өнөөг хүртэл хадгалагдсаар ирсэнтэй ч холбоотой (Fritjof Haft, Aus der Waagschale der Justiz, 3. Auflage, 2001, S. 6). Германы төрийн болон нийгмийн хүчнүүд Холбооны Үндсэн хуулийн шүүхийг бүх талаар хүлээн зөвшөөрөгдсөн Үндсэн хуулийн манаач хэмээн тооцдог.

Европын Холбооны тохиолдсон саяхны нэг жишээ дурдъя: Испанийн хууль сахиулах байгууллагаас улсынхаа нэгэн улс төрчийг ХБНГУ-ын нутаг дэвсгэр дээр баривчлах тогтоол гаргасан байна. Тус улсын шүүх тэрхүү улс төрчийг салан тусгаарлах хөдөлгөөн өрнүүлсний төлөө бослого гаргасан хэрэгт буруутгасан байна. Испанийн хуулиар ийм хэрэгт 30 жил хорих ял оноох боломжтой юм. Уг асуудлыг харьяалах Германы шүүхээс (Шлесвиг мужийн дээд шүүх) тухайн улс төрчийг Испани улсад шилжүүлэхээс татгалзсан шийдвэр гаргажээ. Учир нь ХБНГУ-ын хуулиар салан тусгаарлагчийг гагцхүү хүч хэрэглэсэн тохиолдолд бослого гаргасан (буюу эх орноосоо урвасан) гэмт хэрэг үйлдсэнд тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг. Дээрх хэргийн хувьд ийм байдал тогтоогдоогүй байв. Испанийн Ерөнхий сайд зөөлнөөр илэрхийлбэл ХБНГУ-ын шүүхийн шийдвэрт урам хугарч байгаагаа илэрхийлсэн. Харин Испанийн Хууль зүйн сайд Рафаел Катала: “Испанийн Засгийн газар өөрт нь таалагдсан эсэхээс үл хамаарч шүүхийн шийдвэрт ямагт хүндэтгэлтэй хандаж ирсэн” хэмээн мэдэгдсэн. Энэ мэдэгдэл бол ардчилсан эрх зүйт төрийн үлгэр жишээ болохуйц улс төрч хүний үг юм. Ардчилсан эрх зүйт төрд улс төрч хүн ийм л өнцгөөс асуудалд хандах ёстой юм.

IV. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ӨМГӨӨЛӨГЧ, ХУУЛЬЧДЫН ХОЛБОО, ШИНЖЛЭХ УХААН

Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, өмгөөлөгчид, хуульчдын холбоод болон шинжлэх ухааны салбарынхан ч эрх зүйт төрийн манаач юм.

1) Хэвлэл мэдээллийн хэрэгсэл

Хэвлэл, радио, телевиз нь ардчилсан эрх зүйт төрд төрийн удирдлагад ажиллагчдыг ажиглах, хууль бус үйлдлийг ил болгох үүрэг хүлээдэг. Германы туршлагаас харахад дөрөв дэх хүчин хэмээн нэрлэгддэг хэвлэл, мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаа ямагт нөлөөтэй байсаар ирсэн.

2) Өмгөөлөгч

Өмгөөлөгчболөөрөөрилэрхийлбэл хуулийг өмгөөлөгч юм. Германы нэгэн хуульд түүнийг хууль хэрэглээний байгууллага хэмээн тодорхойлсон байдаг. Өмгөөлөгч иргэний эрх зүйн маргаанд үйлчлүүлэгчийнхээ ашиг сонирхлыг төлөөлдөг, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд яллагдагчийг өмгөөлдөг, захиргааны үйл ажиллагаанд болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд захиргааны хэргийн шүүхийн өмнө үйлчлүүлэгчээ төлөөлдөг. Өмгөөлөгчийн ажил заримдаа хүнд бэрх байж болох ч иргэдийн эрхийн төлөөх тэмцэл нь нөлөөллийн хүрээ өргөнтэй. Өмгөөлөгч нь төрийн эрх мэдлийг зохих хэмжээнд нь барихаас гадна шүүх тухайн тодорхой тохиолдол дээр хуулийг тайлбарлаж, хэрэглэн шийдвэр гаргах үед эргэлзээ бий болгох, ингэснээр эрх зүйн баталгаат байдлыг дэмжих, эрх зүйт төрийн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулж байдаг.

3) Хуульчдын холбоо

Хуульчдын холбоо ч ардчилсан эрх зүйт төрийн манаачийн үүргийг гүйцэтгэж болно. Хэрэв тэрээр бие даасан хараат бус байгууллага байж өөрийн бус, нийтийн эрх ашгийн төлөө ажиллаж чадвал төрийн хууль бус үйл ажиллагааг илчилж ул суурьтай тэмцэж таслан зогсоох боломжтой

4) Шинжлэх ухаан

Шинжлэх ухааны салбар нь хуульчдын залгамж халааг эрх зүйн салбарт хөтлөн оруулж ардчилсан эрх зүйт төрийн зарчим танилцуулж өгдөг. Шинжлэх ухаан нь оюутан суралцагчдад залуу хуульч хүний мэргэжлийн талбарт авч орвол зохих эрх зүйт төрийн ухамсрыг зааж сургадаг. Түүнээс гадна хууль зүйн шинжлэх ухааны эрдэмтэн, багш нар төрийн удирдах эрх мэдлийн хүрээний үйл ажиллагааг амаар болон бичгээр дүгнэх, шүүмжлэх, сайшаах зэргээр дүгнэж байдаг. Чингэхдээ асуудалд улс төрийн бус эрх зүйт төрийн зарчмын өнцгөөс хандаж түүнийг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулж байдаг.

V. ТӨГСГӨЛ

Ардчилсан эрх зүйт төрийг хамгаалах, бэхжүүлэх нь төрийн болон нийгмийн хүчнүүдийн, нэн ялангуяа тухайн улсын хуульчдын мөнхийн үүрэг юм. Ардчилсан эрх зүйт төрд хууль, эрх зүй нь эрх чөлөө, шударга ёсны төлөө үйлчилдэг бөгөөд энэ бол маш том үнэт зүйл юм. Энэ үнэт зүйлийн төлөөх зүтгэл, тэмцэл нь хэзээд үр өгөөжөө өгдөг. Хуульч бүрийн зүрх сэтгэлд эрх чөлөө, шударга ёсны төлөө тэмцэх хүсэл эрмэлзэл улам бүр хүчээ авах болтугай.

13 дугаар зууны үеийн Европын гүн ухаантан Тома Аквиний (1225 – 1274) үгээр энэхүү илтгэлээ өндөрлөе. Тэрээр: “Үнэнийг өгүүлэгч нь хэнтэй ч маргалдсан үл ялагдана” хэмээжээ.

---o0o---

www.hligov.mn

DIE ROLLE DES JURISTEN IM DEMOKRATISCHEN RECHTSSTAAT

Vortrag von Dr. Jürgen Harbich, Ehrendoktor der Mongolischen Staatsuniversität, Träger der Freundschaftsmedaille der Mongolei, Vorstand der Bayerischen Verwaltungsschule a. D.

Die Menschen in der Mongolei leben - ebenso wie wir in Deutschland - in einem Staat, der sich zu Demokratie, Gewaltenteilung und Grundrechten bekennt. Wir leben in einem demokratischen Rechtsstaat, wir leben im modernen Verfassungsstaat. Das war in der Mongolei und in meinem Land nicht immer so. Im vergangenen Jahrhundert machten wir in Deutschland und große Teile der Welt bitterste Erfahrungen, als - ausgehend vom deutschen Boden - die Werte des demokratischen Rechtsstaates mit Füßen getreten wurden. Wir wissen, dass der demokratische Rechtsstaat nicht vom Himmel fällt, sondern ein hohes Gut ist, das zu erringen Kraft kostet; und wir haben keine Garantie, dass uns dieses Gut auf immer und ewig erhalten bleibt.

Der Früchte des demokratischen Rechtsstaates können wir uns nur dann erfreuen, wenn wir uns für diesen Staat einsetzen mit allen Kräften, die wir haben. Rufen wir uns in Erinnerung, was zu diesen Früchten gehört:

Es sind die Menschenrechte, die in unseren Verfassungen verankert sind, die Gleichheit der Menschen vor dem Gesetz, insbesondere die Gleichberechtigung von Mann und Frau, die Religionsfreiheit, die Meinungsäußerungsfreiheit, die Freiheit der Wissenschaft, das demokratische Wahlrecht, die Gewaltenteilung, die Gesetzmäßigkeit der Verwaltung, das Willkürverbot, das Recht auf gerichtlichen Rechtsschutz und die Unabhängigkeit der Richter; und nicht zu vergessen: die Verfassungsgerichtsbarkeit als Krone des Rechtsstaates. Das sind ohne Zweifel hohe Werte!

Jeder Mann, jede Frau ist aufgerufen, sich für den Erhalt dieser Werte einzusetzen. Vor allem werfen wir einen Blick auf die drei Staatsgewalten:

I. Das Parlament

Das vom Volk gewählte Parlament erlässt Gesetze, die das Land rechtspolitisch, wirtschaftlich, sozial gestalten, modernisieren, stabilisieren. Die Gesetze setzen einen Rahmen für das Handeln des Individuums, der privatrechtlichen Organisationen, der Nichtregierungsorganisationen (NGO), der Wirtschaftsbetriebe ebenso wie für das Handeln der Exekutive; und auch die Normen für die gerichtlichen Verfahren finden wir in den Gesetzen.

Das Parlament hat beim Erlass der Gesetze einen Spielraum, in dessen Rahmen die politischen Kräfte Akzente setzen. Das ist legitim, solange es legal ist. Das heißt: Auch das Parlament muss seine Kompetenzen im Rahmen des Rechts, d. h. im Rahmen der Verfassung, ausüben. Für Verfahren und Inhalt seiner Entscheidungen gibt es verfassungsmäßige Schranken. Rechte der Parlamentsminderheit sind zu respektieren, Grundrechte sind zu achten,

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХЭЛТЭС www.nlicd.mn

Willkür ist auszuschließen. Wir wissen, dass Entscheidungsträger - in allen Ländern - diese Prinzipien hin und wieder aus den Augen verlieren. Dann heißt es: wachsam zu sein. Häufig werden sich Konflikte nicht vermeiden lassen. Zwar haben sich Mitglieder einer Organisation nach innen und außen loyal zu verhalten. Doch wenn sich eine Organisation auf rechtswidriges Gefilde begibt, verliert sie bei ihren Mitgliedern den Anspruch auf Loyalität. Man muss es als selbstverständlich ansehen, dass jedes Mitglied des Parlaments verpflichtet ist, darauf hinzuwirken, dass die Normen der Verfassung eingehalten und mit Leben erfüllt werden, dass Demokratie, Freiheit und Gerechtigkeit das Leben der Menschen spürbar prägen. Für einen Juristen im Parlament gilt diese Pflicht im besonderen Maße, unabhängig davon, ob er der Regierungspartei oder einer Oppositionspartei angehört. Das Ethos des Juristen verlangt Widerstand auch gegenüber höheren Autoritäten.

In der Europäischen Union haben wir heute eine lebhafte Rechtsstaatsdiskussion. In nicht nur einem Mitgliedstaat erleben wir seit einigen Jahren, dass sich Parlamentsmehrheiten über Barrieren der Verfassung hinwegsetzen, über Barrieren des Rechtsstaatsprinzips, die bisher als stabile Bollwerke allseits anerkannt waren. Werden die für den Rechtsbruch Verantwortlichen zur Rede gestellt, versuchen sie, sich mit dem Hinweis auf die ihnen vom Volk gewährte parlamentarische Mehrheit zu rechtfertigen. Diesem Argument ist mit Nachdruck entgegenzutreten. Der moderne Verfassungsstaat ist nicht nur durch demokratische Prinzipien charakterisiert. Ebenso prägen ihn ganz wesentlich rechtsstaatliche Elemente, zu denen Gerichte und die Respektierung der Menschenrechte gehören; und der Rechtsstaat verlangt ohne jede Ausnahme, dass die Hoheitsträger auf allen Ebenen - und das Parlament an erster Stelle - Recht und Gesetz achten.

II. Die Exekutive

Wenden wir uns der Exekutive zu, d. h. der Regierung mit allen nachgeordneten Behörden.

Regierungen haben ein Programm, das sie zu realisieren beabsichtigen. Sie wollen am Ende ihrer Amtsperiode Erfolge präsentieren, damit sie von den Wählern erneut einen Regierungsauftrag erhalten. Bei der Verfolgung ihrer Ziele kommt es auch in stabilen demokratischen Rechtsstaaten vor, dass Regierungen rechtliche Schranken aus den Augen verlieren. Das geschieht nicht immer böswillig. Wie auch immer: Der Jurist hat wachsam zu sein. Das mag der Jurist in der Regierung sein, das mag der juristische Berater eines Ministers sein. Er muss aktiv werden und sich zu Wort melden. Zwar ist es auch Aufgabe der Politik, das Recht zu gestalten und das Recht zu ändern. Doch diese Prozesse finden nicht im rechtsleeren Raum statt. Im modernen Verfassungsstaat sind - im Gegensatz zu absoluten Monarchien und diktatorischen Systemen - auch die politischen Kräfte durch das Recht gebändigt. Wir sehen darin einen großen Fortschritt in der Rechtsentwicklung. Die Bindung an das vom Staat gesetzte Recht gilt für die Spitze der Exekutive bis zur untersten Verwaltungsbehörde. Das ist eine Selbstverständlichkeit; so lehrt es uns die Theorie. Doch wir kennen das Problem der Praxis: Alle Rechtsordnungen tragen den Virus in sich, dass Gesetze im Gesetzblatt und im Vollzug auseinander fallen können. Auch in Rechtsstaaten treffen wir auf Vorgesetzte, die vom Mitarbeiter erwarten und verlangen, dem Recht zuwider zu agieren. Ohne Frage hat der Vorgesetzte das Weisungsrecht. Wie aber hat sich der Mitarbeiter zu verhalten, wenn er eine Weisung für rechtswidrig hält? Für diesen Fall mag das Beamtenrecht von Land zu Land unterschiedlich sein. Nach deutschem Recht darf der Beamte den Weisungen der Vorgesetzten nicht blindlinks folgen: Der Beamte ist gesetzlich verpflichtet, dem Vorgesetzten seine rechtlichen Bedenken vorzutragen. Da mag es zum Konflikt kommen. Doch diesem Konflikt

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

darf der Beamte nicht ausweichen. Räumt der Beamte das Feld „kampflos“, d. h. ohne Diskussion mit Rede und Gegenrede, dann darf er bei sich die Verantwortung für zwei Niederlagen feststellen: eine Niederlage des Rechts und eine Niederlage seiner Person. Die erste ist vielleicht reparabel, die zweite nur schwer oder gar nicht. Wer als Beamter hier kein Rückgrat zeigt, wird es wohl auch künftig nicht tun. Der Vorgesetzte wird den Beamten als Spielball betrachten, und der Rechtsstaat leidet. Der deutsche Beamte hat im Konfliktfall keine Entlassung zu befürchten; denn er ist Beamter auf Lebenszeit. Eine Versetzung des Beamten ist möglich; diese ist aber immer möglich. Das hat der Beamte zu akzeptieren; anderenfalls darf er nicht in den öffentlichen Dienst eintreten. Wenn in einem Land die Rechtsstellung der Beamten schwächer ist, so dass sie im Konfliktfall ihren Arbeitsplatz verlieren können, sollten sich juristische Kräfte der Politik, der Medien und der Wissenschaft für Rechtsänderungen einsetzen, dies nicht um der Beamten willen, sondern um den Rechtsstaat zu stärken. Doch unabhängig von der Rechtslage sollte ein starker Vorgesetzter seinen Mitarbeiter ermutigen, die Meinung frei zu äußern und dem Vorgesetzten unmissverständlich zu sagen: „Ich bin anderer Meinung.“ Der vernünftige Vorgesetzte wird sich die Meinung seines Mitarbeiters anhören und nach sorgfältigem Abwägen der Argumente entscheiden. Juristen in der Behörde können diese Gesprächskultur fördern; Bildungsveranstaltungen könnten unterstützend wirken.

III. Die Judikative

Wir müssen uns immer wieder bewusst machen: Der Rechtsstaat ist kein Geschenk des Himmels, er wurde mühsam erkämpft, sein Bestand erfordert Kraft. Die Unabhängigkeit der Richter, die die mongolische Verfassung (Art. 49 Abs. 1) ebenso garantiert wie das deutsche Grundgesetz (Art. 97 Abs. 1), betrachten wir als den Schlussstein der rechtsstaatlichen Entwicklung und die von beiden Verfassungen eingesetzte Verfassungsgerichtsbarkeit als Krönung des Rechtsstaates.

Lassen Sie mich in Erinnerung rufen, was die Judikative von der Exekutive unterscheidet. Die Exekutive verfolgt bestimmte Ziele: Sie fördert die Entwicklung des Landes, sie setzt Akzente für eine bessere Infrastruktur, sie sorgt für die Reinhaltung der Luft, sie setzt sich für eine bessere Schulbildung ein, sie stärkt Forschung und Lehre an den Universitäten. Das alles ist legitim, solange die Mittel legal sind. Es ist eine allgemeine Erfahrung, dass die Exekutive bei der Verfolgung ihrer Ziele das Recht hin und wieder aus den Augen verliert. Dieser Konflikt mit dem Recht macht eine rechtsstaatliche Korrektur notwendig. Im modernen Verfassungsstaat obliegt diese Korrektur der unabhängigen Justiz. Im Gegensatz zur Exekutive verfolgen die Gerichte keine besonderen Ziele; sie haben kein bestimmtes Interesse am Ausgang des Prozesses. Sie dürfen keine Rücksicht darauf nehmen, ob der Kläger oder der Beklagte einen Prozess gewinnt. Alle Gerichte, von der untersten Instanz bis zum Verfassungsgericht, haben als neutrale Instanz nur ein Interesse: das Verfahren gesetzmäßig und fair durchzuführen und ein Urteil zu fällen, das dem Gesetz entspricht. Diese Aufgabe können Gerichte nur erfüllen, wenn sie unabhängig agieren können.

Die Erfahrung lehrt, dass sich Verfassungsorgane auch im demokratischen Rechtsstaat hin und wieder auf Wege außerhalb der verfassungsrechtlichen Normen begeben. Aufgabe des Verfassungsgerichts ist es dann, die Verfassungsorgane wieder in die verfassungsrechtliche Spur zu bewegen. In Deutschland erleben wir das immer wieder. Verfassungsgerichtliche Entscheidungen dieser Art müssen in jedem Fall von allen staatlichen und gesellschaftlichen Kräften akzeptiert werden. Ich erinnere daran, dass eine Verfassung ohne Verfassungsgerichtsbarkeit einem Löwen ohne Zähne ähnlich ist.

Jedermann, staatliche Instanzen im besonderen, aber auch gesellschaftliche Kräfte haben die Unabhängigkeit der Richter zu respektieren. Ein Eingriff in diese Unabhängigkeit ist ein Angriff

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

auf den Rechtsstaat. Doch auch im 21. Jahrhundert erleben wir, dass der Präsident eines europäischen Landes im Fernsehen ankündigt, dass ein laufender Strafprozess mit einer hohen Strafe für die Angeklagten zu enden hat. Dieser Präsident erfährt keine Kritik im eigenen Land, und die Richter folgen seiner Erwartung. Da fällt es nicht schwer, sich ein Bild über die freiheitlichen Defizite dieses Landes zu machen.

Schon im antiken Griechenland, also vor mehr als 2000 Jahren, sahen die Bürger in der Unabhängigkeit der Richter einen wichtigen Garanten für ihre Freiheit. Auch heute gilt:

Die richterliche Unabhängigkeit ist kein Selbstzweck; sie ist kein persönliches Vorrecht des Richters; sie dient der Funktionsfähigkeit der Rechtspflege. Jeder Eingriff in die Unabhängigkeit der Richter, wie z. B. die Androhung oder gar Versetzung eines unliebsamen Richters gegen dessen Willen, ist anzuprangern und zu verurteilen. Auf diesem Feld ist die Wachsamkeit jedes Bürgers gefordert, die des Juristen in besonderem Maße. In solchen Fällen dürfen Wissende nicht schweigen; denn es gilt, den Anfängen zu wehren.

Eine besondere Aufgabe obliegt den Verwaltungsgerichten. Sie gewähren den Bürgern Rechtsschutz gegen Akte der Verwaltung. Es gehört zur Normalität des demokratischen Rechtsstaates, dass Verwaltungsgerichte die Exekutive korrigieren: Da mag es hin und wieder um die Klärung rechtlicher Zweifelsfragen gehen; doch manches Mal werden Verwaltungsgerichte rechtswidrige Praktiken der Exekutive offenlegen und abstellen müssen. Wenn die Exekutive die Anhörungspflicht verletzt, wenn die Exekutive der Pflicht, ihre Entscheidung ordentlich zu begründen, nicht nachkommt, dürfen die Verwaltungsgerichte keine Nachsicht üben; denn zum rechtmäßigen Verwaltungshandeln gibt es für die Exekutive keine Alternative. Wir sprechen in Deutschland davon, dass die Verwaltungsgerichte insofern auch eine erzieherische Aufgabe zu erfüllen haben. Wenn der Verwaltungsbeamte zögert und nochmals prüft, ob die Voraussetzungen für den Erlass eines belastenden Verwaltungsakts vorliegen, ist rechtsstaatlich viel gewonnen.

Ohne Frage ist die rechtsprechende Gewalt ein gewichtiger Faktor im Staatsgefüge. Doch eine starke Gerichtsbarkeit, auch eine starke Verfassungsgerichtsbarkeit hat noch keinem Land geschadet, unkontrollierte Macht dagegen sehr wohl.

In Deutschland genießen die Richter in Staat und Gesellschaft hohes Ansehen. Das mag viele Gründe haben: Vielleicht ist noch ein Abglanz der mittelalterlichen Auffassung zu erkennen, „die den Richter als Statthalter Gottes auf Erden ansah“ (Fritjof Haft, Aus der Waagschale der Justiz, 3. Auflage, 2001, S. 6). Die staatlichen und gesellschaftlichen Kräfte in Deutschland sehen im Bundesverfassungsgericht einen allseits anerkannten Hüter der Verfassung.

Lassen Sie mich noch ein aktuelles Beispiel aus der Europäischen Union erwähnen: Es geht um einen spanischen Politiker, der in Deutschland auf Grund eines von der spanischen Justiz ausgestellten Europäischen Haftbefehls verhaftet wurde. Die spanische Justiz wirft dem Politiker wegen separatistischer Aktionen Rebellion vor, die nach spanischem Recht mit 30 Jahren Freiheitsentzug bestraft werden kann. Das zuständige deutsche Gericht (Oberlandesgericht Schleswig) hat die Auslieferung abgelehnt, weil Rebellion (= Hochverrat) nach deutschem Recht nur bestraft werden kann, wenn der Separatist zur Gewalt greift; das treffe aber im konkreten Fall nicht zu. Der spanische Ministerpräsident zeigte sich - vorsichtig ausgedrückt - enttäuscht von der Entscheidung des deutschen Gerichts. Doch der Justizminister Spaniens Rafael Catalá erklärte: „Die Regierung hat immer Gerichtsentscheidungen respektiert, ob sie ihr gefallen oder nicht.“ Diese Erklärung halte ich für vorbildlich für einen Politiker in einem demokratischen Rechtsstaat. So hat sich jeder Politiker in einem demokratischen Rechtsstaat zu verhalten

www.nli.gov.mn

IV. Medien, Rechtsanwälte, Juristenverbände, Wissenschaft

Wächter für den Bestand des Rechtsstaates sehen wir auch in den Medien, in den Reihen der Anwaltschaft, in Juristenverbänden und in der Wissenschaft.

1) Medien

Presse, Rundfunk und Fernsehen haben im demokratischen Rechtsstaat auch die Aufgabe, die Akteure der staatlichen Autoritäten zu beobachten und rechtswidriges Handeln offenzulegen. Erfahrungen in Deutschland lehren, dass diese Arbeit der vierten Gewalt, wie die Medien oft genannt werden, nicht ohne Wirkung bleibt.

2) Rechtsanwälte

Der Rechtsanwalt ist, anders ausgedrückt, ein Anwalt des Rechts. Ein deutsches Gesetz nennt ihn ein Organ der Rechtspflege. Der Rechtsanwalt nimmt die Interessen seines Mandanten wahr in zivilrechtlichen Angelegenheiten, er verteidigt Angeklagte im Strafprozess und vertritt seinen Mandanten im Verwaltungsverfahren und vor dem Verwaltungsgericht. Die Arbeit des Rechtsanwalts mag manches Mal mühsam sein. Doch sein Kampf um das Recht des Einzelnen wirkt weit darüber hinaus: Der Rechtsanwalt trägt bei zur Mäßigung der staatlichen Gewalt und bewirkt darüber hinaus, dass die Gerichte mit ihren Urteilen rechtliche Zweifel bei der Auslegung und Anwendung der Gesetze über den Einzelfall hinaus klären, dadurch die Rechtssicherheit fördern und die Stabilität des Rechtsstaates festigen.

3) Juristenverbände

Auch ein Juristenverband kann im demokratischen Rechtsstaat die Funktion eines Wächters übernehmen. Wenn er als unabhängige Organisation nicht eigene Interessen wahrnimmt, kann er staatliches Unrecht ansprechen und wird Gehör finden, wenn er seriös agiert.

4) Die Wissenschaft

Die Wissenschaft führt den juristischen Nachwuchs in die Rechtsordnung ein und macht ihn vertraut mit den Prinzipien des demokratischen Rechtsstaates. Sie vermittelt den Studenten rechtstaatliches Bewusstsein, das die jungen Juristen in ihre Berufswelt mitnehmen. Darüber hinaus können die Professoren des Rechts das Agieren von staatlichen Autoritäten durch Wort und Schrift begleiten, kritisieren und gutheißen - das jedoch nicht im parteipolitischen Sinn, sondern unter rechtsstaatlichen Aspekten und dadurch den Rechtsstaat stärken.

V. Schlussbemerkung

Den demokratischen Rechtsstaat zu bewahren und zu festigen, ist eine permanente Aufgabe staatlicher und gesellschaftlicher Kräfte, im besonderen Maße der Juristen des Landes. Das Recht im demokratischen Rechtsstaat dient der Freiheit und der Gerechtigkeit; es ist ein hoher Wert. Einsatz und Kampf für diesen Wert werden sich immer lohnen. Jeder Jurist möge sich zu diesem Einsatz und Kampf aufgerufen fühlen!

Lassen Sie mich schließen mit einem Wort von Thomas von Aquin, einem europäischen Philosophen aus dem 13. Jahrhundert (1225 – 1274): Wer die Wahrheit sagt, kann nicht besiegt werden, mit wem er auch streitet.

---o0o---

www.nlaw.mn

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ПРОЦЕССЫГ МАРГААНЫ ТӨРЛӨӨС ХАМААРАН ЯЛГАМЖТАЙ ЗОХИЦУУЛАХ НЬ:

/Цэцийн шийдвэрийн хууль зүйн үр нөлөөг дээшлүүлэх боломж/

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын референт Д.Амарбаясгалан

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа билээ. Үндсэн хуулийн цэцийн хяналтыг дээд хяналт гэдгийн учир нь Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг давж заалдах, хяналтын журмаар дахин хянах, өөрчлөх, хүчингүй болгох эрх бүхий байгууллага, албан тушаалтан байдаггүйд оршино[1]. Өөрөөр хэлбэл, Цэцийн шийдвэр гармагцаа хуулийн хүчин төгөлдөр болж биелэгдэх хүчин чадалтай, тухайн асуудлаар цаашид нийтээр дагаж мөрдөх, удаан хугацаанд үйлчлэх, жишиг тогтоох хандлагатай байдгаараа бусад байгууллагын шийдвэрээс ялгаатай, мөн тэр хэрээр иргэд болон албан тушаалтан, нийт нийгэмд нөлөөлөл ихтэй байдаг билээ[2].

Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн биелэлт, хууль зүйн үр нөлөөг хэрхэн дээшлүүлэх талаар манай улсын хууль зүйн шинжлэх ухааны тэргүүлэх эрдэмтэд анхаарлаа хандуулж өөрсдийн судалгаа, эрдэм шинжилгээний бүтээлдээ бичсэн байдаг. Тухайлбал:

- Академич Ж.Амарсанаа “Үндсэн хуулийн шүүх өөрийн тогтоолдоо актыг хүчин төгөлдөр бус гэж тооцсоны улмаас зохицуулалтгүй үлдсэн харилцааг зохицуулахаар шинээр хууль гаргах, эсхүл үйлчилж байгаа хууль тогтоомжид шаардлагатай өөрчлөлт оруулахыг өөрийн тогтоолдоо хууль тогтоогчид зөвлөмж болгодог явдлаараа Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр чухал үүрэг гүйцэтгэдэг. Үүнийг манай Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагаанд дорвитой нэвтрүүлэх шаардлагатай.”;

- Доктор, профессор Н.Жанцан “Эдүгээ бидний хэрэглэж байгаа Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх, хангах талаарх зохицуулалтыг нарийвчлан тогтоогоогүй байдаг. Энэ нь зарим талаар бусад улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулахад манай улсад хоцрогдол байгааг нэг талаас харуулж байгаа юм. Энэ мэтчилэн цаашдын хандлага, хөгжлийн чиг баримжаагаа тогтоох, шийдвэрийн

[1] Г.Совд, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиудын тайлбар, Уб., 1999 он, 19 дэх тал.

[2] П.Очирбат, Монгол Улсын Үндсэн хууль /хэрэгжилт, хяналт, судалгаа/, Уб., 2017 он, 361-362 дахь тал.

чанар, үр нөлөөг дээшлүүлэх зэрэг асуудлыг ... онцлон үзэж байна[3].";

- Доктор, профессор Ц.Сарантуяа "Үндсэн хуулийн цэц дунд суудлын хуралдаанаараа Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар дүгнэлт гаргаж их суудлын хуралдаанаараа тухайн хуулийг хүчингүй болгох эсэх тухай тогтоол гаргадаг. Үндсэн хуулийн цэцийн шийдвэр нь аль нэг тохиолдолд буцаж үйлчлэх талаар зохицуулалт манай хуульд тусгаагүй тул энэ талаар цаашид судалгаа хийж, ирээдүйд гарах шийдвэрийнхээ хүчин чадал, үр нөлөөг дээшлүүлэх боломжтой юм." хэмээн бичсэн байдаг[4].

Харин миний бие энэхүү сэдэмж бичигтээ Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэдэг маргааны төрөл, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэн явуулах үндэслэл *(*өргөдөл, мэдээлэл, хүсэлт*)*, Цэцийн шийдвэрээр хүчингүй болсон хууль бусад шийдвэрийн заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн тухай асуудлыг хянан шийдвэрлэх ажиллагаа зэрэгт нарийн тохирсон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тусгай зохицуулалттай болсноор Цэцээс гарах шийдвэрийн чанар, түүний биелэлт, хууль зүйн үр нөлөө дээшлэх боломж байгаа эсэх асуудлыг хөндөхийг зорилоо.

1. Иргэний өргөдлийн дагуу үүссэн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд тусгай журам тогтоох асуудлыг хөндөх нь:

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг:

1/ иргэдийн өргөдөл[5];

2/ иргэдийн мэдээлэл[6];

3/ холбогдох байгууллага, албан тушаалтны хүсэлт[7];

4/ Цэцийн гишүүний тогтоолыг эс зөвшөөрсөн тухай болон хэргийн харьяалал тогтоолгох тухай иргэдийн гомдол[8];

5/ Цэцийн аль нэг гишүүний санаачилгаар[9] үүсгэж шийдвэрлэх зохицуулалттай.

Эдүгээ мөрдөгдөж байгаа Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиар өөрийнхөө эрх, хууль ёсны ашиг сонирхол, эрх чөлөө хөндөгдөж байна гэж үзээд Үндсэн хуулийн цэцэд хандсан иргэний өргөдлөөр үүсгэн шалгаж буй маргааныг өөрийнх нь эрх, хууль ёсны ашиг сонирхол, эрх чөлөө хөндөгдөөгүй боловч нийт иргэн болон улсын ашиг сонирхлын үүднээс, эсхүл төрийн байгууллага, эрх бүхий албан тушаалтантай холбоотой асуудлаар хандсан иргэний мэдээлэлтэй адилхан журмаар хянан шийдвэрлэж дүгнэлт, тогтоол гаргадаг учир бодит байдал дээр өргөдөл гаргасан иргэний зөрчигдсөн байж болох эрх, хууль ёсны ашиг сонирхол сэргээгдэхгүй, хамгаалагдахгүй үлдсэн хэвээр байгаа юм. Уг асуудлыг тодорхой тохиолдолд тулгуурлан тайлбарлахыг хичээе:

Тохиолдол**:** Иргэн "Л" Үндсэн хуулийн цэцэд хандаж "миний бие 2010 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр эрүүгийн онц хүнд гэмт хэрэгт холбогдож Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч "Х"-г өөрийн өмгөөлөгчөөр сонгон мөрдөн

[3] Проф. Н.Жанцан, Бүгд Найрамдах Индонези Улсын Бали хотноо 2016 оны 8 дугаар сарын 9-нөөс 13-ны өдрүүдэд Үндсэн хуулийн шүүх болон түүнтэй адилтгах байгууллагуудын Азийн нийгэмлэгийн /AACC/ 3 дугаар Их хуралд танилцуулсан "Иргэдийн Үндсэн хуулиар баталгаажсан эрхийг Монгол Улсын Үндсэн хуулийн шүүхээс хамгаалах ажиллагааны өнөөгийн байдал ба хэтийн төлөв" сэдэвт илтгэлээс.

[4] Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, Ханнс-Зайделийн сан, "Үндсэн хуульт ёсны төлөвшил, цаашдын хандлага" ОУЭШБХ-ын илтгэлийн эмхтгэл, Уб., 2012 он, 152-161 дэх тал.

[5] Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг.

[6] Мөн тэнд.

[7] Мөн тэнд.

[8] Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль /1997/-ийн 24 дүгээр зүйлийн 4 хэсэг, мөн хуулийн 14 дүгээр зүйл.

[9] Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль /1997/-ийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.

байцаалтын болон бүх шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахаар тохиролцон улмаар зохих төлбөрийг төлж ажиллуулсан юм. Гэтэл өмгөөлөгч "Х" нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342 дугаар зүйлийн 342.1 дэх хэсэгт заасан эрхийнхээ дагуу мөн хуулийн 304 дүгээр зүйлийн 304.1 дэх хэсэгт заасан хугацаанд хяналтын шатны шүүхэд хянуулахаар гомдол гаргаагүй. Учир нь өмгөөлөгч "Х" нь тухайн үед надаас болон гэр бүлийнхнээс маань 10 сая төгрөг төлөхийг шаардсан. Бидэнд түүний шаардсан мөнгө бэлэн байгаагүй учир мөнгийг төлж чадаагүйгээс надад холбогдох эрүүгийн хэргийг хяналтын шатны шүүхээр хянуулахаар хуулийн хугацаанд гомдол гаргах боломжийг ашиглаж чадаагүй юм.

Иймд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342 дугаар зүйлийн 342.1 дэх хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтуудыг зөрчиж байгаа эсэх талаар дүгнэлт гаргаж өгнө үү" гэсэн агуулга бүхий өргөдөл ирүүлжээ.

Цэцийн шийдвэр: Дээрх өргөдлийн дагуу Үндсэн хуулийн цэц маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэн 2014 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн Дунд суудлын хуралдаанаараа хянан хэлэлцэж 01 дүгээр дүгнэлтийг гаргажээ. Энэхүү дүгнэлтэд: Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342 дугаар зүйлийн 342.1 дэх хэсэг нь шүүгдэгч, цагаатгагдсан этгээд, хохирогч нь зөвхөн өмгөөлөгчөөр уламжлан Улсын дээд шүүхэд гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэхээр хуульчилсан нь иргэний өөрийгөө өмгөөлөх эрх болон хяналтын шатны шүүхэд гомдол гаргах эрхийг хязгаарлаж Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... өөрийгөө өмгөөлөх, ... шүүхийн шийдвэрийг давж заалдах ... эрхтэй." гэснийг зөрчсөн байна[10] хэмээн дүгнэжээ.

Шийдвэрийн биелэлт: Үндсэн хуулийн цэцийн дээрх дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйл **/Цэцийн шийдвэрийг биелүүлэх/-ийн 1 дэх хэсэгт заасны дагуу холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байх бөгөөд мөн зүйлийн** 2 дахь хэсгийн зааснаар **түүнийг** Улсын Их Хурал хүлээн авсан тул маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны процесс цааш үргэлжлээгүй байна.

Шийдвэрийн хууль зүйн үр нөлөө: Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээж авснаар шүүгдэгч, цагаатгагдсан этгээд, хохирогч нь эрүүгийн хэргийн талаар хяналтын шатны шүүхэд гомдол гаргах эрх нь нээгдсэн боловч өөрийнхөө эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөгдсөн гэж үзэн Үндсэн хуулийн цэцэд хандсан өргөдөл гаргагчийн Үндсэн хуульд баталгаатай эдлэхээр заасан шүүхэд гомдол гаргах, өөрийгөө өмгөөлөх, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхийг хэрхэн сэргээхтэй холбоотой асуудал шийдвэрлэгдэлгүй орхигдсон байдаг.

Өөрөөр хэлбэл, иргэдээс ирүүлсэн өргөдлийн дагуу үүссэн маргааныг хянан шийдвэрлэж гаргасан дүгнэлт, тогтоолын биелэлт, хууль зүйн үр нөлөө нь мэдээллийн дагуу үүссэн маргааныг хянан шийдвэрлэж гаргасан Цэцийн шийдвэртэй ижил үр дагавар үүсгэж буй явдал нь Монгол Улсын Үндсэн хуулиар "өргөдөл", "мэдээлэл" хэмээн ялгаж хуульчилсны ач холбогдлыг бууруулж байгаа гэж үзэхээр байх тул өргөдлийн дагуу Үндсэн хуулийн цэц маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа

[10] Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дүгээр дүгнэлт., Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342 дугаар зүйлийн 342.1 дэх хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай.

үүсгэх, хуралдаанд бэлтгэх, гарсан шийдвэрийг биелүүлэхэд чиглэгдсэн харилцааг маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тусгай журмаар зохицуулах хэрэгтэй байна.

Тодруулбал, өргөдлийн дагуу үүсгэсэн маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэх явцад Үндсэн хуулиар баталгаатай эдлэхээр заасан иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн байж болох тодорхой үндэслэл илэрвэл */тухайлбал, иргэн "Л"* өөрийнхөө Үндсэн хуулиар баталгаажсан шүүхэд гомдол гаргах, өөрийгөө өмгөөлөх, шүүхийн шийдвэрийг давж заалдах иргэний эрхийг зөрчигдсөн гэж үзээд өргөдөл гаргасан тул Үндсэн хуулийн цэцийн шийдвэр түүний эрх зүйн байдлыг дээшлүүлэхэд тодорхой хэмжээнд нөлөөлөл үзүүлэхэд чиглэх ёстой болов уу/ иргэний хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх талаарх асуудлыг хянан шийдвэрлэх үүрэг бүхий этгээдийг нэрлэн зааж, тухайн этгээд Цэцийн шийдвэрийг хэрхэн биелүүлбэл зохихыг тусгаж байх боломжтой.

Түүнчлэн, Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг хэрэгжүүлж өргөдөл гаргагчийн тодорхой нэг асуудлыг буюу зөрчигдсөн байж болох эрхийг сэргээх, хамгаалах асуудлыг хянан шийдвэрлүүлэхээр шүүхэд шилжүүлэх тухай заалтыг Цэц өөрийн шийдвэртээ тусгаж, түүнийг тухайн этгээд хэрхэн биелүүлбэл зохих гэх мэт зүйлийг тусгай журмаар зохицуулбал[11] Цэцийн шийдвэрийн биелэлт, үр нөлөө тэр хэмжээгээр нэмэгдэж, Үндсэн эрхийн гомдлын дагуу хяналт явуулдаг сонгодог тогтолцоонд бага боловч дөхөж очихыг үгүйсгэхгүй юм.

2. Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэдэг маргааны төрлөөс хамааран процессын тусгай журам тогтоох асуудлыг хөндөх нь:

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь өөр хоорондоо харилцан адилгүй 5 төрлийн маргааныг харьяалан шийдвэрлэдэг хэрнээ процессын нийтлэг нэг журмыг баримтлан хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж шийдвэр гаргадаг. Тодруулбал:

1. Цэц Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай дараах шийдвэрийг хянаж дүгнэлт гаргах бөгөөд шаардлагатай болдахин хянаж, эцэслэн шийдвэрлэнэ*:* хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр /тогтоол/; Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, бусад шийдвэр; Засгийн газрын шийдвэр /захирамж, тогтоол/; Монгол Улсын олон улсын гэрээ; ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний болон Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллага /Сонгуулийн ерөнхий хороо/-ын гаргасан шийдвэр /тогтоол/.

2. Цэц дараах албан тушаалтны үйл ажиллагаа Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай асуудлаар гарсан маргааныг хянаж дүгнэлт гаргана: Монгол Улсын Ерөнхийлөгч; Улсын Их Хурлын дарга; Улсын Их Хурлын гишүүн; Ерөнхий сайд; Засгийн газрын гишүүн; Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч; Улсын ерөнхий прокурор.

3. Цэц дараах албан тушаалтнуудыг огцруулах үндэслэл байгаа эсэх талаар дүгнэлт гаргана: Монгол Улсын Ерөнхийлөгч; Улсын Их Хурлын дарга; Ерөнхий сайд.

4. Цэц Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх талаар дүгнэлт гаргана.

[11] Доктор профессор Ц.Сарантуяа Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн хууль зүйн үр нөлөөг дээшлүүлэх нь сэдэвт илтгэлдээ: "Эрүүгийн эрх зүйн хувьд Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр ялтанд ашигтай тохиолдолд буцаж үйлчлэх шаардлагатай болохыг Венецийн комисс санал болгожээ. ХБНГУ-ын Холбооны Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд зааснаар эрүүгийн эрх зүйн холбогдох хэм хэмжээ хүчингүй байсан нь тогтоогдвол шүүхийн ял шийтгэл оногдуулсан хүчин төгөлдөр тогтоол гарсан хэдий ч хэргийг дахин хянаж үзэх боломжтой болдог ..." хэмээн бичсэн байна., Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц, Ханнс-Зайделийн сан, "Үндсэн хуульт ёсны төлөвшил, цаашдын хандлага" (ОУЭШБХ-ын илтгэлийн эмхтгэл), Уб., 2012 он, 152-161 дэх тал.

5. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар Аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоодог.

Үндсэн хууль болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд зааснаар албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн эсэх, түүнийг огцруулах, эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх талаарх маргааныг Үндсэн хуулийн цэц эцэслэн шийдвэрлэхгүйгээр зөвхөн дүгнэлт гаргахаар, харин хууль Үндсэн хуульд нийцэж буй эсэх маргааныг эцэслэн хянаж тогтоол гаргах тухай ялгамжтай зохицуулалтыг хуульчилсан байдаг. Тийм атал хууль Үндсэн хуульд нийцэж буй эсэх маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд удирдлага болгон баримталдаг процессын зохицуулалтыг бусад төрлийн маргааныг хянан шийдвэрлэх */тухайлбал, албан тушаалтны үйл ажиллагаа Үндсэн хууль зөрчсөн эсэх/* ажиллагаанд мөн адил мөрдөж байна. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулиар тухайн төрлийн маргааны онцлог байдлыг харгалзан Цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалтыг ялгамжтай хуульчилсан байдаг тул процессын хуульд тусгай журам тогтоох боломжтой гэж үзэж болохоор байна.

Дээр дурдсан Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтийн үндэслэл хэсэгт: "... шүүгдэгч, цагаатгагдсан этгээд, хохирогч нь зөвхөн өмгөөлөгчөөр уламжлан Улсын дээд шүүхэд гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэхээр хуульчилсан нь иргэний өөрийгөө өмгөөлөх эрх болон хяналтын шатны шүүхэд гомдол гаргах эрхийг хязгаарлаж ... байна." гэсэн байдаг. Цэцийн уг шийдвэрийн үндсэн агуулга нь Үндсэн хуулиар баталгаажсан өөрийгөө өмгөөлөх, шүүхэд гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэхдээ заавал хэн нэгэн этгээдээр уламжлуулж байхаар хуульчилсан нь Үндсэн хуулийн зөрчилд хүргэж байгаа тухай асуудлыг дүгнэсэн болов уу гэж сэтгэнэ.

Гэтэл энэхүү үндэслэлийн агуулгыг ташаа утгаар ойлгон шүүгдэгч, цагаатгагдсан этгээд, хохирогч нь зөвхөн өмгөөлөгчөөр уламжлуулж буй явдал нь Үндсэн хуулиар баталгаажсан эрхийг хязгаарлаж байгаа юм бол өмгөөлөгчөөс гадна бусад этгээдийг нэрлэн зааж, тэдгээрээр уламжлуулах зохицуулалтыг тусгаж өгвөл Үндсэн хуулийн зөрчил арилна хэмээн хууль санаачлах эрх бүхий этгээд тайлбарлаж байсан нь бий. Тиймээс, одоо мөрдөж байгаа процессын хуулийн зохицуулалтаар Цэцийн шийдвэрийн үндэслэлийг хуралдаан дуусмагц уншиж сонсгон холбогдох байгууллагуудад хүргүүлдэг нийтлэг зохицуулалтаас хууль Үндсэн хууль зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн Цэцийн дунд, их суудлын хуралдааны дүгнэлт, тогтоолыг тусгай журмаар гаргадаг байдлаар зохицуулах боломжтой юм.

Энэ талаар Хууль зүйн ухааны доктор Д.Сугар "Өмчийн харилцааны Үндсэн хуулийн зохицуулалт" сэдэвт өгүүлэлдээ бичсэнийг сийрүүлбэл, тухайн шийдвэрийн шинжлэх ухааны үндэслэлийг гүнзгий ул суурьтай боловсруулах үүднээс 14-21 хоногийн хугацаанд бичгийн хэлбэрт буулгаж албажуулах зэргээр процессын тусгайлсан журмыг хуульчилбал Үндсэн хуулийн зарчим, үзэл санааг нарийн ойлгуулах, олон нийтийг Үндсэн хуулиа хүндэтгэх үзлээр хүмүүжүүлэх Цэцийн шийдвэрийн үр нөлөөний ач холбогдол өндөрсгөнө[12] гэсэн байна.

[12] Доктор Д.Сугар, Өмчийн харилцааны Үндсэн хуулийн зохицуулалт; Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц, Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал (онол, арга зүй, хэрэгжилт), Уб., 2017он, 236-266 дахь тал.

3. Цэцийн шийдвэрээр хүчингүй болсон хууль бусад шийдвэрийн заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн эсэхийг хянан шийдвэрлэх ажиллагаанд тусгай журам тогтоох асуудлыг хөндөх нь:

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлд зааснаар эрх бүхий байгууллага, албан тушаалтан шийдвэр гаргахдаа Цэцийн шийдвэрээр хүчингүй болсон хууль болон бусад шийдвэрийн заалтыг шууд буюу агуулгаар нь дахин сэргээвэл Цэцийн аль нэг гишүүний санаачилгаар Цэц хяналтын журмаар хянан шийдвэрлэдэг зохицуулалттай бөгөөд уул асуудал нь Цэцийн шийдвэрийн хэрэгжилттэй салшгүй холбоотой билээ.

Эрх зүйн соёл өндөр хөгжсөн орнуудад Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр биелэхгүй байх тухай ойлголт байхгүй[13] боловч манайд Цэцийн шийдвэрээр хүчингүй болсон хуулийн зохицуулалтыг агуулгаар нь дахин сэргээх явдал цөөн биш удаа гарч байна. Үүний нотолгоо бол, Үндсэн хуулийн цэц сүүлийн 2 жилийн хугацаанд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Цэцийн шийдвэрээр хүчингүй болсон хууль болон бусад шийдвэрийн заалтыг шууд буюу агуулгаар нь дахин сэргээсэн эсэх тухай маргааныг Цэцийн гишүүний санаачилгаар 4 удаа хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, нэг асуудлаар Үндсэн хуулийн цэц 2 удаа хуралдаж дүгнэлт болон тогтоол гаргасаар байхад тухайн хуулийн заалтыг шууд болон агуулгаар нь дахин сэргээх явдал гарч байгаа нь хууль тогтоогчийн санаатай болон эрх зүйн соёл, ухамсар, улс төр, эдийн засгийн нөхцөл байдал, хууль зүйн болон бусад хүчин зүйлээс хамаарч байхыг үгүйсгэхгүй боловч нөгөө талаар үүнийг процессын нийтлэг журмыг удирдлага болгон шийдвэрлэж байгаатай холбон үзэж болох юм.

Дээрхээс улбаалан Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, тогтоолын үндэслэл хэсэгт дурдсан зөрчил, дутагдлыг арилгасан тохиолдолд[14] Улсын Их Хурал Үндсэн хуулиар олгогдсон онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд Цэцийн шийдвэрээр хүчингүй болсон хуулийн заалтыг сэргээн хуульчлах боломжтой юу гэсэн асуудал урган гарч байгаа юм.

Жишээлбэл, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 12 дугаар дүгнэлтэд: “Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлсэн тохиолдолд түдгэлзүүлэх тухай шийдвэр гарснаас эхлэн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх хугацаа шинээр тоологдох үр дагавартай байдаг. Гэтэл дээр дурдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5 дахь заалтад “... төлбөр төлөгчийг хөрөнгөтэй болох хүртэл.” гэх ойлголтоор хугацаа тодорхойлохоор тогтоосон төдийгүй, түдгэлзүүлэх үндэслэл болгон заасан байна. Мөн түүнчлэн холбогдох хуульд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэхэд ямар журмыг баримтлах, талуудын эрхийг хэрхэн хангах зэргийг холбогдох хуулиудад нарийвчлан тусгаагүй байгаа нь иргэн Үндсэн хуулиар баталгаажсан процессын эрхээ хэрэгжүүлэх, түүнчлэн шүүгчээс холбогдох асуудлыг шударга

[13] Доктор, профессор Н.Жанцан, Үндсэн хуулийн цэц ба Үндсэн хуульт ёсны төлөвшил – илтгэл, Үндсэн хуульт ёсны төлөвшил, ОУЭШБХ-ын илтгэлийн эмхтгэл, Уб., 2012 он, 27-35 дахь тал.

[14] Словенийн эрдэмтэн, Доктор, профессор Арне Мавчич: “Шаардлагатай бол Үндсэн хуулийн шүүх нь өөрийн шийдвэртээ ямар этгээд түүнийг биелүүлэх, ямар хэлбэрээр биелүүлэхийг тусгайлан зааж болно. Үндсэн хуулийн шүүх нь өөрийн шийдвэрээр нийтээр дагаж мөрдөх актын үйлчлэлийг зогсоосон бол дагалдан гарах нэг удаагийн актыг биелүүлэхийг түр түдгэлзүүлэх тухай мөн адил шийдвэрлэж болно.
Маргаж буй нэг удаагийн актыг Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрээр орлуулахыг эрх бүхий этгээд гүйцэтгэх бөгөөд ийм эрх бүхий этгээд хууль тогтоомж, дүрэм, журамд заагдаагүй бол Үндсэн хуулийн шүүх тийм этгээдийг нэрлэн зааж болно” хэмээн өөрийн бүтээлдээ бичжээ., Орч: Г.Баясгалан, Д.Одбаяр, Д.Сугар, Үндсэн хуулийн хяналт, Уб., 2014 он, 75 дахь тал.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН www.pli.gov.mn

ёс, тэгш байдлын зарчмын хүрээнд шийдвэрлэх боломжгүй болгож байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт зөрчигдөх нөхцөлийг бүрдүүлж байна." гэсэн үндэслэлийг тусгажээ.

Хэрэв хууль тогтоогч Үндсэн хуулийн цэцийн дээрх дүгнэлтийн үндэслэлд дурдагдсан иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэхэд ямар журмыг баримтлах, талуудын эрхийг хэрхэн хангах зэрэг асуудлыг нарийвчлан зохицуулсан хэм хэмжээг хуульчилсан тохиолдолд хүчингүй болсон тухайн заалтыг сэргээх боломжтой байх (шууд болон агуулгаар нь сэргээсэн гэж үзэхгүй байх)-ыг үгүйсгэхгүй юм.

Иймд Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг биелүүлээгүй, эсвэл хууль зүйн хувьд бүрэн биелүүлэхгүйгээр хэлбэрийн төдийд хэрэгжүүлэх, ташаа ойлгож мушгин гуйвуулах аваас тухайн шийдвэрийн хууль зүйн үр нөлөө, нийгэмд гүйцэтгэх үүрэг тодорхой хэмжээнд буурах, эрх зүйн хийдэл үүсэх зэрэг сөрөг үр дагавартай гэж үзэж байна. Тиймээс Үндсэн хуулийн үзэл баримтлал, мөн чанар, амин сүнс нь шингэж гаргасан **Цэцийн шийдвэрийн үндэслэлд заасан зөрчил дутагдал**, эрх зүйн хийдэл болон боловсронгуй болгох тухай асуудал, явцуу хийгээд өргөжүүлсэн тухай асуудлыг засаж залруулан ягштал хэрэгжүүлэхэд онцгой анхаарч энэ талаарх зохицуулалтыг тусгайлан хуульчлах нь Цэцийн шийдвэрийн хууль зүйн үр нөлөө дээшлэхэд зохих хэмжээнд түлхэц болно гэж үзэж байна.

Үүний тулд, Цэцийн шийдвэрээр хүчингүй болсон хууль болон бусад шийдвэрийн заалтыг шууд буюу агуулгаар нь сэргээсэн эсэх тухай асуудлыг хяналтын журмаар шийдвэрлэх тохиолдолд холбогдох ажиллагааг тусгай журмаар явуулдаг байхаар холбогдох хуульд тусгах нь зүйтэй.

ДЭЭРХИЙГ НЭГТГЭН ДҮГНЭВЭЛ:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт "өргөдөл", "мэдээлэл" хэмээн хуульчилж, хэн өргөдөл гаргах, ямар тохиолдолд мэдээлэл ирүүлэхийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиар ялгаатай тогтоосон хэрнээ тэдгээрийг хянан шийдвэрлэх процессын ажиллагаа нэг журмаар явагддаг. Энэ байдал нь Үндсэн хуульд баталгаатай эдлэхээр заасан иргэний эрхээ хөндөгдсөн гэж үзээд өргөдөл гаргасан иргэний эрхийг сэргээх талаар ажиллагаа явагдахгүй байх нэгэн хүчин зүйл болж байгааг үгүйсгэх боломжгүй юм.

Хэрэв тухайн маргааны хүрээнд өргөдөл гаргагчийн субъектив эрх хөндөгдсөн болох нь илэрхий эсхүл бусад эрх бүхий байгууллагын шийдвэрээр нотлогдож байвал тэр талаар Цэц шийдвэртээ нэг бүрчлэн тусгаж, иргэний эрхийг сэргээн эдлүүлэх талаар шүүх бусад байгууллага ямар арга хэмжээ авбал зохихыг тусгаж байх нь зүйтэй байна.

2. Үндсэн хуулийн цэц нь хууль, бусад шийдвэр Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг 2 шаттай (дүгнэлт, тогтоол), харин бусад маргааныг 1 шаттай (зөвхөн дүгнэлт гаргах) хянан шийдвэрлэж байхаар Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан ба түүнд нь тохирсон процессын ялгаатай зохицуулалт Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд тусгагдаагүй орхигдсон байдаг.

Тодруулбал, өөр хоорондоо ялгаатай олон төрлийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг процессын нэг журмын дагуу явуулахаар хуульчилсан нь тухайн асуудлыг бүх талаас нь бүрэн гүйцэд, бодитой шийдвэрлэх боломжийг зохих хэмжээнд хязгаарлаж байгаа учир тэдгээрийн онцлог байдалд тохирсон процессын зохицуулалтыг хуульчлан

хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

тогтоосноор нэг талаас Үндсэн хуульд нийцээгүй хууль, бусад шийдвэр хүчин төгөлдөр хэвээр үлдэх, эсхүл холбогдох албан тушаалтаны хууль бус үйл ажиллагаанд холбогдуулан дүгнэлт гаргаж чадахгүй байх нөхцөлийг хууль зүйн хувьд бууруулж, нөгөө талаас хувь иргэний болон нийтийн ашиг сонирхол тэр хэмжээгээр хамгаалагдах боломжтой юм.

3. Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээр хүчингүй болсон хууль болон бусад шийдвэрийн заалтыг шууд буюу агуулгаар нь дахин сэргээсэн эсэх тухай асуудлыг хяналтын журмаар хянан шийдвэрлэхэд мөн л процессын ижилхэн зохицуулалтыг баримтлан холбогдох ажиллагааг явуулан шийдвэр гаргаж байгаа нь Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн чанар, түүний биелэлтэд нөлөөлж байна.

Товчдоо бол, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд зааснаар Цэц нь маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх, хуралдаанд бэлтгэх, нотлох баримт цуглуулах, талуудаас тайлбар гаргуулах, холбогдох шийдвэр гаргах, тухайн маргааныг бүрэн гүйцэд, бодитой хянан шийдвэрлэхэд чиглэсэн нэг бүрчилсэн шинжтэй процессын хуулийн тусгай журамтай болсноор Цэцийн дүгнэлт, тогтоолын үндэслэл, түүний шинжлэх ухааны гаргалгаа, онол, практикийн ач холбогдол өндөрсгөж, тэр хэмжээгээр цэцийн шийдвэрийн хууль зүйн үр нөлөө, ач холбогдол нэмэгдэх боломжтой байна.

Тиймээс Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн хууль зүйн үр нөлөөг дээшлүүлэх үүднээс 1/ өргөдлийн дагуу үүссэн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд тохирсон тусгай журамтай болох, 2/ хууль Үндсэн хууль зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн Үндсэн хуулийн цэцийн дунд болон их суудлын хуралдааны шийдвэрийн үндэслэл боловсруулах хугацааг тусгайлан тогтоох; 3/ Цэцийн аль нэг гишүүний санаачилгаар Цэц хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах тохиолдолд түүнд тохирсон маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тусгай журмыг хуульчлан тогтоох шаардлагатай гэж үзлээ.

Ашигласан эх сурвалж:

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он;

2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль, Уб., 1997 он.

3. Г.Совд, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиудын тайлбар, Уб., 1999 он.

4. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал (онол, арга зүй, хэрэгжилт), Уб., 2017 он.

5. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц (2017), Үндсэн хуулийн шүүх эрх мэдэл: Тулгамдсан асуудал, ирээдүйн төлөв, Уб., 2017 он.

6. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, Ханнс-Зайделийн сан, Үндсэн хуульт ёсны төлөвшил, цаашдын хандлага (ОУЭШБХ-ын илтгэлийн эмхтгэл), Уб., 2012 он.

7. П.Очирбат, Монгол Улсын Үндсэн хууль (хэрэгжилт, хяналт, судалгаа), Уб., 2017 он.

8. Н.Жанцан, Үндсэн хуулийн шүүх болон түүнтэй адилтгах байгууллагуудын Азийн нийгэмлэгийн 3 дугаар их хуралд хэлэлцүүлсэн илтгэл, Уб., 2017 он.

9. Доктор Д.Сугар, “Өмчийн харилцааны Үндсэн хуулийн зохицуулалт” сэдэвт өгүүлэл, Уб., 2016 он.

10. Арне Мавчич, Орч: Г.Баясгалан, Д.Одбаяр, Д.Сугар, Үндсэн хуулийн хяналт, Уб., 2014 он.

11.Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн эмхтгэл, V, VI боть, Уб., 2017 он.

12.Шихихутаг Хууль зүйн дээд сургууль, Монгол Улсын эрх зүйн шинэчлэл, Ази-Номхон далайн орнуудын эрх зүйн хөгжлийн чиг хандлага, Уб., 2011 он.

---o0o---

ГЭМТ ХЭРГИЙН АНГИЛАЛ ТҮҮНИЙ НИЙГМИЙН ХОР АЮУЛЫН ШИНЖ, ХЭР ХЭМЖЭЭНЭЭС ХАМААРАХ НЬ

Баян-Өлгий аймгийн прокурорын газрын Ерөнхий прокурор Т.Батсүх

Баян-Өлгий аймгийн хяналтын Прокурорын газрын хууль цаазын ахлах зөвлөх М.Фарида

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРААЛЭН www.mli.gov.mn

ТҮЛХҮҮР ҮГ:

Гэмт хэрэг, нийгмийн аюул, хор хохирол, ял, хувийн болон нийтийн эрх ашиг, эрүүгийн хууль, хэргийн ангилал, хөнгөн, хүнд, онц хүнд хэрэг, Үндсэн хуулийн зөрчил.

ТОВЧЛОЛ:

Эрүүгийн хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд гэмт хэргийг хөнгөн, хүнд гэж хоёр ангилсан нь нийгмийн сэтгэл зүй, ёс суртахуун, шударга ёсны үнэлэмжид хэрхэн нийцэж байгааг болон цаашид ялын зорилготой уялдуулан өөрчлөх шаардлагатай эсэхийг энэ өгүүлэлд хөндсөн болно.

УДИРТГАЛ:

Олон улсын эрүүгийн эрх зүйн хөгжлийн орчин цагийн чиг хандлагатай уялдуулан Монгол Улс 2015 онд Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулсан нь эрүүгийн эрх зүйн шинэ үзэл баримтлал руу зоригтой шилжсэн түүхэн алхам болсон. Шинэ Эрүүгийн хуулийг 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж хэрэгжүүлж эхэлснээр уг хуулийн үзэл баримтлалыг судлан хуулийг хэрэглэх эрх бүхий субъектүүд мөрдөгч, өмгөөлөгч, прокурор, шүүгч, шийдвэр гүйцэтгэгч/ анхнаас нь зөв голдирлоор авч явах /зөв практик тогтоохын төлөө чармайсаар байна / нь юу юунаас чухал болж байна.

Эрүүгийн хууль тогтоомжийн[1] шинэчлэлийн үзэл баримтлал буюу эрүүгийн хуулийн онолын суурь ойлголтыг тайлбарлахад чиглэсэн сургалтуудыг 2017 оны сүүлийн хагас жилд шүүх, прокурор, мөрдөгч, зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтнуудын хүрээнд улсын хэмжээнд амжилттай зохион байгуулсан билээ. Хуулиудыг хэрэгжүүлж, хэрэглэж эхэлснээс хойш нэг жилийн хугацаа өнгөрсөн хэдий ч төдий л бүрэн дүүрэн ойлгож хэвшээгүй

[1] Монгол Улс 2015 онд эрүүгийн хууль тогтоомжийн бодлогын чанартай шинэчлэл хийсэн бөгөөд Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Прокурорын тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг шинэчлэн найруулах шинээр батлах байдлаар хэрэгжүүлсэн юм.

алдаа оноо, ойлголтын зөрүүтэй зүйлүүд тохиолдсоор л байна.

Эрүүгийн хуулийг хамгийн энгийнээр томьёолбол гэмт хэрэг ба ялын тухай л заасан хууль билээ. Иймээс эрүүгийн эрх зүй бол гэмт хэрэг ба ялын тухай ойлголтоос бүрддэг[2] материаллаг эрх зүйн салбар юм. Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг гэдэг нь хувийн болон нийтийн эрх ашигт халдсан[3] хүн, хуулийн этгээдийн гэм буруутай үйлдэл, эс үйлдэл /үйлдэхүй гэдэг нь монгол хэлний тайлбар тольд байдаггүй[4] үг/-ийн үр дагавар юм. Хувийн болон нийтийн эрх ашигт халдснаар түүнд гэм хор /хор уршиг/ учруулсан байх учиртай болдог. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн хэмжүүр зөвхөн нийгэмд учруулсан гэм хорын[5] шинж хэмжээнээс хамаардаг бөгөөд түүнд нийцүүлэн ял шийтгэлийг тогтоодог.

Хүний аливаа зөрчигдсөн эрх ашгийг хуулиар хамгаалдаг бөгөөд зөвхөн гэмт халдлагад өртсөн эрх ашгийг л эрүүгийн хуулиар хамгаалан зохицуулдаг. Тухайлбал, хөдөлмөрлөх эрх ашиг зөрчигдвөл иргэний эрх зүйгээр, харин газар ашиглах нийтийн эрх ашиг зөрчигдвөл захиргааны эрх зүйгээр, амгалан тайван амьдрах, амрах эрх ашиг зөрчигдвөл зөрчлийн хуулиар хамгаалан сэргээлгэдэг бол эдгээр эрх зүйгээр сэргээх боломжгүй бол сүүлийн боломж болох эрүүгийн эрх зүй рүү хандах хэрэгтэй[6] болно.

Эрүүгийн эрх зүйгээр хамгаалж буй эрх ашгийг нийгмийн хор аюулын шинж хэр хэмжээг нь шалгуур болгон Эрүүгийн хуулийн 10 дугаар бүлгээс эхлэн 29 дүгээр бүлэг хүртэл эрэмбэлэн тогтоосон байна. Эдгээр бүлэг тус бүрд заасан гэмт хэрэг нь тухайн бүлгийнхээ ямар эрх ашгийг хамгаалсан болохыг илэрхийлнэ. Жишээ нь, Аравдугаар бүлэгт "Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг", хорин наймдугаар бүлэгт "Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг" гэх зэргээр эрх ашгийн хүрээгээр системчлэлд оруулан тогтоожээ.

Нэг. Гэмт хэргийг нийгмийн хор аюулын шинжээр нь ангилахын ач холбогдол.

Одоогийн мөрдөж буй Эрүүгийн хуульд /2015 оны/ гэмт хэргийг хөнгөн, хүнд гэж хоёр ангилсан нь хэр оновчтой болсон эсэх талаар хуульчид, эрдэмтдийн дунд асуудал хөндсөөр байна. Хуулийг хэрэглэж гэмт хэрэг үйлдэгчдэд зохих эрүүгийн ял, хариуцлагыг хүлээлгэх үүргээ биелүүлж байгаа мөрдөгч, өмгөөлөгч, прокурор, шүүгч нарын хувьд ч уг асуудал анхаарал татаж байгаа нэг сэдэв боллоо. Чухам иймээс одоогийн гэмт хэргийн ангиллын талаар саналаа хуваалцахаар энэхүү өгүүллийг бичиж байна.

Монгол Улсын орчин цагийн эрүүгийн хуулийн хөгжил 1926 оноос[7] эхтэй бөгөөд Эрүүгийн хууль батлагдах бүрд гэмт хэргийн тухай тодорхойлолтыг тусгаж ирсэн байдаг. Тухайлбал анхны эрүүгийн хууль болох БНМАУ-ын Шүүх цаазын бичгийн 1 дүгээр зүйлд "аливаа цааз хуульд заасан эл явдлыг гэмт хэрэгт тооцвоос зохино.", 3 дугаар зүйлд "Энэхүү шүүх цаазын бичгийг ... хамаг эрүүгийн хэргийг шийдэхэд журамлан дагавараас зохино.", 26 дугаар зүйлд "Аливаа гэмт явдал үйлдэгсдийг шийтгэхэд ... эдний халдсан хэргийн хүнд, хөнгөн басхүү ялт хүний байдлын аймшгийн их бага зэргийг харгалзаж ял тогтоовоос

[2] Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

[3] Эрүүгийн хуулийн 1.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

[4] Я.Цэвэлийн монгол хэлний тайлбар толь болон 2018 онд бүтээсэн "Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь"-д ийм үг байдаггүй.

[5] Чезаре Беккариа. Гэмт хэрэг ба ялын тухай. Нээлттэй академи. Сонгодогууд цуврал Уб., 2009 он, 38 дах тал

[6] Т.Золбоо. Эрүүгийн эрх зүй. Гэмт хэргийн бүтээц. Уб.,2016 он, 20 дахь тал.

[7] Засгийн газрын 1926 оны 1 сарын 15-ны өдрийн хурлаар Шүүх цаазын бичгийн ерөнхий ангийг баталсан ба БНМАУ-ын 3 дугаар Их хурлын 10 дахь өдрийн тогтоолоор Тусгай ангийг баталснаар анхны бүрэн хэмжээний "БНМАУ-ын Шүүх цаазын бичиг" гэдэг эрүүгийн хуультай болжээ. Энэ хуулийг боловсруулахдаа Холбоот Орос улсын 1922 оны болон ЗХУ-ын 1924 оны Эрүүгийн хуулийг гол үзэл баримтлал болгосон гэдэг.

Хуулийн дээдлэх хүрээлэн www.hdc.gov.mn

зохино."[8] гэж тус тус заажээ. Энд зөвхөн эрүүгийн хуульд заасан явдлыг гэмт хэрэгт тооцож гэмт хэргийн хүнд хөнгөн, нийгмийн хор аюулын шинж /аймшгийн их бага зэргийг харгалзаж/ хэр хэмжээгээр ял оногдуулах зарчмыг анх удаа тогтоосон төдийгүй орчин цагийн эрүүгийн эрх зүйн гэмт хэргийн ойлголтыг тодорхойлсон гэж үзэж болохоор байна. Анхны энэ хуульд гэмт хэргийн аюултай шинжийг бус гэмт этгээдийн аюултай шинжийг харгалзсан байна. Харин гэмт хэргийн нийгмийн шинж хор аюулыг харгалзан ялгамжтай ял шийтгэх санааг 1934 оны Шүүх цаазын бичгийн 12 дугаар зүйлд "...үйлдсэн хэрэг ба оролцсон хүний аюул нь аль зэрэг болохыг үзэж" гэж анх удаа тогтоосон бөгөөд мөн хуулийн 4 дүгээр зүйлд "...олон нийт дор аюултай явдал үүсгэснийг гэмт хэрэг гэнэ." хэмээн хүний ямар үйлдлийг гэмт хэрэгт тооцохыг анх удаа хуульчилжээ. Гэмт хэргийн үндсэн шинж буюу нийгэмд аюултай байх шинжийг тодорхойлж өгснөөр энэ хууль чухал ач холбогдолтой болжээ.

Гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинжийг 1942 оны[9] БНМАУ-ын Эрүүгийн хуулийн 6-д /дугаар зүйл гэдэг техник хэрэглээгүй/ "Хувьсгалт засаг төрд эсэргүү хандсан буюу ардын хувьсгалт засгаас тогтоон явуулсан хууль журмыг зөрчин үйлдсэн буюу эс үйлдсэнээр нийтэд аюултай явдлуудыг гэмт хэрэг гэнэ." гэж тодорхойлолсон байна.

Манай улсын түүхэн дэх гурав дахь Үндсэн хуулийг 1960 онд баталсан бөгөөд уг суурь хуульд Эрүүгийн хуулийг нийцүүлэн боловсруулж 1961 оны 1 дүгээр сарын 31-нд Ардын Их Хурлын 2 дугаар чуулганаар баталж мөн оны 04 дүгээр сарын 01-нээс мөрдөж эхэлсэн байдаг. Социализмын байгуулалт, социалист өмчийг гэмт халдлагаас хамгаалах үзэл суртал, улс төрийн зорилтын агуулгаар боловсруулагдсан энэ хуулийн 2 дугаар зүйлд "...нийгэмд аюултай хэргийг санаатай буюу болгоомжгүй үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж шийтгэнэ." хэмээн гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинжийг илүү тодорхой заасан байна.[10] Мөн хуулийн 4 дүгээр зүйлд нийгэмд хор аюул учруулаагүй, ялимгүй хэргийг гэмт хэрэгт тооцохгүй гэжээ.

ОХУ-ын Эрүүгийн хуульд[11] "эрүүгийн хуулиар ял оногдуулахаар хориглосон бөгөөд нийгэмд аюултай гэм буруутай үйлдлийг гэмт хэрэгт тооцно" гэж заасан бол БНКазУ-ын Эрүүгийн[12] хуульд мөн адил утгаар гэмт хэргийг тодорхойлсон байна.

Гэмт хэргийг нийгмийн хор аюулын хэр хэмжээгээр нь ангилж ирсэн уламжлал манай эрүүгийн хуулийн түүхэн замналаас тодорхой харагддаг. 1926 онд баталсан БНМАУ-ын Шүүх цаазын бичгийн 26 дугаар зүйлд "... халдсан хэргийн хүнд, хөнгөн...зэргийг харгалзаж ял тогтоовоос зохино[13].", 1929 оны Шүүх цаазын бичгийн 12-15 дугаар зүйлүүдэд[14] хэргийн хүнд, хөнгөн ангиллыг харгалзан ял оноох эсэхийг шийдэх талаар зохицуулжээ.

Харин 1934 оны Шүүх цаазын бичиг, 1961 оны Эрүүгийн хуульд гэмт хэргийг хүнд, хөнгөн гэж тусгайлан ангилсан зохицуулалт байхгүй ба 1986 оны Эрүүгийн хуульд анх удаа Хүнд гэмт хэргийн ойлголт гэсэн шинэ зүйл[15] орж ирсэн байдаг. Тэнд "...санаатай үйлдсэн, нийгэмд нэн аюултай хэргийг

[8] Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал /1911-2009/ Уб., 2011 он, 282- 285 дахь тал.

[9] БНМАУ-ын 25 дугаар Бага хурлаас 1942 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр баталжээ. 1940 оны шинэ Үндсэн хуулийн улс төрийн үзэл санаанд нийцүүлэн шүүх цаазын бичгийг боловсронгуй болгох зорилтын хүрээнд БНМАУ-ын эрүүгийн хууль гэдэг нэртэйгээр баталсан байна. Ингэснээр "Эрүүгийн хууль" гэдэг оноосон нэртэй хууль бий болжээ.

[10] Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал /1911-2009/ Уб., 2011 он, 417 дахь тал.

[11] Уголовный кодекс Российской Федерации. Статья 14.

[12] Казахтсан Республикасынын кылмыстык кодекси. 9-бап

[13] Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал /1911-2009/ Уб., 2011 он, 285 дахь тал.

[14] Мөн тэнд. 313-314 дэх тал.

[15] 1986 оны Эрүүгийн хуулийн 6 дугаар зүйл.

хүнд гэмт хэрэг гэж үзнэ.” гэж нийгмийн хор аюулын хэр хэмжээгээр нь ангилсан байна.

Гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж 4 янзаар ангилсан заалтыг анх 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар[16] 1986 оны Эрүүгийн хуулийн дээрх 6 дугаар зүйлийг өөрчлөн найруулж оруулж ирсэн байдаг юм. Энэхүү ангиллыг бид 2002 оны Эрүүгийн хуульд хэвээр нь авч үлдэж хэрэглэсэн бөгөөд харин 2015 оны Эрүүгийн хуулиар хөнгөн, хүнд гэж хоёр ангилан одоо хэрэглэж байна. Гэмт хэргийн дээрх дөрвөн төрлийн ангилалт бидний судалсан ОХУ, БНКазУ-ын эрүүгийн хуулиудад мөн адил тусгагдсан байна.

Хоёр. Гэмт хэргийг ангилах нь түүний нийгмийн хор аюулын хэмжээг олон нийтэд мэдрүүлэх, урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой болох нь.

Гэмт хэргийг дээрх 4 янзаар ангилан хэрэглэх явц 1993 оны 8 дугаар сарын 1-нээс 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэл 24 жил үргэлжилсэн бөгөөд иргэдийн ухамсарт өдгөө хүртэл нөлөөлсөн хэвээр байна. Өөрөөр хэлбэл, хүмүүс хүнийг алах, бага насны хүүхдийг хүчиндэх зэрэг нийгмийн хор аюулын хэр хэмжээ ихтэй зарим төрлийн гэмт хэргийг онц аюултай гэмт хэрэг гэж хандах хандлага, ойлголтоос ангижраагүй байна.

Гэмт хэрэг бүр нийгэмд аюултай боловч уг шинж нь хэр зэрэг байгаагаас хамааралд хүмүүсийн сэтгэхүйд нөлөөлж хүрэх нь өөр өөр байдаг. Шинж гэдэг нь юмны чанар, байдал, дүр, төлөв[17] гэж Монгол хэлний тайлбар тольд тусгажээ. Өөрөөр хэлбэл шинж нь хүнд мэдрэгдэх /харах, сонсох, ойлгох, цэгнэж дүгнэх/ хүчин зүйлийн хэмжээ юм. Энэ байдлаар нь гэмт хэргийг хөнгөн хүндээр нь ангилан ойлгож жигших, цэрвэх, айх байдлаар хандахад хүргэдэг.

Одоогийн Эрүүгийн хуулийг анх “Гэмт хэргийн тухай хууль” гэсэн нэртэйгээр боловсруулсан бөгөөд гэмт хэргийг ангилахгүйгээр хэрэг үйлдсэн хүний гэм буруу, учруулсан хохирол, хор уршгийн шинжийг нь харгалзан ял оногдуулж байхаар боловсруулжээ[18]. Ингэж дөрөв эрэмбэлж ангилахаас татгалзсан үндэслэлээ тодруулахдаа “хохирлын хэмжээнээс хамааралд” хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг өөрчлөх бүрд гэмт хэргийн ангилал өөрчлөгддөг байсан учраас түүнээс татгалзсан гэжээ. Гэмт хэргийг материаллаг шинж, босго тогтоосон хэмжигдэхүүнээс зайлсхийсэн нь давуу тал болсон боловч гэмт хэргийн шинжээр буюу нийгмийн хор аюулын хир хэмжээгээр нь ангилахын сөрөг сул талыг уг үндэслэлд дурдаагүй байна. Гэмт хэргийг эрүүгийн хуульдаа хөнгөн хүнд зэргээр эрэмбэлэн ангилдаггүй улс орон олон байдаг.

Манай улсын эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны онолын түвшинд жишиг болгож ирсэн Германы Эрүүгийн хуульд гэмт хэргийг хөнгөн, хүнд хэмээн эрэмбэлдэггүй[19] үйлдэл, эс үйлдлийг гэмт хэрэг, санаатай ба болгоомжгүй гэмт хэрэг, ердийн ба тусгай гэмт хэрэг, гэмт хэрэг ба гэмт зөрчил гэж шаталсан байдлаар ангилдаг байна.

Эрүүгийн хуульд /2015 оны/ зааснаар гэмт хэргийг хөнгөн, хүнд гэж хоёр шатлалаар эрэмбэлж ангилсан нь ял шийтгэл оногдуулах шударга ёсны зарчимд болон олон түмний зүгээс гэмт хэргийн нийгмийн хор аюулын сэтгэл зүйн, ёс суртахууны, эдийн засгийн[20] шинж байдалд хандах хандлагад сөрөг нөлөөтэй болсон байна. Учир нь эд хөрөнгө хулгайлах, хүний амь нас бусниулах хоёр гэмт хэргийн шинж нь нийгэмд өөр өөр үнэлэлт

[16] Төрийн мэдээлэл. 1994 он. № 4-5

[17] Query.mn сайт

[18] Гэмт хэргийн тухай хуулийн төсөл. Уб., 2014 он, 5 дахь тал.

[19] Э.Хилгендорф, Д. Чанцалдулам. Германы эрүүгийн эрх зүйн ерөнхий анги. Уб., 2015 он, 30-32 дахь тал.

[20] Монгол улсын Эрүүгийн хуулийн тайлбар. Уб., 2013 он, 73 дах тал.

дүгнэлт төрүүлдэг. Яагаад гэвэл эдгээр хэргийн нийгмийн аюулын шинж, хор уршгийн хэр хэмжээ тэс өөр. Гэтэл айл амьдардаг байшинд хууль бусаар нэвтэрч ороод 100 000 төгрөгийн эд зүйл хулгайлсан өсвөр насны хүүхдийн үйлдсэн гэмт хэрэгт хоёроос найман жил хүртэл хорих ял оногдуулах ба хүнд гэмт хэрэгт тооцогдоно.[21] Хүнийг онц харгис хэрцгий аргаар алсан хүний үйлдсэн хэрэг ч мөн дээрх хүүхдийн үйлдсэн хэргийн нэгэн адил хүнд гэмт хэргийн ангилалд багтаж байгаа нь шударга үнэлэмж биш юм.

Эрүүгийн хуульд заасан хүнд ялтай хэргийн байдлыг доорх хүснэгтээр үзүүлэв.

2-8 жил	5-8 жил	5-12 жил	8-15 жил	12-20 жил
65 хэрэг	1 хэрэг /18.18-2/	41 хэрэг	7 хэрэг	23 хэрэг

Хоёроос найман жилийн хорих ял оногдуулдаг дээрх 65 гэм буруутай үйлдлийн /хэргийн/ хор аюулын хэр хэмжээ нь 12-20 жилийн хорих ял оногдуулдаг 23 гэм буруутай үйлдлийн шинж чанар, хэр хэмжээнээс бага боловч гэмт хэргийн ангиллын хувьд нэг ижил буюу “ХҮНД” гэмт хэрэгт тооцогдож байгаа нь иргэдэд гэмт хэргээс жигших, сэрэмжлэх сэтгэл зүйн болон ёс суртахууны хандлагад сөргөөр нөлөөлж Эрүүгийн хуулийн урьдчилан сэргийлэх зорилгоос ухарсан байдалд хүргэсэн гэж үзэхээр байна.

Гэмт хэргийг хөнгөн, хүнд хэмээн шатлан эрэмбэлэхдээ тухайн хэрэгт оногдуулах ялын хэмжээгээр ангилж ирсэн уламжлалтай. Өмнөх 2002 оны Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлд хөнгөн гэмт хэрэгт хорих ял оногдуулдаггүй байсан бөгөөд хүндэвтэр, хүнд, онц хүнд хэрэгт оногдуулах хорих ялын хэмжээг маш тодорхой тогтоож өгсөн байсан. Тухайлбал, 5 жил хүртэл хорих ял оногдуулах хэргийг хүндэвтэр, 5 жилээс дээш 10 жил хорих ял оногдуулах хэргийг хүнд, 10 жилээс дээш 15 жил хорих ял оногдуулах хэргийг онц хүнд гэмт хэрэг гэж ангилж байв. Гэтэл 2015 оны Эрүүгийн хуульд хорих ялын ийм зааг ялгаа тодорхой бус буюу давхардсан байдлаар зохицуулсан байна.

Хөнгөн гэмт хэрэг үйлдсэн хүн 5 жилийн хорих ял авах, хүнд гэмт хэрэг үйлдсэн хүнд 2 жилийн хорих ял оногдуулж болох нөхцөл байдалтай болсон. Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлийн 1.3 дахь хэсгийг журамлан хүнд гэмт хэрэг үйлдсэн хүн тухайн зүйл, хэсэг, заалтад заасан ялын доод хэмжээний хоёрны нэгээс багагүй ял оногдуулах боломжтой. Тухайлбал иргэн Е, Т, А, М нар машин ашиглан Баян-Өлгий аймгийн төвийн ойролцоох шохой шатаах цэгээс 600 кг, нийт 360,000 төгрөгийн үнэтэй шохойг хулгайлан авсан хэргийг тус аймаг дахь Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх[22] хянан хэлэлцээд шүүгдэгч нарт 1-2 жилийн хугацаагаар хорих ял оногдуулсан байна. Эндээс үзэхэд нэгдүгээрт хэргийн нийгмийн хор аюулын шинж, учруулсан хохирлын хэр хэмжээ нь бага боловч хүнд ангиллын гэмт хэрэгт багтаасан, хоёрдугаарт оногдуулах ялын хувьд хөнгөн гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээнээс бага ял оногдуулах боломжтой болсон зэрэг оновчтой бус зохицуулалт болжээ.

ДҮГНЭЛТ

Эрүүгийн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгөх энгийн иргэдийн шударга ёсны төсөөлөлд хөнгөн, хүнд, онц хүнд гэмт хэргийн ялгаа заавал байх шаардлагатай болж байна. Учир нь бусдын 8 бод хулгайлсан үйлдэл нь найман настай охиныг хүчиндсэн

[21] Эрүүгийн хуулийн 2.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хорих ялын дээд хэмжээг 5 жил, түүнээс доош хугацаагаар ял оногдуулах гэмт хэргийг хөнгөн гэмт хэрэгт тооцдог.

[22] Баян-Өлгий аймаг дахь Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 02 сарын 19-ний өдрийн 22 дугаар шийтгэх тогтоол.

үйлдэлтэй адил эрэмбэтэй /ангиллын/ хэрэг болж жирийн иргэний нүдэнд харагдаж байгаа нь Эрүүгийн хуулийн урьдчилан сэргийлэх зорилгоос хазайж, шударга ёсны зарчмыг алдагдуулахад хүргэж байна. Нөгөө талаар улсын хэмжээний эрүүгийн нөхцөл байдлын статистик мэдээ судалгаа гаргахад "онц хүнд" гэмт хэрэг гэдэг ойлголт байхгүйгээс хүнд гэмт хэргийн дотор жигшүүрт, онц харгис хэрцгий аргаар үйлдэгдсэн хэргүүд багтдаг тул нийгмийн хор аюулын хэр хэмжээгээр нь ялгаж салгах боломжгүй байдалд хүргэдэг.

Эрүүгийн хуулийг 2015 онд батлахад гэмт хэргийг хөнгөн хүндээр нь эрэмбэлж ангилаагүй байсан үзэл баримтлалыг харгалзахгүйгээр 2017 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 2.6 дугаар зүйлийг шинээр нэмж "Гэмт хэргийн ангилал"-ыг шууд тогтоосноос болж хэргийн нийгмийн хор аюулын хэмжээнд тохироогүй байдлаар буюу зөвхөн ялын их багын хэмжээгээр эрэмбэлсэн нь алдаатай болсон гэж үзэж байна. Учир нь бусдын дөчин сая төгрөгийн үнэтэй хөөргийг халааснаас нь хулгайлсан хүний үйлдэл хөнгөн гэмт хэрэгт тооцогдож 5 жилийн хорих ялаар шийтгүүлэх, айлын гэрээс нэг сая төгрөгийн үнэтэй хөөрөг хулгайлсан хүний үйлдэл хүнд гэмт хэрэгт тооцогдох ба түүнд 2 жилийн хугацаагаар хорих ял оногдуулах боломжтой болсон байна. Өөрөөр хэлбэл, хөнгөн хүнд гэмт хэрэгт оногдуулах хорих ялын хэмжээг давхцуулсан /аль ч ангиллын хэрэгт 2, 3, 4, 5 жилийн хорих ял оногдуулж болохоор/ байдал нь ялыг гэмт хэргийн ангилалтай нийцүүлж тогтоохын[23] хууль зүйн ач холбогдлыг бууруулж эрүүгийн ялын бодлогоор дамжуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгод нийцээгүй байна. Өмнөх 2002 оны Эрүүгийн хуулиар хөнгөн гэмт хэрэгт хорих ял оногдуулдаггүй байсан бөгөөд хүндэвтэр гэмт хэрэгт 5 жил хүртэл, хүнд гэмт хэрэгт 5-аас дээш 10 жил, онц хүнд гэмт хэрэгт 10-аас дээш 15 жил хүртэл хорих ял оногдуулах байдлаар ялын хэмжээг давхцуулдаггүй туйлын ойлгомжтой тогтоосон байсан юм.

САНАЛ

Эрүүгийн хуулийн 2.6 дугаар зүйлд заасан гэмт хэргийн ангилалдаа нийцүүлэн Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргүүдэд оногдуулах хорих ялын хэмжээг дахин шинээр өөрчилж тогтооно гэвэл энэхүү органик хуулийн хэрэглээнд ноцтой хүндрэл чирэгдэл учрах тул 2015 онд баталсан үзэл баримтлалаар нь буюу шинжээр нь зүйлчилж хэрэглэх нь зүйтэй. Харин нийгэмд нэн түгшүүртэй, онц харгис хэрцгий аргаар үйлдэгдсэн, онц ноцтой хор уршиг учруулсан гэмт хэргийн тухай /бүх насаар нь хорих ял оногдуулж болох/ ойлголтыг Эрүүгийн хуулийн 2.6 дугаар зүйлд тусгаж өөрчлөх хэрэгтэй гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, "онц хүнд гэмт хэрэг" гэсэн ойлголтыг Эрүүгийн хуульдаа оруулж өгөх нь гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээнд тохирсон ял оногдуулдаг шударга ёсны зарчимд[24] нийцэх ач холбогдолтой юм.

Эрүүгийн эрх зүйн онолоор гэмт хэргийг нийгмийн хор аюулын шинж, хэр хэмжээгээр нь зааглан үзэж түүнд нь тохируулан ял оногдуулдаг зарчимтай тул "Онц хүнд гэмт хэрэг" гэдэг ойлголтыг Эрүүгийн хуульдаа тусгахад алдахгүй.

[23] Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. Уб., 2013 он, 74 дэх тал.

[24] Эрүүгийн хуулийн 1.3 дугар зүйл.

---o0o---

ХУУЛЬ ЗҮЙН ЭРДЭМ ШИНЖИЙН ТҮҮВЭР www.nlzr.mn

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ЗААСАН “ХУЛГАЙЛАХ” ГЭМТ ХЭРЭГТ ОНОГДУУЛАХ ЯЛ ШИЙТГЭЛИЙН ҮР НӨЛӨӨНД ТАТГАЛЗУУЛАХ ОНОЛ (DETERRENCE THEORY)-ЫН ҮҮДНЭЭС ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Сонгинохайрхан дүүргийн прокурорын газрын Хяналтын прокурор, хууль цаазын ахлах зөвлөх Д.Нямбат

Эрүүгийн хуулийн зорилго нь... хүний эрх, эрх чөлөө,...ашиг сонирхол,... аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино.

ТҮЛХҮҮР ҮГ:

Эрүүгийн хууль, хулгайлах, гэмт хэрэг, ял шийтгэл, криминологийн онол, татгалзуулах, эмээлгэх, эрүүгийн хариуцлага

УДИРТГАЛ:

Иргэд бидний эрх, эрх чөлөө, өмч хөрөнгө цаашлаад нийтийн болон үндэсний ашиг сонирхол гэмт халдлагаас хамгаалагдаж чадсан уу, бид эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдарч, сурч байгаа билүү, өнөөдрийн байдлаар Эрүүгийн хуулийн дээрх зорилго биелсэн үү, биелэх гэж байгаа юм уу, нэг бол ямар түвшинд хүрсний дараа биелсэн гэж үзэх юм, тийм шалгуур үзүүлэлт бий юү, эсвэл биелэхгүй байгаа бол яагаад гэсэн олон асуулт урган гарсаар байна.

Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн зорилго нь гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргийн гаралтыг бууруулах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм буруутай үйлдэлд тохирсон ял шийтгэл оногдуулах, нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулах, ялын бодлогоор дамжуулан гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдийн гэмт хэрэг үйлдэхээс айлган татгалзуулж урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн байх учиртай. Эрүүгийн хуулийн зорилго биелэхгүй байгаа, биелэгдэхгүй байгаа шалтгааныг “хулгайлах” гэмт хэрэг болон “татгалзуулах онол”-той холбож дараах байдлаар судаллаа.

СУДАЛГАА, ҮР ДҮН

Манай улсын хууль тогтоох байгууллагаас Монгол Улсын үнэт зүйл болсон, үнэ цэнэтэй зүйлсийг гэмт халдлагаас хамгаалахаар 209 гэмт хэргийг Эрүүгийн хуульд тусгаж өгсөн боловч хууль хэрэгжиж эхэлсэн 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш өнөөдрийг хүртэл нэг ч тохиолдол бүртгэгдээгүй гэмт хэрэг байгаа бол, “хулгайлах” гэмт хэрэг харин эсрэгээрээ хэдэн мянгаараа бүртгэгдэж байна. Нэг үгээр хэлбэл, нийт гэмт хэргийн түвшин, хөдөлгөөн нь бусдын эд хөрөнгийг “хулгайлах” гэмт хэргийн түвшингээс шууд хамааралтай байгаа нь анхаарал татаж байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Жишээ нь:

Зураг 1. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн түвшин

Графикаас харахад бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн хандлага 2008-2011 он хүртэл бага зэрэг буурч, сүүлийн жилүүдэд энэ төрлийн гэмт хэргийн гаралт өссөн үзүүлэлт харагдаж байна. Тухайлбал, хулгайлах гэмт хэргийн түвшинг өмнөх оны түвшинтэй харьцуулан үзэхэд 2012 онд 990 хэргээр буюу 18.8 хувь, 2013 онд 1621 хэргээр буюу 25.8 хувь, 2014 онд 540 хэргээр буюу 6.8 хувь, 2015 онд 745 хэргээр буюу 8.8 хувь, 2017 онд 3157 хэргээр буюу 34.8 хувиар тус тус өссөн байна.[1]

Харин шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн хэрэгжиж эхэлсэн 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2018 оны 6 дугаар сарын 1-ний өдрийн хооронд улсын хэмжээнд хулгайлах төрлийн нийт 35397 гомдол, мэдээлэл хүлээн авч, 8390 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Энэ нь 2002 оны Эрүүгийн хуулийн хэрэгжих цаг хугацаанд хулгайлах гэмт хэргийн гаралт жил ирэх бүр өсч байсан ба 2015 оны Эрүүгийн хуулийн хэрэгжих цаг хугацаанд мөн л өссөөр байгааг харуулж байна.

Олон удаагийн судалгааны ажлын үр дүнгээс “хулгайлах” гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг:

❖ хүн ам төвлөрсөн, нягтаршил ихтэй газар илүүтэй үйлдэгддэг (хулгайлах төрлийн гомдол, мэдээллийн 56.7 хувийг Улаанбаатар хотод бүртгэгддэг),

❖ хулгайлах гэмт хэрэг үйлдэж байгаа этгээдүүдийн дийлэнх нь эрхэлсэн тодорхой ажилгүй, орлогын эх үүсвэргүй байдагтай холбоотой (учирсан хохирлын 93.9 хувь нь нөхөн төлөгддөггүй),

❖ бүртгэгдэх үедээ сэжигтэн яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй (ийм байдлаар 41.320 хэрэг бүртгэгдсэн нь улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт эзэнгүй хэргийн 63.9 хувийг эзэлж байна) гэх зэргээр олон олон шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон байдаг.

Түүнээс гадна “хулгайлах” гэмт хэргийн шалтгаан нөхцөл нь хүйсийн ялгаа, гэмт хэрэг үйлдэгдэж байгаа ямар цаг хугацаанд, гаригт үйлдэгдсэн гэдгээрээ төдийлөн нөлөөлдөггүй буюу ялгагдахгүй болохыг бас тогтоосон байдаг. Жишээлбэл, улсын хэмжээнд 2017 оны 7 дугаар сарын 1-нээс 2018 оны 6 дугаар сарын хооронд 1 жилийн хугацаанд хулгайлах төрлийн гэмт хэргийн 2094 буюу 25.0 хувь нь 06-14 цагийн хооронд, 2568 буюу 30.6 хувь нь 14-19 цагийн хооронд, 1093 буюу 13.0

[1] ЦЕГ-ын Мэдээлэл нэгтгэн боловсруулах газар, Монгол Улсад 2008-2017 онд бүртгэгдсэн гэмт хэргийн статистик үзүүлэлт, Уб., 2018 он.

хувь нь 19-22 цагийн хооронд, 2635 буюу 11.7 хувь нь 22-06 цагийн хооронд үйлдэгджээ.





Зураг 2. Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг

Улсын хэмжээнд 2017 оны 7 дугаар сарын 1-нээс 2018 оны 6 дугаар сарын 30-ны хооронд 1 жил орчим хугацаанд нийт 1650 хүн хулгайлах гэмт хэрэгт холбогдон шалгагдсанаас 137 буюу 8.3 хувийг эмэгтэй хүн, 1513 буюу 91.7 хувийг эрэгтэй хүн, 199 буюу 12.1 хувийг хүүхэд эзэлж байна. Өөрөөр хэлбэл, цаг хугацаа, гариг, сар нь хулгайлах гэмт хэргийн гаралтад онцгой анхаарал татахаар нөлөөлдөггүй боловч хулгайлах гэмт хэрэг үйлдсэн 10 хүн тутмын 9 нь эрэгтэйчүүд байгаа нь бас л энэ төрлийн гэмт хэргийн уламжлалт онцлог буюу криминологийн биологийн онолоор тайлбарлагдах ойлголт юм.

Харин хулгайлах гэмт хэрэгт оногдуулж байсан одоо оногдуулж болох боломжтой эрүүгийн хариуцлагыг доорх байдлаар харьцуулж үзэж хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, үйлдэхээс татгалзуулж айлгахаар оновчтой тогтоон тэмцэж чадаж байгаа эсэхийг үзье.

ХАРЬЦУУЛАЛТ

2002 оны Эрүүгийн хуулийн145 дугаар зүйл	2015 оны Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл
145.1.Бусдын эд хөрөнгийг хулгайлсны улмаас бага бус хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.	1.Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан бол хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
145.2.Энэ гэмт хэргийг давтан бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, машин механизм, тусгайлан бэлтгэсэн багаж хэрэгсэл хэрэглэж буюу орон байр, агуулах саванд нэвтэрч үйлдсэн, энэ хэргийн улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан, олон тооны мал хулгайлсан бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	2.1.хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч; 2.2.түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлж; 2.3.ноцтой хохирол учруулж, их хэмжээний эд хөрөнгийг хулгайлж; 2.4.учрах саадыг арилгах зорилгоор зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, машин механизм ашиглаж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

хуулийн зүйн мэдээлэл, судалгаа www.pdcy.mn

145.3.Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн, эсхүл энэ хэргийн улмаас хохирогчийг амьдралын эх үүсвэрээс нь салгасан буюу их хэмжээний хохирол учирсан, түүнчлэн гамшгийг далимдуулж үйлдсэн бол эд хөрөнгийг хурааж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	3.1.байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон; 3.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
145.4.Энэ хэргийг булаах, дээрэмдэх, уулгалан довтлох гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтэн, гэмт бүлэглэл үйлдсэн, энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хурааж, арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	

Дээрх хүснэгтээс үзэхэд хуучин, шинэ Эрүүгийн хуулийн ял шийтгэлийн хувьд одооны Эрүүгийн хуулийн ялын бодлого чангарсан байна. Тодруулбал, 2002 оны Эрүүгийн хуульд бусдын эд хөрөнгийг хулгайлсан бол 3 сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэлтэй байсан бол 2015 оны Эрүүгийн хуульд бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заажээ. Өөрөөр хэлбэл, хууль тогтоогчоос ялын бодлогоор дамжуулан хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилго тавьсан боловч шинэ Эрүүгийн хуулийн зорилго биелэхгүй байгааг илтгэж байна.

Түүнээс гадна 2002 оны Эрүүгийн хуульд хулгайлах гэмт хэргийн улмаас 240.000 төгрөгийн хохирол учирсан байхыг шаарддаг байсан бол одоо 300.000 төгрөгөөс дээш хохирол учирсан байхыг шаардаж байна. Хохирлын хэмжээг өсгөж өгсөнтэй холбоотойгоор 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хулгайлах гэмт хэргийн бүртгэгдсэн тоо өссөн байх боломжгүй байна. Нэг үгээр хулгайлах гэмт хэрэг мөн гэж тооцох хохирлын хэмжээг нэмэгдүүлснээр энэ төрлийн гэмт хэргийн тоо өссөн байж болзошгүй гэсэн таамаглал үгүйсгэгдэж байна.

Жишээ нь: Эрүүгийн хуулийн сүүлийн хоёр он дамнаж хэрэгжсэн хугацаанд 35397 гомдол, мэдээлэл бүртгэгдсэн бол өнгөрсөн 7 жилийн хугацаанд дунджаар жилд 30929 гомдол, мэдээлэл бүртгэж байжээ.

Хулгайлах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүйсийн харьцаа, үйлдэгддэг цаг, өдөр, гараг гэх мэт шууд болон шууд бус хамаарал бүхий өгөгдлүүд анхаарал татахуйц өөрчлөгдөөгүй мөн нөлөөлөөгүй, хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагууд хуулиар хүлээсэн үүргээ өдөр тутам цалгардуулалгүй биелүүлсээр, орчин үеийн техник технологийн шийдэл, шинэ санааг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн тэмцсээр байгаа, эрүүгийн хариуцлагыг чангатгасан хэдий боловч “хулгайлах” гэмт хэрэг яагаад буурахгүй байна вэ?

ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

1. Ялтай байдал буюу өмнө нь шийдвэрлэсэн хэргийг сөхөж, ял шийтгэл оногдуулахдаа харгалзан үздэг байдлыг эргэж бий болгосон зохицуулалтыг хулгайлах гэмт хэргийн шинжид тусгаж өгснөөр гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдийг гэмт хэрэг үйлдэхээс айлган татгалзуулах боломжтой. Урьд ял шийтгүүлсэн этгээд ялаа эдэлж дуусанаас хойш тодорхой хугацаа өнгөрөх хүртэл гэмт хэрэг шинээр үйлдэхгүй байх нь

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.pi.gov.mn

түүнд ашигтай тул түүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс татгалзуулж чадах хүчин зүйл нь "ялтай байдал" гэдэг ойлголтыг тусгаж өгөх арга бий боловч энэ нь 2015 оны Эрүүгийн хуульд нэг төрлийн гэмт хэргийг 2 ба түүнээс дээш удаа үйлдсэн тохиолдолд гэмт хэргийг давтан үйлдсэн шинжээр нь хүндрүүлэн зүйлчлэхийг хассан шударга ёс, тэгш эрхийн зарчимтай зөрчилдөх тул УИХ-аас давтан гэмт хэрэг, ялтай байдал гэсэн ойлголтуудыг шинэ Эрүүгийн хуульд тусгаж өгөөгүй юм. Өөрөөр хэлбэл, хулгайлах гэмт хэрэгт оногдуулах хорих ялын хугацаа өмнөх Эрүүгийн хуультай харьцуулахад чангарсан боловч энэ нь гэмт этгээдэд нөлөөлөхгүй байна гэсэн үг юм.

2. Эрүүгийн хуульд хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулах зохицуулалтыг тусгаж өгөхдөө "хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахдаа гэмт хэрэг тус бүрд ял оногдуулж нэмж нэгтгэн нийт эдлэх ялын төрөл, хэмжээг тогтооно" гэж үйлдэл тус бүрд ял оногдуулж, ялыг нэмж нэгтгэж нийт эдлэх ялыг тогтоож өгнө гэж зохицуулсан. Жишээ нь: дээрэмдэх гэмт хэргийг хүч хэрэглэн хохирогчид хөнгөн гэмтэл учруулан үйлдсэнийг Эрүүгийн хуулийн 17.2 (дээрэмдэх)+11.6-1(хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах) гэж Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 2 бие даасан гэмт хэрэг гэж давхар зүйлчлэн ял оногдуулж байна. Энэ нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг заасан "эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна" гэсэн **шударга ёсны зарчимтай нийцэж байгаа боловч нэг төрлийн гэмт хэргийн хувьд** Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар "энэ хуулийн тусгай ангид заасан нэг гэмт хэргийн шинжийг хэд хэдэн удаагийн үйлдэл, эс үйлдхүйгээр хангасан байвал үргэлжилсэн нэг гэмт хэрэг үйлдсэнд тооцно" гэсэн заалтаас шалтгаалж хэрэгжихгүй байна.

Учир нь Эрүүгийн хуулийн гол агуулга болох нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулах нь шударга ёсны зарчим гэж заасан, мөн нэг гэмт хэрэгт ял оногдуулсан л бол тухайн ял шийтгүүлсэн байдлыг гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүний шинж, ялыг хүндрүүлэх нөхцөл байдал болгохгүй байх утга агуулгыг давхар илэрхийлж[2] байгаа боловч хулгайлах гэмт хэргийг 100 ба түүнээс дээш удаа үйлдсэн ч 20 жил, 10 ба түүнээс дээш удаа үйлдсэн ч 20 жил хорих ял оногдуулах нь хууль ёсонд нийцэхгүй, шударга, зөв шийдэл биш байна.

Жишээлбэл, уржигдар Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт иргэн А-ыг гэрт нэвтрэн зурагтыг нь, өчигдөр Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт иргэн Б-ийн гражаас тээврийн хэрэгслийг нь, өнөөдөр Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт иргэн С-ийн халааснаас гар утсыг нь хулгайлсан үйлдэл нь цаг хугацааны хувьд тасарсан, өөр өөр газар нутагт үйлдэгдсэн, халдлагын зүйл, хохирлын хэмжээ ялгаатай, бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нуцаар, хууль бусаар авахдаа бусдын орон байр, гражид нэвтрэн үйлдсэн учраас хүндрүүлэх шинжтэй боловч гар утасны хулгай нь нэвтрэлтгүй тул хүндрүүлэх шинжгүй, 3 тусдаа хохирогчтой зэрэг олон нөхцөл байдлаас үл хамаарч үргэлжилсэн үйлдэл гэж дүгнэн 3 гэмт хэргийг нэг гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хэргүүдийг нэг "малгай"-н дор нэгтгэж шийдвэрлэж байна. Тодруулбал, дээрх 3 үйлдэлд 2-8 жилийн хорих ял, 30 үйлдэлд ч ялгаа байхгүй 2-8 жилийн хорих ял шийтгэгдэж байна.

Тодруулж хэлбэл, Эрүүгийн хуульд нэг гэмт хэрэгт нэг ял шийтгэл гэсэн

[2] Эрүүгийн хэргийн анхан шатны шүүгч Г.Ганбаатар "Эрүүгийн хуулийн шинэчлэл "төсөл"-д зааснаар хязгаарлагдахгүй" (2018 он)http://www.judcouncil.mn/index/8155--.html

үзэл баримтлал бий болсон боловч түүнийг хэрэглэх боломжгүй байгаа нь хуулийн мөн чанарыг алдагдуулах, гэмт хэрэгтэнд ял завшуулах, хуулийн байгууллагад зохиомол ачаалал, давхардал үүсгэсэн, хохирсон иргэдийг чирэгдүүлэх, хохирсон дээр нь нэмж хохироох, гэмт хэргийн гаралт буурахгүй байх сөрөг үр дагавар дагуулж байна.

ТАТГАЛЗУУЛАХ ОНОЛ (DETERRENCE THEORY)

Криминологийн шинжлэх ухааны энэ онолыг "эрүүгийн хариуцлагаар эмээлгэх" онол ч гэж орчуулж болох юм. Энэхүү классик буюу сонгодог онолын гол агуулга нь аливаа хүн үйлдэл хийх, шийдвэр гаргах нь тухайн этгээдийн хийх нь зүйтэй юм, оновчтой юм гэж үзсэн өөрийнх нь чөлөөт сонголт юм. Хувь хүн бүгд хууль тогтоомжоос урган гарч буй боломжит аз жаргалыг хүртэх үү эсвэл зовлогоо зулгалуулах уу гэдэг эрсдэлээ тооцсоны үндсэн дээр хуулийг сахин биелүүлэх, эсвэл хууль зөрчих эсэхээ шийдвэрлэх нь тухайн хүний өөрийнх нь сонголт юм. Гэмт этгээд нь Эрүүгийн хуулийн ял шийтгэлийн хэмжээ, төрлийг дэнслэхийн зэрэгцээ баригдах эрсдэлээ бас тооцож үзэх ба хэрвээ гэмт этгээд нь хуульд заасан ял шийтгэл нь гэмт хэрэг үйлдэж ашиг хонжоо олохоос илүүтэй намайг зовоох юм байна гэж тооцвол тухайн хүн гэмт хэрэг үйлдэхгүй байх болно гэж үздэг.

Иймд Эрүүгийн хуулийн ял шийтгэлийн нэн тэргүүний зорилго бол гэмт хэрэг үйлдэхээс айлгах юм. Улмаар ял шийтгэл нь иргэдийг хууль сахин биелүүлэх сэдлийг өгч байхаас биш хууль зөрчихийг дэмжсэн байж болохгүй. 18 дугаар зууны үед сонгодог онолын гол төлөөлөгчид Чезар Беккари, Жереми Вентон нар ял шийтгэл гэмт хэрэгтээ таарсан байх ёстой гэхээс гадна хатуу ширүүн шийтгэлийг санал болгож байсан юм. Учир нь тэд ял шийтгэл нь үйлдсэн гэмт хэргээс нь илүү хатуу ширүүн байвал гэмт хэргээс олох олзноос татгалзана гэж үзсэн. Ял шийтгэл нь хэтэрхий хатуу, ширүүн байх нь шударга бус боловч ял шийтгэл нь хатуу байхгүй бол гэмт хэрэг үйлдэхээс татгалзах, айх шалтгаан болж чадахгүй гэж сургасан байдаг.[3]

ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГААС

> Хүүхэд хулгайлж, хүчиндсэн Ариел Кастро хэзээ ч тэнсэн суллагдах нөхцөлгүйгээр бүх насаараа хорих ял*+1000 жилийн ял шийтгүүллээ*[4].

АНУ-д 2009 онд залилах гэмт хэрэгт 150 жилийн, цуврал аллага үйлдсэн этгээдэд 835, 957, 1000 жилийн, Испани Улсад залилах гэмт хэрэгт 2000 жилийн, 2004 онд Израйлд 63 хүнийг тэсрэх бөмбөгөөр алсан этгээдийг 63 удаагийн бүх насаар нь / 1удаа нь 25 жилтэй тэнцэнэ/ хорих ял ба дээр нь нэмээд 5200 жилийн, 1996 онд 35 хүнийг алсан этгээдийг 35 удаагийн бүх насаар нь хорих ял дээр нь нэмээд 1035 жилийн хугацаагаар хэзээ ч тэнсэж суллахгүй, эргэлт оруулахгүй нөхцөлтэйгээр хорих ял шийтгүүлсэн олон олон жишээнээс үзэхэд энэ нь гэмт хэрэг тус бүрд ял оногдуулж түүнийгээ нэмэх хэлбэрээр хүний амьд байх боломжтой биологийн насны хязгаараас хэтэрсэн хугацаагаар ял шийтгэх хэлбэр юм. Яагаад гэвэл түүний үйлдсэн гэмт хэрэг бүрийн ард хохирсон иргэд, гэр бүл нь бий. Энэ нь тэдний эрх ашгийг хохирогч нэг бүрээр хангаж, улмаар цаашдын аюулгүй байдлыг нь хамгаалж байгаа нэг хувилбар юм.

Олон жилийн хугацаагаар хорих ял оногдуулж байгаа бас нэг шалтгаан нь дэлхийн олон оронд эрүүгийн хариуцлагаар эмээлгэх онолын судалгаа олноор хийгдэж үр дүн нь батлагдсан байдагтай холбоотой. Жишээлбэл, судалгаагаар 6-12 сарын хугацаатай хорих ял шийтгэгдсэн этгээд нь 2-4 жилийн хугацаагаар хорих ял

[3] Ronald L. Akers, Christine S.Sellers, Wesley G.Jennings (2017), Criminology Theory номын 14-16 хуудас

[4] BBC-ийн мэдээ: Яагаад хорих ял ийм удаан хугацаатай байдаг вэ? https://www.bbc.com/news/blogs-magazine-monitor-23495284

шийтгүүлсэн этгээдээс илүүтэйгээр суллагдаж гарч ирснийхээ дараа дахин гэмт хэрэг үйлддэг гэдгийг тогтоосон байна. Өөрөөр хэлбэл, хорих ялын хугацаа ихсэх тусам дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэл буурч байдаг гэсэн үг юм[5]. Манай улсад энэ төрлийн судалгаа хийгдээгүй боловч хууль сахиулах байгууллагын зарим практик ажилтнууд дээрх судалгааны үр дүнг хүлээн зөвшөөрч, улмаар үнэн эсэх тухай таамаглал дэвшүүлж судалгааны ажлыг эхлүүлэх шаардлагатай байгаа.

ДҮГНЭЛТ

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 209 гэмт хэргийн зөвхөн 1 гэмт хэрэг нь 2015 оны Эрүүгийн хуулийн зорилго биелэхгүй байх шалтгаан, нөхцөл нь болж байгаа манай улсын хувьд хулгайлах гэмт хэрэгт оногдуулах ялын нийт нийлбэр буюу дээд хэмжээг хязгаарлан тогтоохгүй байх, улмаар ялын нийт нийлбэр хэмжээг ямар хугацааны дараа хэрхэн бууруулах үндэслэл, журмыг нарийвчлан зохицуулах шаардлагатай байна. Дээрх жишээнээс үзэхэд хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээд 3 үйлдэл тус бүртээ 2-8 жилийн хорих ял шийтгүүлж, түүнийг нь нэгтгэснээр 6-24 жилийн хугацаагаар хорих ял шийтгэгдэх юм. Хэдийгээр олон жилийн хугацаагаар хорих ял шийтгэх боловч тухайн хүний нийгэмд аюулгүй болсон, дахин хулгай хийх, хүн алах хүч тамиргүй болох хүртэлх буюу 25-40 жилийн дараа, дэлхийн жишгээр 20, 50, 75, 80 хувийн ялаа эдэлж дуусаны дараа суллах боломжтойгоор хуулийн зохицуулалтыг бий болгох юм[6].

Хулгайлах гэмт хэргийг бууруулах, түүнтэй тэмцэх, иргэдийнхээ өмчлөх эрхийг хамгаалах бас нэг хувилбар бол хулгайлах гэмт хэргийг өөр цаг хугацаанд, өөр газар нутаг, объектод халдаж үйлдсэн үйлдлүүдийг үргэлжилсэн нэг гэмт хэрэгт тооцохгүй, харин тус тусдаа нь бие даасан гэмт хэрэг юм гэсэн зохицуулалтыг Эрүүгийн хуульд тусгах эсвэл "үргэлжилсэн" гэмт хэрэг гэсэн ойлголтыг хасч улмаар Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар "шүүх хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахдаа гэмт хэрэг тус бүрд ял оногдуулж нэмж нэгтгэн нийт эдлэх ялын төрөл, хэмжээг тогтооно", 6.8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "хэд хэдэн бүлэгт заасан гэмт хэрэгт оногдуулсан ялыг нэмж нэгтгэсэн нийт хэмжээ нь хамгийн хүнд ялтай бүлгийн хорих ялын дээд хэмжээнээс хэтэрч болохгүй"[7] гэж үйлдэл тус бүрт нь ял оногдуулах талаар тодорхой заасныг удирдлага болгон хэрэгжүүлэх боломжтой байна.

2015 оны Эрүүгийн хууль нь криминологийн шинжлэх ухааны сонгодог онол тэр дундаа ял шийтгэл тодорхой, хатуу, түргэн шуурхай байх, нийгэмд хэр хэмжээний хохирол учруулж, олон нийтийг түгшээсэн тэр хэмжээгээрээ ял шийтгэлийн тун нь таарч байх тухай сургадаг эрүүгийн хариуцлагаар эмээлгэх онол /deterrence theory/-ын суурь ухагдахууныг үндэслэн "хулгайлах" гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх, түүний гаралтыг бууруулах, урьдчилан сэргийлэх, иргэдийнхээ өмчлөх эрхийг хамгаалахын тулд ял шийтгэлийг чангатгасан нь онолын хувьд үндэслэлтэй байсан боловч хулгайлах гэмт хэргийг хэд хэдэн удаагийн үйлдлээр үйлдсэн бол үйлдэл тус бүрт нь хорих ял оногдуулж нэмж нэгтгэх зохицуулалт байхгүй улмаас онолд суурилсан бодлого хэрэгжихгүй байгаа нь "хулгайлах" гэмт хэргийн гаралтыг өсгөсөн байх боломжтой байна.

[5] Урт хугацааны туршид хорих ял оногдуулах нь илүү үр дүнтэй байгааг шинэ судалгаагаар тогтоов. https://www.mirror.co.uk/news/uk-news/longer-prison-sentences-are-more-effective-127826

[6] Яагаад шүүгч нар бүх насаар нь хорих ял оноосон мөртлөө дээр нь нэмж 1000 жилийн хорих ял нэмэгдүүлж оноож байна вэ? https://www.quora.com/Why-do-judges-sometimes-add-plus-1000-years-on-a-life-sentence

[7] 2015 оны Монгол Улсын Эрүүгийн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2016 оны 7 дахь дугаар.

---o0o---

ГЭМТ ХЭРГИЙГ ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААНЫ АСУУДЛЫГ ХҮНИЙ ЭРХИЙН ҮҮДНЭЭС АВЧ ҮЗЭХ НЬ

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ахлах ажилтан Г.Халиунаа

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан Б.Ариунжаргал

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

ТҮЛХҮҮР ҮГ:

Эрүүгийн хууль, гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа, хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээ, хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээ

ТОВЧЛОЛ:

Энэхүү өгүүллээр “гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа”-г Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад хэрхэн тусгасан, уг зохицуулалтыг хэрэгжүүлэх явцад учирч буй хүндрэлтэй асуудлыг тодорхойлох, хуулийн зохицуулалт хүний эрхэд хэрхэн нөлөөлж буйг судлан, хуулийг цаашид боловсронгуй болгох талаар санал дэвшүүлэхийг зорив.

УДИРТГАЛ:

Эрүүгийн хууль хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилготой хууль юм. Энэ ч утгаараа эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал нь хүний эрхийг хамгийн ихээр хязгаарладаг хариуцлагын хэлбэр билээ. Хүн бүр тэгш эрхтэй ч эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэн хуулийн дагуу хариуцлага хүлээж буй этгээдийн эрхийг хуулиар хязгаарлах нь зүйн хэрэг. Нөгөөтэгүүр хүний эрх, эрх чөлөөг хамгийн ихээр хязгаарладаг Эрүүгийн хууль нь эрх зүйн хэм хэмжээний хийдэлтэй байвал энэ нь эргээд нийгэмд сөрөг үр дагаврыг бий болгож, хүний эрхийг хязгаарлах гол хэрэглүүр болж хувирахыг ч үгүйсгэх аргагүй юм.

Хууль бол шударга ёсыг тогтоох хэрэгсэл гэтэл эсрэгээрээ шударга бус зүйлийг бий болгох эх уурхай болж болохгүй гэдгийг санах нь зүйтэй.

Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний суурь эрх, халдашгүй байдлыг илүү баталгаажуулсан, олон улсын нийтийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцсэн урт хугацаанд тогтвортой

үйлчлэх хуулийг батлан гаргах зүй ёсны шаардлага бий болж[1] улмаар Улсын Их Хурлаас Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр баталж, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх болсон билээ.

Уг хуульд эрх зүйн шинэ орчин нөхцөлийг бүрдүүлэн, хуучин хуулийн эрх зүйн хэм хэмжээний хийдлийг арилгахад чиглэгдсэн олон зүйл, заалтууд шинээр тусгагдсан хэдий ч зарим зүйл, заалтуудын хувьд хүний эрхийг зөрчин, хэрхэн хэрэглэх нь эргэлзээтэй байдлыг үүсгэсээр байна. Эдгээр тулгамдсан асуудлыг тоймлон авч үзвэл 1/ Хөөн хэлэлцэх хугацаа тооцох зохицуулалт; 2/ Гэм буруугийн хэлбэр; 3/ Гэмт үйлдлийн улмаас учирсан гэм хор, хохирол, хор уршгийг тогтоох зохицуулалт; 4/ Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулах, уг ялыг хорих ялаар солих зохицуулалт; 5/ Эрх зүйн байдлыг дордуулсан зохицуулалт зэрэг болно. Энэхүү сэдвийн хүрээнд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолох зохицуулалтын эргэлзээтэй асуудлыг тусгайлан авч үзэв.

ҮНДСЭН ХЭСЭГ

2002 оны Эрүүгийн хуулиар гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн ангиллаас /хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд/ нь хамааруулан тоолдог байсныг 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар өөрчлөн ялын доод болон ялын дээд хэмжээнээс хамааруулан ялгамжтай байдлаар тоолохоор зохицуулсан нь эрх зүйн шинэчлэлийн хүрээнд нэлээдгүй ахиц дэвшлийг авчирсан нь сайшаалтай хэдий ч зарим гэмт хэргүүд дээр гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь ойлгомжгүй байдлаар хуульчлагджээ.

Шинэ батлагдсан Эрүүгийн хуульд 209 төрлийн гэмт хэрэг хуульчлагдсанаас 83 төрлийн[2] гэмт хэрэг дээр гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь эргэлзээтэй, ойлгомжгүй байдлыг үүсгээд байна.

Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд "Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа"-г хуульчлан өгсөн. Тодруулбал,

Хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт[3] "Гэмт хэрэг үйлдсэнээс хойш дараах хугацаа өнгөрсөн нь тогтоогдвол яллагдагчаар татаж болохгүй:

1.1.энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн;

1.2.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн" гэж хуульчилснаас үзвэл, энэхүү зохицуулалт нь эрх зүйн хэм хэмжээний хийдлийг бий болгосон хэмээн үзэж болохоор байна.

Эрүүгийн хуульд хорих, зорчих эрхийг хязгаарлах, торгох, эрх хасах, нийтэд тустай ажил хийлгэх гэсэн 5 төрлийн ялыг оногдуулахаар тусгаснаас эрх хасах ял нь нэмэгдэл ял бусад нь үндсэн ял.[4] Гэтэл хууль тогтоогч хорих болон зорчих эрхийг хязгаарлах гэсэн 2 төрлийн ялтай гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тоолохоор хуульчлан өгчээ.

Практикт хамгийн түгээмэл гардаг "Хулгайлах" гэмт хэрэг буюу Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн зорчих эрхийг хязгаарлах болон хорих

[1] Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлал, Хууль зүйн яам, Уб., 2013 он.

[2] Дэлгэрэнгүйг тус өгүүллийн асуудал 1 болон 3 дахь хэсгээс үзнэ үү.

[3] Төрийн мэдээлэл эмхэтгэл, (2016), №7

[4] Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 5.2 дугаар зүйлд ялын төрлийг хуульчилсан.

ялын доод хэмжээ нь 6 сар, ялын дээд хэмжээ нь 5 жил. Прокурор тухайн гэмт хэрэг үйлдсэн этгээдийн үйлдэлд 1 жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулах саналтай тохиолдолд 5 жилийн хугацаагаар гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тоолно. Харин гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай ч түүнд ашигтай байдлаар гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг 1 жилээр яагаад тоолж болохгүй гэж хэмээн гомдол гаргах боломжтой. Тэгвэл дээрх тохиолдолд хэнийх нь зөв бэ?

Энэ асуулт нь зангилаатсан утас шиг тайлагдахад бэрх хариултыг өөртөө агуулж байна.

Энэ мэтчилэн эргэлзээтэй, хийдэлтэй зохицуулалтын улмаас хүний эрхийг ноцтойгоор зөрчих нь хуулийн зорилго, ач холбогдлыг алдагдуулж буй явдал юм. Иймд дараах асуудлыг сэдвийн хүрээнд дэвшүүлж байна.

Асуудал 1.

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан дараах хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялтай гэмт хэргүүдийн хувьд ялын хэмжээгээр хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох вэ? гэсэн асуудал урган гарч ирж байна. Үүнд:

Д/д	Зүйл, заалт	Ялын доод хэмжээ	Ялын дээд хэмжээ
1.	10.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
2.	11.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
3.	11.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
4.	11.4 дүгээр зүйлийн 2.3 дахь заалт	6 сар	3 жил
5.	11.7 дугаар зүйлийн 2.3 дахь заалт	6 сар	2 жил
6.	12.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил
7.	12.5 дугаар зүйлийн 2.2 дахь заалт	6 сар	3 жил
8.	13.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил
9.	**13.5 дугаар зүйлийн 2.2 дахь заалт**	**3 сар**	**2 жил**
10.	14.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	2 жил
11.	15.1 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	3 жил
12.	17.1 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	**5 жил**
13.	17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	**5 жил**
14.	17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
15.	17.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
16.	17.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	2 жил
17.	17.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	2 жил
18.	17.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	**5 жил**
19.	18.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
20.	18.4 дүгээр зүйлийн 2.2 дахь заалт	6 сар	3 жил
21.	18.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил
22.	18.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил
23.	18.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
24.	18.16 дугаар зүйлийн 2.2 дахь заалт	6 сар	3 жил
25.	19.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
26.	19.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
27.	19.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил
28.	19.15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
29.	19.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	3 жил
30.	19.16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
31.	19.17 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил
32.	20.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
33.	21.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил
34.	21.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	3 жил
35.	21.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
36.	22.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил

Хуль зүйн яамны мэдээлэл www.nlo.gov.mn

37.	22.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг	6 сар	3 жил
38.	22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
39.	22.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
40.	22.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
41.	22.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
42.	23.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
43.	23.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	3 жил
44.	23.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
45.	23.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	2 жил
46.	25.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	6 сар	3 жил
47.	25.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
48.	25.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
49.	25.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	3 жил
50.	26.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил
51.	27.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил
52.	27.10 дугаар зүйлийн 2.4 дэх заалт	6 сар	3 жил
53.	28.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	6 сар	2 жил

Дээрх хүснэгтээс харвал хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээ нь 3 сараас эхлэх бөгөөд харин ялын дээд хэмжээ нь 5 жил хүртэл байна. Гэтэл хуульд тусгаснаар хорих ялын доод хэмжээ нь 1 жил, дээд хэмжээг нь 8 жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг 5 жил байхаар хуульчилсан боловч дээрх гэмт хэргүүдийн хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээ **3 сараас** эхэлж байгаа нь Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.2 дахь заалт нь хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээ болох 1 жилд хүрэхгүй байна. Өөрөөр хэлбэл, хорих ялын доод хэмжээ нь 1 жил хүрэхгүй байгаа учраас энэхүү заалтаар хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь ойлгомжгүй байна.

Мөн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.1 дэх заалтад зааснаар хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээг 1 жил түүнээс бага хугацаагаар тогтоосон хэлэлцэх хугацааг 1 жил байхаар тогтоосон. Гэтэл зарим гэмт хэргийн хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээ 3 эсхүл 6 сараас эхэлж байгаа ч ялын дээд хэмжээ нь 5 хүртэл жил байгаа нь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг 1 болон 5 жилийн аль хугацаагаар тоолох нь эргэлзээтэй байдлыг бий болгож байгаа юм.

Жишээ нь, Иргэн “С” нь Эрүүгийн хуулийн 11.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах” гэмт хэргийг 2017 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр үйлдсэн. Энэхүү гэмт хэргийн хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээ 6 сар харин дээд хэмжээ нь 3 жил. Тэгвэл гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох вэ? гэсэн асуудал гарч байна.

Хувилбар 1. Хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээ 6 сар учир Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.1 дэх заалтад зааснаар гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг 1 жилээр тоолно.

Хувилбар 2. Хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээ 3 жил учир Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.2 дахь заалтад зааснаар гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг 5 жилээр тоолно. Гэсэн 2 үзүүртэй утас шиг хариултыг бий болгож байна.

Гэтэл дээрх хоёр хувилбарын алийг нь ч сонгон хэрэглэж болохгүй байдал бий болж байна. Эрүүгийн хуулийг бусад хуулиас ялгаатай нь хууль ёсны зарчим буюу “Эрүүгийн хуулийн төсөөтэй хэрэглэж болохгүй”. Өөрөөр хэлбэл, “А” биш бол “Б” байж болох юм гэсэн үг биш. “А” бол “А”, “Б” бол “Б” л байх ёстой.

Хуульчдын нэгдсэн сүлжээ www.nlsc.mn

Ийнхүү иргэн “С”-ийн үйлдсэн гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь эргэлзээтэй байснаар “С”-ийн эрх зөрчигдөхөөр байна.

Түүнчлэн, Эрүүгийн хуулийн **13.5 дугаар зүйлийн 2.2** дахь заалтад оногдуулах хорих ялын доод хэмжээг 3 сар байхаар хуульчилж өгсөн байгаа нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар “... 6 сараас 20 жил хүртэл хугацаагаар .... хорих ялыг эдлүүлнэ” гэж заасантай зөрчилдөж байгаа юм. Өөрөөр хэлбэл, 13.5 дугаар зүйлийн 2.2 дахь заалт нь алдаатай заалт болж байна.

Асуудал 2.

Эрүүгийн хуульд зааснаар хорих ялгүй, харин зорчих эрхийг хязгаарлах ялтай нийт 48 хэрэг байгаагаас хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь эргэлзээтэй нэг хэрэг байгаа нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 15.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг юм.

Зорчих эрхийг хязгаарлах ял нь 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөгдөхөөр “түдгэлзүүлсэн”[5] байх тул хорихоос бусад сонгох ялтай гэмт хэргийн хувьд мөн гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхгүй болох нь. Тэгвэл хорих ялгүй, зорчих эрхийг хязгаарлах ялтай дээрх хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох вэ? гэдэг нь бас нэг том асуудал.

Асуудал 3.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Энэ хуульд бүх насаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг, хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй” хэмээн хуульчилж өгсөн. Хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй гэмт хэргүүд:

1. 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг;
2. 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг;
3. 12.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг;
4. 13.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг,
5. 19.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг;
6. 19.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг;
7. 19.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг;
8. 19.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг;
9. 19.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг;
10. 29.1 дүгээр бүлгийн гэмт хэргүүд.

Нийт 5 бүлгийн 19 гэмт хэрэгт гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй. Үүнээс 14 гэмт хэрэг нь бүх насаар нь хорих ял оногдуулахаар заасан, 5 гэмт хэрэг нь бүх насаар хорих ял оногдуулахаар заагаагүй ч 29 дүгээр бүлэгт заасан гэмт хэрэг учраас хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй байхаар хуульчилж өгсөн байна.

Дээрхээс дүгнэхэд, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 1.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас бусад гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохоор байна. Тэгвэл зөвхөн торгох ял оногдуулахаар хуульчилсан заалтуудад хэрхэн хөөн хэлэлцэх хугацааг тоолох нь мөн л тодорхойгүй. Хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох талаар хуулийн зохицуулалт байхгүй гэмт хэргүүд:

1. 18.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг;
2. 18.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг;
3. 18.5 дугаар зүйлийн 5 дахь хэсэгI;
4. 18.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэг;
5. 18.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг;
6. 18.8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг;
7. 18.9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг;
8. 18.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг;
9. 18.13 дугаар зүйлийн 4 дэх хэсэг;
10. 20.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг;
11. 20.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг;
12. 20.11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг;
13. 20.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг;
14. 20.12 дугаар зүйлийн 3 дахь хэсэг;
15. 20.12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг;
16. 20.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг;
17. 20.14 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг;
18. 20.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг;
19. 22.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг;

[5] Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль https://www.legalinfo.mn/law/details/11950

20. 24.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг;
21. 24.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг;
22. 24.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг;
23. 24.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэг;
24. 24.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг;
25. 24.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг;
26. 24.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг;
27. 24.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг;
28. 24.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг;
29. 25.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг;
30. 25.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг.

Дээрхээс дүгнэхэд, Эрүүгийн хуулийн 6 бүлгийн 28 зүйл, заалтад зөвхөн торгох ял оногдуулахаар заасан байна. Харин хөөн хэлэлцэх хугацааг зөвхөн хорих болон зорчих эрхийг хязгаарлах зохицуулалт бүхий гэмт хэрэгт тоолж болохоор хуульчилж өгсөн учир торгох ял[6] оногдуулахаар заасан хэргүүдэд хэрхэн хөөн хэлэлцэх хугацааг тоолох нь ойлгомжгүй үлджээ.

Асуудал 4.

Зөрчлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт "Хөөн хэлэлцэх хугацааг зөрчил үйлдсэн өдрөөс эхлэн зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэх өдрийг хүртэл тоолно." гэж[7] заасан атал Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт " хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно"[8] гэж заасан нь өөр хоорондоо зөрүүтэй байна.

Эрүүгийн хуульд заасан дээрх зохицуулалтаас Зөрчлийн тухай хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалт нь илүү гэмт /зөрчил/ хэрэг үйлдсэн хүний эрх зүйн байдлыг чангатгасан гэж үзэж болохоор байна.

Өөрөөр хэлбэл, Зөрчлийн тухай хуульд зааснаар хөөн хэлэлцэх хугацааг зөрчил үйлдсэн өдрөөс эхлэн зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэх өдрийг хүртэл харин Эрүүгийн хуулиар "... хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн хүчин төгөлдөр болох хүртэл" ялгамжтай байдлаар тоолж байгаа нь хууль хоорондын уялдаа холбоог алдагдуулж байна.

Түүнчлэн, Эрүүгийн хууль нь хүний эрхийг хамгийн ихээр хязгаарладаг хууль болохынхоо хувьд Зөрчлийн тухай хуулиас илүү өндөр санкцтай ялын бодлогын хувьд ч илүү чанга байдаг. Гэтэл зөрчлийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт хэлэлцэх хугацааны зохицуулалтаас илүү хатуу байгаа нь хэр зохистой вэ? Уялдаа холбоо бүхий хуулиудын хоорондын ойлголт өөр хоорондоо зөрүүтэй байх нь зөв үү? гэх мэт олон асуултыг ар араасаа дагуулж байна.

Жишээ 1. "А" нь 2017 оны 7 дугаар сард БНСУ-д очиж ажиллахаар виз хөөцөлдөж эхэлсэн бөгөөд түүний танил "Р" нь түүнд 6 сарын хугацаанд БНСУ-ын виз найдвартай гаргаж өгнө. Үүний тулд 10 сая төгрөг бэлнээр өгөх хэрэгтэй хэмээн хэлж улмаар холбоо барилгүй алга болсон байна. Ийнхүү "А" цагдаагийн байгууллага энэ үйл явдал болсноос 10 сарын дараа хандаж, гомдол гаргасан байна. Улмаар "Р"-ийг гомдол гаргаснаас 14 хоногийн дараа олж илрүүлэн мэдүүлэг авч, нотлох баримтыг цуглуулж эхэлсэн бөгөөд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дуусахаас өмнө прокурор яллах дүгнэлт үйлдэн шүүх рүү шилжүүлсэн. Шүүх хуралдаан болоход

[6] Зөвхөн торгох ялтай гэмт хэргүүдийн хувьд 10.000-80.000, 20.000-100.000, 20.000-120.000, 40.000-200.000, 120.000-400.000, 200.000-400.000 нэгжтэй тэнцэх хэмжээгээр торгох ял оногдуулахаар хуульчилсан байна.

[7] Зөрчил үйлдсэнээс хойш, хуулиар тухайн зөрчилд оногдуулах шийтгэлийн төрөл, хэмжээнээс хамааран тодорхой хугацаа өнгөрсөн тохиолдолд зөрчлийг шалгаж шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй байхаар хууль тогтоогчоос тогтоож өгсөн зохицуулалт юм.

[8] 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр батлагдсан Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэх өдрийг хүртэл тоолно. Гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлснээр хөөн хэлэлцэх хугацааг тоолохыг зогсооно." гэж хуульчилсан байсныг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан.

шүүгдэгчийн өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хөдөө орон нутагт явна гэх үндэслэлээр шүүх хуралдаан хойшилсон бөгөөд 2018 оны 8 дугаар сарын 8-ны өдөр шүүх хуралдаан болж, “Р”-ийн үйлдсэн гэмт хэргийн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна.

Энэ тохиолдолд Эрүүгийн хуульд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг “... гэмт хэрэг үйлдсэн өдрөөс анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно” гэж заасан учир прокурор хэлэлцэх хугацаа дуусахаас өмнө шүүх рүү яллах дүгнэлт үйлдэн шилжүүлсэн хэдий ч анхан шатны шүүх хуралдаан болохоос өмнө гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан учир шүүх хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэх үндэслэл болж байна.

Жишээ 2. Иргэн “С” нь 2017 оны 8 дугаар сарын 5-ны өдөр Өргөө 2 кинотеатраас гарч явахдаа I phone 6 маркийн гар утсаа алдсан бөгөөд цагдаагийн байгууллагад гомдол гарган эд зүйлийн үнэлгээ хийлгэхэд 290.000 төгрөгөөр үнэлэгдсэн бөгөөд хулгай хийсэн “Х”-г 2018 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр цагдаагийн ахмад “А” олж илрүүлсэн. Ийнхүү Зөрчлийн тухай хуулийн 8.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу 2018 оны 2 дугаар сарын 20-ний өдөр шүүх хэргийг хянан хэлэлцээд “Х”-д 14 хоног баривчлах шийтгэл оногдуулсан байна.

Энэ тохиолдолд зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаа анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох үед дууссан байсан хэдий ч зөрчлийн хөөн хэлэлцэх хугацааг тус хуульд зааснаар зөрчил үйлдсэн өдрөөс зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэх өдрийг хүртэл тоолж байгаа учир зөрчил үйлдсэн “Х”-д шийтгэл оногдуулах боломжтой байна.

Дээрх хоёр жишээнээс харвал, хөөн хэлэлцэх хугацаа тоолох асуудал Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуульд эрс ялгаатай байдлаар зохицуулагджээ. Гэтэл анх 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр батлагдсан Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэх өдрийг хүртэл тоолно. Гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлснээр хөөн хэлэлцэх хугацааг тоолохыг зогсооно” гэж одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Зөрчлийн тухай хуулийн хөөн хэлэлцэх хугацаа тоолох зохицуулалттай адил байдлаар хуульчилсан байсныг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан юм.

Иймд дээрх асуудлыг дахин судлан үзэж Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулийн хөөн хэлэлцэх хугацаа тоолох асуудлыг нэг мөр болгон шийдвэрлэх нь зүйтэй.

ДҮГНЭЛТ

Одоо мөрдөгдөж буй Эрүүгийн хуульд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны асуудал төдийгүй өөр бусад хэд хэдэн эрх зүйн хэм хэмжээний хийдэлтэй зохицуулалтууд байгааг хэлэх нь зүйтэй. Эрүүгийн хуульд заасан эрх зүйн хэмжээний хийдэлтэй, хүний эрхийг хамгийн ихээр зөрчих заалт нь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны асуудал хэмээн үзэж байна. Тиймдээ ч бусад эрх зүйн хэм хэмжээний хийдэлтэй зохицуулалтаас гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг сонгон авч судалсан болно.

Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны тухайд зөвхөн торгох ялтай буюу хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг яаж тоолох нь орхигдсон нь нэлээд том алдаа болсноос гадна гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно гэсэн зохицуулалт нь Зөрчлийн тухай хуульд тусгасан зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаанаас харьцангуй сул

хуулийн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

зохицуулалт болсон гэж үзэж болохоор байна.

Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. Гэтэл гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох асуудал нь дээр дурдсанчлан эргэлзээтэй байдлыг бий болгож байгаа тохиолдолд хуулийг буруу хэрэглэх нөхцөл үүсч болзошгүй юм. Иймд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны талаарх Эрүүгийн хууль дахь зохицуулалтыг боловсронгуй болгон, зөв гольдролд нь оруулах нь зүйтэй.

Өөрөөр хэлбэл Эрүүгийн хуулийн энэхүү асуудал практикт ихээхэн маргаан дагуулж, хүний эрхийг ноцтойгоор зөрчих аюулын харанга дэлдэж байхад тул үүнээс урьдчилан сэргийлэхийн тулд Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны талаарх зохицуулалтыг өөрчлөн, найруулах шаардлагатай.

САНАЛ

Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны талаарх хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгосноор хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх нөхцөл бололцоо бүрдэнэ. Үүний тулд:

1. Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанараас хамааруулан хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын тухайд ялгамжтайгаар нарийвчлан зохицуулах.[9]

2. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.5 дугаар зүйлийн 2.2 дахь заалтад заасан хорих ялын доод хэмжээ 3 сар гэснийг өөрчлөх.

3. Торгох ял оногдуулахаар заасан хэргүүдэд ялын хэмжээнээс хамааруулан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолдог байхаар хуульчлах. Өөрөөр хэлбэл, өмнө дурдсан зөвхөн торгох ял оногдуулахаар хуульчилсан хуулийн заалтуудад торгох ялын доод хэмжээг 10.000, ялын дээд хэмжээг 400.000 нэгж хүртэл байхаар хуульчилсан байх тул гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг торгох ялын хэмжээнээс хамааруулан ялгамжтай тоолохоор хуульчлах.

4. Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх хугацаа түр хойшилсонтой холбогдуулан тус хугацаанд тухайн гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хорих ялын хөөн хэлэлцэх хугацаатай ижил тоолох уу? ялгаатай тоолох уу? гэдгийг нэг мөр болгох.

5. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тоолох зохицуулалтыг Зөрчлийн тухай хуулийн холбогдох зохицуулалттай уялдуулах шаардлагатай.

[9] 2015 онд өргөн баригдсан хуулийн төслийн хувьд гэмт хэргийн ялын доод хэмжээг тогтоолгүйгээр дээд хэмжээнээс хамааруулан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тоолохоор бичигдэж байсан нь эрх зүйн хэм хэмжээний хийдлийг арилгах нэг гарц байсан гэж үзэж болно.

---o0o---

Хүний эрхийн үндэсний комисс www.nhrc.mn

МОНГОЛ УЛСАД СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООГ ТОДОРХОЙЛОХ ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ

МУИС–ийн Хууль зүйн сургуулийн докторант, С.Номынбаясгалан

I. ОРШИЛ

II. Сонгуулийн тогтолцоог хууль зүйн үүднээс тодорхойлох боломж

А. Монгол Улсын Үндсэн хуулиар сонгуулийн тогтолцооны эрх зүйн үндэс тавьсан нь

Б. Монгол Улсын Үндсэн хуульд сонгуулийн эрх зүйн зарчмын үндсийг тодорхойлсон нь. Түүнд харгалзсан Монгол Улсын олон улсын гэрээний заалтын түүвэр

В. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт сонгуулийн тогтолцоог тодорхойлох урьдач нөхцөл болсон нь

III. Дүгнэлт, санал

ТОВЧЛОЛ:

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлд "Улсын Их Хурал нэг танхимтай, далан зургаан гишүүнтэй. Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно. Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно" хэмээн зохицуулжээ. Монгол Улсын Үндсэн хууль судлалын гол судлагдахууны нэг нь сонгуулийн асуудал бөгөөд энэ нь үндсэн хуулийн эрх зүйн цөм хэсэг. Энэ өгүүллийн сэдвийг сонгуулийн тогтолцоог тодорхойлох эрх зүйн асуудал хэмээн томьёолж, агуулгыг тодорхой үндсэн хуулийн маргаанаар хязгаарлав. Тиймээс энэ асуудлын учир холбогдол, чухлыг үндсэн хуулийн маргааны үүднээс хөндөн, дурдсан маргаан дээр үндэслэн "сонгуулийн тогтолцоо" гэж юу болох, түүний агуулгад юу хамаарах, хэрхэн тодорхойлох вэ, сонгуулийн тогтолцоо нь сонгуулийн зарчимд үндэслэгдсэн болохыг тодруулахад өгүүллийн зорилго оршино.

УДИРТГАЛ:

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц агуулга, ач холбогдлын хувьд үндсэн хуулийн суурь үзэл баримтлал, иргэний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан олон чухал шийдвэрүүд гаргасан боловч, түүний зарим шийдвэрийн үндэслэл, тайлбар нь үндсэн хуулийн нөөц, боломжийг хязгаарлан цаашид үндсэн хуулийн эрх зүйг хөгжүүлэхэд бэрхшээл үүсгэх нөхцөлийг бий болгож байна.[1] Түүнчлэн Үндсэн хуулийн цэц олон улсын хүний эрхийн эрх зүй болон ардчилсан бусад улсуудын сайн туршлага, *тогтсон ойлголтод*

[1] Бямбажаргал Б., Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ: Органик хууль ба түүнийг тогтоох эрх зүйн боломж // Analysis of the constitutional tsets decision: Organic act and chance to legislate organic act, Эрх зүй сэтгүүл, Уб., 2017, №4, (40), 170 дахь тал.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.pli.gov.mn

үл нийцсэн байдлаар зарим үндсэн эрх, эрх чөлөөг гуйвуулан тайлбарлаж байсан.[2] Үүний нэг тодорхой тохиолдол (Constitutional case/disputes) нь энэхүү өгүүллийн хүрээнд хөндөж байгаа Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 4 дүгээр сарын 22–ны өдрийн 05 дугаар дүгнэлт (МУҮХЦ, дүгнэлт №05/2016.04.22.) юм.[3]

Угтаа бол "Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр нь үндсэн хуулийн эрх зүйн харилцааны хууль зүйн фактыг үүсгэх, өөрчлөх, дуусгавар болгоход зохих нөлөө үзүүлдэг" онцлогийг[4] нь харгалзан үндсэн хууль дахь сонгуулийн үндсэн зарчмуудыг нэгбүрчлэн үзэх биш, нэр дурдах төдий байдлаар өгүүлэлд гаргалаа. Учир нь сонгууль явуулж байгаагийн философи утга нь Засгийн газрыг байгуулахад бэрхшээлгүй байх, намын лидерүүдийн санаа зоригийн давамгайллыг хязгаарлах зэргээс илүүд авч үзэх зүйл – сонгогч олон түмний санаа зоригийн илэрхийллийг илүү тусгасныг сонгох явдал мөн. Үүгээр сонгуулийн шударга чанарыг хэмжиж болох юм.[5] Тийм ч учраас ихэнх арчилсан улс орнуудад хувь тэнцүүлсэн төлөөллийн тогтолцоог (*"ялагч бүгдийг авдаг" тогтолцооноос "хувь тэнцүүлж төрд иргэдийн төлөөллийг бүрдүүлдэг" тогтолцоо илүү шударга* хэмээн үздэг) түгээмэл хэрэглэж байгаа нь санаандгүй хэрэг биш бололтой.[6] Иймд Үндсэн хуулийг улс төрийн агуулгын үүднээс бус, хууль зүйн агуулга болох Үндсэн хууль өөрөөс нь урган гарч нөхцөлдсөн, түүнийг бүрдүүлэгч бусад хуульд холбогдох хэм хэмжээ[7] бүхий судлагдахууны үүднээс авч үзлээ.

Энэхүү өгүүлэл нь эрдэм шинжилгээний суурь судалгааны дүгнэлт, санал биш. Онол, танин мэдэхүйн асуудлыг ч гол болгоогүй. Харин Монгол Улсын Үндсэн хуулийн[8] Хорин нэгдүгээр зүйлд "Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно" гэж заасан. Энд заасан үндэслэлийн дагуу Улсын Их Хурлын, Ерөнхийлөгчийн, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тус тусын сонгуулийн тухай хуулиар,[9] эсвэл Сонгуулийн тухай хуулиар[10] бэхжүүлсний үндсэн дээр сонгуулийн эрх зүйн харилцаа үүсэж хэрэгжинэ. Иймд "сонгууль бол Үндсэн хуулийн эрх зүйн асуудал мөн"[11] болох нь харагддаг. Энэ бол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоог бүрдүүлэгч гол зарчим, журам, гишүүний бүрэн эрхийн хугацааг гол шалгуур болгон тодорхойлсон үндэслэл юм. Үүнийг Үндсэн хуулийн эрх зүйд бол сонгуульд "иргэдийн оролцооны зарчим" гэж нэрлэх нь бий (Б.Чимид). Түүнчлэн энэ бол сонгуулийн тогтолцооны тухай биш харин түүний үндэс болсон сонгуулийн эрх зүйн үндсэн зарчмыг тодорхойлсон

[2] Мөнхсайхан О., Үндсэн хуулийн соёл: Сайн туршлага ба Монгол // Constitutional culture: Best experiences ans Mongolia, Эрх зүй сэтгүүл, Уб., 2017, №4, (40), 40 дэх тал.

[3] Номынбаясгалан С., Үндсэн хуулийн маргаан: Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн лавлах бичиг, Уб., 2018 он.

[4] Цогтоо Ш., Гадаад орнуудын үндсэн хуулийн эрх зүй, (Харьцуулсан судалгаа) Уб., 2018, 25 дахь тал.

[5] Лүндэндорж Н., Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага // The state and legal thoughts (Trends and Development) Уб., 2002 он, 159 дэх тал.

[6] Мөн тэнд

[7] Цогтоо Ш., Гадаад орнуудын үндсэн хуулийн эрх зүй, (Харьцуулсан судалгаа) Уб., 2018, 45 дахь тал.

[8] Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992 он, №1 дугаарт нийтлэгдсэн.

[9] Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25–ны өдөр баталсан "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай", "Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай", "Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай", "Аймаг, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай" хуулиуд байх бөгөөд эдгээрийг Сонгуулийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөх тухай зохицуулсан. *https://www.legalinfo.mn/law/?cat=27* (*last visited 2018.12.30.*)

[10] Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25–ны өдөр баталсан Сонгуулийн тухай хууль *https://www.legalinfo.mn/law/details/12178?lawid=12178* (*last visited 2018.12.30.*)

[11] Чимид Б., Үндсэн хуулийн мэдлэг, Уб., 2008 он, 218 дахь тал.

заалт гэж үздэг.[12] Энэ утгаар, сонгуулийн үндсэн зарчмыг үндсэн хуулиар тогтоож, сонгуулийн хуулиар нарийвчлан зохицуулах[13] бөгөөд үүнд л илүүтэйгээр сонгуулийн эрхийг[14] зохицуулсан хэм хэмжээ агуулагддаг.[15]

Тиймээс Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацааны зэрэгцээгээр сонгуулийн тогтолцооны үндсэн зарчмыг тогтоосон заалт[16] гэж ойлговол зохилтой. Энэ тухай бусад улс өөрийн Үндсэн хуулиараа сонгуулийн тогтолцоог тогтоодоггүй бөгөөд харин сонгуулийн зарчмыг тогтоож өгдөг. Үүнтэй нэгэн адил Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан "шууд сонгох эрх" нь сонгогч ямар нэгэн төлөөлөлгүйгээр өөрөө саналаа өгөх, сонгуулийн үр дүн нь сонгогчийн саналд үндэслэгдэх гэсэн агуулгыг илэрхийлдэг.[17] Сонгуулийн тогтолцоо, түүнд хамаарах судалгаа цөөнгүй хийгдсэн.[18] Гэвч үүнийг "сонгуулийн тогтолцоо" гэх олон эрэмбийн ойлголтын нэг хувилбар болох сонгогчдын саналыг дүгнэж, гишүүний (мандат) суудал хувиарлах арга болсон "мажоритар", "пропорционал" тогтолцоотой хутгаж, ойлгон хэрэглэх

[12] Чимид Б., Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний үндсэн хууль буруутай юу?! (Үндсэн хуульт ёсны төлөвшил цувралын IV), Уб., 2011 он, 39 дэх тал

[13] Цогтоо Ш., Гадаад орнуудын үндсэн хуулийн эрх зүй, (Харьцуулсан судалгаа) Уб., 2018, 405 дахь тал.

[14] "Сонгуулийн эрх" нь субъектив утгаараа тодорхой этгээдийн сонгуульд оролцох эрх.

[15] Мөн номд 406 дахь тал.

[16] Чимид Б., Сонгуульд суралцахуй (Тогтолцоо, үйл явц, эрх зүй), Уб., 2008 он, 58 дахь тал.

[17] Монгол Улсын Үндсэн хуульд Улсын Их Хурлын сонгуулийг явуулах зарчмыг шууд зааж өгөөгүй ч гэсэн энэ хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Улсын Их Хурлын гишүүнийг . . . , шууд . . . сонгоно" хэмээн заасан байдаг. Энэ нь сонгогчид Улсын Их Хурлын гишүүнийг "шууд" буюу аль нэгэн нам эвслийн төлөө санал өгөх бус харин уг нэр дэвшигчид саналаа өгнө гэсэн утгатай гэж зарим иргэд үздэг.
Амарсанаа Ж., Үндсэн хуулийн маргаан, (Анхны хэвлэл), Уб., 2012 он, 55 дахь тал.

[18] Судалгааны мэдээллийн сангийн ***2009 оноос 2018 оны 9 дүгээр сарын 25–ны өдрийн байдлаарх*** лавлагаа: Сонгуулийн пропорционал тогтолцоо бүхий улс орнуудын суудал хуваарилах арга, босгын хувь болон тойргийн хэлбэр (2016), Сонгуулийн хувь тэнцүүлэн хуваарилах болон холимог тогтолцоо бүхий орнуудын намаас нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах тухай (2016), Парламентын засаглалтай орнуудын сонгуулийн тогтолцоо ба ротацийн журмаар парламентын гишүүдийг сэлгэдэг зарим орны туршлага (2015), Болгар улсын сонгуулийн систем, 2009 оны сонгууль болон Европын парламентын сонгуулийн талаарх товч мэдээлэл (2015), БНМАУ–ын Ардын Их Хурлын сонгуультай холбогдох лавлагаа (2015), Монгол Улстай ижил төстэй зарим орны засаглалын болон эрх зүйн тогтолцоо, сонгуулийн хэлбэрийн талаарх мэдээлэл (2015), Дэлхийн 25 оны сүүлийн 50 жилийн засаглалын хэлбэр, төрийн тэргүүний сонгуулийн тогтолцоо, төрийн тэргүүнээр ажилласан хүмүүс (2015), Дэлхийн улс орнуудын ерөнхийлөгч болон парламентын сонгуулийн тогтолцоо – Монгол Улстай адил Ерөнхийлөгч болон парламентын гишүүдийг бүх ард түмний сонгуулиар сонгодог улс орон бий эсэх талаарх лавлагаа (2015), Улсын Их Хурлын болон орон нутгийн хурлын сонгуулийг хамтад нь явуулах боломжтой эсэх асуудлаар харьцуулсан судалгаа (2012), Сонгуулийн холимог тогтолцоот улс орнуудын сонгогчдын санал гаргах хувилбарууд (2011), Улс төрийн намын гишүүнчлэл, төлөвшил, нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгууль, парламент болон орон нутгийн сонгуулийг зэрэг явуулах талаарх мэдээлэл (2011), Зарим улс орнууд дахь сонгуулийн холимог тогтолцооны эрх зүйн зохицуулалт (2011), Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөлд хийсэн дүн шинжилгээ (2011), Сонгуулийн эрх зүйн тогтолцооны онол арга зүйн үндэслэл, зохистой хувилбарыг сонгох зарчим (2010), Европын гишүүн зарим улсуудын орон нутгийн сонгуулийн тогтолцоо, улс төрийн намуудын оролцооны талаарх харьцуулсан мэдээлэл (2010), Сонгуулийн системийн харьцуулалт: давуу ба сул тал (2009), . . . зэрэг болно. *http://www.parliament.mn/n/u7ky* (*last visited 2018.12.30.*)

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН www.nli.gov.mn

хууль зүйн практик бүрэлдэн тогтсон.[19]

Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "тогтолцоо" гэсэн нэмэлт оруулах төслийг боловсруулах үндэслэл, шаардлага бүхий асуудал болсон байна.[20] Ямар сонгуулийг шударгад тооцох асуудал өнөөдөр том асуудал, улс төрөөс хамаарсан үзэгдэл болоод байна. Сонгуулийн тогтолцоо эерэг, сөрөг талтай хэмээн нэрлээд түүнийгээ улс төрийн "хөзөр тоглох" шалтаг, шалтгаан болгожээ. Энэ нь өдгөө дэлхий дахины үзэгдэл болсон байна. Эрх баригчид өөр өөрсдөө ашигтай, тоглож дадсан тогтолцоог өдгөө сонгодог нь бараг нууц биш болжээ.[21] Энэ байдлыг улс төр – эрх зүйн[22] болон тоглоомын[23] (Game theory) онолуудын үүднээс шинжилж болох юм.

Ийнхүү сонгуулийн тогтолцооны учир холбогдлыг Үндсэн хуулийн үзэл баримтлал болоод Үндсэн хуулийн маргааны мөн чанартай холбон тайлбарлаж болох юм. Учир нь Үндсэн хуулийн хамгаалагч (цаашид "Үндсэн хуулийн цэц" гэх) монгол төрийн улс төрийн бодлогын зангилаа асуудлаар хэлэлцэн шийдвэр гаргах тул тэрхүү шийдвэр монгол төрийн гол бодлогод хамаарах онцлогтой.[24] Энэ утгаараа судлаачид Үндсэн хуулийг эрх зүйн төдийгүй улс төрийн баримт бичиг гэж үздэг[25] учраас Үндсэн хуулийн маргааныг хууль зүйн хэлбэртэй, улс төрийн агуулгатай хэмээн тодорхойлдог.[26] Энэ тухай тэмдэглэсэн судалгаа цөөнгүй.[27]

Монгол Улсын сонгуулийн хууль тогтоомж[28] дахь сонгуулийн тогтолцооны түүхэн уламжлал, тусгагдсан байдлыг үзвэл, Улсын Их Хурлын 1992, 2008[29] оны сонгуулийг (мажоритар тогтолцоогоор) олон мандаттай томсгосон 26 тойргоор, харин 1996, 2000, 2004, 2016 оны сонгуулиудыг нэг мандаттай 76

[19] Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 04 дүгээр сарын 22–ны өдрийн "Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай" 05 дугаар дүгнэлтээр: "Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтад "хувь тэнцүүлсэн / пропорционал/", *120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэгт "Улсын Их Хурлын 48–аас илүүгүй гишүүнийг олонхийн сонгуулиар, 28–аас илүү гишүүнийг хувь тэнцүүлэх сонгуулиар тус тус сонгоно" гэж заасны ". . . 28–аас илүүгүй гишүүнийг хувь тэнцүүлэх сонгуулиар . . ." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий ирэгд . . . шууд . . . сонгоно", Хорин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий ирэгнийг сонгоно" гэснийг зөрчсөн*" гэж шийдвэрлэсэн байна. Энэ дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын 2016 оны 05 дугаар сарын 04–ний өдрийн "Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 05 дугаар дүгнэлтийн тухай" 38 дугаар тогтоолоор хүлээн зөвшөөрсөн байдаг. Номынбаясгалан С., Үндсэн хуулийн маргаан: Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн лавлах бичиг, (Эмхэтгэл) Уб., 2018 он, 290–292 дахь тал.

Үүнтэй холбогдогдуулан Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 05 дугаар сарын 05–ны өдөр батлагдсан Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйлд 1/"7 *дугаар зүйл. Сонгуулийн тогтолцоо 7.1.Сонгууль нь олонхийн / мажоритар/ тогтолцоотой байна.*" гэсэн заалт орсон байдаг. https://www.legalinfo.mn/additional/details/2800?lawid=12178 (*last visited 2018.12.30.*)

[20] Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн тайлбар, (Монгол Улсын Их Хурал), Уб., 2017 он, 68 дахь тал.

[21] Лүндэндорж Н., Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага // The state and legal thoughts (Trends and Development) Уб., 2002 он, 159 дэх тал

[22] Лүндэндорж Н., Эрх зүй судлал: философи – онол // Jurisprudence, Уб., 2011 он, 126 дахь тал.

[23] Кэн Бинмор., Тоглоомын онолын товч танилцуулга, Уб., 2016 он.

[24] Хууль дээдлэх ёс сэтгүүл, Уб., 2003 он, №1, 82 дахь тал.

[25] Өнөрбаяр Ч., Үндсэн хуульт ёсны хөгжил, түүний чиг хандлага, Уб., 2014 он, 37 дахь тал.

[26] Арне Мавчич., Үндсэн хуулийн хяналт, (Орчуулсан), Уб., 2014 он, 173 дахь тал.

27 Номынбаясгалан С., Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг хууль тайлбарлах аргаар төрөлжүүлэн ангилах асуудал, Хууль дээдлэх ёс сэтгүүл, Уб., 2017 он, №4 дугаар.

[28] Монгол Улсын Бага Хурлаас 1992 оны 4 дүгээр сарын 4–ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл 1992 он, №2 дугаарт нийтлэгдсэн. Монгол Улсын хууль тогтоомжийн хөгжлийн түүхэн товчоон, (*1911–2008*),Уб., 2008 он, 246–247 дахь тал.

[29] 2008 онд шинэчлэн баталсан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар Улсын Их Хурлын тав дахь удаагийн сонгууль явагдсан ба тухайн үед сонгуулийн тогтолцоог өөрчилж, олон мандаттай томсгосон тойрог бүхий сонгуулийн тогтолцоонд шилжсэн явдал ба ингэснээр нэг сонгогч олон нэр дэвшигчид саналаа өгөх эрхтэй болсон. Шүүхийн практикийн судалгааны цахим сэтгүүл, №9, 6–7 дахь тал http://www.judcouncil.mn/ins/main/198--9.html (*last visited 2018.12.30.*)

тойргоор зохион байгуулсан. Харин 2012[30] онд явагдсан Улсын Их Хурлын ээлжит сонгуулийг олонхийн болон хувь тэнцүүлсэн тогтолцоог хослуулан Улсын Их Хурлын 48 гишүүнийг олон мандаттай томсгосон 26 тойргоос, бусад 28 гишүүнийг улс төрийн нам, эвслийн нэрийн жагсаалтаар нэр дэвшигчдээс сонгосон[31] болох нь харагдах юм. Парламентын сонгуулийн мажоритар буюу олонхийг төлөөлөх, пропорционал буюу хувь тэнцүүлэн хуваарилах гэсэн үндсэн хоёр тогтолцоо, эдгээрийн олон янзын хувилбарууд дэлхийн улс орнуудын парламентын сонгуульд хэрэглэгддэг. Сонгуулийн энэ хоёр үндсэн тогтолцоо өөрсдийн эерэг болоод сөрөг шинжийг агуулдаг. Энэ хоёр тогтолцооны сайн талуудыг нэгтгэж, сөрөг шинжийг нь багасгах замаар илүү шударга, ардчилсан сонгуулийн тогтолцоог бий болгож хэрэглэх хандлага олон оронд хэвшиж байна.[32] Ийнхүү сонгууль нь сонгуулийн ямар системээр явагдсан, тэрхүү систем буюу тогтолцооны давуу болон сул талыг харуулсан байдал, сонгуулийн ямар системийг авч хэрэглэх нь сонгогч, нам эвсэлд тохиромжтой байх тухайд Монгол Улсад "сонгуулийн хосолмол буюу холимог систем" гэж үзсэн байдаг.[33]

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ[34] нь сонгуулийн тухай холбогдох заалтаараа "сонгуулийн эрх зүйн эх сурвалж" болж болно. Тиймээс Үндсэн хуулийн дээрх заалт буюу сонгуулийн эрх зүйн үндсэн зарчмын талаарх асуудлыг эрх зүйн ерөнхий онолын үүднээс хөндөх төдий практик шинжтэй юм. Энэ өгүүлэл шийдвэрийг "шийдвэрээр" тайлбарлах арга зүйг баримтлан бичигдсэн.

Тиймээс Үндсэн хуулийн шүүхийн хяналтын тогтолцоо болох механизмыг "Үндсэн хуулийн амин сүнс" гэж нэрлэх бөгөөд үүний үр дүнд Үндсэн хууль бусад хуулийн адил шууд хэрэгжих, заавал биелэгдэх шинжтэй болно.[35] Үндсэн хуулийн цэцийн практикт сонгуулийн "тэгш эрхийн"[36], "чөлөөт"[37], "шууд сонгох" гэсэн зарчмуудтай холбогдох цөөнгүй шийдвэр бий. Чухамдаа шүүхийн (ямар *"эрүү, иргэн, захиргаа, үндсэн хуулийн"* шүүхийн шийдвэр гэдгээс үл хамааран) шийдвэрийн эрх зүйн асуудал нь процессын болон материаллаг эрх зүйн асуудал гэж хуваагдах бөгөөд ингэхдээ процессын журам зөрчсөнтэй холбоотой шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ

[30] 2011 оны 12 дугаар сарын 15–ны өдөр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2012 оны 9 дүгээр сарын 14–ний өдөр Аймаг, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг тус тус батлалсан. Шинэ батлагдсан сонгуулийн тухай хууль тогтоомжийн дагуу сонгуулийн мажоритар болон пропорционал систем хосолсон холимог тогтолцоог нэвтрүүлсэн. Улсын Их Хурлын нийт 76 суудлын 48 мандатыг 26 томсгосон тойргоос, 28 мандатыг намын жагсаалтаар сонгосон. Шүүхийн практикийн судалгааны цахим сэтгүүл, №9, 8 дахь тал *http://www.judcouncil.mn/ins/main/198--9.html* (*last visited 2018.12.30.*)

[31] Монгол Улсын Их Хурлын сонгуулиудын дүн: (Монгол Улсын Их Хурлын 1992, 1996, 2000, 2004, 2008 , 2012, 2016 оны ээлжит сонгуулиуд, 1997 – 2009 онуудад явагдсан нөхөн сонгуулиудын дүнг аймаг, дүүрэг, сум, тойрог, хэсэг, нэр дэвшигч, нам, эвсэл бүрээр нэгтгэн гаргав), Уб., 2017 он, 4 дэх тал. *http://gec.gov.mn/uploads/IHsonguuli2012.pdf* (*last visited 2018.12.30.*)

[32] *http://legaldata.mn/buteel/pdf?id=83* (*last visited 2018.12.30.*)

[33] Сонгуулийн системийн харьцуулалт: давуу ба сул тал, Бодлогын судалгаа шинжилгээ, (Судалгааны эмхэтгэл), IV, Уб., 2010 он, 217 дахь тал.

34 Сонгуулийн холбогдолтой олон улсын гэрээ, конвенц нь Монгол Улсын Үндсэн хуульд харшлахгүй бол дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил баримтлах ёстой.

[35] Гангабаатар Д. Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал // Constitutional law: State structure, principles and policies, Уб., 2016 он, 148 дахь тал.

[36] Монгол Улсын Үндсэн хуулийн 1993 оны 12 дугаар сарын 22–ны өдрийн "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн холбогдох заалтууд Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянан хэлэлцсэн тухай" 04 дүгээр дүгнэлт (МҮҮХЦ, дүгнэлт №04/1993.12.22.)–ийг үз.

[37] Монгол Улсын Үндсэн хуулийн 1996 оны 5 дугаар сарын 23–ны өдрийн "Сонгуулийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн тухай" 03 дугаар дүгнэлт (МҮҮХЦ, дүгнэлт №03/1996.05.23.) болон Монгол Улсын Үндсэн хуулийн 1996 оны 6 дугаар сарын 19–ний өдрийн "Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай" 02 дугаар тогтоол (МҮҮХЦ, тогтоол №02/1996.06.19.) зэргийг үз.

хийх нь тийм ч ач холбогдолтой биш. Иймд материаллаг эрх зүйн асуудал хөндсөн шүүхийн шийдвэрийг сонгон, материаллаг эрх зүйн асуудлыг хөндөх нь зүйтэй гэж үздэг.[38] Энэ өгүүлэл дээрх байдлаас хөндийрөхгүй болно. Тиймээс өгүүллээ ийнхүү нэрлэсний учир энэ билээ.

Энэ нь Үндсэн хуулийн цэцийн зарим (сонгуулийн тогтолцоонд холбогдох хоёр маргаан) шийдвэрийг[39] уншаад төрсөн хувийн сэдэлтэй сэтгэгдэл төдий зүйл болох Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт үндэслэсэн Монголын өнөөгийн хууль тогтоох байгууллага, бусад эрх мэдэл бүхий субьектын үйл ажиллагааны цараа, чадавх, алдаа оноо, ажлын арга барилыг ямар нэг хэмжээгээр дүгнэх[40] боломжтойг харуулахыг зорилоо. Бидний авсан улс төрийн загварт хүмүүс боломжит сонголтуудын үр дүнгийн талаар бүрэн мэдээлэл авсан ба тиймээс тэд өөрсдийн авах үр өгөөжийг харьцуулж, сонголт хийдэг гэж үздэг.[41]

Энэ тухай "Парламентын төлөөлөгчдийг сонгох сонгуулийн тогтолцоог буюу жинхэнэ парламентын ардчиллыг бүтээхэд мажоритар аль эсвэл пропорцианал төлөөллийн сонгуулийн тогтолцооны аль нь илүү тохиромжтой вэ гэсэн асуултыг шүүн тунгаах хэрэгтэй болно. Сонгуулийн тогтолцоог сонгох шийдвэр нь хойшид тухайн тогтолцооны улс төрийн ач холбогдлын талаар шинжилгээ хийхэд чухал ач холбогдолтой" гэж үздэг.[42] Монгол Улсад засгийн эрх ард түмний мэдэлд байх, ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдлэх талаарх Үндсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэх, иргэний сонгуулийн эрхийг хангах гол нөхцөл бол холбогдох хуулиар сонгуулийн тогтолцоог зөв тодорхойлох асуудал юм.[43] Тиймээс Үндсэн хуулиар нэгэнт сонгуулийн тогтолцоог шууд тодорхойлоогүй учраас сонгуулийн ямар тогтолцоотой байхыг Улсын Их Хурал шийдвэрлэх бүрэн эрхтэй[44] эсэхэд хариулт өгөхөд чиглэсэн. Үүнд л энэ өгүүллийн гол утга учир оршино.

II. Сонгуулийн тогтолцоог хууль зүйн үүднээс тодорхойлох боломж

Энэ талаар судлаачид өөр өөрсдийн байр сууриа илэрхийлсэн нь цөөнгүй. Жишээлбэл, "Пропорционал төлөөллийн тогтолцоо нь энгийн мажоритар тогтолцоотой харьцуулахад илүү хатуу зохион байгуулалтын дэг бүхий намын тогтолцоог шаарддаг. Үр дүнд нь улс төрийн намаар дамжуулан төлөөлөгчдийг байнга хянах тухай үзэл санаа нь сонгогчдыг зохион байгуулалтад ороход хүргэж байна" гэж

[38] http://www.judinstitute.mn/zagwar.html (last visited 2018.12.30.)

[39] Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 3 дугаар сарын 28–ны өдрийн "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтын холбогдох хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай" 02 дугаар дүгнэлт (МУҮХЦ, дүгнэлт №02/2012.03.28.), Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 5 дугаар сарын 2–ны өдрийн "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтын холбогдох хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай" 03 дугаар тогтоол (МУҮХЦ, тогтоол №03/2012.05.02.)–ыг үз.

Өмнө дурдсан шийдвэрийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 4 дүгээр сарын 22–ны өдрийн "Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай" 05 дугаар дүгнэлт (МУҮХЦ, дүгнэлт №05/2016.04.22.)–тэй харьцуулж үз.

[40] Амарсанаа Ж., Үндсэн хуулийн маргаан, (Анхны хэвлэл), Уб., 2012 он, 21 дэх тал.

[41] Жозеф Штиглиц., Төрийн эдийн засгийн онол // Economics of the Public sector (Гурав дахь хэвлэл), Уб., 2009 он, 203 дахь тал.

[42] Ханс Кельзен., Ардчиллын мөн чанар ба үнэт зүйл, (Орчуулсан Д.Оргил), Уб., 2015 он, 69 дэх тал.

[43] Жанцан Н., Үндсэн хуулийн цэц иргэдийн улс төрийн эрхийн баталгаа болох нь // Constitutional Court (tsets) as the guarantee of citizens' political rights, Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал, (Онол, арга зүй, хэрэгжилт) Уб., 2017 он, 38 дахь тал.

[44] Мөнхсайхан О., Монгол Улсын Үндсэн хуулиар сонгуулийн холимог тогтолцоог хориглоогүй // The Constitution of Mongolia does not prohibit mixed election system, Эрх зүй сэтгүүл, Уб., 2016 он, №2(34), 23 дахь тал.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

дүгнэсэн байх нь бий.[45] Монгол Улсын хувьд “*2012 онд* Үндсэн хуулийн цэц сонгуулийн холимог тогтолцоог Үндсэн хуульд нийцсэн гэж зөвшөөрсөн боловч 2016 онд уг тогтолцоог Үндсэн хууль зөрчсөн гэж шийдвэрлэсэн бөгөөд энэ талаар хангалттай үндэслэл хэлээгүй” гэж шүүмжлэх судлаач цөөнгүй.[46]

Нэр томьёоны тухай товч өгүүлэх нь

Хууль зүйн толь бичгүүдэд нийтлэг байдлаар ““Сонгуулийн тогтолцоо” гэж (англ. election (*electoral*) system), ор. (избирательная система) – 1. Төрийн сонгуульт байгууллагыг бүрдүүлэх журам; 2. Санал хураалтын үр дүнг тогтоосны дараа сонгуульт байгууллагад суудал хуваарилах тогтолцоо” гэж тэмдэглэсэн байх нь бий.[47] Үүнээс гадна, “Сонгуулийг хэрхэн яаж явуулахыг “сонгуулийн тогтолцоо” тодорхойлно. Хамгийн товчоор хэлбэл, энэ нь сонгуулийн дүнг тооцох санал хуваарилах арга мөн” гэж үздэг.[48]

Хууль зүйд “сонгуулийн тогтолцоо буюу систем” хэмээх нэр томьёо өргөн, явцуу хоёр утгаар хэрэглэгддэг гэж үзэх нь бий. Явцуу утгаар нь тодорхойлбол, ““сонгуулийн систем*” гэдэг* нь бүх нийтийн сонгуулиар улс төрийн нам болон тэдгээрээс нэр дэвшигчдийн авсан сонгуулийн саналыг парламентын суудал болгон хувиргах аргачлал юм” гэж үздэг.[49] Систем гэдэг “тогтолцоо” гэсэн монгол үгтэй яг тохирдог. Тэгээд л “сонгуулийн тогтолцоо” гэж байгаа юм.[50] Орчин үед сонгуулийн тогтолцоог явцуу утгаар тодорхойлдог өөр нэгэн ойлголт, зарчим бий. Тухайлбал, сонгуулийн үр дүнг тооцох арга буюу мандат хуваарилах аргаар нь сонгуулийн тогтолцоог олонхийн (мажоритар), хувь тэнцүүлэх (пропорционал) гэсэн хоёр үндсэн төрөлд хуваахын зэрэгцээ бас холимог буюу энэ хоёр аргыг хослуулан хэрэглэх тохиолдол бий.[51]Мажоритар аргын тухайд: Энэ аргаар (системээр) явуулсан сонгуулийг дотор нь харьцангуй мажоритор сонгууль, үнэмлэхүй мажоритар сонгууль гэж хуваах бөгөөд харьцангуй мажоритар сонгуулиар тухайн сонгуулийн тойрогтоо хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг сонгох бол үнэмлэхүй мажоритар сонгуулиар тэр тойргийн нийт сонгогчийн талаас илүү хувийг авсан хүнийг сонгогдсон гэж үздэг.[52]

Эдгээрийг хууль зүйн толь бичигт ““сонгуулийн олонхийн төлөөллийн тогтолцоо” (англ. majority election; ор. Мажоритарная избирательная система) – нутаг дэвсгэрийн тойргоор санал өгсөн хамгийн олонхи сонгогчдын саналыг авсан нэр дэвшигчийг сонгогдсонд тооцдог сонгуулийн тогтолцоо” гэж

[45] Ханс Кельзен., Ардчиллын мөн чанар ба үнэт зүйл, (Орчуулсан Д.Оргил), УБ., 2015 он, 52 – 53 дахь тал.

[46] Мөнхсайхан О., Үндсэн хуулийн соёл: Сайн туршлага ба Монгол // Constitutional culture: Best experiences ans Mongolia, Эрх зүй сэтгүүл, Уб., 2017 он, №4, (40), 28–29 дэх тал.

[47] Нарангэрэл С., Монголын эрх зүйн эх толь бичиг // Dictionary of Mongolian Law with english, Russian and latin translations, Уб., 2015 он, 377 дахь тал, . . . гэх мэт

[48] Ядамсүрэн Ж., Сонгуулийн тухай зарим ойлголт, товч тайлбар, Уб., 2008 он.

[49] Гангабаатар Д. Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал // Constitutional law: State structure, principles and policies, Уб., 2016 он, 195 дахь тал.

[50] Уг нь өөр өөрийн онцлогтой ерөнхий гол шинж чанараараа холбогдсон олон язгуур махбодийг нэг тогтолцоо гэдэг. Ерөнхий тогтолцоо нь нэг маягийн төрлийн салбарын гэх мэтээр дэд тогтолцоонд салж нарийсна. Түүний адил Монголын сонгуулийн тогтолцоог хамрах хүрээ зарчим аргаар нь өөрөөр хэлбэл, олон утгаар тодорхойлж болно. Манай сонгуулийн нэгдсэн тогтолцоог субъектээр нь (1) Улсын их хурлын; (2) Ерөнхийлөгчийн; (3) Орон нутгийн ИТХ–ын гэж гурван дэд тогтолцоонд хувааж болно. Энэ нь бүлэглэн тогтолцоожуулсны үр дүн мөн. Улс орнуудын орчин үеийн сонгуулийн тогтолцоог аргаар нь (1) Олонхийн; (2) Хувь тэнцүүлсэн; (3) Холимог гэж хуваана. Чимид Б., Сонгуульд суралцахуй (тогтолцоо, үйл явц, эрх зүй), УБ., 2008 он, 49 дэх талаас дэлгэрүүлж үз.

[51] Чимид Б., Үндсэн хуулийн мэдлэг, Уб., 2008 он, 220 дахь тал.

[52] Хэрэв ингэж чадаагүй бол хоёр дахь шатны сонгууль шаардлагатай болдог. Энэхүү системийн давуу тал нь Засгийн газраа байгуулах олонхийг бүрдүүлж чаддагт оршдог бол сул тал нь парламентын бүрэлдэхүүнд сонгогчдын хүсэл зориг шууд тусгалаа олж чаддаггүйтэй холбоотой. Сонгуулийн системийн харьцуулалт: давуу ба сул тал, Бодлогын судалгаа шинжилгээ, (Судалгааны эмхэтгэл), IV, Уб., 2010 он, 216 дахь талаас үз.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

үздэг.[53] Мөн түүнчлэн төлөөллийн байгууллагын гишүүнийг сонгоход зайлшгүй шаардагдах сонгогчдын саналын хамгийн доод хэмжээг хэрхэн тодорхойлсноос хамааран мажоритар тогтолцоог харьцангуй олонхийн, үнэмлэхүй олонхийн, дийлэнх олонхийн гэсэн хувилбаруудад хуваан авч үздэг.[54] Толь бичигт ""сонгуулийн хувь тэнцүүлсэн төлөөллийн тогтолцоо" (англ. proportional electoral system; ор. Пропорциональная избирательная система) – парламентын гишүүний мандат буюу суудлыг намуудад тэдгээрийн авсан саналын хувь хэмжээгээр хуваарилах сонгуулийн тогтолцоо" гэж тайлбарлажээ.[55]

Тэгвэл өргөн утгаараа, "сонгуулийн харилцаа нь нийгмийн улс төрийн харилцааны томоохон бүрэлдэхүүн хэсэг мөн. Түүнд насанд хүрсэн бүх иргэн, төрийн эрх мэдлийн бүх салаа мөчир, нам, олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нутгийн өөрөө удирдах болон бусад бүх байгууллага, албан газар зохих эрх үүрэгтэй нийтээр оролцдогийг бид мэднэ. Эдгээр харилцааны харилцан шүтэлцээ бүхий нийлбэрийг бүхэлд нь "сонгуулийн тогтолцоо" *гэж болно*" хэмээн үздэг.[56] Өөр үгээр хэлбэл, "иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хангаж, төлөөлөгчдийн байгууллагын гишүүн, сонгуульт албан тушаалтныг тохоон тавих, сонгуулийг зохион байгуулж хөтлөн явуулах, дүнг гаргаж сонгогдсон хүнд бүрэн эрх *(мандат)* олгох, түүнийг хүлээн зөвшөөрөх талаар хуулиар тогтоосон зарчим, журмын цогц" гэж бас үздэг.[57] Түүнчлэн "төрийн институтыг бүх нийтийн сонгуулиар байгуулах явцад үүссэн нийгмийн харилцааг хэлнэ" гэсэн ч бий.[58] Дээр тэмдэглэснээс үзвэл, Монгол Улсын Үндсэн хуульд Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоог иргэдийн сонгох эрхийн зарчмыг үндэслэн тодорхойлсон байна гэж үзэж болох юм.

Энэ талаарх гадаад улсын хууль тогтоох байгууллагын (парламентын) сонгуулийн тухай Үндсэн хуульд заасан үндэслэлийн (2011) түүврээс "нийт 56 орны 39 нь нийтээр, шууд сонгох зарчмыг заасан бөгөөд үүнээс 27 нь парламентын гишүүнийг шууд сонгох эрхийн үндсэн дээр сонгоно, 12 нь битүү утгаар парламентыг шууд сонгох эрхийн үндсэн дээр сонгоно гэж заасан байна. Үүнээс үзэхэд манай Үндсэн хуульд Улсын Их Хурлын гишүүнийг шууд сонгох эрхийн үндсэн дээр сонгоно гэж заасан тул гишүүний суудал хуваарилахад сонгуулийн хувь тэнцүүлсэн аргыг хэрэглэж болохгүй гэх тайлбар буруу болох нь тодорхой байна *(Б.Чимид)*" гэж дүгнэсэн болохыг анхаарахгүй орхиж болохгүй.

Эрх зүй *(*улс төр*)*–өөс ялгаатай болох нь

Эрх зүй болон улс төрийн харилцаа, тэдгээрийн харилцан хамаарлын тухай асуудал эрх зүй судлалын чухал хэсэг. Эдгээрийн харилцан хамаарлыг зөв ойлгохгүйгээр эрх зүйн асуултад ул суурьтай ухаалаг хариулт өгөх, үзэгдэл, харилцааг зөв тайлбарлах бололцоогүй гэж үздэг.[59] Нэр томьёо талаас, политикс гэсэн нэр томьёог олон улсын харилцааны (*IR*) хувьд өргөн утгаар нь "бодлого зүй" хэмээн монгол хэлнээ буулган хэрэглэх нь зүйтэй.[60] Харин улсын дотоод

[53] Нарангэрэл С., Монголын эрх зүйн эх толь бичиг, Уб., 2015 он, 376 дахь тал.

54 Энхбаатар Ч., Үндсэн хуулийн эрх зүй, Уб., 2007 он, 167–170 дахь тал.

[55] Нарангэрэл С., Монголын эрх зүйн эх толь бичиг, Уб., 2015 он, 378 дахь тал.

[56] Чимид Б., Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний үндсэн хууль буруутай юу?! (Үндсэн хуульт ёсны төлөвшил цуврал IV), Уб., 2011 он, 49 дэх тал.

[57] Чимид Б., Үндсэн хуулийн мэдлэг, Уб., 2008 он, 218 дахь тал.

[58] Харин явцуу утгаар "сонгуулийн тогтолцоо" гэдэг нь тухайн сонгуульд явсан нэр дэвшигчдийн хооронд мандаж хуваарилах аргын цогц гэж үздэг. Энхбаатар Ч., Үндсэн хуулийн эрх зүй, Уб., 2007 он, 166–167 дахь тал.

[59] Лүндэндорж Н. Эрх зүй судлал: Философи, онол // Jurisprudence, Уб., 2011 он, 27 дахь тал.

[60] Политикс (*politics*) нь эвсэл, хүчний төлөө тэмцэл, хуйвалдаан, зохицуулалт, эв зүй гэсэн олон утга нэгэн зэрэг илэрхийлдэг бөгөөд "*policy*" буюу бодлогуудын суурь, үндэс нь болдог гэж үздэг. (А Т.)

бодлого, эрх мэдэл, хүч чадавхийн хуваарилалтын тухайд энэхүү “политик” хэмээх өргөн хүрээтэй ойлголтыг “улс төр” гэдэг үүднээс авч үзэх нь илүү оновчтой байж болох юм.[61] Улс төрийг яаж задлан шинжилбэл, хамгийн зүйтэй тухай үл дуусах мэтгэлцээнүүдийн зарим нь “бүхэл социал систем болон түүнийг бүрэлдүүлэгч хэсгүүдийн хооронд ямар харилцаа байдагт анхаарлаа хандуулах ёстой” гэж үздэг.[62] Тиймээс сонгуулийн ямар системийг сонгосноос хамаарч сонгогчид улс төрийн намд саналаа өгөх эсвэл нэр дэвшигчид саналаа өгөх, түүнчлэн сонгогчдын саналыг ямар аргачлалаар парламентын суудалд хуваарилах, сонгуулийн тойргийг хэрхэн тогтоох, тойрог бүрээс хэдэн төлөөлөгч сонгох зэрэг асуудал тодорхой болно.[63]

А. Монгол Улсын Үндсэн хуулиар сонгуулийн тогтолцооны эрх зүйн үндэс тавьсан нь

Монгол Улсын Үндсэн хуулийн хавсралт хууль нь Үндсэн хуультай адил хүчин чадалтай боловч Монгол Улсын Үндсэн хууль биш гэж үздэг. Өөр үгээр хэлбэл, “хавсралт хууль нь хуучин Үндсэн хуулиас шинэ Үндсэн хуулийг дагаж мөрдөх шилжилтийн үед Монгол Улсын Үндсэн хуулийг хэрэгжүүлэх явцыг тодорхойлсон хууль мөн” гэж үздэг.[64] Тиймээс энэхүү хавсралт хууль нь үндсэн хуулийн заалт, шаардлагын дагуу хэрэгжих ёстой бөгөөд хавсралт хуулийн[65] 1 дүгээр зүйл (1)–д заасны Монгол Улсын Их Хурлын сонгуулийг Монгол Улсын Үндсэн хуульд заасан зарчмын дагуу Улсын Их Хурлыг байгуулсан. Энэ үндсэн дээр Улсын Бага Хурлаас <<Улсын Их Хурлын сонгуулийн тухай>> хуулийг батлан гаргаж сонгуулийн тогтолцоо үйл явцын журмыг тодорхойлсон гэж үздэг.[66] Үүний үр дүнд улс төрийн тогтолцоог улс төрийн нам, хүчнүүдийн тэгш оролцоотойгоор өөрчлөх, ардчилсан сонгуулийг явуулах нөхцөл бүрдсэн бөгөөд сонгуулийн үр дүнд бий болсон улс төрийн шинэ бүтэц, бүрэлдэхүүн нь ардчилсан төрийн тогтолцоог бүрдүүлсэн гэж үздэг.[67]

Б. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт сонгуулийн тогтолцоог тодорхойлох урьдач нөхцөл болсон нь

Үндсэн хуулийн цэцийн практикт сонгуулийн тогтолцоотой холбоотой дараах хоёр маргааныг хянан шийдвэрлэсэн бөгөөд тэдгээрийн агуулгыг тус бүрт нь товч танилцуулахын зэрэгцээ үндсэн хуулийн бусад маргаантай (Constitutional cases) холбон авч үзэхийг оролдлоо. Учир нь шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ бол нэг төрлийн “эрдэм шинжилгээний ажил” мөн гэж үздэг[68] учир энэ өгүүллээр маргагч талын хэлбэр, маргааны зүйл, үндсэн хуулийн хэм хэмжээ, маргааныг шийдвэрлэсэн байдал, маргаан бүхий агуулга нь нийтийн ашиг сонирхолд (*public interests*) хамаарах Үндсэн хуулийн цэцийн зарим шийдвэртэй танилцаад, төрсөн хувийн сэдэлтэй сэтгэгдэл төдий зүйлийг “Монгол Улсад сонгуулийн тогтолцоог тодорхойлж буй байдал”–д анализ хийхийг оролдлоо. Ингэхдээ Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт дүн шинжилгээ хийх тодорхой аргачлалыг ашиглахыг

[61] Ариунсанаа Т. Олон улсын харилцаа: Дэлхийн бодлого зүйн удиртгал, (I хэсэг: Системийн хандлага), Уб., 2015 он, 9 дэх тал.

[62] Ариунсанаа Т. Олон улсын харилцаа: Дэлхийн бодлого зүйн удиртгал, (II хэсэг:Аюулгүй байдлын систем), Уб., 2013 он, 9 дэх тал.

[63] Мөн тэнд 195 – 196 дахь тал.

[64] Монгол Улсын Үндсэн хуулийн 1993 оны 1 дүгээр сарын 13–ны өдрийн “Орон нутгийн харьяалалтай зарим хот, хороодыг тухайн суманд нь нэгтгэн харьяалуулах тухай Монгол Улсын Их Хурлын 1992 оны 8 дугаар сарын 21–ний 24 дүгээр тогтоол Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг зөрчсөн тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай” 01 дүгээр тогтоол (МУУХЦ, тогтоол №01/1993.01.13.)–ыг үз. *https://www.legalinfo.mn/law/details/1074* (*last visited 2018.12.30.*)

[65] *https://www.legalinfo.mn/law/details/364?lawid=364* (*last visited 2018.12.30.*)

[66] Чимид Б., Сонгуульд суралцахуй (Тогтолцоо, үйл явц, эрх зүй), Уб., 2008 он, 35 дахь тал.

[67] Лүндэндорж Н., Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага // The state and legal thoughts (Trends and Development) Уб., 2002 он, 159 дэх тал.

[68] *http://www.judinstitute.mn/ach_holbogdol.html* (*last visited in 2018.05.18*)

эрмэлзсэн болно.[69] Хууль зүйн шинжилгээ нь удирдлагын шийдвэр (хууль тогтоох) гаргалтын хэрэгсэл болох учиртай гэж үздэг. Энэ өгүүлэлд шийдвэрийг сургалт, судалгаанд хэрхэн ишлэх зохистойг харуулахын зэрэгцээ холбогдох процессын хуулийн зарим зохицуулалтын[70] талаас хөндөв.

Эхний маргаан буюу Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 05 дугаар сарын 02–ны өдрийн 03 дугаар тогтоол (МУҮХЦ, тогтоол №03/2012.05.02.)–ын хувьд, 2012 онд Үндсэн хуулийн цэцэд нэр бүхий иргэдээс өргөдөл, мэдээлэл ирүүлсэн бөгөөд тэдгээрийн зарим (цөөнх) нь пропорционал тогтолцооны асуудлыг хөндсөн бол зарим (олонх) нь "гулсдаг тогтолцоо" буюу Улсын Их Хурлын сонгуулийн мажоритар тогтолцоогоор тойрогт өрсөлдсөн нэр дэвшигчид ялагдал хүлээсэн ч гэсэн сонгогчдоос өндөр санал авсан бол пропорционал тогтолцоогоор сонгогдох намын нэрийн жагсаалтын нэр дэвшигчдийн өмнө бичигдэж дахин сонгогдох боломж олгосон заалт Үндсэн хууль зөрчиж байна гэж үзэж хандсан байна. Ингээд уг өргөдөл, мэдээллийг хүлээн авч шалгасан гишүүн зөвхөн "гулсдаг" тогтолцоотой холбоотой асуудлаар маргаан үүсгэж Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар хэлэлцүүлсэн. Ийнхүү хэлэлцээд олонхийн тогтолцоогоор /сонгуулийн 26 тойрогт 48 мандатын төлөө/ өрсөлдсөн нэр дэвшигчдээс тойрогтоо ялагдал хүлээсэн болов 28 ба түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигч улс төрийн нам, эвслийн жагсаалтын эхэнд шилжин орох зохицуулалт хуульчилсан нь ардчилсан ёс, шударга ёс, тэгш байдал, засгийн бүх эрх ард түмний мэдэл байх Үндсэн хуулийн суурь зарчимд харшилсан, иргэний сонгох, сонгогдох эрхийг зөрчсөн болохыг тогтоож хүчингүй болгосон. Үүнээс үзэхэд, "сонгуулийн холимог тогтолцооны талаар буюу намын нэрээр жагсаалтаар сонгогддог асуудлаар Үндсэн хуулийн цэц 2012 онд шийдвэр гаргаагүй бөгөөд Улсын Их Хурлын сонгуульд өрсөлдөөд өөрийнхөө тойрогт ялагдсан атлаа өндөр санал авсан гээд намын жагсаалтын өмнө бичигдэн дахин сонгогдож болох заалтыг байсныг Үндсэн хууль зөрчсөн гэж хүчингүй болгосон" гэсэн тайлбарыг хийсэн байна.[71]

Удаах маргаан буюу Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 04 дүгээр сарын 22–ны өдрийн 05 дугаар дүгнэлт (МУҮХЦ, дүгнэлт №05/2016.04.22.)–ын хувьд, 2015 онд Үндсэн хуулийн цэцэд нэр бүхий иргэний мэдээлэл, гомдлын дагуу сонгуулийн хувь тэнцүүлэх буюу пропорционал тогтолцоотой холбоотой асуудлаар бага суудлын хуралдаанаас маргаан үүсгэсэн ба шалгаж байх хугацаанд нэр бүхий иргэн ижил агуулгатай мэдээлэл ирүүлсэн учир нэгтгэн шалгажээ. Ийнхүү Сонгуулийн тухай хуулийн 28–аас илүүгүй гишүүнийг хувь тэнцүүлэх сонгоно гэсэн заалтууд нь Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийг зөрчсөн гэж дүгнэжээ. Энэ дүгнэлтээрээ "Үндсэн хуулийн дээрх зүйл, заалтыг аль нэг намд бус нэр дэвшигч иргэнд өөрт нь саналаа өгөх замаар Улсын Их Хурлын гишүүнийг сонгох агуулгаар хуульчилсан хэмээн тайлбарлан шийдвэр гаргасан. *Энэ маргааны*

[69] Мөнхсайхан О. "Цэцийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргачлал УИХ э. Н.Хайдав [2007]" Шүүх эрх мэдэл сэтгүүл, Уб., 2015 он, №2, 77 дахь талаас дэлгэрүүлж үзнэ үү. *http://www.judinstitute.mn/shinjilgee/37--2015-2.html* (*last visited 2018.12.30.*)

[70] Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Цэц маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг зөвхөн өргөдөл, мэдээлэл, хүсэлтээр үүсгэн явуулна. Хэрэв эрх бүхий байгууллага, албан тушаалтан шийдвэр гаргахдаа Цэцийн шийдвэрээр хүчингүй болсон хууль болон бусад шийдвэрийн заалтыг шууд буюу агуулгаар нь дахин сэргээвэл Цэцийн аль нэг гишүүний санаачилгаар Цэц хяналтын журмаар хянан шийдвэрлэж болно" гэж хуульчилсан байна. *https://www.legalinfo.mn/law/details/19?lawid=19* (*last visited 2018.12.30.*)

[71] Жанцан Н., Үндсэн хуулийн цэц иргэдийн улс төрийн эрхийн баталгаа болох нь // Constitutional Court (tsets) as the guarantee of citizens' political rights, Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал, (Онол, арга зүй, хэрэгжилт) Уб., 2017 он, 38–39 дэх тал.

тухайд аваад үзвэл хувь тэнцүүлэх тогтолцоонд сайн тал олон байсныг үгүйсгэхгүй. Гагцхүү Үндсэн хуулийн цэц тэр талаас нь биш зөвхөн Монгол Улсын Үндсэн хуульд тусгагдсан үзэл баримтлал, зохицуулалт талаас нь шийдвэрээ гаргасан. Энэ утгаараа Үндсэн хуулийн цэцийн зарим шийдвэр нь Үндсэн хуулийн агуулга, үзэл баримтлалд тайлбар хийж байгаа шинжийг агуулдаг" хэмээн тэмдэглэлийг хийжээ.[72]

Аливаа шүүх, түүний дотор Үндсэн хуулийн цэц хэрэг, маргаан шийдвэрлэхдээ хэрэг маргааны оролцогч (ялангуяа мэдээлэл, өргөдөл, хүсэлт, *гомдол*) нарын гаргасан шаардлагын хүрээнд, эсхүл түүний хүрээнээс хальж шийдвэр гаргаж байх эсэх (*ultra petita* буюу өргөдөл, мэдээллээс цааш яв гэсэн утгатай зарчим) нь ихээхэн маргаантай, практикт (тухайн шүүх эрх мэдлийн) багагүй зөрчилтэйгээр явагддаг. Дурдсан маргаантай холбогдуулан шүүмж бичсэн судалгаа цөөнгүй.[73] Энэ өгүүлэлд чухамхүү энэ утгаар нь илүүтэй хөндөхийг эрмэлзлээ. Иймд сонгуулийн тогтолцооны хууль зүйн үндэслэлийг нийтийн ашиг сонирхлын (*interpreting electional system by public interests*) үүднээс тайлбарлаж болох юм. Тиймээс шаардлагын хүрээнд шийдвэрлэх, түүний эерэг сөрөг тал, нийтийн ашиг сонирхлын болон бусад үндэслэлээр тодорхой хүрээнээс хальж шийдвэрлэхийн дутуу, сул тал гэж аль ч тохиолдолд байдаг. Учир нь Үндсэн хуулийн шүүхийн хяналтад байдаг хэм хэмжээ тогтоосон аливаа шийдвэр зөвхөн маргагч талуудад биш, бүх нийтэд (***erga omnes***) хамааралтай үйлчилдэг онцлогтой. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр бүх нийтээрээ заавал дагаж мөрдөх (***erga omnes***) эрх зүйн баримт бичиг болдог.[74] Энэ нь ердийн шүүх болон бусад аливаа этгээд биелүүлэх үүрэг тогтоосон учраас нийтээр дагаж мөрдөх үүргээр баталгаажсан ийм шийдвэрийг бүгдэд хамаарах нөлөөтэй гэж үздэг.[75]

Дээрх дүгнэлтийг үр дагаврыг тодруулахад маргаан бүхий зүйл (пропорционал тогтолцоог заасан Сонгуулийн тухай хуулийн зарим заалт) нийтийн ашиг сонирхолд хохирол учруулсан байдал, хэрхэн хор уршиг учирч болох эсэхээс хамаарч, түүнд хөндөгдөж буй асуудлыг зайлуулах гэсэн Үндсэн хуулийн цэцэд нэр бүхий иргэд хандсан биш түүнээс илүү хор уршгийг бий болгосон шийдвэрийг гаргуулсан. Энэ нь "гал унтраах гэсэн усанд автуулчихвал юуны тустай байх билээ" гэсэн бодомжтой утга адил юм.

III. ДҮГНЭЛТ, САНАЛ

1/ Монгол Улсын Үндсэн хуульд бататган тунхагласан дурдсан[76] зарчмыг Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны үндсэн зарчим гэж ойлгох нь зөв байх болов уу хэмээн дүгнэн үзлээ. Иймийн учир Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны шинж байдлыг түүний дээр дурдсан үндсэн зарчмуудын агуулгаар нь авч үзэх нь зүйтэй. Үүнээс гадна, Үндсэн хуулийн цэцийн дээрх (МУҮХЦ, дүгнэлт №05/2016.04.22.) шийдвэр нь цаашид монголын эрх зүйн тогтолцоонд сонгуулийн тогтолцооны ойлголт, шинж, ач холбогдол, түүний үр нөлөөг хязгаарласан шийдвэр болсон хэмээн дүгнэх боломжтой. Ийнхүү дүгнэх болсон үндэслэлийг энэхүү өгүүлэл дэх дүн шинжилгээний үр дүн (Монгол Улсын Үндсэн хуульд тусгагдаагүй үзэл санаа үндсэн хуулийн

[72] Мөн номд, 40–41 дэх тал

[73] Мөнхсайхан О., Монгол Улсын Үндсэн хуулиар сонгуулийн холимог тогтолцоог хориглоогүй, Эрх зүй сэтгүүл, Уб., 2016 он, №2, 2 дахь тал.

[74] "Гадаадын их, дээд сургууль төгсөгчдийн эрдмийн бүтээлийн эмхэтгэл" Уб., 2003 он, 101–102 дахь тал.

[75] "Эрх зүй сэтгүүл" Уб., №01(31), 2015 он, 16 дахь тал.

[76] Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлд "Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно" гэж заасан.

зөрчлийг агуулна гэсэн хандлагыг өөрчлөх зайлшгүй шаардлагатайг) нотлон харуулж байна.[77]

2/ Эцэст нь тэмдэглэхэд, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Цэц маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг зөвхөн өргөдөл, мэдээлэл, хүсэлтээр үүсгэн явуулна. Хэрэв эрх бүхий байгууллага, албан тушаалтан шийдвэр гаргахдаа Цэцийн шийдвэрээр хүчингүй болсон хууль болон бусад шийдвэрийн заалтыг шууд буюу агуулгаар нь дахин сэргээвэл Цэцийн аль нэг гишүүний санаачилгаар Цэц хяналтын журмаар хянан шийдвэрлэж болно" гэж заасны дагуу нэгэнт Үндсэн хуулийн цэцээр шийдвэрлэгдсэн тохиолдолд цаашид дээрх (МУҮХЦ, дүгнэлт №05/2016.04.22.) шийдвэрийн үр дагавар хэвээр хадгалагдаж болох юм. Энэ нь Монгол Улс дахь сонгуулийн тогтолцоо, түүний агуулгыг үндсэн хуульд заасан хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд хэрхэн, ямар арга хэлбэрээр тодорхойлж буй асуудалд холбогдох юм.

3/ Сонгуулийн тогтолцооны түүхэн хөгжлийг үндсэн хууль болоод сонгуулийн тухай хуулиудаар хангахад чиглэсэн эрх, хамгаалахыг чиглэсэн эрх ашиг, ашиг сонирхол, хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлого, ардчилсан нийгмийн үнэт зүйлтэй холбон тайлбарлах замаар Монгол Улс дахь сонгуулийн тогтолцоог уламжлагдан шинэчлэгдэх бус харин шинэчлэгдэн уламжлагдах зайлшгүй шаардлагатай байна гэсэн санааг дэвшүүлж байна.

IV. Ашигласан материал

1. Гангабаатар Д., Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал, Уб., 2016 он.

2. Чимид Б., Сонгуульд суралцахуй, Уб., 2008 он.

3. Чимид Б., Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний үндсэн хууль буруутай юу?!, Үндсэн хуульт ёсны төлөвшил цуврал IV, Уб., 2011 он.

4. Лүндэндорж Н., Jurisprudence // Эрх зүй судлал: философи – онол, Уб., 2011 он.

5. Лүндэндорж Н., Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага, Уб., 2002 он.

6. Үндсэн хуулийн маргаан: Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн лавлах бичиг, Уб., 2018 он.

7. Цогтоо Ш., Гадаад орнуудын үндсэн хуулийн эрх зүй, (Харьцуулсан), Уб., 2018 он.

---o0o---

[77] Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2000 оны 3 дугаар сарын 13–ны өдрийн 02 дугаар дүгнэлтийн (МУҮХЦ, *дүгнэлт №02/2000.03.13.*) хянавал хэсэгт ". . . Улсын дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгч гэсэн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг "Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана", Тавин нэгдүгээр зүйлийн 1 хэсэгт "Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ" заасантай зөрчилдөж байн гэж үзэх үндэслэлтэй байна. . . ." хэмээн тэмдэглэжээ. Ийнхүү "Улсын дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгч" гэсэн нь дурдсан Үндсэн хуулийн зүйл, заалтуудыг тус тус зөрчсөн гэж дүгнэжээ. https://www.legalinfo.mn/law/details/1134 (*last visited 2018.12.30.*) Энэ дүгнэлтийг Улсын Их Хурал хэлэлцээд хүлээн зөвшөөрөөгүй тухай Монгол Улсын Их Хурлын 2000 оны 4 дүгээр сарын 21–ний өдрийн 36 дугаар тогтоолыг гаргасан байна. Тиймээс энэ маргааныг дахин Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар хэлэлцээд "маргааны зүйл нь үндсэн хуультай зөрчилдөж байна гэх үндэслэл тогтоогдохгүй байгаа учраас Улсын Их Хурлын 2000 оны 36 дугаар тогтоолын 1 дэх заалтыг хүлээн авах боломжтой" хэмээн үзээд "Улсын дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгч гэсэн нь дурдсан Үндсэн хуулийн зүйл заалтыг зөрчөөгүй байна гэж эцэслэн (МУҮХЦ, тогтоол №01*/2000.09.08.*) шийдвэрлэсэн байна. https://www.legalinfo.mn/law/details/1095 (*last visited 2018.12.30.*)

www.nlegov.mn Хуулийн үндэсний хүрээлэн

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН 72.3 ДАХЬ ЗОХИЦУУЛАЛТЫН ОНОЛЫН ТАЙЛБАР, ПРАКТИК ХЭРЭГЛЭЭ

“Жунсон констракшн” ХХК-ийн хуульч А.Түвшинтөгс

НЭГ. ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Хариуцагч нэхэмжлэлийг гардан авснаас хойш хуульд заасан эсхүл шүүгч тогтоосон хугацаанд хариу тайлбарын үндэслэл, нотлох баримтаа шүүхэд ирүүлээгүй тохиолдолд шүүх хариуцагчийг нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцох ойлголт нь цэвэр хууль зүйн ойлголт билээ. Нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрсөнд тооцох тухай шийдвэрийг англиар Judgement by default хэмээн нэршсэн байдаг. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад хариуцагчийн Иргэний процессийн журмыг зөрчсөнд оногдуулж буй санкци (*Sanction on Procedural irregularities*) хэмээн томьёолсон байдаг[1]. Хариуцагч Иргэний процесс ажиллагааны журмыг зөрчсөнд оногдуулж буй санкци хэмээх ойлголт үүсэн гарах үндэслэл нь хариуцагчийн хариуцлагыг өндөржүүлэх, гарах үр дагаврыг зохицуулан хуульчлахад оршиж байсан. Онолын хувьд нэхэмжлэгч шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүйг тэрээр уг хэргийн талаар сонирхолгүй болсон гэж тайлбарладаг бол хариуцагч шүүх хуралдаанд ирээгүйг нэхэмжлэгчийн шаардлагыг эсэргүүцэхгүй байна гэж үздэг[2].

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа голон улс оронд шүүх хуралдаанаас өмнөх үе шат буюу бэлтгэл ажиллагаа, шүүх хуралдааны үе шат хэмээн хуваан авч үздэг байна. Ингэж хуваан ангилахын ач холбогдол нь шүүх хуралдаанаас өмнөх үе шатны үндсэн элемент нь бичгэн процедур байх, шүүх хуралдааны үндсэн элемент нь аман элемент байна гэж үздэгтэй холбогдон тайлбарладаг. Энэ талаар Freiburg-ийн Их сургуулийн профессор Dieter Leipold “Иргэний процессийн ажиллагааны бэлтгэл үе шат дахь элемент нь бичгэн процедур байна[3]” хэмээн бичжээ. Бичгэн хэлбэрээр тайлбар гаргаснаар талуудын мэтгэлцэх зарчим хангагдаж байгаа нэгэн илэрхийлэл болно. Мэтгэлцэх зарчим нь (*adversary principle*) олон жилийн турш хууль зүйн шинжлэх ухаанд судлагдаж, танилцуулагдсан зарчим бөгөөд нийтлэг болон иргэнлэг эрх зүйн тогтолцоотой улс орнуудад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх

[1] Harald Koch, Frank Diedrich. Germany civil procedure. London. 1998.p.75, Roger blanpain, Paul Lemmens. International encyclopaedia of laws: Civil procedure. London. 1998,Volume1

[2] Ю.Ёоахимски. Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар. Мюнхэн хот., Уб., 2004 он, 175 дахь тал.

[3] Dieter Leipold. oral and written elements within the introductory phase of civil procedure. 11 дэх тал

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ www.pli.edu.mn

ажиллагааны үндсэн зарчим гэж хүлээн зөвшөөрөгдсөнөөс гадна Nominate principle-д хамааруулан ойлгодог[4]. Энэ үүднээс хариуцагч нэхэмжлэлийг гардан авсан өдрөөс хойш хуульд заасан болон шүүгчээс тогтоосон хугацаанд хариу тайлбараа бичгээр шүүхэд ирүүлснээр хариуцагчийн хүсэл зорилго, эсэргүүцэл, татгалзал, хүлээн зөвшөөрч буй эсэх ил тодорхой болж нэхэмжлэгчийн үйл ажиллагааг дэмжих эхлэл болдог. Харин хуульд заасан болон шүүгчээс тогтоосон хугацаанд нь хариу тайлбараа шүүхэд ирүүлээгүй бол нэхэмжлэгч хариуцагчийг буруутган шүүхийн шийдвэр гаргахыг эрэлхийлэх боломжтой гэж тайлбарладаг байна.

Нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрсөнд тооцох хэмээх ойлголтыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны зарим тэргүүлэх зарчмуудыг удирдлага болгон тайлбарлавал:

"Шүүх болон талуудын хооронд процессын шударга ёс үйлчлэх буюу зүй ёсны мэдэгдэх зарчим (the principle of due notice)"-ын тухайд Шүүгчийн зүгээс талуудыг сонсох, хүлээх бөгөөд аливаа тохиолдолд урьдаас дүгнэлт гаргахгүй гэсэн агуулгыг илэрхийлдэг. Шударга шүүхээр шүүлгэхийн тулд талуудын хувьд тайлбар, хариу үндэслэлүүдээ шүүхэд танилцуулах, сонсгох үүргийг хүлээнэ гэж үздэг. Зүй ёсны мэдэгдэх зарчмын суурь шаардлага нь талууд тус бүртээ тухайн тохиолдолд тайлбарын үндэслэл, нотлох баримтыг эсрэг талуудад танилцуулах, мэдэгдэх юм[5].

Хялбаршуулсан шударга ёсны зарчим (*The principle of accelerated justice*) нь онцгой тохиолдолд хэрэглэгддэг зарчим юм. Хялбаршуулсан шударга ёсны зарчмын агуулга нь шүүх хуралдаан хийхгүйгээр зарим тохиолдолд шийдвэр гаргаж болно гэж үздэг бөгөөд уг тохиолдол нь хариуцагч нэхэмжлэгчийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагын эсрэг хариу тайлбар гаргаж өөрийгөө хамгаалаагүй эсхүл хамгаалахгүй тухайгаа илэрхийлж буй үйлдэл, эс үйлдэл хамаардаг байна[6].

Шударга ёсны зарчмын үүднээс тайлбарлавал шүүх шударга ёсыг тогтоох, нийгмийн инженерийн[7] үүргийг гүйцэтгэх институт учир хэн нэгнийг хариуцлагагүй гэсэн үндэслэлээр буруутган талуудыг сонсохгүй байх ёсгүй гэсэн эсрэг тайлбар гаргадгаас гадна "нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн тайлбар нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны зохигч болон гуравдагч этгээдээс тодорхой нөхцөл байдал, үйл ажиллагаа, баримтуудыг хүлээн зөвшөөрсөн идэвхтэй, бодит үйл ажиллагаануудаар тодорхойлогдоно. Ийм учраас Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны зохигч бусдын тайлбарт хариу өгөхгүй байх, маргахгүй байхыг хүлээн зөвшөөрөх үйл ажиллагаанд хамааруулан үздэггүй байна[8]. Зохигч тэдгээрийн төлөөлөгчид, гуравдагч этгээдийн тайлбаруудыг шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар бичгээр эсхүл хуралдааны явцад хуралдааны тэмдэглэлд тусгах замаар хүлээн авна. Тайлбарыг албадан гаргуулахгүй бөгөөд хуулиар тогтоосон эдгээр журмыг хангах замаар авсан, зохигч, тэдгээрийн төлөөлөгч, гуравдагч этгээдийн тайлбар нь нотолгооны хэрэгсэлд тооцогддог"[9] гэж тайлбарладаг. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны шударга ёсны зарчмаас гажих онцгой нөхцөл нь хариуцагч

[4] Niel Andrews. Principles of Civil procedure. London. 1994 он, 12 дахь тал.

[5] Niel Andrews. Principles of Civil procedure. London. 1994. 17 дахь тал.

[6] Niel Andrews. Principles of Civil procedure. London. 1994. 21 дэх тал.

[7] Роское Фаундийн "Ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх онол буюу balancing of interest"

[8] Хянан тохиолдуулсан Т.Мөнхжаргал. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй (Ерөнхий анги).Уб., 2011 он, 110 дахь тал.

[9] Хянан тохиолдуулсан Т.Мөнхжаргал. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй (Ерөнхий анги).Уб., 2011 он. 111 дэх тал.

өөрийгөө хамгаалаагүй тохиолдолд нэхэмжлэгч хариуцагчийн эсрэг үүргээ биелүүлээгүй гэж үзэн шүүхийн шийдвэрийг гаргуулахыг эрэлхийлэх боломжтой гэж үзэж тайлбарладаг байна[10].

ХОЁР. ПРАКТИК СУДАЛГАА

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн (2002 он) 72 дугаар зүйлийн 72.3 дахь зохицуулалтыг шүүх хэрэглэхдээ нэгдүгээр, хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор нэхэмжлэлийг зөвшөөрсөн эсхүл татгалзсан үндэслэл, түүнийг нотлох баримтаа шүүхэд ирүүлээгүй, хоёрдугаарт, шүүх хуралдааны тов мэдэгдэхэд шүүхэд ирж тайлбар өгөөгүй тохиолдолд хариуцагчийг нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцож байна[11].

Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээс иш татвал[12]:

“Хариуцагч нь нэхэмжлэгчийн шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг эс зөвшөөрч байгаа эсэх талаарх тайлбарыг шүүхэд бичгээр ирүүлээгүйгээс гадна шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүй тул Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.3-т заасан “Хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авсан боловч энэ хуулийн 72.2-т заасан үүргээ биелүүлээгүй түүнчлэн энэ хуулийн 77 дугаар зүйлд заасан журмын дагуу шүүхэд ирж тайлбар өгөөгүй бол нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцох” зарчмын үндсэн дээр хэрэг маргааныг хянан шийдвэрлэсэн болохыг дурдаж байна” гэжээ.

“Шүүх хариуцагч талыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.2, 38.1-д заасан үүргээ биелүүлээгүй гэм буруутайн гадна нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн гэж үзэн нэхэмжлэлийг хангав. Хариуцагч нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.2-т заасны дагуу нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрсөн, татгалзсан үндэслэл түүнийг нотлох баримтаа шүүхэд ирүүлэх үүрэгтэй боловч уг үүргээ биелүүлээгүйгээс мөн зүйлийн 72.3-т заасан үр дагавар бий болжээ.[13]” гэжээ.

Шүүхийн практикт хариуцагчийн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дах үүргээ биелүүлээгүй үйл ажиллагааг буруутган гарах үр дагаврыг шийдвэртээ дурдан шүүх шийдвэрлэж буй нь үндэслэл бүхий байна. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2002)-ийн 72 дугаар зүйлийн 72.3-т заасан зохицуулалтын “... түүнчлэн энэ хуулийн 77 дугаар зүйлд заасан журмын дагуу шүүхэд ирж тайлбар өгөөгүй бол...” гэсэн хэсгийг шүүхийн зүгээс хэрэглэх тохиолдолд хариуцагчийн гэм буруутай, үүргээ хуульд заасан хугацаанд биелүүлээгүй үйл ажиллагаанд хариуцлага тооцох, нэхэмжлэгч давуу талаа алдах эрх зүйн үндэслэл тогтсон байна. Шүүхийн зүгээс хариуцагчийн эзгүйд шүүх хуралдааныг явуулах үндэслэл нь хариуцагч шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй, хэргийг шийдвэрлэхэд хангалттай гэж үзэх нотлох баримт цугларсан байх юм. Харин хариуцагчийн зүгээс шүүх хуралдаанд хүрэлцэн ирж аман

[10] Niel Andrews. Principles of Civil procedure. London. 1994. 21 дэх тал.

[11] Дүүргийн иргэний хэргийн хоёрдугаар шүүхийн 3673 тоот шийдвэр (2015-06-03), Дүүргийн иргэний хэргийн хоёрдугаар шүүхийн 3955 тоот шийдвэр (2015-06-16), Сум дундын Иргэний хэргийн шүүхийн 00718 тоот шийдвэр (2015-06-30), Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн шүүхийн 636 тоот шийдвэр, (2011-05-02), Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн шүүхийн 182/ШШ2016/00477 тоот шийдвэр, (2016-08-29)

[12] Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 182/ШШ2016/00477 тоот шийдвэр, (2016-08-29)

[13] Дүүргийн иргэний хэргийн хоёрдугаар шүүхийн 3673 тоот шийдвэр (2015-06-03)

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nlj.gov.mn

хэлбэрээр тайлбар өгөх тохиолдолд хариуцагчид хариуцлага тооцох зорилго бүхий эрх зүйн зохицуулалт үйлчлэлээ алддаг гэдгийг дурдах нь зүйтэй байна. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Австри, Солонгос зэрэг улсуудад "judgement by default" шийдвэрийг гаргахдаа хариуцагч нэхэмжлэлийг гардан авах үед хугацаандаа тайлбараа гаргаагүй тохиолдолд үүсэх эрх зүйн үр дагаврыг сануулж, мэдэгдсэн байхад хангалттай гэж үздэг.

ГУРАВ. ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭНИЙ АСУУДАЛ

Хуулийг хэрэглэхдээ тайлбарлан хэрэглэх нь эрх зүйн шинжлэх ухааны ололтуудын нэг юм. Шинжлэх ухааны үндэслэлтэйгээр харьцуулсан судалгааны арга зүйд тулгуурлан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.3-т заасан зохицуулалтыг тайлбарлая.

III.I ХУУЛИЙГ ТАЙЛБАРЛАН ХЭРЭГЛЭХ НЬ:

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн (2002 он) 72 дугаар зүйлийн 72.2-т "хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш арван дөрөв хоногийн дотор, эсхүл шүүгчээс тогтоосон хугацаанд нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрсөн, эсхүл татгалзсан үндэслэл, түүнийг нотлох баримтаа шүүхэд ирүүлэх үүрэгтэй[14]". Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.3-т Хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авсан боловч энэ хуулийн 72.2-т заасан үүргээ биелүүлээгүй, түүнчлэн энэ хуулийн 77 дугаар зүйлд заасан журмын дагуу шүүхэд ирж тайлбар өгөөгүй бол нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрсөнд тооцож энэ хуулийн 100.3-т зааснаар түүний эзгүйд хэргийг шийдвэрлэнэ хэмээн зохицуулсан.

Дээрх зохицуулалтыг хууль тогтоогчийн хүсэл зоригийн үүднээс тайлбарлавал хариуцагч нэхэмжлэлийг гардан авсан өдрөөс хойш арван дөрөв хоногийн дотор эсхүл шүүгчээс тогтоосон хугацаанд нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрсөн эсхүл татгалзсан үндэслэл, түүнийг нотлох баримтаа ирүүлэх үүргээ огт биелүүлэхгүй тохиолдолд шүүхийн зүгээс нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцохоор зохицуулсан учир нь хариуцагчийн хариуцлагыг өндөржүүлэх, шүүхийн зүгээс хэргийг тал бүрээс бүрэн бодитойгоор шийдвэрлэхэд хамтран ажиллах, шүүхийн ажиллагааг удаашруулахаас сэргийлэх зорилготой хэмээн тайлбарлаж болно.

Хэл зүйн буюу үгийн шууд утгаар тайлбарлавал хүлээн зөвшөөрсөнд тооцох хэмээх үг нь хариуцагчийг нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнтэй адилтган авч үзнэ гэсэн үг юм. Системчлэн тайлбарлах аргаар тайлбарлавал Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд[15] заасан нэг талын гаргасан тайлбарыг эсрэг тал буюу хариуцагч эсэргүүцээгүй, эсхүл хуулиар тогтоосон хугацаанд тайлбар өгөөгүй бол тайлбарыг хүлээн зөвшөөрсөнд тооцохоор зохицуулсан зохицуулалтын үр дагаврыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.3-т зохицуулжээ.

Хууль хэрэглээний хувьд дээрх зохицуулалтыг шүүх хэрэглэхдээ Нэгдүгээрт хариуцагч хуулиар тогтоосон хугацаанд хариу тайлбараа шүүхэд өгөөгүй байх, Хоёрдугаарт шүүх хурлын

[14] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2002-01-10)

[15] Иргэний хэрэг шүүхэд хянан шүүхэд шийдвэрлэх тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2-т Зохигч нэг талын гаргасан тайлбар, нотлох баримтын талаар эсрэг тал өөрийн тайлбараа холбогдох нотлох баримтын хамт гаргаж өгнө, 42.3-т "Энэ хуулийн 42.2-т заасан тайлбарыг зохигч тал гаргахдаа нөгөө талын гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн буюу түүний зарим хэсгийг хүлээн зөвшөөрч болно.", 42.4-т "Нэг талын гаргасан тайлбарыг эсрэг тал эсэргүүцээгүй, эсхүл хуулиар тогтоосон хугацаанд тайлбар өгөөгүй бол тайлбарыг хүлээн зөвшөөрсөнд тооцно" гэж зохицуулжээ.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

товыг мэдсэн ч шүүх хуралдаанд ирээгүй байх гэсэн урьдчилсан нөхцөлийг тогтоодог. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар хариуцагч хариу тайлбараа шүүхэд гаргаж өгөх үүргээ биелүүлээгүй, хугацаа хожимдуулсан тохиолдолд нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцох боломжгүй байдал үүсдэг. Үндэслэл шалтгаан нь хууль хэрэглээний үүднээс дээрх зохицуулалт шүүхийн бэлтгэл ажиллагаанд бичгэн хэлбэрээр тайлбар гаргах, шүүхийн шатанд аман хэлбэрээр тайлбар гаргах боломжийг олгосон зохицуулалт юм. Бичгэн хэлбэрээр тайлбар гаргаагүй тохиолдолд нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцох боломжтой ч шүүх хуралдаанд аман хэлбэрээр тайлбар гаргах тохиолдолд нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцон шийдвэрлэх боломжгүй байна[16].

Гадаад орнуудын[17] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг судлан үзэхэд хариуцагчийн хариу тайлбар гаргах үйл ажиллагааг түүний үүрэг хэмээн үзэж[18], хуульд заасан хугацаанд хариу тайлбарын үндэслэл, нотлох баримтаа шүүхэд ирүүлээгүй тохиолдолд хариуцагч үүргээ биелүүлээгүй гэж нэхэмжлэгчийн талд хариуцагчийн эсрэг judgement by default шийдвэрийг гаргадаг. Гэхдээ Нэхэмжлэгчийн тайлбар түүний шаардлагыг хангалттай үндэслэж байсан нөхцөлд л хариуцагчийн эзгүйд шийдвэрлэж болно. Нэхэмжлэлийн шаардлага хангалттай үндэслэлгүй байвал хариуцагч хугацаа хожимдуулсан үед ч гэсэн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгоно. Гэхдээ ийм тохиолдолд нэхэмжлэл үндэслэлгүй байгаа тухай нэхэмжлэгчид мэдэгдэнэ[19].

Солонгос Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн[20] 255 дугаар зүйлийн 255.1-т "Шүүх хариуцагчид нэхэмжлэлийн хувийг гардуулах ажиллагааг явуулна", 256 дугаар зүйлийн 256.1-т "Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг эсэргүүцэж байгаа тохиолдолд, нэхэмжлэлийн хувийг гардан авсан өдрөөс хойш гуч хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ[21].", 256.2-т Шүүх нэхэмжлэлийн хувийг гардуулах ажиллагааг явуулахдаа хариуцагчид нэхэмжлэлийн шаардлагыг эсэргүүцэж байгаа тохиолдолд, нэхэмжлэлийн хувийг гардан авсан өдрөөс хойш гуч хоногийн дотор бичгээр мэдэгдэхийг сануулж, мэдэгдэнэ." гэж тус тус зохицуулсан байна.

Мөн Солонгос Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн[22] 257 дугаар зүйлийн 257.1-т "Хариуцагч нэхэмжлэлийн хувийг гардан авсан өдрөөс хойш гуч хоногийн дотор нэхэмжлэлийн шаардлагыг эсэргүүцэж байгаа талаар бичгээр тайлбар гаргаагүй үед, шүүхийн зүгээс хариуцагч нэхэмжлэлийн шаардлагад тусгагдсан фактуудыг хүлээн

[16] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.3-т заасан зохицуулалтад "...түүнчлэн..." хэмээн заасан нь уг зохицуулалт хоёр урьчилсан нөхцөлтөй байх хууль тогтоогчийн хүсэл зоригийг илэрхийлсэн байна.

[17] Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд найрамдах Солонгос Улс, Авсри Улс гэх мэт.

[18] Монгол Улсын хувьд ч бас үүрэг хэмээн үздэг. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн (2002 он) 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт заасан "Зохигч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд өөрийн шаардлага ба татгалзлын үндэс болж байгаа байдлын талаарх нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах үүрэгтэй" гэдгийг: "Нэхэмжлэгч түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч нэхэмжлэлийн шаардлагаа, хариуцагч түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд нь нэхэмжлэгчийн шаардлагыг хүлээн авахаас татгалзаж байгаа үндэслэлээ нотолсон тайлбар ...хүсэлт гаргахыг ойлгоно" гэж тайлбарлажээ.

[19] Ю.Ёоахимски. Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар. Мюнхэн хот., Уб., 2004 он, 128-129 дэх тал.

[20] Солонгос Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (Civil procedure act- Republic of Korea), (Act No. 547 of April 4, 1960, as amended up to Act No. 10373 of July 23, 2010), http://www.wipo.int/wipolex/en/details.jsp?id=7144

[21] Si Cheol Kim, Introduction to the Korean Civil Procedure: An Overview, 2008 он, 5 дахь тал

[22] Солонгос Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (Civil procedure act- Republic of Korea), (Act No. 547 of April 4, 1960, as amended up to Act No. 10373 of July 23, 2010), http://www.wipo.int/wipolex/en/details.jsp?id=7144

Хуулийн мэдээлэл, судлалын төв www.nlsc.mn

зөвшөөрсөнд тооцож хариуцагчийг ямар ч тайлбар гаргах эрхгүйгээр шүүх хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.”, 257 дугаар зүйлийн 257.3-т Шүүх хариуцагчид нэхэмжлэлийн хувийг гардуулах ажиллагааг явуулах үед гарах үр дагаварын талаар сануулна гэжээ. Солонгос Улсад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дах бэлтгэл үе шатанд хариуцагчаас зөвхөн бичгэн тайлбарыг шаарддаг байна[23].

Герман Улсад хариуцагч нэхэмжлэлийг гардан авснаас хойш арван дөрвөн хоногийн дотор хариу тайлбарын үндэслэл, нотлох баримтаа шүүхэд өгөөгүй бол хариуцагчаас аман тайлбар шүүх хуралдаан дээр авах шаардлагагүйгээр Иргэний хэргийн процессийн ажиллагааг дуусгавар болгож болдог[24]. Хариуцагчийг үүргээ биелүүлээгүй хэмээн нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрсөнд тооцож шийдвэр гаргаж байгаа нь хариуцагчид оногдуулж буй Иргэний процессын ажиллагааны зөрчлийн хариуцлага (Sanction on Procedural irregularities) гэж Германд үздэг байна[25].

Герман Улсад хариуцагч нэхэмжлэлийн хувийг гардан авснаас хойш хоёр долоо хоногийн дотор хариу тайлбарыг шүүхэд гаргах үүрэгтэй. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Иргэний процессын хуулийн[26] 269 дүгээр зүйлийн 269.2-т “Нэхэмжлэлийн хувийг гардуулан өгсөн өдрөөс хойш хуульд заасан хугацаа буюу хоёр долоо хоногийн дотор бичгэн тайлбараа шүүхэд ирүүлээгүй бол нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрсөнд тооцож, эсэргүүцлийг хүчингүйд тооцно. Урьдаас хариуцагчид энэхүү үр дагаврыг мэдэгдсэн байна.” гэж заасан байна.

Австри Улсын хувьд Иргэний процессийн шүүхийн үе шатыг шүүх хуралдаанаас өмнө үе шат, дараах үе шат хэмээн ангилан үздэг. “Шүүхийн бэлтгэл үе шат нь шүүх хуралдааны хамгийн ач холбогдол бүхий үе шат гэж үзэх хандлага[27] Австри Улсад зонхилж буй талаар Австрийн Венийн Их сургуулийн Профессор Walter Rechberger дурджээ. Хариуцагч нь нэхэмжлэлийн шаардлагын эсрэг хязгаарлагдмал цаг хугацаанд буюу 14 хоногийн дотор бичгэн хэлбэрээр хариу тайлбарыг гаргах үүрэгтэй бөгөөд энэхүү үүргээ хуулиар тогтоосон хугацаанд үл биелүүлсэн тохиолдолд бусад талуудын хүсэлтээр хариуцагчийг үүргээ биелүүлээгүй хэмээн шүүх үзэн хүлээн зөвшөөрсөнд тооцсон шийдвэрийг гаргаж болно гэж үздэг байна[28].

Холбооны Бүгд найрамдах Герман Улс, Солонгос, Австри Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зохицуулалтад хариуцагч хуульд заасан болон шүүгчийн тогтоосон хугацаанд хариу тайлбарын үндэслэлээ, нотлох баримтаа шүүхэд ирүүлээгүй тохиолдолд шүүхийн зүгээс хариуцагчид шүүх хуралдаанд аман болон бичгэн тайлбар гаргах эрхийг олгохгүйгээр judgement by default шийдвэрийг гаргахаар зохицуулсан байна. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.3-т заасан зохицуулалтыг бусад улсын жишигт нийцүүлэн хэрэглэх нь тус зохицуулалтын ач

[23] Dieter Leipold. oral and written elements within the introductory phase of civil procedure. 13 дахь тал http://www.uv.es/coloquio/coloquio/ponencias/5oraleip.pdf

[24] Harald Koch, Frank Diedrich. Germany civil procedure. London. 1998.p.32, Roger blanpain, Paul Lemmens. International encyclopaedia of laws: Civil procedure. London. 1998,Volume1, Dieter Leipold. oral and written elements within the introductory phase of civil procedure. 12 дахь тал http://www.uv.es/coloquio/coloquio/ponencias/5oraleip.pdf

[25] Harald Koch, Frank Diedrich. Germany civil procedure. London. 1998.p.75, Roger blanpain, Paul Lemmens. International encyclopaedia of laws: Civil procedure. London. 1998,Volume1

[26] Орчуулсан: Samson Übersetzungen GmbH, Dr. Carmen von Schöning. Civil procedure law in Germany (Version of the Code of Civil Procedure dated 30 January 1877)

[27] Roger blanpain, Paul Lemmens. International encyclopaedia of laws: Civil procedure. London. 1998.p.47,Volume1

[28] Roger blanpain, Paul Lemmens. International encyclopaedia of laws: Civil procedure. London. 1998.p.46,Volume1

холбогдлыг илэрхийлэх үндэслэл болно. Нэхэмжлэгч нотлох үүргийн хуваарилалтын зарчмын үүднээс буруутгаж буй этгээдийн буруутайг нотлох үүднээс нотлох баримтыг шүүхэд гаргах үүргийг хүлээнэ. Нэхэмжлэгч энэхүү үүргээ үл биелүүлэх тохиолдолд шүүхийн зүгээс нэхэмжлэгчид үүргээ үл биелүүлсэн, шүүхтэй хамтран ажиллах зарчмыг баримтлаагүй гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийг буцаах зохицуулалт бий. Харин Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг эсэргүүцэж, татгалзаж, зөвшөөрч буй эсэх тухай хариу тайлбар, нотлох баримтаа шүүхэд ирүүлээгүй тохиолдолд хариуцагчийг нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцож санкци олгох зохицуулалт нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.3-т заасан зохицуулалт юм.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн (2002 он) 72 дугаар зүйлийн 72.3 дахь зохицуулалтыг шүүх хэрэглэхдээ Нэгд, хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор нэхэмжлэлийг зөвшөөрсөн эсхүл татгалзсан үндэслэл, түүнийг нотлох баримтаа шүүхэд ирүүлээгүй, Хоёрдугаарт, шүүх хуралдааны тов мэдэгдэхэд шүүхэд ирж тайлбар өгөөгүй тохиолдолд хариуцагчийг нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцож байна.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Солонгос Улс, Австри Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зохицуулалтад хариуцагч хуульд заасан болон шүүгчийн тогтоосон хугацаанд хариу тайлбарын үндэслэлээ, нотлох баримтаа шүүхэд ирүүлээгүй тохиолдолд шүүхийн зүгээс хариуцагчид шүүх хуралдаанд аман болон бичгэн тайлбар гаргах эрхийг олгохгүйгээр judgement by default шийдвэрийг гаргахаар зохицуулсан байна. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.3-т заасан зохицуулалтыг бусад улсын жишигт нийцүүлэн хэрэглэх нь тус зохицуулалтын ач холбогдлыг илэрхийлэх үндэслэл болно.

Санал: Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хариуцагч үүргээ биелүүлэхгүй үйлдэлд оногдуулах санкцын эрх зүйн зохицуулалт үндсэн агуулгаараа хэрэгжиж чадахгүй байгаа үндэслэл нь шүүх хуралдааны шатанд хариуцагчид аман тайлбар гаргах боломж олгосон явдал юм. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.3-т заасан зохицуулалтыг "Хариуцагч нэхэмжлэлийн хувийг гардан авсан өдрөөс хойш арван дөрөв хоногийн дотор нэхэмжлэлийн шаардлагыг эсэргүүцэж байгаа талаар бичгээр тайлбар гаргаагүй үед, шүүхийн зүгээс хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцож хариуцагчийг ямар ч тайлбар гаргах эрхгүйгээр шүүх хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэнэ" хэмээн өөрчлөх саналтай байна.

ТАВ. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Хянан тохиолдуулсан Т.Мөнхжаргал. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй (Ерөнхий анги).Уб., 2011 он, 111 дэх тал.

Ю.Ёоахимски. Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар. Мюнхэн хот., Уб., 2004 он, 128-129 дэх тал.

Niel Andrews. *Principles of Civil procedure*. London. 1994. 21 дэх тал.

Si Cheol Kim, *Introduction to the Korean Civil Procedure: An Overview*, 2008 он, 5 дахь тал.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ГАЗАР www.num.edu.mn

Dieter Leipold. *oral and written elements within the introductory phase of civil procedure*. 13 дахь тал http://www.uv.es/coloquio/coloquio/ponencias/5oraleip.pdf

Harald Koch, Frank Diedrich. Germany civil procedure. London. 1998.p.75, Roger blanpain, Paul Lemmens. International encyclopaedia of laws: Civil procedure. London. 1998,Volume1

Roger blanpain, Paul Lemmens. International encyclopaedia of laws: Civil procedure. London. 1998.p.47,Volume1.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2002-01-10, Дугаар.8)

Орчуулсан: Samson Ьbersetzungen GmbH, Dr. Carmen von Schцning. *Civil procedure law in Germany* (Version of the Code of Civil Procedure dated 30 January 1877)

Солонгос Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (Civil procedure act- Republic of Korea), (Act No. 547 of April 4, 1960, as amended up to Act No. 10373 of July 23, 2010), http://www.wipo.int/wipolex/en/details.jsp?id=7144

Дүүргийн иргэний хэргийн хоёрдугаар шүүхийн 3673 тоот шийдвэр (2015-06-03), Дүүргийн иргэний хэргийн хоёрдугаар шүүхийн 3955 тоот шийдвэр (2015-06-16), Сум дундын Иргэний хэргийн шүүхийн 00718 тоот шийдвэр (2015-06-30), Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн шүүхийн 636 тоот шийдвэр, (2011-05-02), Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн шүүхийн 182/ШШ2016/00477 тоот шийдвэр, (2016-08-29).

---o0o---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

ШҮҮХ ЭРХ МЭДЭЛ-ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС БАЙДАЛД АВЛИГА НӨЛӨӨЛӨХ НЬ

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын ахлах мэргэжилтэн Н.Онударь

УДИРТГАЛ:

Монгол Улсын Үндсэн хуульд шүүх эрх мэдэл хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдэлтэй харилцан хяналт тэнцвэртэй, чиг үүрэг нь халдашгүй дархан, бие даасан удирдлага, зохион байгуулалттай болохыг үзэл баримтлалын төвшинд тодорхойлсны зэрэгцээ “шүүх эрх мэдлийг хэрэгжүүлнэ”, “шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно”, “шүүх үйл ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хариуцна”, “шүүх бие даасан шүүгч хараат бус байна”, “хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй” гэж заасан нь Монгол Улсад шүүх эрх мэдлийн хараат бус байдлын Үндсэн хуулийн эрх зүйн үндэс бүрэлдсэн байдаг. Шүүгчийг томилохдоо мэдлэг, ёс зүйтэй, шударга шулуун байдал, тал үл харах буюу төвийг сахих байдлаасаа илүү нам, засгийн бодлогод үнэнч байх, улс төрийн хувьд найдвартай байдлыг харгалздаг байжээ.[1] Мөн шүүх нь гүйцэтгэх эрх мэдлийн бүрэлдэхүүнд багтдаг байсан нь шүүх, шүүгч нарын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үүрэг бүхий төрийн байгууллага тэдгээрт хамгийн их нөлөө үзүүлж шүүгчид нэр дэвшихэд намын гишүүн байхыг шаарддаг, намд үнэнч байж л албан тушаалын шатлалаар өгсөх боломжтой байжээ.[2]

Харин Монгол Улсын шинэ Үндсэн хууль нь шүүх эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдэлтэй ижил түвшинд тогтоон тунхаглаж, Үндсэн хуульд шүүхийн байгууламжтай холбоотой олон зарчмыг тогтоож өгснөөрөө онцлог юм. Монгол Улсын Үндсэн хууль төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэлд харилцан тэнцвэртэй, хяналттай, бие даасан байх зарчмын дагуу хуваарилснаар Монгол Улсын түүхэнд анх удаа шүүх эрх мэдэл нь Үндсэн хуулийн дагуу бие дааж бусад эрх мэдлээс хараат бус байх төдийгүй тэдгээрийг хуулийн хүрээнд хянах, эрх мэдлийн хувьд тэнцвэртэй, аливаа хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх бүрэн эрх бүхий эрх мэдлийн зохион байгуулалт, тогтолцоо болсон юм[3]. Шүүх эрх мэдлийн хараат бус байдал нь төрийн эрх мэдлийн тогтолцоонд шүүх бие даан оршиж байдаг бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд шүүх эрх мэдлийн хараат бус байдлыг “шүүхийн бие даасан,

[1] Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ Уб., 2016 он, Шүүх эрх мэдэл 110 дахь тал.

[2] Монгол Улсын 1992 оны үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ Уб., 2016 он, Шүүх эрх мэдэл 113 дахь тал.

[3] Улсын дээд шүүхийн шүүгч Л.Бямбаа Шүүхийн бие даасан шүүгчийн хараат бус байдлын тухай Үндсэн хуулийн эрх зүйн үндэслэл Монгол Улсын Үндсэн хуулийн цэц-илтгэлийн эмхэтгэл /2007/ 68 дахь тал.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.pli.gov.mn

шүүгчийн хараат бус байдал" гэсэн хоёр зарчмын нийлбэр гэх үзлээр Үндсэн хуульд томьёолсон байна.[4] Харин шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд буюу шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд юу саад болж мөн гагцхүү юу ганхуулж байна вэ гэдэг асуудал хөндөгдөнө. Тиймээс шүүх тогтолцоон дахь авлигын асуудлыг тодорхойлж, түүний шалтгаан ба илтгэх үзүүлэлтийг судлахыг зорьсон юм. Түүнчлэн, авлигатай тэмцэх нөөц бололцоог судалж шүүхийн албан тушаалтнуудын цалин хангамж зэрэг шүүхийн төсөв хөрөнгө, шүүхийн дэд бүтцэд зарцуулагдах санхүүжилттэй холбоотой асуудлыг олон улс оронтой харьцуулан авлигаас урьдчилан сэргийлэх талаас нь авч үзэн шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг бататгах арга замыг судлахыг хичээж мөн шүүхийн бие даасан байдлыг хангах болон шүүхийн үйл ажиллагаанд тавих хяналт хоорондын зохистой харьцаа, тэдгээрийн харилцан хамаарал нь авлигыг таслан зогсоох үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд хэр ач холбогдолтой эсэх талаар авч үзсэн болно.

Нэг. Шүүхийн хараат бус байдал

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана." гэж заасан нь шүүх эрх мэдлийн мөн чанар, гол онцлог, шударга ёс, шүүгчийн статусын амин сүнсийг илэрхийлсэн Үндсэн хуулийн зарчим бөгөөд шинэ үзэл баримтлалын цөм нь мөн.

Олон улсын баримт бичгүүд болон Банглорын зарчмын жишгийг үндэс болговол шүүхийн хараат бус байдал дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:[5]

1) шүүх нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдэлтэй ижил эрх зүйн байдалтай төрийн бие даасан эрх мэдэл;

2) хараат бус байдлаа хадгалахын тулд шүүх нь бодлогоо өөрөө тодорхойлно;

3) шүүхийн төсвийг өөрсдөө боловсруулж, батлуулахаар парламентад оруулна;

4) шүүгч нарыг томилох буюу сонгох, дэвшүүлэх журам нь ил тод, тодорхой байх;

5) шүүгч нарыг бүх насаар нь томилох;

4) шүүгч нарын цалин нь амьдралд хүрэлцээтэй байх;

6) шүүгч нар боловсрол, туршлагын хувьд наад захын өндөр шаардлага хангасан байх;

7) шүүгчийг дэвшүүлэх нь түүний мэргэжлийн мэдлэг, туршлага, ёс зүйн чанарыг бодитоор үнэлсний үндсэн дээр хийгдэх;

8) шүүгчид сахилгын арга хэмжээ ногдуулах буюу огцруулах ажиллагааг зөвхөн сахилгын зөрчил гаргасан, эсхүл ажил эрхлэх чадваргүй болсны үндсэн дээр ихэнх төлөв буюу бүхэлдээ шүүгч нараас бүрдсэн сахилгын баг хэрэгжүүлэх учиртай. Эдүгээ шүүгч нарыг ажилд томилох, дэвшүүлэх, сахилгын шийтгэл ногдуулах, бүрэн эрхийн хугацаа, цалин хангамж ба шүүхийн санхүүжилттэй холбоотой хараат бус байдлын үндсэн баталгаа Монгол Улсад Үндсэн хуулийн болон бусад хуулийн түвшинд бий болсон гэж үзэж болно. Тэгвэл шүүгчийн хараат бус байдлыг зөвхөн шүүхийн албан тасалгаанд бус амьдралынх нь бүх орчинд авч үзэх ёстой. Албан ажил мэргэжлийн хараат бус байдал, хувийн

[4] Улсын дээд шүүхийн шүүгч Л.Бямбаа Шүүхийн бие даасан шүүгчийн хараат бус байдлын тухай Үндсэн хуулийн эрх зүйн үндэслэл Монгол Улсын Үндсэн хуулийн цэц-илтгэлийн эмхэтгэл /2007/ 68 дахь тал.

[5] Шүүхийн ерөнхий зөвлөл шүүхийн судалгаа, мэдээллийн төв, Олон Улсын онол-практикийн бага хурлын илтгэлийн эмхтгэл-Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахад шүүхийн захиргааны үүрэг, тулгамдсан асуудлууд-/2014/, 22 дахь тал

Хуулийн зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

хараат бус байдал гэх зэрэг шүүгчийн хараат бус байх бүхий л бололцооны түвшинд судлах нь чухал. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх онцгой чиг үүрэг бүхий шүүгч нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох баталгаа болдог тул ардчилсан нийгмийн аль ч үед анхаарлын төвд байдаг. Тийм ч учраас шүүгчид хууль зүйн мэдлэг, ур чадвар, туршлага төдийгүй ёс зүй, зан чанарын хувьд бусдаас хүлээн зөвшөөрөгдсөн байж, аливаа нөлөөллөөс ангид, хэнээс ч хараат бус байдлаар үйл ажиллагаа явуулж гагцхүү хууль, шударга ёсонд захирагдах учиртай.

1.1. Шүүхийн хараат бус байдлыг хангах нь

Монгол Улс нь шүүхийн шинэтгэлийг шилжилтийн үе буюу 1992 оноос хойш үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа бөгөөд 2013 он хүртэл нэг л хуулиар шүүхийн зохион байгуулалт, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын баталгаа, шүүгчийн сонгон шалгаруулалт, шүүхийн захиргааны асуудлыг зохицуулж байсан. 2013 онд Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүхийн захиргааны тухай хуулийг баталж шүүх эрх мэдлийн хүрээн дэх эрх зүйн зохицуулалтыг илүү шинэчлэн хуульчилсан. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар анхан шат, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шүүгчид тавигдах шаардлагыг нарийвчлан зааж, нэр дэвшигчийг шалгах арга, ажиллагаа болон шүүгчийг сонгон шалгаруулах тогтолцоонд хэд хэдэн өөрчлөлт оруулсан. Мөн түүнчлэн шүүгчийг огцруулах, чөлөөлөх үндэслэл, журмыг нарийвчлан зохицуулсан эрх зүйн орчныг бий болгон шинэчлэл хийсэн байна.

Гэсэн хэдий ч судалгаанаас үзэхэд шүүгчийн сонгон шалгаруулах ажиллагаа, шүүгчид тавигдаж буй шалгуур бодитой, объектив болж чадаагүй, шүүгчийг сонгон шалгаруулах ажиллагааг албан тушаалтан өөрийн үзэмжийн хүрээнд шийдвэрлэх бололцоо байсаар байна[6]. Мөн шүүхийн бүтэц, зохион байгуулалт өөрчлөлтийн үед Үндсэн хуулийн дагуу шүүгч хугацаагүй томилогдох зарчим зөрчигдөж, зарим шүүгч албан тушаалаасаа чөлөөлөгдсөн, зарим шүүгчийг өөрийнх нь зөвшөөрөлгүй шилжүүлэн томилсон тохиолдол гарсаар байгаа.[7]

Улс орон бүр шүүхийн бие даасан хараат бус байдлыг хууль тогтоомждоо хуульчлан зааж практикдээр хамгаалдаг байх шаардлагатай. Шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөх гаднын нөлөөлөл нь маш олон хэлбэртэй байдаг. Төр, засгийн албан тушаалтнууд эсхүл хэрэг маргааны оролцогч талуудын зүгээс тодорхой хэрэг маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар шүүгчдэд тушаал заавар өгөх зэргээр шууд нөлөөлөх нь ч бий. Түүнчлэн нөлөөллийн шууд бус хэлбэрүүд ч байна. Шүүгчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох оролцоог хязгаарлаж шүүгчийг хамгаалахын тулд төр засгийн зүгээс шүүгчдийг сонгох томилох дэвшүүлэх үнэлж дүгнэх хариуцлага тооцох тогтолцооны шударга ил тод байдлыг хангах хэрэг маргааныг хуваарилах тогтолцоог стандартчилах шаардлагатай. Шүүх хурлын процедур нь тогтсон дүрэм журмыг байнга хэлбэрэлтгүй дагаж мөрдөх байдлаар хууль дээдлэх ёсыг сахиж байх ёстой. Ял шийтгэл оноох, хариуцагч түүний өмгөөлөгчийг хамгаалах талуудын мэдээлэл авах болон хэрэгтэй танилцах тэгш эрхийг хангахтай холбоотой

[6] Шүүгчийн томилгооны өнөөгийн нөхцөл байдал-судалгааны тайлан /2016/ Нээлттэй нийгэм форум. Дугаар 18.

[7] Монгол Улсын 1992 оны үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ /2016/-Шүүх эрх мэдэл 114 дахь тал

зааварчилгаа хамгаалалтыг бий болгох шаардлагатай. Эрх зүйн системийн гол зорилго нь шүүхийн хараат бус байдлыг хангах явдал байдаг бөгөөд шүүхийн томилгооны механизм нь энэхүү зорилгыг хангахад чухал нөлөөтэй гэж үзэж байна. Учир нь шүүгчийн үнэнч, шударга, хараат бус байдал нь шүүгчийг томилох механизмтай шууд холбоотой.

"Шүүгчийн сонгон шалгаруулалтын арга нь зохисгүй шалтгаанаар шүүгчийн томилгоог хийхгүй байх баталгааг хангасан байна"[8] гэсэн зөвлөмж, түүнчлэн Европын зөвлөлийн сайд нарын хорооноос гишүүн орнууддаа зөвлөсөн зөвлөмжид "шүүгчийн хувийн карьертэй холбоотой аливаа шийдвэр, шүүгчийн сонгон шалгаруулалт нь мерит зарчим болон мэргэшсэн байдал, шударга чанар, ур чадвар, ажлын үр дүн зэрэг бодит шалгуурт тулгуурлах ёстой"[9] гэсэн дүгнэлт манай улсад ач холбогдолтой бөгөөд үүнийг хэрэгжүүлж ажиллах нь маш чухал байна.

Хоёр. Шүүх, шүүгчийн хараат бус байдалд авлига нөлөөлөх нь

Монгол Улс Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын гишүүн орны хувьд авлигын хэргийг мөрдөн шалгах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор халдашгүй байдлыг тэнцвэртэй хэрэглэх үүрэг хүлээсэн болно. Уг конвенцыг 2006 онд соёрхон баталсан тул дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил заавал мөрдөх эрх зүйн акт юм. Сүүлийн жилүүдэд Дээд шүүхийн болон дагнасан шүүхийн шүүгчид авлигын гэмт хэрэгт сэжиглэгдэх болсонтой холбоотойгоор халдашгүй байдлын агуулга тодорхой хэмжээнд хөндөгдөх болсон. "Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн албан хаагчдад албан үүргээ гүйцэтгэхэд нь туслах зорилгоор олгож байгаа халдашгүй байдлыг шаардагдах хамгаалалтаас хэтрүүлэн хэрэглэж байгаа нь тус конвенцын дагуу гэмт хэрэгт тооцогдох хэргийг мөрдөн шалгах, шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулж байна.[10]" гэжээ.

Шүүхийн хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцох нь хууль дээдлэх ёс, шударга шүүхэд хандах боломжоор хангах чухал ач холбогдолтой. Шүүх тогтолцоон дахь авлига нь хэрэг, маргаанд оролцогч талуудын эрхийг хөнддөгөөс гадна эрх зүйн тогтолцооны суурийг ганхуулж, улс орны засаг захиргаа, эдийн засгийг бүхэлд нь өндөр түвшний авлигыг бий болгодог. Авлига нь орон нутгийн шүүхээс эхлээд бүх шатны шүүх, түүнчлэн Шүүхийн Ерөнхий зөвлөл хүртэл улс орны хэмжээнд шүүх засаглалын бүхий л үе шатад нөлөөлдөг. Шүүх засаглал дахь авилга нь олон хэлбэртэй байдаг ч тэр болгонтой тэмцэхийн тулд төр засаг, шүүх тогтолцооны зүгээс батлан хэрэгжүүлж болох хууль зүйн болон арга зүйн шинжтэй хамгаалах арга хэрэгсэл маш олон бий.

2.1. Шүүх засаглал дахь авлигын шалтгаан ба хэлбэрүүд

Шүүх засаглал дахь авлига нь авлига гэх ерөнхий утгаараа ихээхэн төвөгтэй үзэгдэл. Асуудлыг шууд өдөөдөг анхан шатны шалтгаан, тогтолцооны түвшинд оршиж, асуудлыг бүхэлд нь тодорхой болгодог авлига бий болох боломжийг олгодог суурь шалтгаануудыг ялгаж зааглаж үзэх нь зүйтэй юм. Шүүгчид, шүүхийн ажилтнуудын цалин бага, олон нийтийн мэдээлэл авах эрх хязгаарлагдмал мэргэжлийн ур чадвар сул, хууль тогтоомжийн зохицуулалт тодорхойгүй байх зэрэг нь авлигын анхан шатны

[8] НҮБ-ын Шүүхийн байгууллагын хараат бус байдлын талаарх үндсэн зарчмуудын 10 дахь хэсэгт http://www.unodc.org/unodc/en/treaties холбоосоор үзнэ үү.

[9] Шүүгчийн үүрэг болон ажлын бүтээмж, хараат бус байдлын тухай европын зөвлөмж http://www.unodc.org/unodc/en/treaties холбоосоор үзнэ үү.

[10] "Монгол Улсын тайлан" (НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба, 2011) 5-8 дугаар тал.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

шалтгаан болдог. Нөгөөтэйгүүр засаглалын эрх мэдлийг салгаж зааглаагүй, институциуд нь сул, шүүхийн шийдвэр гаргах эрх мэдлийг хэрэгжүүлж буй байдалд үр нөлөөтэй хяналт тавьдаггүй, хууль сахиулалт хангалтгүй байх зэрэг нь шүүх тогтолцоонд авлигыг нөхцөлдүүлж байгаа үндсэн шалтгаануудын жишээ юм. Шүүх тогтолцоонд нөлөөлөх авлигын шинжтэй үйлдлийг янз бүрийн түвшний гүйцэтгэх засаглалын гишүүд зэрэг хэд хэдэн төрлийн оролцогчдын зүгээс гаргаж болно. Шүүх тогтолцоон дахь авлигын нэг хэлбэр болох шууд, эсвэл гуравдагч талын оролцоотойгоор дамжин хийгдэх зохион байгуулалттай гэмт хэрэг нэн хор хөнөөлтэй байдаг. Иймэрхүү хүчирхэг бүлгүүд буюу талуудаас гадна тодорхой хэргийн шийдвэрт нөлөөлөх гэсэн энгийн иргэд хээл хахуульд холбогдох шалтгаан болдог.

Шүүх тогтолцоон дахь авлига нь шүүгч, шүүхийн албан тушаалтнууд төсвийн өмч хөрөнгийг хувьдаа завших, эсхүл танил тал харж улс төржсөн томилгоо хийх зэрэг янз бүрийн хэлбэрээр илэрч болно. Шүүх засаглал дахь авлига нь төсвийн хөрөнгө мөнгийг шамшигдуулах бизнесийн эсхүл улс төрийн дэмжлэг туслалцаа авсны хариуд томилгоо хийх зэргээр үл хязгаарлагдах ба тодорхой нэг талын ашиг сонирхолд нийцүүлж шүүхийн шийдвэр гаргах зорилгоор хуулийг зүй бусаар ашиглахыг дэмждэг байна. Түүнчлэн шүүгчид албан тушаал ахих тэтгэмж тэтгэлэг шагнал урамшуулал хүртэх боломжоо нэмэгдүүлэхийн тулд аливаа шийдвэрийг засгийн газрын эрх ашигт нийцүүлж гаргах нь бий.[11]

2.2 Шүүх засаглалын авлигыг илтгэх үзүүлэлтүүд

Илтгэх үзүүлэлтүүд нь гол төлөв шүүх чиг үүргээ хэр үр нөлөөтэй хэрэгжүүлж байгаа болон хэрэг маргааныг шийдвэрлэсэн байдал нь эрх зүйн хөдөлшгүй үндэслэлд тулгуурласан эсэхийг хэмжих зорилготой байдаг. Үүнд шийдвэрлэлтийн хугацаа алдсан байдал буюу хэргийг хуульд заасан шалгах тодорхой хугацаанд шийдвэрлэсэн эсэх, нотлох баримтыг үл хэрэгсэх, тодорхой гэрчүүдийг хэрэгт оролцуулаагүй байх, дуудаагүй байх, танил тал харах зэргийг дурдаж болно. Шүүх засаглал шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэхгүй байх, эсхүл түүнийг үл ойшоох зэрэг нь гүйцэтгэх засаглалын зүгээс шүүх засаглалын хараат бус бие даасан байдлыг хүндэтгэн үзэж буй эсэхийг илэрхийлдэг тул шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлээгүй болон үл ойшоохтой холбоотой тоон мэдээг ашиглах хэрэгтэй. Өөр нэг хэрэгцээт үзүүлэлт нь шүүгчийн эсрэг гаргасан сахилгын хэргүүдийн тоо, тэдгээрийг шийдвэрлэсэн байдал юм. Цөөн тооны хэргүүд дээр халдашгүй байдлын асуудал хөндөгдөж магадгүй. Гэвч илүү өргөн хүрээнд авч үзэхгүй бол авлига оршин байгаа эсэхийг ямар ч үзүүлэлт тодорхой зааж өгч чадахгүй.[12]

2.3. Шүүх засаглалын материаллаг байдал

Шүүхийн дэд бүтэц болон цалин хөлсийг зохистой хэмжээнд санхүүжүүлэх нь шүүхийн тогтолцоон дахь авлигаас урьдчилан сэргийлэх үндсэн хүчин зүйлүүдийн нэг юм. Шүүгчдийн цалин нь нөлөөллөөс ангид, хараат бус байлгах хэмжээнд хангалттай байх шаардлагатай[13]. Шүүхийн санхүүжилт хангалтгүйгээс хээл хахууль бий болох хөрөнгө завших эрсдэл нэмэгддэг. Түүнчлэн төр засгийн зүгээс нэр нөлөө бүхий хүмүүстэй холбоотой аюултай хэргийг шийдвэрлэж

[11] Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага /2016/, Авлигатай тэмцэх гарын авлага, 185 дахь тал.

[12] Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага /2016/, Авлигатай тэмцэх гарын авлага-186 дахь тал.

[13] Киевийн зөвлөмж 13 дугаар заалт /2014/ http://www.judge.mn/home/view/?id=313 холбоосоор үзнэ үү.

байх үед шүүхийн байр болон шүүгчдийн аюулгүй байдлыг найдвартай хамгаалж чадаагүйгээс шүүгч өмгөөлөгчид аюул заналхийлэлд өртдөг нь их. Үүний нэгэн адил санхүүжилтгүй шүүхийн тогтолцоо авлигын хэргийг цаг тухайд нь бүрэн дүүрэн шийдвэрлэж чадахгүй билээ.

Шүүгч шүүхийн албан тушаалтнуудад хангалттай хэмжээний цалин хангамж олгохын чухлыг олон улсын дийлэнх стандартад тусгасан байдаг. Шүүгчдийн цалин нь тэднийг зүй бус нөлөөллөөс ангид, хараат бус байлгах хэмжээнд хангалттай байх шаардлагатай. Шүүгч шүүхийн ажилчдын цалин тэтгэвэр нь тэдэнтэй ижил түвшний дадлага туршлагатай мэргэшсэн албан тушаалтантай харьцуулахад боломжийн хэмжээнд байх ёстой. Шүүгчийн цалин хангамж амьдралд хүрэлцэхүйц байх нь тэдний хараат бус байдалд чухал байдаг. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд "Шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээ нь эдийн засгийн хувьд бусдаас хараат бус ажиллах, амьдрахад хүрэлцээтэй, баталгаатай байх боломжийг хангасан байна"[14] гэжээ. Мөн уг хуулийн 23 дугаар Шүүгчийн эдийн засгийн баталгааг хуульчилж өгсөн байна.

Хуулийн эдгээр заалт үйлчилж эхэлснээр шүүгчдийн цалин хангамж өмнөх үеийнхтэй харьцуулбал ойролцоогоор 1.5-2 дахин нэмэгдсэн. Шүүхийн санхүүжилт нь шүүхүүд тогтолцооны хувьд бие даасан байхад чухал ач холбогдолтой билээ. Шүүхийн үйл ажиллагааг санхүүжүүлэх тогтолцоог Үндсэн хуулийн түвшинд бэхжүүлсэн байдаг. Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 3 дахь хэсэгт шүүхийг төсвөөс санхүүжүүлнэ гэж мөн заасан байдаг. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 28.2 дугаар зүйл заасны дагуу шүүх бие даасан төсөвтэй байх бөгөөд Монгол Улсын шүүхийн төсөв нь улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна. Дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл шүүхийн төсвийн төслийг Улсын Их Хуралд шууд өргөн барьдаг болсон үеэс хойш улсын төсөвт эзлэх шүүхийн төсвийн хэмжээ нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, Монгол Улсын төсөвт шүүхийн төсвийн эзлэх хувь 1997 оноос хойш ойролцоогоор 0.39-0.48 орчим хувьтай хэлбэлзэж ирсэн[15].

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргасан Монгол Улсын шүүхийн 2015 оны тайлангаас үзэхэд шүүхэд хуваарилсан төсвийн хэмжээ 2013 онд улсын нэгдсэн төсвийн 0.65 хувь, 2014 онд 0.85 хувь, 2015 онд 0.82 хувь болж нэмэгдсэн байна. Түүнчлэн 2016 онд шүүхийн төсвийг 3.9 тэрбум төгрөгөөр бууруулах заалт бүхий төсвийн тодотголын тухай хуулийн төслийг Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлж байв. Эдгээр оролдлого хэрэгжвэл шүүхийн эдийн засгийн хараат бус байдлын талаар Үндсэн хууль, холбогдох бусад хуулиар тогтоосон баталгаа ямар нэг байдлаар алдагдахад хүрэх аюултай. Шүүхийн эдийн засгийн баталгааг аль болох хөндөхгүй байх нь төрийн үүрэг мөн. Шүүхийн бие даасан байдал, шүүгч нарын хараат бус байдлыг бэхжүүлэх талаар Монголын төр дорвитой алхам хийж, дэлхий нийтийн жишигт нийцсэн байдлаар хуульчлан тогтоосон боловч хуулийн хэрэгжилт төдийлөн хангалтгүй байна[16].

2.4 Шүүгчийг сонгох, томилох

Шүүгчдийг сонгох, томилох тогтсон аргачлал улс орон бүрт шүүх тогтолцоо болгонд харилцан адилгүй байдаг ба тэдгээрийн дунд шатлан захирах ёс байдаггүй. Тухайн улс шүүгчийн томилгоонд ямар ч аргыг хэрэглэсэн

[14] Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 23.1 дүгээр зүйл

[15] Д.Солонго, "Шүүхийн захиргааны талаарх судалгааны тойм," (УБ: Нээлттэй нийгэм форум, 2014)

[16] Шүүгчийн томилгооны өнөөгийн нөхцөл байдал-Судалгааны тайлан /2016/ 4-5 дэх тал.

Хуулийн эрх зүйн хүрээлэн www.nlrgov.mn

бай, энэ нь ил тод, олон нийтийн хяналт дор явагдах ёстой. Шүүхийн томилгоонд ил тод байдал, олон нийтийн хяналтыг бий болгох нь шүүхэд ажиллах хамгийн чадвартай хүнийг сонгох, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг олж авахад тэргүүн зэргийн ач холбогдолтой. Гадны нөлөөнд автаагүй ил тод процесс нь хамгийн ур чадвартай шүүгчийг шилж сонгох боломжийг олгодог.

Манай Улсад Үндсэн хууль, холбогдох бусад хуулийн дагуу шүүгч нарыг тэтгэврийн нас хүртэл нь томилдог. Шүүгч нарын ажил үүргээ гүйцэтгэх хугацаа нь төрийн албан тушаалтан, намын дарга нар, дээд шатны шүүгч нар, түүнчлэн төр засгийн өөрчлөлтөөс үл хамарна. Хуулийн эдгээр заалтаас үзвэл шүүгчийн бүрэн эрхийн хугацаа хуулиар хамгаалагдсан нь харагдаж байна. Гэхдээ 2013 оны Шүүх байгуулах тухай хуулийн дагуу тухайн үед ажиллаж байсан давж заалдах болон анхан шатны шүүхийн бүх шүүгчийг албан тушаалаас нь чөлөөлж, өөрчлөн байгуулагдсан шүүхэд нь дахин томилох саналыг Шүүхийн ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчид тавьсан ч Ерөнхийлөгч шүүгчдийг тойргийн шүүхэд нь дахин томилсон зарлигийг гаргахдаа нийт 409 шүүгчээс 397-г томилж, 12 шүүгчийг томилоогүй үлдээсэн. Энэ байдал 2015 оны Шүүх байгуулах тухай хуулийн дагуу хийгдсэн томилгоонд дахин давтагдаж мөн л нэг шүүгчийг томилохгүйгээр албан тушаалаас нь огцруулжээ. Ийнхүү огцруулахдаа эдгээр шүүгч нарт огт мэдэгдээгүй, ямар үндэслэлээр томилоогүй нь тодорхойгүй байжээ. Тодорхой бус шалтгаанаар дахин томилогдоогүй шүүгч нар болон Хуульчдын холбоо, Шүүхийн ерөнхий зөвлөл, Ерөнхийлөгчийн Тамгын газар, иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүх, мөн Үндсэн хуулийн цэцэд хандсан боловч одоог хүртэл ямар нэгэн арга замыг олоогүй байгаа тул энэхүү жишээг дурдах нь зүйтэй. Уг нь Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт шүүгчдийг Үндсэн хууль болон Шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулахаас бусад тохиолдолд албан тушаалаас нь огцруулахаас хамгаалдаг. Энэхүү тогтолцоо нь 2000 оноос хойш бодит үр дүнгээ өгч эхэлсэн бөгөөд авлигын асуудал гарсаар байгаа боловч төрийн албан хаагчийн зохисгүй үйлдлийг хязгаарлах чадвар тодорхой хэмжээнд бүрдсэнийг харуулж байна.

Гэхдээ шүүхийн зохион байгуулалт өөрчлөгдөх бүрт ийм байдал давтагдахгүй гэх баталгаа байхгүй байгаа тул Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсгийн заалт шүүгч нарыг дур зоргоор огцруулахаас хангалттай хамгаалалт болж чадахгүй байна. Шүүгчийн ажилд ямар нэг байдлаар хөндлөнгөөс оролцохыг Үндсэн хуулийн болон хуулийн түвшинд хориглож огцруулахгүй байх аргыг хуульд тодорхой нарийвчлан заах нь чухал юм.

2.5 Шүүгчийн Ёс зүйн дүрэм

Шүүгчийн ёс зүйн дүрэм нь шүүгчийн хүлээх үүрэг хариуцлага болон ёс зүйн хэм хэмжээний талаарх тусгай зохицуулалтыг агуулж байх ёстой. Хуульд зааснаар, шүүгч нараас сахилгын зөрчил гаргасан эсэх асуудлыг шийдвэрлэх зорилго бүхий Ёс зүйн хороог нэр хүндтэй хуульч нар (гол төлөв шүүгч нар)-ын бүрэлдэхүүнтэйгээр байгуулах ёстой. Шүүхийн ерөнхий шүүгч нь холбогдох шүүхийг тэргүүлэх боловч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шүүгчийн шүүн таслах ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, энэхүү ажиллагаатай холбоотой заавар өгөх, удирдамжаар хангах, шүүгчид тодорхой хэрэг, маргааныг нэр заан хуваарилах зэргээр шүүгчийн хараат бус байдалд халдахыг хориглодог[17].

[17] Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.

Харин Банглорын зарчимд үр ашиг бүхий хэд хэдэн нэмэлт хамгаалалтыг ёс зүйн дүрэмдээ оруулж өгсөн байдаг ба эдгээрээс дурдвал шүүгчийн өөрийнх нь болон гэр бүлийнх нь санхүүгийн ашиг сонирхол шийдвэрлэх гэж буй хэрэг, маргаанд холбогдсон эсэх талаар нягтлан шалгах тодорхой мэдлэг чадвар эзэмшихийг шүүгчдэд уриалдаг. Шүүгчид өөрийн ажилтнууддаа аливаа бэлэг хүлээн авахыг зөвшөөрч болохгүй. Бангалорын зарчмууд мэргэжлийн болон хувийн харилцаандаа бусдад ялгавартай хандах өчүүхэн төдий ч хандлага гаргаж болохгүйг шүүгчдэд зөвлөдөг[18]. Европын орнуудад шүүгчдийг улс төрийн шинжтэй үйл ажиллагаанд оролцохыг хязгаарласнаас гадна багшлах, эрдэм шинжилгээний ажил хийхээс бусад хэлбэрээр орлого олох аливаа үйл ажиллагааг хориглодог байна[19].

ДҮГНЭЛТ

Шүүхийн хараат бус, бие даасан байдлыг найдвартай хангах нь түүний төвийг сахисан байр суурийг хадгалах гол түлхүүр билээ. Мөн шүүх бие даасан байх нь ард иргэдийн эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг бодитой хамгаалах хамгийн хүчирхэг механизм шүүх эрх мэдлийн эрх зүйн баталгаа болж өгдгөөрөө ихээхэн чухал үүрэг гүйцэтгэнэ. Түүнчлэн шүүхийн байгууллага нь хараат бус байдлаа хэзээд хадгалж байхын сацуу ил тод байж үйл ажиллагаандаа хариуцлага хүлээдэг байх ёстой. Үүний дотор авлигаас урьдчилан сэргийлж, авлигыг таслан зогсоохын тулд шүүхийн байгууллага, шүүгчид, түүний албан хаагч, шүүхийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахын тулд шүүх засаглалыг авлигаас хамгаалах нь нэн чухал. Шүүх дэх авлигын эсрэг тэмцэл нь засаглалын нэг салаа мөчрийг амжилттай байлгахаас илүү өргөн хүрээний зорилго агуулгатай. Шүүх засаглал нь нийт улс орны хэмжээнд авлигын хамгийн чухал хамгаалалт болдог. Хангалттай санхүүтэй хараат бус хариуцлагатай шүүх нь засаглалын бусад салбар дахь авлигаас урьдчилан сэргийлэх хариуцлага хүлээлгэх гол хэрэгсэл юм. Аливаа хэргийг шударга, үндэслэлтэй шийдвэрлэх нь шүүхийн гаднах этгээдийн үйлдэж болзошгүй авлигыг илрүүлж, таслан зогсоож чадна.

Улс орнууд авлигыг тодорхойлж, хэмжих механизмтай байхаас гадна авлигажсан үйлдлийг шийтгэх тогтолцоог бүрдүүлэх ёстой. Ийм тогтолцоо нь хараат бус, нөлөөнд үл автах байдлаар хэрэгжих эрх зүйн зохицуулалтад үндэслэх учиртай. Мөн шүүхийн албан тушаалтнууд шүүгчид авлигад өртөх автах эрсдэлийг бууруулах үүднээс шүүх нь хууль сахиулахаас гадна хангалттай хэмжээний санхүүжилттэй байх шаардлагатай. Үүний гол эрх зүйн үндэс нь Үндсэн хуулийн Шүүх эрх мэдэл гэсэн Дөрөвдүгээр бүлэгт хэрхэн тусгаснаас шалтгаалж бусад салбар хуулиудад өөрчлөлт, шинэчлэлт хийх боломжтой.

Энэхүү сэдэмжид хамгийн их хөндөгдөж байгаа асуудал буюу шүүгчдийн бие даасан байдалд авлига нөлөөлөх, шүүгчдийг сонгон шалгаруулах асуудалд авлига нөлөөлөх боломжтой байгааг дурдсан тул үүнээс гарах арга замууд бол:

Шүүгчийг сонгон шалгаруулах болон томилох шийдвэрийг шүүхийн байгууллага өөрөө гаргадаг байх, эсхүл тодорхой тооны шүүгчдээс бүрдсэн хараат бус байгууллагаар гаргуулбал зохистой байдаг. Хараат бус байгууллагын шүүгчдийн бүрэлдэхүүнд зөвхөн дээд шатны бус бусад шатны

[18] Банглорын зарчимууд 4.1, 4.7, 4.15 дугаар заалт, Европын хүний эрхийн шүүх, Польш 2012 оны 1 дүгээр сарын 10-ны шүүхийн шийдвэрийг үз. 35-38 дугаар хэсэг.

[19] Европын шүүгчдийн ёс зүйн дүрэм 1.7 дугаар заалт, Шүүх засаглалын хараат бус байдлын үндсэн зарчмууд 8-9 дүгээр заалт.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

шүүхийн шүүгчид ч мөн хамрагдах ёстой. Шүүгчид нэр дэвшигчийг сонгон шалгаруулах үйл явцыг нээлттэй ил тод явуулж нэр дэвшигчийг нууц санал хураалтаар тодруулна. Сонгох, томилох эрх бүхий байгууллагад тавих хяналтыг нэг хүний гарт төвлөрүүлэх ёсгүй, мөн сонгох, томилох үйл ажиллагааг шүүх засаглалын тодорхой хэмжээний оролцоогүйгээр гүйцэтгэх, эсхүл хууль тогтоох засаглал удирдан явуулах нь авлигад өртөх эрсдэлийг нэмэгдүүлдэг тул үүнээс зайлсхийх.

Шүүгчийг гадны нөлөөлөлд өртөх байдалд тулгуурлан томилох эрсдэлийг бууруулахын тулд шүүгчийг сонгох, томилох тусгай шалгуур үзүүлэлтүүдийг тогтоож мөрдөх шаардлагатай юм. Тэдгээр шалгуур үзүүлэлтүүдэд ёс зүйтэй, шударга байх, хараат бус байх асуудлыг онцлон тусгах хэрэгтэй. Үүний нэгэн адилаар шүүгчийг томилох шийдвэрийг шүүгчийн ур чадвар, туршлага, нөлөөнд үл автах чадавхад нь тулгуурлан гаргаж байхыг шүүгчийн сонгон шалгаруулалт болон томилгоог зохицуулдаг хууль тогтоомж эрх зүйн актад онцлон тусгах нь зүйтэй юм.

Ашигласан эх сурвалж:

- Монгол Улсын Үндсэн хууль1992 он
- Монгол Улсын шүүхийн тухай хууль 2012 он
- Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль 2012 он
- Шүүхийн захиргааны тухай хууль 2012 он
- Дэлхийн улсуудын шүүхийн тогтолцоо Уб., 2005 он. Хууль зүйн үндэсний төв.
- Европын шүүгчдийн ёс зүйн дүрэм Уб., 2011 он.
- Шүүх засаглалын хараат бус байдлын үндсэн зарчмууд, Уб., 2013 он.
- Бангалорын зарчмууд Уб., 2012 он
- Шүүгчдийн олон улсын хороо хараат бус хариуцлагатай байдлын талаарх олон улсын зарчмууд Уб., 2007 он.
- Монгол Улсын 1992 оны Үндсэн Хуулийн Хэрэгжилтийн Байдалд Хийсэн Дүн Шинжилгээ-2016 /Улсын Их Хурал, Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрөөс 2013-2016 онд хэрэгжүүлсэн “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн хүрээнд ажилласан эрдэмтдийн багаас бэлтгэв./
- Д.Солонго, “Шүүхийн захиргааны талаарх судалгааны тойм,” (УБ: Нээлттэй нийгэм форум, 2014)
- Шүүгчийн томилгооны өнөөгийн нөхцөл байдал-Судалгааны тайлан /2016/. Нээлттэй нийгэм форум. Дугаар 18.
- Л.Бямбаа Шүүхийн бие даасан шүүгчийн хараат бус байдлын тухай Үндсэн хуулийн эрх зүйн үндэслэл-Улсын - Монгол Улсын Үндсэн хуулийн цэц-илтгэлийн эмхэтгэл-2007
- www.legalinfo.mn
- www.supremecourt.mn
- www.unodc.org
- www.u4.no
- www.osce.org
- www.transparency.org

---o0o---

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ИРГЭНИЙ НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ ҮНДЭСЛЭЛ



Хууль сахиулах их сургуулийн докторант М.Ванчигмаа

ТҮЛХҮҮР ҮГ:

Нэхэмжлэл, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргах иргэний нэхэмжлэл, хохирол, хор уршиг, гэм хор.

УДИРТГАЛ:

Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны нэгэн сонирхолтой судлагдахууны нэг бол Францын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь иргэний нэхэмжлэлийн тухай сургааль юм. Энэхүү сургааль нь Францад хууль зүйн практик болон номлолоор олон зууны туршид боловсрогдсоор иржээ. Нийтийн /төрийн/ ба иргэний нэхэмжлэлийг гэмт хэргээс нийгэм ба бие хүнийг хамгаалах үндсэн хоёр аргын хувьд нь ялган авч үзэх явдал 1532, 1670 оны Ордонансад бий болж эхэлсэн юм. Францын шашны эрүү шүүлт, мөрдөлт мөшгөлтийн үед бий болсон Францын эрүүгийн байцаан шийтгэх онолын энэ ололт нь өнөөг хүртэл ач холбогдлоо алдаагүй байна. Гэмт хэрэг нь нийгмийг бүхэлд нь буюу хувь хүмүүст нэгэн зэрэг хохирол учруулдаг гэсэн үзэл баримтлалд төрийн ба иргэний нэхэмжлэлийн тухай энэ сургааль тулгуурладаг байна. Иймд нийгэм болон хувь хүмүүсийн аль алинд учирсан хохирлыг шүүхийн журмаар нөхөн төлүүлэхээр шаардах эрх нэгэн зэрэг үүснэ. Энэ зорилгын үүднээс нийгэмд (төрд) нийтлэг ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд "нийтийн нэхэмжлэл" гаргах эрх бий болно. Нийгэм нь өөрийн ашиг сонирхлоо түүний нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах тодорхой төлөөлөгчөөр дамжуулан хамгаалах бөгөөд, тухайн тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд гаргаж байгаа нийтийн нэхэмжлэлийн эрхийг төрөөс тусгайлан байгуулсан прокурорын байгууллага эдэлнэ. Тухайн гэмт хэрэгт өртөгдсөн хувь этгээд нь нийтийн бус, харин хувийн ашиг сонирхлын үүднээс иргэний нэхэмжлэл гаргах замаар өөрийн эрх ашгаа хамгаалах эрхтэй байна[1].

Францын эрүүгийн процесс дахь иргэний нэхэмжлэлийг зөвхөн явцуу цивиль талаас нь ойлгож болохгүй юм. Хэрэв хохирогч нь яллагдагчаас иргэний зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээхтэй холбоотой, эд хөрөнгийн ямар нэгэн гомдол санал байхгүй боловч, өөрийгөө гомдоосон этгээдийн гэм бурууг нотлох, шударга ёсыг тогтоох зорилгоор, уг байцаан шийтгэх ажиллагаанд бүрэн эрхтэй талын хувьд оролцохыг хүсвэл, хувь этгээдийн хувьд ямар нэгэн "ex offico" (албан ёсны) эрх эдлэхгүй боловч, улсын яллагчийн зэрэгцээ иргэний нэхэмжлэл гаргаж оролцдог.

[1] Ч.Нямсүрэн "Гэмт хэргийн виктимологи", УБ., 2005, 451 дэх тал.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ҮҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр иргэний нэхэмжлэл гаргах эрх нь үндэсний төдийгүй олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцуудад баталгаажсан хүний үндсэн эрх юм. Монгол Улсын Үндсэн Хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт "Монгол Улсын хууль олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх..." эрхтэй хэмээн хуульчилсны зэрэгцээ Хүний эрхийн түгээмэл тунхаглалын[2] 8 дугаар зүйлд "Үндсэн хууль болон бусад хуулиар олгогдсон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ сэргээн тогтоолгох эрхтэй", мөн "Үндсэн хууль болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт[3]"-ны 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Шүүх ба тусгай шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй. Хүн бүр өөрт тулгарсан эрүүгийн хэргийг хянан хэлэлцүүлэх буюу иргэний нэхэмжлэлийн хүрээнд эрх, үүргээ тодорхойлуулахдаа хуулийн дагуу байгуулагдсан эрх бүхий, хараат бус, шүүхээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй" хэмээн тунхагласан явдал нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад иргэний нэхэмжлэлтэй холбогдох асуудлыг шалгах, шийдвэрлэх үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлсон байна.

Монгол Улсын ЭХХШ тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэгт ЭХХШ ажиллагаан дахь иргэний нэхэмжлэлтэй холбогдох журмыг хуульчилсан нь дээрх дурдсан эрхийг хангах, "төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэсэн Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн нэг дэх хэсэгт заасныг хэрэгжүүлэх үндсэн баталгаа болсон гэж үзэж байна.

Гэмт явдал нь нийгэмд аюултай сөрөг үзэгдэл болохын хувьд иргэн, хуулийн этгээдэд тодорхой хэмжээний эдийн болон эдийн бус хор уршгийг тодорхой хэмжээнд учруулж байдаг. Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн, түүнийгээ нөхөн төлүүлэхээр шаардлага тавьж байгаа иргэн, хуулийн этгээдийг иргэний нэхэмжлэгч гэнэ гэж ЭХХШт заажээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго нь гэмт хэргийг илрүүлж, гэм буруутай этгээдэд ял оногдуулснаар хязгаарлахгүй, хүний зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх үүрэгтэй байдаг.

Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрийн ашиг сонирхлыг хамгаалж оролцож байгаа бие даасан субъектийн нэг бол иргэний нэхэмжлэгч юм. Доктор Ж.Авхиа: "хэрэв гэмт хэргийн уршгаас хохирогчид эд материалын хохирол учирсан байвал тэр иргэний нэхэмжлэл гаргаж болно. Хохирогч иргэний нэхэмжлэгчээр тогтоогдсон үед хуульд заасан иргэний нэхэмжлэгчийн эрхийг эдэлнэ"[4] гэжээ. Эрүүгийн хэрэг дэх иргэний нэхэмжлэл нь хуулийн этгээд болон хувь хүнээс гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгуулах талаар хэрэг бүртгэх, шүүх, мөрдөн байцаах, прокурорын байгууллагад гаргаж байгаа шаардлага гэж ойлгож болох юм.

Нэхэмжлэлийг амаар буюу бичгээр аль ч хэлбэрээр гаргаж болох боловч дараах агуулгыг тусгаж бичгээр гаргасан байх нь зүйтэй байдаг.

[2] Http//www.legalinfk.mn/insys/lawmain.php?viawld=3756

[3] Http//www.legalinfk.mn/insys/lawmain.php?viawld=3757. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдөр 2200А (XXI) тоот тогтоолоор баталж 1976 оны 3 дугаар сарын 2-ны өдөр хүчин төгөлдөр болсон Монгол Улс 1968 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр гарын үсэг зурж, 1974 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр соёрхон баталсан.

[4] Ж.Авхиа. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчид ба тэдний эрх үүрэг. // Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. Ред: Г.Совд, К.Тажебакед. УБ.,1987., 38-р тал.

➢ Нэхэмжлэлийг гаргаж буй иргэн, хуулийн этгээдийн нэр, оршин суугаа газрын хаяг, холбоо барих утасны дугаар буюу шуудангийн хаяг

➢ Нэхэмжлэл гаргах болсон шалтгаан, тавьж буй шаардлага

➢ Өөрт нь хохирол учруулсан гэмт хэргийн шинжтэй \холбогдол бүхий\ үйлдэл, эс үйлдэхүйн талаарх өөрт байгаа баримт сэлт, мэдээлэл

➢ Нэхэмжилж буй хохирлын шинж байдал, хэр хэмжээ, үнийг тусгасан байх, бөгөөд нэхэмжлэлийг хүлээн авч буй хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нь нэхэмжлэлийн шаардлага хангахгүй байна гэсэн шалтгаанаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзахыг хориглоно гэж хуульчлан тусгах нь зүйтэй байна.

Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх нэгэн хэлбэр бол эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн этгээдийн зөрчигдсөн эрхийг нэхэмжлэл ба гомдол, хүсэлтийн үндсэнд хамгаалах, сэргээн эдлүүлэх явдал[5] байдаг тул гэмт хэргийн улмаас учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлүүлэх, асуудлыг уг гэмт хэргийн хамт хянан шийдвэрлэх нь олон талын ач холбогдолтой байдаг. Тухайлбал:

➢ Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг богино хугацаанд, нөхөн төлүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг,

➢ Хохирогч, иргэний нэхэмжлэчийн хувьд хохирлын асуудлаар Иргэний хэргийн шүүхэд дахин хандах шат дамжлагыг багасна.

➢ Нэхэмжлэлийн шаардлага хэмжээг тогтооход ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтоохын тулд гэрч, шинжээч, мэргэжилтэн зэрэг оролцогчдыг процессын ажиллагаанд оролцуулахын тулд дахин дахин дуудаж чирэгдүүлэхгүй.

➢ Нэхэмжлэлтэй холбоотой нөхцөл байдлыг шалгаж тогтоох процессын ажиллагааны зардлыг хэмнэнэ.

➢ Гэмт хэрэг үйлдсэн гэмт буруутай этгээдэд зохих ялыг ялгамжтайгаар ногдуулах нөцлийг бүрдүүлэх зэрэгт ихээхэн ач холбогдолтой юм.

Харин дараах үндэслэл тогтоогдвол иргэний нэхэмжлэл гаргах буюу гаргаагүй бол хэрэг бүрдгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нэхэмжлэл гаргах эрх бүхий иргэн, хуулийн этгээдэд албан ёсоор мэдэгдэж иргэний нэхэмжлэгчээр тогтоон энэ тухай тогтоол, захирамж гаргадаг.

Үүнд:

1) Гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйн улмаас эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус шинжтэй шууд хохирол учирсан байх,

2) Нэхэмжлэл гаргах эрх бүхий иргэн, хуулийн этгээдэд хохирол учирсан байх,

3) Гэмт хэрэг болон учирсан хохирлын хооронд шалтгаант холбоо тогтоогдсон байх[6] зэрэг үндэслэлийг нотлох баримтаар тогтоогддог.

Гэмт хэрэг болон иргэний нэхэмжлэлийн зүйл болох хохирлын хооронд шалтгаант холбоотой байх тухай асуудал нь эрүүгийн эрх зүйн онолоор авч үзэх гэмт хэргийн бүрэлдэхүүний обеъктив талын нэг шинж болох гэмт үйлдэл эс үйлдэхүй, түүний хор уршиг, тэдгээрийн хооронд шалтгаант холбоотой байх гэсэн шинжээс харьцангуй өргөн ойлголт юм.

Гэмт хэргийн хор уршиг гэдэг нь субъект Эрүүгийн хуулийн хамгаалалтанд авагдсан хүн, нийгэм, төр, байгууллага, аж ахуй нэгжийн эрх, ашиг сонирхолд халдсаны улмаас эрүүгийн хуулийн тусгай ангийн тодрохой зүйл, хэсгийн диспозицид заасан өөрчлөлт оруулсан буюу бодитой хохирол учруулсан, тийм

[5] МУИХ-ХЗС Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй /ерөнхий анги /.УБ., 2004 он, 128 дахь тал.

[6] В.Н.Григорьев и.др.Уголовный Процесс Учеб 2-е изд., Москва 2008 стр-154

хохирол учруулах нөхцөл бүрдүүлсэн байхыг хэлдэг[7].

Гэмт хэргийн хор уршиг тухайн гэмт үйлдэл, эс үйлдэхүй хор аюулын хэр хэмжээг тодорхойлох шалгуур бөгөөд субъектын гэмт үйлдэл эс үйлдэхүй улмаас гэмт хэргийн үндсэн болон нэмэгдэл обеъктод учирсан хор уршиг юм.

Харин иргэний нэхэмжлэлийн зүйл болох хохирол нь Эрүүгийн хуулийн хамгаалтад авагдсан хүн, нийгэм, төр, хуулийн этгээд буюу хохирогчид учирсан хор уршиг төдийгүй гэмт хэргийн обеъктын шинжийг агуулаагүй гэмт этгээдийн шууд санаа бодол чиглээгүй боловч субъектийн гэмт үйдэл эс үйлдэхүй улмаас тухайн тохиодолд Эрүүгийн хуулиар хамгаалагдсан иргэн, хуулийн этгээдийн эд хөрөнгийн болон эдийн бус эрх ашиг сонирхолд учруулсан хохирол юм. Гэхдээ субъектийн гэмт үйлдэл эс үйлдэхүй болон түүний улмаас учирсан иргэний нэхэмжлэлийн зүйл болох хохирол хоёрын хооронд субъектив байдлаар оршиж буй шалтгаант холбоог заавал тогтоох шаардлагатай юм.

Гэм хорыг албан ёсны эрх зүйн баримт бичгүүд, ном зохиолуудад янз бүрээр тодорхойлсон байдгаас дурдвал:

- Гэм хор тодорхой этгээдийн эрх зөрчигдсөнөөс түүнд бий болсон эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус сөрөг үр дагавар юм. Үүнд эд хөрөнгө устгасан, гэмтээсэн иргэний эрүүл мэндэд гэмтэл учруулснаас эмчилгээний зардал гарсан, цалин дутуу авсан, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутааснаас олох ёстой байсан орлого алдагдсан, зарлага гарсан, биеийн болон сэтгэл санааны шаналал амссан зэрэг ордог[8],
- Гэм хорыг "материаллаг болон материаллаг бус" гэж ангилан авч үздэг бөгөөд материаллаг гэдэгт алдагдал, олох байсан орлого, зардлыг, харин материллаг бус гэдэгт амь нас, эрүүл мэндийг хохироосон, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан зэрэг үнэ өртгөөр илэрхийлэгддэггүй, хохирогчийг санаа сэтгэлийн дарамтанд оруулсан үр дагаврыг ойлгоно. Энэ нь хохирогчийн амин хувийн болон эд хөрөнгийн эрхийг ямар нэгэн байдлаар зөрчсөн явдлаар илэрдэг[9]",
- Гэм хор учруулснаас үүсэх үүргийн зүйл (обьект) нь бусдын амь нас, эрүүл мэндийг бусниулсан, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг доромжилсон, гутаасан хохирол байна. Хохирол нь мөнгөн илэрхийллээр тодорхойлогддог[10] хэмээн тодорхойлсон байна.

Гадаадын зарим эрдэмтдийн тодорхойлсон байдлыг судлан үзвэл: Гэм хор нь хохирлоос өргөн ойлголт юм. Зарим судлаачид гэм хорыг мөнгөн илэрхийлэл гэж авч үздэг. Учир нь гэм хорын хохирлыг мөнгөөр илэрхийлэн барагдуулдаг[11] гэж үзсэн байдаг бол нөгөөтээгүүр зарим судлаачид гэм хор эд хөрөнгө устсан, гэмтсэн, олох байсан орлого багассан, хөдөлмөрлөх чадвар алдагдсан буюу багассан, тэжээгчээ алдсан, бусад нэмэлт зардал гарсан бие махбодийн болон ёс суртахууны шаналал байдлаар илэрнэ үүнийг мөнгөн хэлбэрээр үнэлэх нь харьцангуй[12] гэж үзэх нь бас байна.

"Гэм хор", "хохирол", "хор уршиг" гэх мэт эрх зүйн ойлголтын онцлог болон ялгааг тодорхойлохын тулд дараах байдлаар схемчлэн харуулъя.

[7] С.Жамцан. Монгол улсын Эрүүгийн эрх зүйн онол.УБ., 2009 он, 360-361 дэх тал.

[8] Т.Мөнхжаргал,"Иргэний эрх зүй . Тусгай анги",УБ.,1997 он, 46 дахь тал.

[9] Д.Наранчимэг "Иргэний эрх зүйн үндсэн асуудал", УБ., 1999 он, 89 дэх тал.

[10] Т.Мөнхжаргал "Иргэний эрх зүй Үүргийн тусгай төрөл" Уб., 1998 он, 144 дэх тал.

[11] М.Н.Брагинский, В.В.Витранский, Договорнов право общее положение Москва., 2000г,СВ

[12] П.Сергееве., Ю.К.Толстого, Гражданснoё право/том-3/ Москва. 2000г. СВ

“Гэм хор”, ”хохирол”, ”хор уршиг” нь гэмт хэргийн улмаар үүсэх сөрөг үр дагавар мөн боловч дараах шинжээр ялгагдана. Үүнд:

Гэм хор гэдгийг эрх зүйн зөрчил буюу гэмтэй үйлдэл эс үйлдэхүйн улмаас үүсэх сөрөг үр дагавар гэж үзэж болох юм. Товчхондоо бол гэмт хэргийн улмаас бий болох “муу нөлөө” юм. Гэмт хэргийн илрэх хэлбэр нь “хор уршиг”, ”хохирол” байдаг.

Хуулиар хамгаалагдсан эрх ашгийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас гэм хор учирдаг бол тухайн этгээдийн эрх хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөнтэй холбоотойгоор бий болж байгаа сөрөг үр дагаврыг “хохирол”, ”хор уршиг хэмээн” ойлгож болохоор байна. Өөрөөр хэлбэл, хуулиар хамгаалагдсан эрх ашиг зөрчигдөх бүрийд гэм хор учирна, харин тухайн тохиолдол бүрт хохирол, хор уршиг учирдаггүй гэж үзэж байна.

Иргэний хуулийн “гэм хор учруулснаас үүсэх үүрэг” гэх бүлгийн зохицуулалттай нийцэхгүй бөгөөд хэрэгжих боломжгүй байгаа юм. Өөрөөр хэлбэл, “гэм хор” гэдэг нь гэмт хэргийн улмаас үүсч буюу сөрөг үр дагавар учраас уг сөрөг үр дагаврыг зөвхөн “хүндэвтэр гэмтэл учирсан” гэдгээр хязгаарлах нь Үндсэн хуулийн 16 зүйлийн 14 дэх хэсгийн ”.... бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах эрх”-ийг хязгаарлаж буй хэрэг юм. Иймд хуулийн холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгож, зөв тайлбарлан хэрэглэх шаардлагатай байгааг харуулж байна.

Хуулийн заалтын агуулгаас хүний амь нас хохирох, эсвэл эд эрхтэн ажиллагаагүй болох буюу дахин нөхөн сэргээх, засан сайжруулах боломжгүй болох, мөн уг байдал нь амьдралынх нь хэвийн байдлыг алдагдуулахад хүргэх, нийгмийн идэвхтэй байдлаа үргэлжлүүлэх боломжгүй болох, гэр бүл зохиох, хүүхэд төрүүлэх боломжгүй болох гэх зэргээр “хүнд хор уршиг” гэж ойлгогдохоор байна. “Хор уршиг” дараах шинжийг агуулсан ойлголт юм.Үүнд:

- Ирээдүйд чиглэгсэн, тасралтгүй үргэлжлэх, хохирогчийн ирээдүйн боломж алдагдах, нөхөн төлөгдөхгүй, арилахгүй

Өөрөөр хэлбэл, хор уршиг гэдэг нь арилгах болон нөхөн төлөх боломжгүй ирээдүйд үр дагавар нь бий болох, гинжин хэлхээ мэт үргэлжлэн бий болох сөрөг үр дагавар байна.

Монгол Улсын Дээд Шүүхээс 2003 оны 7 дугаар сарын 9-ний өдөр “Эрүүгийн хууль “хор уршиг”, ”гэм хор” гэсэн заалтыг зөв хэрэглэх” тухай зөвлөмж гаргасан байх бөгөөд Эрүүгийн хуулийн тусгай ангийн зүйл, хэсэг бүрт заасан “хүнд хор уршиг” гэдэгт юуг хамруулж ойлгох талаар нарийвчлан заасан байна.

Хохирол гэдэг нь: гэмт хэргийн улмаас үүсч буй алдагдал, гарз, сүйтгэл, хөнөөл бөгөөд “нөхөн төлөгдөх” шинжтэй. Өөрөөр хэлбэл, “Хохирол” нь тодорхой этгээдийн эрх зөрчигдсөнөөс түүнд бий болсон эдийн болон эдийн бус сөрөг үр дагавар юм. Хохирлын гол шинж нь: тооцож, хэмжиж болохуйц: эрх зүйн зөрчил, үр дагаврын шалтгаант холбоо ойрхон бөгөөд хүчтэй байх явдал.

Хүний амь бие, эрүүл мэнд нь зарим төрлийн гэмт хэргийн халдлагын зүйл болдгийн хувьд хүний амь биед хүнд гэмтэл учруулсан нь гэмт хэргийн улмаас учрах хохирол мөн бөгөөд биед учирсан гэмтлийн зэрэг нь хэргийн зүйлчлэлд нөлөөлнө гэдгийг санах нь зүйтэй юм. Нөгөөтэзгүүр хохирол мөн эсэхийг тодорхойлоход эргэлзээ гарвал “тухайн гэмт хэрэг үйлдэгдээгүй бол, гэмт хэргийн халдлагад өртөөгүй бол энэ хохирол учрах байсан уу” гэдэг асуултанд хариулах замаар тодорхойлох боломжтой гэж үздэг байна.

Хохирлыг дараах байдлаар ангилж болно. Үүнд:

www.nli.gov.mn

А/ Хууль тогтоомжид хохирлыг дараах байдлаар нэрлэн хуульчилжээ. Эдийн болон эдийн бус хохирол[13], эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол[14],

"Эд" гэдэг нь "эдэлж хэрэглэж болох юм эдлэл", "хөрөнгө" гэдэг нь хүний хийгээд улс нийгэмд хамаарагдаж буй өмч, үнэ бүхий зүйлийн нийтлэг нэр" хэмээх утгыг монгол хэлэнд илэрхийлдэг ажээ[15].

Харин "эд хөрөнгө" гэдэг нь "эд юм" гэдэгтэй утга нэг агуулгыг илэрхийлэх бөгөөд "юм" гэдэг нь монгол хэлний аливаа бүх зүйлийг ерөнхийлөн нэрлэх үг юм[16].

Эд хөрөнгийн шинжтэй хохирол нь нэхэмжлэгчийн өмчлөл, эзэмшилд байсан материаллаг эдийн баялаг болох эд юмсад учирсан мөнгөөр буюу биет байдлаар илэрхийлэгдэх боломжтой хохирол юм. Эдийн бус хөрөнгийн шинжтэй хохирол нь иргэн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, оюуны үнэт зүйлс болон өөрт нь ашиг өгөх, эсхүл бусдаас шаардах эрх олгох эрх буюу шаардлагад учирсан мөнгөөр илэрхийлэгдэн нөхөн төлөгдөх, эсхүл хуучин байдлаар нь сэргээн эдлүүлэх боломжтой хохирол юм. Хуучин байдлаар сэргээн эдлүүлэх боломжгүй эдийн бус хөрөнгийн хохирлын хэмжээ мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх боломжтой байхыг шаардана[17].

Монгол хэлний зүй талаас нь авч үзэхэд гэм хор, хохирлыг Монгол Улсын Иргэний хуульд "эдийн гэм хор-хохирол" гэсэн нэр томьёогоор, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд "эд хөрөнгийн" хохирол - гэм хор гэсэн нэр томьёогоор хуульчилсан нь төдийлөн ялгаатай утга агуулгыг илэрхийлэхгүй байна.

Нэхэмжлэлийн зүйл болох гэмт хэргийн улмаас учирсан хохирол нь эд хөрөнгийн буюу эдийн бус хөрөнгийн шинжтэй байж болох тухай эрдэмтэн судлаачид бүтээлдээ нилээдгүй дурджээ.

Хуульд хохирлыг хэлбэрийн хувьд дээр дурдсанчлан ангилан хуульчилсан боловч эрдэмтэн судлаачид материаллаг, материаллаг бус болон бодит, бодит бус хэмээн томьёолдог байна.

Б/ Хохирлыг учрах байдлаар нь:

Шууд хохирлын хэмжээ нь хэргийн зүйлчлэлд шууд нөлөөлөхүйц хохирол бөгөөд ийнхүү хохирлын шинж чанар, хэр хэмжээг тогтоох нь гэмт хэрэгтэнг ял завшуулахгүй байх, мөн гэм буруугүй этгээдэд ял оногдуулах явдлыг таслан зогсоох буюу хуулийн шаардлагыг хэрэгжүүлэх чухал нөхцөл болдог.

Харин шууд бус хохирлын хэмжээ нь хэргийн зүйчлэлд нөлөөлөхгүй боловч гэмт хэргийн улмаас хохирол учирсантай холбоотойгоор үүсч буй дагалдах хохирол юм.

В/Хохирлыг барагдуулах хэлбэрээр нь:

Германы эрдэмтэн Эманнуэль-Къяр хохирлыг арилгах аргаар нь дараах байдлаар ангилсан байна[18]. Үүнд:

Нөхөн сэргээгдэх хохирол гэдэг нь: эрх зүйн зөрчил гарахаас буюу гэмт хэрэг үйлдэгдэхээс өмнөх байдалд нь нөхөн сэргээх боломжтой хохирол юм. Өөрөөр хэлбэл, анхны байсан байдалд нь буцаан оруулах боломжтой хохирлыг нөхөн сэргээгдэх хохирол гэж үзнэ.

Нөхөн төлбөрөөр барагдуулах хохирол гэдэг нь: нөхөн сэргээгдэхгүй хохирлын тухайд яригдах бөгөөд учирсан хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн тооцохыг ойлгоно.

[13] Иргэний хуулийн 9 дүгээр зүйл

[14] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт

[15] Н.Цэвэл Монгол хэлний товч тайлбар толь.,Уб.,1996 он, 716- 869 дэх тал.

[16] Мөн бүтээлийн 289 дэх тал.

[17] Т.Мөнхжаргал Иргэний эрх зүй Үүргийн тусгай төрөл. Уб., 1998 он, 144 дэх тал.

[18] Ч.Нямсүрэн "Гэмт хэргийн виктимологи",Уб., 2005 он, 454 дэх тал.

Хуулийн дэлгэцийн хуулбар www.nlaw.mn

Уучлал гуйх гэдэг нь: хэрэг үйлдсэнээ хүлээн зөвшөөрч, харамсал илэрхийлэх, уучлал гуйх байдлаар хохирлыг барагдуулж буй хэлбэр гэж тодорхойлсон байна.

Нэхэмжлэж буй хохирлоос нь хамаарч нэхэмжлэлийг дараах байдлаар ангилж болох юм.

- Нэр төр, алдар хүндээ сэргээлгэх, эрх хүлээн зөвшөөрүүлэх нэхэмжлэл;
- Эд хөрөнгийн хохирол гаргуулах нэхэмжлэл;
- Эдийн бус хөрөнгийн хохирол гаргуулах нэхэмжлэл;
- Эрх зүйн харилцааг өөрчлүүлэх нэхэмжлэл;

Эрх хүлээн зөвшөөрүүлэх нэхэмжлэл нь иргэний нэхэмжлэгчээс иргэний хариуцагчтай маргаж байгаа болон зөрчигдсөн гэж үзэж буй эрхээ хууль ёсны болох эсэхийг хүлээн зөвшөөрч баталгаажуулахыг хүссэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах төрийн байгууллага, албан тушаалтанд хандсан шаардлага байдаг байна. Ийм нэхэмжлэлд ихэвчлэн залилан мэхлэх гэх мэт хэргийн улмаас алдсан өмчлөх, эзэмших эрхээ сэргээлгэх буюу зөвшөөрүүлэх шаардлага бүхий нэхэмжлэл хамаардаг байна.

Эд хөрөнгийн хохирол гаргуулах нэхэмжлэл гэдэг нь гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн хохирол хүлээсэн этгээд тухайн эд хөрөнгийг гаргуулж авахаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах төрийн байгууллага, албан тушаалтанд хандсан нэхэмжлэлийн шаардлага юм. Ийм нэхэмжлэлд эд хөрөнгийн хохирол учрахаас өмнө байсан байдалд нь сэргээх буюу учирсан хохирлоо мөнгөөр нөхөн төлүүлэхээр шаардах, гэмт хэргийн улмаас эрүүл мэндэд нь хохирол учирсан этгээд хөдөлмөрийн чадвараа алдсан бол эмчилгээний зардал болон дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого зэргээ шаардан нэхэмжилсэн нэхэмжлэл хамаардаг.

Эдийн бус хөрөнгийн хохирол гаргуулах нэхэмжлэл гэдэг нь гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, сэтгэл санаа, бие эрхтний хохирол хүлээсэн этгээд хохиролоо нөхөн төлүүлэхээр ЭХХШ ажиллагаа явуулах төрийн байгууллага, албан тушаалтанд хандсан шаардлага болно. Энэхүү нэхэмжлэлд гэмт хэргийн улмаас сэтгэл санаанд учирсан таагүй үр дагавар болон бие эрхтний өвчин шаналал, зовиур гэх мэт хохирлыг нөхөн төлүүлэх эрхээ хангуулахаар гаргасан нэхэмжлэл хамаарах юм.

Эрх зүйн харилцааг өөрчлүүлэх нэхэмжлэл гэдэг нь эрх зүйн харилцааг өөрчлөх, дуусгавар болгоход чиглэсэн нэхэмжлэл юм. Монгол Улсын Иргэний хуульд заасны дагуу шүүх эрх зүйн харилцааг өөрчлөх, дуусгавар болгох аргаар хамгаална гэж заасан байдаг. Эрх зүйн харилцааг 2 тал харилцан тохиролцсоны үндсэн дээр болон нэг талын санаачлагаар дуусгавар болгож болно. Хоёр талын харилцан тохиролцооны үндсэн дээр эрх зүйн харилцаа өөрчлөгдөх, дуусгавар болох нөхцөлд ямар нэг маргаан үүсэх, зохих байгууллагад нэхэмжлэл гаргах факт байхгүй нь ойлгомжтой юм. Харин ямар нэг маргаан буюу эрх зүйн зөрчил үүссэн нөхцөлд эрх зүйн харилцааг нэг талын санаачилгаар өөрчилж, дуусгавар болгодог байна. Тухайлбал, хэрэглэгчийг хуурч мэхлэх, төөрөгдүүлэх гэмт хэргийн улмаас хохирол хүлээсэн этгээд үйлдвэрлэл, үйлчилгээ худалдааны байгууллагын ажилтантай байгуулсан гэрээнээс татгалзах буюу гэрээг дуусгавар болгохыг шаардах эрхтэй байдаг. Энэхүү нэхэмжлэл нь эрх зүйн харилцааг өөрчлүүлэх нэхэмжлэлийн төрөлд хамаарна.

Дээр дурдсан онцлог шинжүүдэд тулгуурлан эрүүгийн хэрэгт гаргах

хуульчдын мэдээлэл www.hurgelt.mn

иргэний нэхэмжлэлийг дараах байдлаар тодорхойлж болох юм.

Эрүүгийн хэрэгт гаргах иргэний нэхэмжлэл гэдэг нь гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон эдийн бус хөрөнгийн хохирлоо гэм буруутай этгээд[19], эсхүл хуулиар тэдний өмнөөс эд хөрөнгийн хариуцлага хүлээвэл зохих иргэн, хуулийн этгээдээр нөхөн төлүүлэхээр иргэн, хуулийн этгээд, хуульд заасан тохиолдолд прокуророос хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхэд хандан эрүүгийн хэрэг үүсгэснээс хойш шүүхийн хэлэлцүүлэг хүртэлх шатанд амаар буюу бичгээр гаргаж буй шаардлага юм.

НОМ ЗҮЙ

Хууль:

1. “Монгол Улсын Үндсэн Хууль ”1992 он.

2. “Монгол Улсын Үндсэн Хууль ”1986, 2002он.

3. “Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль” 2002 он.

4. “Шүүхийн тухай хууль”2002 он.

5. “Өмгөөллийн тухай хууль”2002 он.

6. “Прокурорын байгууллагын тухай хууль” 2002он.

7. “Цагдаагийн байгууллагын тухай хууль” 1993 он.

8. Улсын Дээд шүүхээс гаргасан “Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар” Уб., 2010 он.

9. “Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбар” Уб., 2003 он.

10. Г.Совд нар “Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар” Уб., 2003 он.

11. “Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль, шинжлэх ухааны тайлбар” Уб., 2003 он.

12. ОХУ-ын “Эрүүгийн байцаан шийтгэх хууль” 2001 он.

Ном, сурах бичиг:

Монгол хэл дээр

1. Ж.Бямбаа, Г.Баясгалан “Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үндсэн асуудлууд “УБ., 1998 он.

2. Ж.Бямбаа “Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үндсэн асуудлууд” УБ., 2008 он.

3. Ж.Авхиа нар “БНМАУ-ын ЭБШ эрхзүй”, УБ.,1987 он.

4. Б.Бат-Эрдэнэ. “ЭБШ эрх зүй. Ерөнхий анги”,УБ.,2010, ЭБШ эрх зүй. Тусгай анги” ,УБ., 2010 он.

5. Ж.Бямбаа. “ЭБШ эрх зүйн ерөнхий асуудлууд”, УБ., 2008 он.

6. Шүүгчийн гарын авлага ” Эрүүгийн байцаан шийтгэх болон иргэнийхэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудыг хэрэглэх онол арга зүй” УБ., 2004 он.

7. Б.Бат-Эрдэнэ “Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй” /ерөнхий анги/ УБ., 2000 он.

8. Б.Бат-Эрдэнэ ”Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй”/тусгай анги/ УБ.,1999 он.

9. Х.Сэлэнгэ “Ромын эрх зүй” УБ., 2000 он.

10. Д.Батсайхан “Ромын эрх зүй” УБ., 2000 он.

11.Ц.Бүжинлхам “Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй”/ тусгай анги/ шүүхийн ажиллагаа. УБ., 2007 он.

Гадаадын хэл дээр

1. “Уголовный процесс” общая часть. Под ред., Григорьев В.Н.,М.,1997 он

2. Чельцов-Бебутов М.А.”Курс уголовно-процессуального право”СП.,1995 г

3. Рустамов Х.Ц. “Уголовный процесс”М.,1998г

[19] Гэм буруутай болох нь шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор тогтоогдсон этгээд төдийгүй хэрэг хүлээх чадваргүй боловч гэмт хэрэг үйлдсэн болох нь нотлох баримтаар хангалттай тогтоогдсон этгээд

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

4. Громов Н.А. “Уголовный процесс России” М., 1998г

5. Карев Д.С”Сущность и задача уголовного процесса” учербник “Уголовный процесс”М.,1998г

6. Строгович М.С. “Право обвиняемого на защиту и презумпция невиновности” М.,1984г

7. Строгович М.С.” Правовие гарантии законности в РФ” М.,1995г

8. Бабаев О.Я. “Презумпцич в советском праве” Горький.,1974г

9. Мицкевич А.В “О.гарантиях прав и свобод граждан РФ”, Российская юстиция М.,1997г

10. Матузов Н.И. “Субъективныие права граждан РФ”, Юридическая литература М.,1996г

11. Васьков П.Т. “Основы теории госдарства и права” М.,1997г

12. Элькинд П.С. “Сущность уголовно-процессуального права” ЛГУ.,1993г

13. Куцова Э.Ф”Совершенствование демократических гарантии прав и законных интересов граждан в уголовной политики” М.,1997г

14. М.Чубинсий” Курс уголовной политики” М.,1912г

15. Арсеньев Б.Я.”Революционный трибунал французской буржуазной революции XVIII века”М.,1940г

16. Гуляев А.П. “Следователь в уголовном процессе” М.,1981г

17. Кудявцев В.Н. “Прхвовие поведение:норма патагия” М., 1982г

18. Anthony Bimb” Molly Mackqier” Pennsylvania.,1950

19. “Теория доказательств в советском уголовном процессе” М.,1973г

20. Мотовилоковер Я.О. “Презумпция невиновности и толкование сомнений в советском уголовном процессе”Ярославль.,1991г

21. Головка Л.В. “Реформа уголовного процесса во франции”/ Государство и право 2001№8/

22. Гученко К.Ф, Филипинов Б.А. “Уголовный процесс зарубежных государств” М.,2004г

23. International Encyclopedia of laws. Criminal provedure law Volnme 4.London Boston 1993-2004

Бусад материал:

1. Д.Зүмбэрэллхам “Иргэдийн гэм буруугүйд тооцохдоо баталгаа ба хэвлэл мэдээлэл” Монголын төр, эрхзүй сэтгүүл. УБ.,1998 он, /1дугаар 30-31 дүгээр тал

2. Д.Зүмбэрэллхам “Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах ажиллагааг зарчмын үүднээс авч үзэх нь” Монгол төр,эрх зүй сэтгүүл. УБ.,1996 он, /4дугаар 30-31 дүгээр тал

3. Д.Жаргалсайхан “Вопросы презумпции невиновности доказывании” /на олыт МНРиСССР/ М.,1989г

4. “Өмгөөлөгч” сэтгүүл 2012оны №48

5. “Хууль дээдэлх ёс” сэтгүүл, 2012 оны №1(38)

6. Прокурорын мэдээлэл сэтгүүл 2012 он №5/30

---o0o---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

ХУУЛЬ БА УЛС ТӨРИЙН ШҮТЭЛЦЭЭ

ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарын Эрдэм шинжилгээний дэд ажилтан М.Долгорсүрэн

Товч агуулга: Энэхүү өгүүллээр хууль ба улс төрийн онолын үзэл баримтлал, хууль ба улс төрийн харилцан хамаарлыг судалж, төрийн хуулиа улсынхаа онцлогт тохируулж боловсруулах, хууль тогтоохдоо зөвхөн мэргэшсэн, шударга хуульчдын санааг авах, хууль тогтоогчид гаргаж буй хуулиа улсынхаа эрх, ашиг сонирхолын төлөө батлах, эрх зүй, улс төр хоёрын уялдаа холбоо, түүнийг төгөлдөржүүлэх талаар санал дэвшүүлэхийг зорьсон.

I. Хууль ба улс төрийн онолын үзэл баримтлал

Хууль бол тухайн улс орны улс төрийн бодлогын томьёолсон илэрхийлэл, хэрэглүүр юм. Энэ талаас нь авч үзэхэд түүнд эрх зүйн бүлийн үүднээс хандаж, улс төрийн бодлогоо эрх зүйн бүлийн онцлогт тохируулан шинжлэх ухааны түвшинд боловсруулах нь тухайн улс орны багтаж буй эрх зүйн бүлийн зүй ёсны шаардлага юм. Үүнтэй холбоотойгоор улс төрийн бодлого хууль тогтоомжийн уялдаа холбоо, харилцан хамаарлыг нарийн судалж, хуулийг улс төрийн бодлогын алдаа гажуудлаас урьдчилан сэргийлж, хамгаалах, улс төрчдийн аминч үзлийн түр зуурын хэрэгсэл болгохгүй байх, хууль зүйн болон бусад арга хэрэгслийг шинжлэх ухааны үүднээс судалж боловсруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Хууль бол улс төрийн харилцааг бэхжүүлэх, тохируулан тогтворжуулдаг хамгийн гол хэрэглүүр мөн. Нөгөөтээгүүр хууль нь улс төрийн тогтолцооны бүрдэл хэсэг бүрт өвөрмөцөөр холбогдон нөлөөлдгийг ухааран, мөрдвөл зохино. Тухайлбал,

-Засаг төр бол хууль тогтоомжийг ягштал мөрдөж, хуулийн хүрээнд биш яг зааснаар нь ажилладаг.

-Нам, иргэний нийгмийн байгууллага хуулийн хүрээнд тус тусын дүрмийг мөрддөг.

-Иргэд бол хуулиар хориглоогүйг хийж чөлөөтэй амьдардаг. Ийм л алтан гурван дүрмийг улс төрд баримталдаг[1].

Улс төрийн бүрдэл хэсгүүдийн зах залгааг, ер нь зааг, ялгаа, хязгаарын асуудлыг хуулиар зохицуулдаг.

Улс төр нэгэнт бодлого учраас тухайн бодлогын илрэл, хэрэгжүүлэх гол арга хэлбэр нь хууль болно. Хууль нь улс төрийн бодлого хэрэгжүүлэх эрх бүхий “улс төрийн нам гэх бүлэг, фракц”-ийн дур зорго, бохир бодлогынх уу эсхүл олон түмний хүсэл зоригийн илэрхийллийг дээд зэргээр хангасан цэвэр бодлогынх уу гэдэг нь төрийн ямар дэглэмтэй эсэхээс хамаарна. Ардчилсан улс төрд хууль нь ард түмний хүсэл зоригийн илэрхийлэл ба төрийн эрх мэдлийн хийгээд бусад байгууллага, албан тушаалтан, иргэн хэн боловч хуулийн үйлчлэлээс

[1] Б.Чимид Өнөөгийн улс төр хуульчийн нүдээр Уб., 2006 он, 123 дахь тал.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

гадуур байх боломжгүй байх ёстой[2]. Иргэний нийгэмлэгийн санал бодол, хуулийн тухайн бүхэллэг чанарыг улс төрийн санаа болгон хүлээн авсан төр бусдаасаа илүү эрх зүйт ёсны шаардлагад нийцдэг. Хууль боловсруулж, баталж, ойлгож, онож хэрэглэж, төлөвшүүлбэл улс төрийн тогтолцоо бэхжиж, төр тогтворжино. Үүний тулд хууль тогтвортой байх ёстой. Хуулийг сайн боловсруулсаны эцэст хүчийг нь гүйцэд шавхан ашиглаад тусыг эс олвоос өөрчил гэсэн сургаал байдаг.

Хууль ёс, эрх зүй гэж ярихад заавал ч үгүй төрийн эрх мэдлийн хүч чадлыг дурдах хэрэгтэй болдог. Хэрвээ дурдахгүй гэвэл тэнд төр байхгүй эсвэл эрх зүй байхгүй гэж ойлгоход хүрнэ. Аль ч *“газар нутаг”*-т хүмүүсийн харилцаан дээр тулгууралсан нийгэм байгаа л бол тэдний дагаж мөрдөх ёстой хэм хэмжээ байна. Тэрхүү хэм хэмжээний хүчин чадал түүнийг хэрэгжиж байгаа эсэхийг хянах субъектийн албадлагын хүчээр тодорхойлогдоно. Гол нь өөрийн гэсэн хэрэгжүүлэх субъекттэй бас хүлээлгэх хариуцлагатай байдаг. Энэ бүх хэм хэмжээнээс хамгийн сонирхол татахуйц эсвэл хамгийн ойлгомжгүй нь төр түүний зүгээс тогтоосон хууль цааз юм.

Хууль дээдлэх ёс бол нийгэм, төрийн нэг үндсэн эхлэл юм. Энэ нь хууль шиг хууль төрийн дээр буюу Засгийн гурван салаан дээр заларч, тэдгээрийг нэгтгэн жолоодно гэсэн үг[3].

Хуулийн амин сүнсэд улс төрийн бодлого, шийдвэр үзэл суртал давамгайлж байсан үеийг Монголчууд өдгөө даван туулж, хууль өөрийн амин сүнсүүдийг тодорхой хэмжээгээр агуулах болсоноор хууль дээдлэх, түүнийг хүлээн зөвшөөрөх оюун санааны сэтгэлгээ бүрэлдэн төлөвшиж байна.

Төрийн хууль тогтоох бодлогод улс төр, эдийн засгийн бүлэглэлүүд ашиг сонирхолоо хэрэгжүүлэх орон зай гарч байсны улмаас Францын нэрт эдийн засагч Ф.Бастиагийн хэлснээр “хэрэв хууль зохиогч нар өөрсдийн эрх ашгийн үүднээс тонуулаа хууль ёсны болгосон бол луйвардуулсан буюу тонуулсан анги эв найрамдлаар ч бай, хувьсгалын замаар ч бай хууль зохиогчдын хүрээнд багтаж орохыг эрмэлздэг”[4] явдал Монгол Улсад илэрч байна. Бизнес эрхлэгчид УИХ-ын гишүүн болж, болох гэж хөрөнгө мөнгөө хайр найргүй цацдаг болсон явдал үүнийг гэрчилнэ.

Хуулиудад төрийн захиргааны байгууллагын эрх хэмжээг нэмэгдүүлэх нь төрийн дэглэмийн шинжийг цагдаажсан тал руу хэлбийлгэх сөрөг талтай үзэгдэл гэдгийг анхаарах цаг болсон.

Төрийн албан хаагчид хууль биелүүлэхийг өөрсдөөсөө биш зөвхөн иргэдээс шаардан суудаг. Энэ байдлыг эргүүлэн тавих нь нийгмийн оюун ухаан, эрх зүйн ухамсрын шинэтгэлийн асуудал юм.

И.Кант ёс зүй агаад улс төрийн жинхэнэ нэгдмэл байдал зөвхөн эрх зүйд үндэслэж баймааж л бололцоотой болно. Харин энэ бололцоо хэрэгжих баталгаа нь ил тод байдал ажээ[5]. Улс орныхоо сайн сайханы төлөө ёс зүйтэй зүтгэдэг, зарчимд зорилгоо захируулдаг жинхэнэ манлайлагчид л бидэнд хэрэгтэй.

Иргэд улс төрийн нэгдсэн байгууллагад нэгдэж түүний тогтвортой байдал нь удирдлагаас хамаарна. Иргэд нь хуульд захирагдана гэж үзсэн.

Үндсэн хуулиа чандлан сахиулах баталгаа болсон улс төр-эрх зүйн шинж бүхий төрийн дээд хяналт мөн.

Улс төрийн бодлогыг захиран зохицуулах зорилго бүхий улс төрийн тэнцвэржилтийг тогтоон барих хуулийн тогтолцоог тодорхойлсон.

Улс төрийн зүтгэлтэнүүд төр улсаа авч явах хариуцлага хүлээдэг, энэ хариуцлага нь зөвхөн хууль зүй дээр

[2] Р.Дворкин. Хуулийн эзэнт гүрэн. Уб., 2015 он.

[3] Б.Чимид. Өнөөгийн улс төр хуульчийн нүдээр. Уб., 2006 он, 124 дэх тал.

[4] Ф.Бастиа Хууль Уб., 2001 он, 9 дэх тал.

[5] А.Гулыга Кант.М.,с 1981.239

тогтдог. Аристотель *...”төр улсын сайн сайхан байдал хуулиас хамаардаг, хуулиуд бол төрийн ажил хэрэг дэх ур чадварын бүтээл, хууль тогтоох урлаг бол төрийн ажлын урлагийн хэсэг нь мөн, хууль бол албадлагын хүчтэй байдаг, зард гарч алдаршсан хуулиудыг хамж шимж байгаад амарханаар хууль тогтоочихож болно хэмээн бодож болохгүй, сайн зохиогдсон хуулиуд гол нь боломжийн хэрээр, бүхнийг өөрөө тодорхойлсон байх ёстой, шүүгчийн дур зоргод аль болох бага зүйл үлдээсэн байх учиртай”*[6]. Иймээс нэгд, сэтгэхүйн зөв дүр төрхтэй, хууль боловсруулж ял оноох чадвартай хүн олон олддоггүй, хоёрт, хуулийг хүмүүс удаан бодож сэтгэж байж зохиодог, гэтэл шүүхийн ял оноолт тэр дорхноо гарчихдаг[7] гэжээ. Энэ нь төрийн хуулиа улсынхаа онцлогт тохируулан боловсруулж хийж байх, хууль тогтоохдоо зөвхөн мэргэшсэн, шударга хуульчдын санааг авах, хууль тогтоогчид гаргаж буй хуулиа улсынхаа төлөө гэж хийх ёстой, өчүүхэн хувийн эрх ашигаа хууль тогтоогчид гол зүйлд бодож болохгүй гэсэн үг. Эрх зүй, улс төр хоёр ингэж нэгдмэлээр холбогддог. Манай одоогийн хуулиудад давхардал, зөрчил, хийдэл их байна. Эдгээрийг арилгах хэрэгтэй. Хууль тогтоомжид тодорхойгүй байдал их байна. Энэ тодорхойгүй байдлыг судалж нарийвчлах ёстой. Иймээс хууль цэвэрлэх ажлыг хийх нэн шаардлагатай байна.

И.Кантын хэлснээр “хууль өөрөө эрх зүйт”[8] болсон байх явдал юм. Хууль өөрөө хүлээн зөвшөөрөгдөхүйц байх ёстой. Байгаль, нийгмийн жам ёс, амьдралын зүй тогтолыг зөв тусгасан, аливаа улс төрийн хүчний хүсэл зоригоос ангид, шударга энэрэнгүй хуулийг ард түмэн хүлээн зөвшөөрнө бас дээдэлнэ. Нөгөө талаас хуулийг хүлээн авч хэрэгжүүлдэг нийгмийн бүх субъектүүд хуулийг эрх чөлөөний нийтлэг хэмжүүр болж буй эсэхийг үнэлж, дүгнэж, шүүн тунгаах эрхийн ухамсар, улс төрийн соёл, иргэнлэг ёс бүхий байхыг бас шаардана. Хууль нь эрх зүйт болоогүй, хуулиа манах хэмжээнд ард түмэн нь хүрээгүй манай өнөөдрийн нөхцөлд хуулийн үндэс хүний эрх болоогүй, харин хууль хүний эрхийн үндэс байхаас хэтрээгүй байна. Германы төр судлаач Ф.Ю.Шталийн хэлснээр төрийн удирдлага эрх зүйг хэрэгжүүлэх арга хэрэгсэл бус[9] харин эсрэгээр эрх зүй төрийн удирдлагын арга хэрэгсэл болсоор байгаа билээ.

Платон “Хэрэв хууль нь ямар ч хүчгүй, өөрөөр хэлбэл, ямар нэг засаглалдаа захирагддаг бол энэ төрийн мөхөл ойрхон байна. Харин хууль нь засаглалын дээр, бүхний дээр байж, тэд хуулийн “боол” нь байвал энэ нь төрийн аврал, бурханаас төрд хайрлаж болох бүхий л сайн сайхан бэлэг юм” хэмээн *“Хуулиуд”* зохиолдоо онцлон тэмдэглэжээ. Германы төр судлаач, эрх зүйт төрийн онолч Р.Гнейстын тэмдэглэснээр эрх зүйт төрийн гол мөн чанар болсон өөрийгөө хязгаарлах байнгын хүсэл зоригийн[10] оронд эрх мэдлээ өргөжүүлэх хүсэл зориг нь Үндсэн хуулийн зохицуулалт ёс төдий хүлээс болж байхаас өөр замгүй юм.

Үндсэн хуулийн тайлбар нь улс төрийн эрх мэдлийн суурь зохицуулалтад нийцэж, бас түүний үндэслэл болох буюу улс төрийн онолын хамгийн сайн философи хүрээнээс урган гарсан үндэслэл байх ёстой. Хуулийн агуулга, бүтэц нь нийгмийн бодит амьдралаас урган гарсан, олон нийтийн санаа бодлыг хамгийн сайнаар илэрхийлсэн, шударга ёс, зүй ёс, хуулийн бүхэллэг чанар, процедурын

[6] Б.Даш-Ёндон. Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж Эмхтгэл III боть, УБ., 2012 он, 493 дахь тал

[7] Мөн тэнд. 477 дахь тал

[8] И.Кант. Идей к всеобщей историй. Соч.в 6 томах.Т.6.,М., 1966,с.11

[9] Stahl.Staats-Rechtslehre auf die Grundlage christliche weltanshaung Heidelherg.1856.S.137-138

[10] Гнейст Р.Правовое государство и административные суды Германий. Спб.1896.С.265

хуульдэлхийн.мн www.mi.gov.mn

процессын шалгуур, уялдаа холбоог ханган нөхцөлдүүлсэн байх ёстой.

Улс төрийн тогтолцооны өөрчлөлт нь иргэдийн эрх тэгш байх, улс төрийн амьдралд шууд оролцож, хувийн шийдвэр гаргах бололцоо бүхий төрийн байгуулал, эрх зүйн тогтолцоог бүрдүүлэхэд чиглэгдэх ёстой.

Либериал зарчимд үндэслэсэн нийгэмд хүн анх улс төрийн амьдралд шууд оролцох бололцоотой болж, улс төрийн зорилго, эрхэмлэлийн талаар хувийн шийдвэр гаргах үүрэг хүлээж иргэд нь эрх тэгш байх төрийн тогтолцоо бүрэлдэж, төрийн эрх мэдлийн хүрээнд улс төрийн үнэт зүйлүүдийг цогцлон биелүүлэх хүслээр нэгдсэн хүмүүсээс бүрдсэн улс төрийн намууд оршиж, тэдгээр намууд нь парламентад улс төрийн тодорхой асуудлаар өөр өөр байр суурь баримталж байх боловч өөрсдийгөө ямар нэг нийгмийн давхрааны төлөөлөгчид гэж үзэлгүй нийт үндэстний төлөөлөгч гэж үзэх ёстой гэсэн алдарт үндэслэлүүд нь манай улс төрийн тогтолцооны өөрчлөлтийг үнэлэх, шалгах, цаашид баримтлал болгох тулгуур үндэс юм[11].

Монголын өнөөгийн улс төр, эрх зүйн сэтгэлгээнд гарсан хувьсал, өөрчлөлтийг авч үзэхэд:

-Ангич, намч онол, үзэл суртал, намын бодлого шийдвэрийг дээдэлдэг үзэл сэтгэлгээ Үндсэн хууль, хууль дээдлэх сэтгэлгээгээр солигдох нөхцөл төлөвшиж байна.

-Намаар хамгаалагдаж, амьдралын баталгаагаа бүрдүүлнэ гэсэн үзэл сэтгэлгээ хуулиар хамгаалуулж, хувийн ашиг сонирхлоо хэрэгжүүлж амьдарна гэсэн үзэл санаагаар өөрчлөгдөж байна.

-Хууль тогтоомжид хүний эрх, эрх чөлөөг үндэслэхээ болих, хүний эрх, эрх чөлөө хуулийн үндэс болох чиг хандлагыг баримтлах болов.

-Хуулийн амин сүнсэд намын бодлого, шийдвэр, үзэл суртал давамгайлж байсан үеийг даван туулж, хууль тогтоомж өөрийн зүй ёсны амин сүнсүүдийг тодорхой хэмжээгээр агуулж, чөлөөт ардчилсан сонгуулиар ард түмнээс мандат авсан элч төлөөлөгчид хууль тогтоодог түгээмэл жишиг, технологиор хууль тогтоодог болсноор хууль дээдлэгдэх, хүлээн зөвшөөрөгдөх сэтгэлгээ бүрэлдэн төлөвшиж байна.

-Төрийн эрх мэдлийг харилцан тэнцвэр, хяналт бүхий бие даасан өндөрлөгүүдэд хуваарилж, хүний эрх чөлөөний Үндсэн хуулийн баталгааг бүрдүүлсэнээр иргэд Үндсэн хуулиар олгосон, хамгаалуулсан тогтолцооны дагуу эрхээ эдэлж, үүргээ хэрэгжүүлэх ухамсар, соёл бүрдэнэ гэж итгэх болсон.

-Нам төвтэй улс төрийн тогтолцооноос төр төвтэй улс төрийн тогтолцоонд шилжих, хүний эрх, эрх чөлөө хууль дээдлэсэн эрх зүйт төрийн үзэл баримтлалыг Үндсэн хуулиараа тунхагласан нь ардчилсан төрийн тогтолцоонд шилжих, төр ард түмнээс эх үндэстэй, иргэнлэг шинж чанартай болох улмаар хууль дээдлэгдэх, төр хүлээн зөвшөөрөгдөх үзэл, сэтгэлгээг төлөвшүүлэх эхлэл болсон.

-Монголын ард түмэн төрд үйлчилнэ гэсэн тоталитар сэтгэлгээнээс хөндийрч “төр иргэний нийгмийг бус, иргэний нийгэм төрийг нөхцөлдүүлнэ” гэсэн үзэл санаанд шилжиж, иргэний нийгэм, төр харилцан тэнцвэртэй, хяналттай орших хууль зүйн бололцоог бүрдүүлэхэд сэтгэлгээний болоод үйл ажиллагааны ахиц өөрчлөлт гарсан.

-Сонгуулийн ардчилсан тогтолцоонд шилжсэнээр төрийг удирдах үйл хэрэгт ард түмэн оролцох, төрийн эрх мэдэл ард түмнээс эхтэй, засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна гэсэн сонгодог үндэслэлүүдийн утга санаа Монголын улс төр, эрх зүйн сэтгэлгээнд төлөвшиж, үйл ажиллагааны хүрээнд шилжиж эхэлсэн. Энэ хувьсал өөрчлөлт бол дэлхий нийтийн улс төр, эдийн засаг, нийгэм,

[11] Н.Лүндэндорж. Шилжилтийн үе: улс төр, эрх зүйн асуудал.Уб., 2010 он, 192 дахь тал.

Хуулийн эсэхийг үзэхийн www.mjs.gov.mn

соёл, эрх зүйн үнэт зүйлсийг Монголын төр хүлээн зөвшөөрч, Үндсэн хуулиараа тунхаглан баталгаажуулсаны үр дүнд нийгмийн улс төрийн тогтолцооны дотоод мөн чанарт буюу ард түмний улс төр, эрх зүйн сэтгэлгээнд гарсан хамгийн том өөрчлөлт юм.

II. Улс төрийн засаглал, төрийн засаглалын ялгаа ба онцлог

-Улс төрийн засаглал-нийгмийн зохион байгуулалттай тодорхой хүчнээс хүн амын янз бүрийн бүлгийн харилцаа ба үйл ажиллагаагаар өөртөө учруулах бэрхшээл эсэргүүцлийг даван туулж өөрийн зохих хүслийг эрх зүй, ёс суртахууны зэрэг нийтлэг хэм хэмжээгээр хүлээн зөвшөөрүүлэх чадвар. Тэгэхээр улс төрийн засаглал сайн дурын үндсэн дээр, эсвэл аргагүйн эрхэнд зөвшөөрөгдсөн улс төр, эрх зүй, ёс суртахууны хэм хэмжээнүүдээр зохицуулагддаг засаглал юм.

-Төрийн засаглал-хууль цаазын үндэстэй албадлагын тусгай аппаратад тулгуурладаг, хүн амыг нийтэд нь хамардаг зэргээрээ онцлог. Төрийн засаглал нь шийдвэр гаргах, албадах онцгой эрхээрээ улс төрийн засаглалаас ялгаатай. Харин улс төрийн засаглал нь төрөөс гадна нам зэрэг бусад хүч, хөдөлгөөнтэй бас холбоотой, түүний нөлөөлөл, хяналтад тулгуурлаж байдаг.

-Улс төрийн ноёрхол ба легитим шинж. Ноёрхол бол тодорхой тушаал, шийдвэрт захирагдаж даган биелүүлэх боломж. Легитим шинж бол ноёрхлыг институжсэн засаглал болохын хувьд иргэд өөрөөр үнэлж болно. Түүнийг иргэд эерэгээр үнэлж, хүлээн авах, удирдуулах, захирагдахыг хүлээн зөвшөөрөх явдлыг хэлнэ.

-Легаль шинж. Төрийн баримт бичигт хуульчлагдан тусгагдаж, эрх зүйн хэм хэмжээ болж баталгаажихыг хэлнэ. Уламжлалт легитим шинж: захирах, захирагдах зуршил, ёс заншил, эртнээс уламжилж ирсэн дэг журам, хөдөлшгүй бат бэх бөгөөд ариун шудрага гэсэн итгэл үнэмшилд тулгуурладаг. Харизмат (бурхан тэнгэрээс олгосон чадвар) удирдагчийн харизм буюу онцгой чадварт нь итгэх итгэлд үндэслэдэг. Иймд удирдагчаа бурханчлан үзэх, бие хүнийх нь хувьд өргөмжилж, нэр хүндийг нь засаглалын институтаар дэмжин бэхжүүлдэг.

-Хууль ёсны легитим. Эх сурвалж нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хууль, дүрмийн дагуу буюу ардчилсан хэм хэмжээ, журмын дагуу бүрэлдэн тогтсон төр, түүний гаргасан шийдвэрт хүмүүс захирагдаж дагаж биелүүлэхэд нь түлхэц болж өгдөг ухамсарласан ашиг сонирхол юм.

III. Хууль ба улс төрийн харилцан хамаарал

Эрх зүйн философид эрх зүй, улс төрийн харилцан хамаарлын асуудлаар гурван гол хандлага зонхилдог ажээ. Гэхдээ эдгээр асуудалд хандахдаа хэт туйлширч эрх зүй ба төрийн уг чанарыг зөв ойлгох бие биендээ хэрхэн нөлөөлөх ямар үүрэгтэйг ойлгон тэдгээрийг нь орхигдуулж болохгүй юм.

-**Этатист хандлага.** Төр нь эрх зүй дээр байна, эрх зүй бол төрийн үйл ажиллагааны үр дагавар гэж үздэг.

-Эрх зүйг дээдлэх хандлага. Эрх зүй төрөөс өмнө үүссэн бөгөөд "төрөөс ахмад", "ямар ч төр эсхүл засаглал, эрх мэдэл эрх зүйн хувьд анхдагч эх сурвалж биш" үзэл санааны эх сурвалж нь төрөлх эрх зүйн онол */жам ёсны эрх зүй/* бөгөөд энэхүү онолыг баримтлагчид төрийн тухай ойлголт нийгмийн гэрээнээс гаралтай. Төрийн эрх зүйн хязгаарлалт нь төрөлх эрх зүй, түүнд үндэслэгдсэн бодгалийн субъектив нийтийн эрх хөдлөшгүй гэж үздэг. Энэхүү үзэл улс төрийн практикт эрх зүйг дээдлэх зарчмыг хэрэгжүүлэх философийн үндэс суурь болдог.

-Эрх зүй болон улс төрийн хооронд дээр дурьдсан шиг *"өрөөсгөл"* шалтгаан, үр дагавар холбоо байдаггүй, эрх зүйгээс улс төр үүсдэг шиг улс төрөөс эрх зүй үүсдэг байна. Эрх зүй

улс төрийн харилцан хамаарал ихээхэн нарийн төвөгтэй бөгөөд хоёрдмол шинжтэй: эрх зүй ба төр бие биенээ нөхцөлдүүлдэг, нэг нь нөгөөгүйгээр оршин тогтнож чадахгүй, иймээс тэдгээр нь хоорондоо чиг үүргийн уялдаа холбоотой. Улс төр... эрх зүйд оршино, харин эрх зүй өөрийнхөө тогтоодог засаглал болох улс төрд оршино.

Шударга ёс, зүй ёс, процедурын процесс нь улс төрийн онолын гол санаа *(шударга улс төрийн бүтэц, нөөц болон боломжийг шударга хуваарилах, холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг тэгш хангах тухай үзэл санаа)*-д хамаарах буюу улс төрийн эрхэм чанарт тооцогдож байна. Энэ агуулгаар хуулийн бүхэллэг чанар нь улс төрийн гол санаа буюу эрхэм чанартай хамааралтай, харилцан нөхцөлдсөн байна.

Хуулийн бичвэр хийгээд практикийн хамгийн сайн тайлбар нь тухайн асуудлаарх улс төрийн эрхэм чанарыг нарийн цогц байдлаар тодорхойлж, түүнд мэдрэмжтэй байгаагаас хамаарахаар байна.

Улс төрийн шийдвэр буюу хуулийн агуулга зарим талаар бүрхэг байгаа нөхцөлд хуулийг хэрэгжүүлэхэд зөвхөн «механик" аргаар хандах боломжгүй. Шийдвэрийг дагалдах сөрөг үр дагаварыг үл харгалзан ёс зүй болон шударга байхын хосолмол байдлыг хуулиас дээгүүрт үнэлэх шаардлага үүсч болно[12].

Монгол Улсад хууль ба улс төрийн харилцан хамаарлыг төлөвшүүлэн хөгжүүлэхэд эрх зүйт төрийн онолын сэтгэлгээний хөгжил, хувьсал, төгөлдөржилтийг ойлгож ухаарах нь маш чухал ач холбогдолтой. Монгол Улс нь 1990 оны эхээр социализмыг халж ардчиллыг авчирч 1992 онд анхны ардчилсан Үндсэн хуулийг баталж өгсөн нь эрх зүйт төрийг үүсгэх үндэслэлийг бий болгосон. Үндсэн хуулийн шинэлэг тал нь *(Монгол Улсын Үндсэн хуулийн 1.2-т)* ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, хууль дээдлэх нь эрх зүйт төрийн үйл ажиллагаандаа удирдлага болговол зохих үндсэн зарчмууд юм. Тухайлбал, тэгш байдлын зарчим гэдэг нь хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэйгээр оролцохыг хэлнэ. Энэ нь хүн бүр гэдэг нь энгийн нэгэн малчнаас сэхээтэн тэр ч байтугай Улсын Их Хурлын гишүүд, Ерөнхийлөгч хүртэл хууль шүүхийн өмнө тэгш эрхтэйгээр оролцоно гэсэн үг.

АНУ өөрийн Үндсэн хуулийн эрхийг мажоритари институциудын ухамсарт найдан орхиогүйн буюу олонхийн шийдвэрийн эсрэг хувь хүний эрхийг баталгаажуулсны, засаг төрийн аливаа бодлого буюу шийдвэр Үндсэн хуулиар тэдэнд олгосон эрх мэдлийг хэтрүүлэн ашигласан тохиолдолд хүчингүй болгох эрх мэдлийг ердийн болон Дээд шүүхэд хадгалуулсны, шүүх эрх мэдлийг ард түмнийг эрх зүйн хувьд хамгаалагч, шударга ёс, хууль ёс, хүний эрх, эрх чөлөө зэрэг ардчиллын үнэт зүйлсийг хамгаалах, эрх зүйт төрийн оршин хөгжих үндэс гэж үзсэнийн үндсэн учир шалтгаан, утга агуулга энд оршиж байна.

Шүүх эрх мэдэлд улс төрийн бодлого буюу хуулийн агуулгыг хянах, хуулийн тэгш, шударга үйлчлэлийг хангах, хангуулах онцгой эрх мэдэл нэгэнт хадгалагдсан тул улс төрийн бодлого нь зүсээ хувиргаагүй, ардчилсан, цэвэр, зүй ёс, шударга ёс, процедурын процессын шаардлагад нийцсэн, хууль нь эрх зүйт, шударга, амьд, хүний эрхэд үндэслэгдсэн байх нь Хуулийн эзэнт гүрний зайлшгүй шалгуур, шаардлага болно[13]. **Эрх зүйт төрийн үндсэн шинж:**

- Төрийн бодлого нь ард иргэдийн эрх, эрх чөлөөг дээдлэх. Нэг хүний эрх нөгөө нэгний эрхээр хязгаарлагдаж байдаг. Хүний эрхийн хууль зүйн илэрхийлэл нь Үндсэн хууль байдаг.

[12] www.judcouncil.mn.2018.8.8

[13] www.legalinfo.mn-2018.8.8

Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т хүний үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна гэж заажээ. Иймд хуулиас дээгүүр хүн гэж үгүй.

- Хүн бүр хууль шүүхийн өмнө тэгш эрхтэй байх. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т зааснаар гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн, буруутай тооцож үл болно.

- Шүүх хараат бус байх. Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 1-т шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдана. Энэ нь албан тушаал, ёс суртахуун, эд хөрөнгийн талаар бусдын нөлөөнд үл автах юм. Өөрөөр хэлбэл шүүхийн үйл ажиллагаанд хэн ч нөлөөлж болохгүй.

-Монгол Улсын засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 1-т зааснаар Монголын ард түмэн төрийн хэрэгт шууд оролцож, сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ. Өөрөөр хэлбэл, төрийн хэрэгт өөрийн төлөөлөгчөөр дамжуулан шууд оролцохыг хэлнэ. Жишээ нь иргэд өөрийн төлөөлөгч болох Улсын Их Хурлын гишүүнээр дамжуулан төрийн хэрэгт шууд оролцоно.

-Үндсэн хууль нь дээд хүчин чадалтай хууль ба тайлбарыг нь гагцхүү Улсын Дээд Шүүхээс гаргана. Монгол Улсын бүх хууль, хуульчилсан актууд Үндсэн хуульд нийцсэн байх ёстой. Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 4-т зааснаар Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад бичиг баримтыг дагаж мөрдөхгүй. Үүний зэрэгцээ, эрх зүйн тогтолцоо нь улс төрийн эрх ашиг сонирхол, төрийн үйл ажиллагааг хуульд нийцүүлэн хариуцлагын тогтолцоог бий болгож байна. Гэхдээ эрх зүйт төр үүсэж 27 жилийг ардаа орхиж байгаа хэдий ч бүрэн утгаараа хөгжиж амжаагүй байна. Энэ нь иргэдийн дийлэнх нь оролцдог Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын сонгуулиудад оролцож байгаа иргэдийн оролцоо, идэвх, шударга бус байдлаас харагддаг. Үүгээрээ эрх зүйт төрийн үндсэн шинжүүд манай оронд алдагдаж байгаа нь харагдсаар байна.

Монголчууд эрх зүй, хуулийг сайн ойлгож мэддэггүйгээс их алддаг. Хууль батлагдаад хуулинд өөрөөр заагаагүй бол 10 хоногийн дотор ард иргэдэд таниулж мэдүүлэхийн тулд өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгсэл ба төрийн мэдээлэл сэтгүүлд хэвлэгдэн нийтлэгдэж байж үйлчилж эхэлдэг. Хуулийн үг хэллэг нь хэн ч уншихад ойлгомжтой байх ёстой.

Өнөө үед иргэдийн эрхийн хамгааллыг шударгаар хангах боломжтой цорын ганц байгууллага бол бие даасан, хараат бус шүүх юм. Ер нь шүүх үйл ажиллагаа нь эрх зүйт төрийн ойлголтод шууд холбоотой байдаг тул эрх зүйт төр нь бие даасан хараат бус байдлаар орших хяналтын механизм ажиллуулах замаар өөрийн монополь эрх мэдлээ хязгаарлаж иргэдийн эрх мэдлийг хамгаалдаг. Нөгөө талаас шүүх үйл ажиллагаа нь ардчилсан төрийн салшгүй нэгэн чухал элемент болохын хувьд хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтийг хангах баталгаа болдог.

Ер нь эрх зүйт төрийн үзэл санаа нь төр болон төрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж буй гүйцэтгэх байгууллагуудын хууль бус үйл ажиллагааны эсрэг эрхээ хамгаалах боломжийг иргэддээ бүрдүүлж өгдөг.

Төр нийгмийг бүхэлд нь зохион байгуулагч хувьдаа нийгэмд нийтлэг хэрэгждэг шийдвэрүүдийг гаргадаг. Төрийн эрх мэдлийн хуваарилалтын сонгодог онолын дагуу хууль тогтоох, хуулийг хэрэгжүүлэх болон хуулийг сахиулах эрх мэдлээр салбарлан хэрэгждэг бөгөөд Монгол Улс ч 1992

оны Үндсэн хуулиар мөн ийм байдлаар төрийн байгуулалтыг тодорхойлсон. Эдгээр төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч этгээдээс иргэн, хуулийн этгээдийн өдөр тутам зайлшгүй харилцах шаардлагатай болдог байгууллага, албан тушаалтан нь чиг үүргийн дагуу төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтан байдаг. Бүхий л салбарын өргөн хүрээний харилцааг зохицуулдаг, олон тооны албан хаагч, тодорхой шатлан захирах бүтэцтэй, улсын төсвөөс санхүүжилтийн эх үүсвэр авдаг энэхүү захиргаанаас хуульд үндэслэсэн, хууль ёсны хүрээнд үйл ажиллагаа хийж, нийтэд, иргэнд, хувь хүнд хамаатай шийдвэр гаргах ёстойд л эрх зүйт төрийн буюу эрх зүйд захирагдах агуулга нь оршино.

Хуулийн үзэл баримтлалыг нь эцэслэн хянаж гаргаад биелэлтийг хангуулдаг газар Улсын Их Хурал, хуулийг амьдралд нэвтрүүлж ёсчлон биелүүлдэг эзэн Засгийн газар, Үндсэн хууль түүнд нийцсэн хуулийг хамгаалж, дур зоргыг хязгаарладаг шүүх, иргэний нийгэм улс төр, эрх зүйн ухамсраа дээшлүүлж засаг төрийн үйл ажиллагаанд хүчтэй хяналт нөлөөлдөг бол биелэхгүй хууль, бүтэхгүй ажил үгүй болж ардчилал үр дүнгээ өгнө. Тухайлбал, Засгийн газар 4 жилийн бүрэн эрхийн хугацаанд УИХ-аар батлагдаж буй хуулийн ихэнхийг санаачилан оруулдаг. Эдгээр хуулиуд хэр алсыг харж бодож хийснийг судлахад сонин дүр төрх харагдаж мэднэ. Засгийн газар 40 жилийн алсыг харахаасаа илүү 4 жилээ бодож хуулийг хийх нь олонтаа байна. Энэ нь нийгмийн харилцааг хүний сайн сайхан, нийтлэг эрх ашгийн төлөө зохицуулж буй хууль улс төрчдийн бүрэн эрхийн хугацааны хүсэл зориг болчихвий гэсэн болгоомжлолыг төрүүлж байна. Эдийн засгийн салбарын хуулиуд ялангуяа худалдааны харилцааг зохицуулсан хуулиудад улс төрийн бодлого, сонирхол хамгийн ихээр тусгалаа олсон байдаг ажээ[14].

Манай Улсын хууль тогтоох дээд байгууллагын эрхэм гишүүд дотор суурь судалгаа хийдэг мэргэжлийн хуульч, нийгмийн инженерүүд гэгдэх цэвэр нийгмийн салбарын мэргэжилтнүүд тун цөөхөн байгаа учраас, улс төрийн ашиг сонирхлын нөлөөлөл хэт түрэмгий байгаагаас болж хууль боловсруулах үйл явцад олон алдаа дутагдал, нугалаа завхрал гарч байна. Энэ нь эрх зүйт төрийг төлөвшүүлэх манай улсын эрхэм зорилгыг олон талаар сатааруулж, үйл явцыг нь удаашруулж байна.

-Хууль боловсруулах үйл явц */улс төрийн ашиг сонирхлын зөрчил*дөөнөөс үүдэлтэйгээр/ удаашралтай байгаа учраас нийгмийн олон харилцаа зохицуулалтгүй үлдэж энэ нь эргээд нийгмийн хөгжилд чөдөр тушаа болж байна.

-Дээр дурдсанчлан мэргэжлийн ур чадвар дутуугаас нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангаж чадахгүй чанар муутай хууль олноор төрж байна. Үндсэн хууль болон салбар хуулиудын хоорондын зохицол, харилцан хамаарал, уялдаа холбоо муу байгаагаас хамаарч хууль зөрчсөн хууль олноор батлагдах болж энэ нь эргээд нийгэмд зөрчил үүсгэх, эмх замбараагүй байдлыг өөхшүүлэх гол үндэс болж байна.

-Монгол Улсын Үндсэн хуулийн зарим зүйл, заалтыг нийгэм-эдийн засгийн хөгжлийн үйл явцтай уялдуулан зайлшгүй өөрчлөх ёстой байтал улс төрийн нөхцөл шалтгаан, ашиг сонирхлын зөвшилцөл мэтийн асуудлаас хамаатуулан одоо хүртэл гацаасаар байна.

-Өмнө батлагдсан хуулиудыг цаг хугацааны болоод нийгмийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан мөн нийцүүлэн өөрчлөх, шинэчлэх ажил маш удаашралтай байгаагаас болж нийгэмд

[14] Williams J. Political factors that affect development. https://makewealthhistory.org/2007/07/01/political-factors-that-affect-development/. July 1,2007

бухимдал үүсгэх нэг үндэс болж байна. Нэгэнт батлагдсан хууль нь хөдлөшгүй, өөрчлөгдөшгүй зүйл биш юм. Хууль нь хүний нийгмийн харилцааг зохицуулдаг учраас уян хатан чанартай байх ёстой.

-Хууль тогтоох дээд байгууллагаас баталж байгаа хууль бол нийтийн хүсэл зориг */таалал/*-ийг илэрхийлэгч байх ёстой. Уг батлагдсан хууль нь аливаа эрх чөлөөг үгүйсгэх, хязгаарлах бус харин ч түүнийг хамгаалах, өргөтгөх зорилготой байх ёстой. Хууль нь хууль байхын тулд бус хүний тусын тулд л хууль болж батлагдах хэрэгтэй юм.

-Хууль тогтоох төрийн дээд байгууллагаас батлагдаж байгаа олонх хууль нь төрийн эрх ашгийг илүүд бодох, тодорхой улс төрийн нам, бүлэглэлүүдийн эрх ашгийг илэрхий хамгаалах, төрийн өмч хөрөнгийг илүү найдвартай хамгаалах ёстой гэх мэтийн үзэл баримтлал доор боловсрогдон гарч байгаа нь эрх зүйт төр төлөвшин хөгжих гол зарчмыг илт алдагдуулж байгаа нэг арга хэрэгсэл болно.

-Батлагдаж байгаа хуулийн багагүй хувь хэмжээ нь нийгмийн халамжийн асуудалд чиглэгдэж байгаа бөгөөд энэ нь өнгөн дээрээ нийтийн эрх ашгийн тусын тулд мэтээр харагдавч цаад бодит агуулга нь иргэдээ идэвхигүй, хүлцэнгүй, дорой буурай байдал руу түлхэж байгаагаараа хамгийн харгис шинжтэй хууль болон илэрхийлэгдэж байна.

-Хууль тогтоох дээд байгууллагаас батлагдан гарч байгаа хууль дотоод агуулгын хувьд зөрчилтэй, олон улсын эрх зүйн гэрээ, конвенцийн зүйл, заалтыг зөрчсөн байх нь хэвийн үзэгдэл болох хандлагатай байна.

-Хууль тогтоох дээд байгууллагыг бүрдүүлдэг ардчилсан чөлөөт сонгуулийн эрх ард түмний эрх мэдэлд байна уу аль эсвэл эрх баригч улс төрийн намуудын эрх мэдэлд байна уу гэдэг асуудал юм. Хуулийн шудрага болон шудрага бусын тухай асуудал бол уг хууль, эрх зүйн шинжтэй эсэх, эрх зүйд нийцэж байгаа эсэх асуудал юм. Хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн хүндэтгэж, түүнийг эдийн засаг, улс төр, хууль, эрх зүйн баталгаагаар найдвартай хангах нь эрх зүйт төрийн үндсэн шинжийн нэг төдийгүй, төрийн ардчилсан мөн чанарыг илэрхийлдэг гол хүчин зүйл мөн.

Хэрвээ Монгол Улс эрх зүйт төрийг байгуулах эрхэм зорилтыг өөртөө хүлээж байгаа бол тэр эрх зүйт төр нь хүний эрх, эрх чөлөөг зөвхөн тунхаглан зарлах төдийгүй, түүнийг хэрэгжихүйц нийгэм, эдийн засаг, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хүлээнэ. Эрх зүйт төрийн туйлын зорилго нь нийгэмд эрх зүйн ноёрхол тогтоох явдал юм. Төрөөс батлан гаргаж буй хууль тогтоомж нь иргэдэд төдийгүй төрд ч өөрт нь зайлшгүй хамааралтай гэдгийг хүлээн зөвшөөрсөн тэр цагт нь хууль, эрх зүйн ноёрхол тогтох юм. Нөгөө талаар эрх зүйт төр төлөвшихөд иргэний нийгэм бүрэлдэн тогтсон байх явдал чухлаар нөлөөлнө. Учир нь эрх зүйт төр нь угтаа төр, иргэн хоёр харилцан үүрэг, хариуцлага хүлээж, харьцангуй тэнцвэртэй орших арга юм. Нэг талаас төр нь иргэд хийгээд түүний нэгдэлтэй харьцуулахад ямагт хүчтэй байдаг хэдий ч нөгөө талаас иргэний нийгэм нь төр, түүний байгууллага, албан тушаалтны зүгээс хууль бус, дураар авирлах явдлыг хязгаарлаж байдаг. Иймд иргэний нийгэм хийгээд төр нь бие биеэсээ хамааралтай, харилцан нөхцөлдсөн ойлголтууд юм. Философич Альберт Камюгийн “Дарлагдсан ард түмэнд эрх гэж үгүй хойно, жинхэнэ үүрэг гэж байхгүй” гэдэг шиг эрх зүйт төрийн үед бие хүн, төр, нийгмийн өмнө тодорхой үүрэг, хариуцлага хүлээхийн сацуу эрхээ эдлэх, төр-улс нь иргэдийнхээ өмнө үүрэг хүлээж засаглах эрхээ эдэлж байх учиртай.

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцэд ирүүлсэн иргэдийн өргөдлийг шийдсэн Цэцийн 20 жилийн шийдвэрийг судалж үзэхэд эл шийдвэрийн ихэнх нь тухайн цагийн Улсын Их Хурал хууль тогтоохдоо Үндсэн хууль зөрчсөн байна гэсэн дүгнэлт гаргаж байжээ. Үндсэн хууль зөрчсөн хуулиа Улсын Их Хурал цуцалдаг байсан уу?, Хууль сахидаггүй эрх баригчид улс орноо мөхөөдөг гэдгийг *“дээрээ ч доороо ч”* ойлгох цаг

болсон[15].

Үндсэн хуулиас гадуур элдэв үйлдэл, Үндсэн хуулиас гадуур эрх зүй, Үндсэн хуулиас гадуур ёс зүй гэж улс төрийн албан хаагчдад байж таарахгүй билээ. Хэрвээ ийм байж болноо гэвэл Үндсэн хуулийн хэрэг гэж байхгүй.

Сүүлийн жилүүдэд улсынхаа Үндсэн хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах эсхүл засвар оруулах тухай ихээхэн ярьцгаах болсон. Үндсэн хуулийг өөрчлөх асуудлыг зөвхөн улс төрчдийн болон улс төр сонирхогчдын хүсэл зоригийн дагуу шийдэж болохгүй.

2000 оны 12-р сарын 14-ны өдөр Улсын Их Хурал ямар ч судалгаа шинжилгээ хийлгүй, Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн үл зөвшөөрсөн шийдвэр агаад Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг үл тоож Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан юм. Улс төрчид санааны зоргоор ингэж авирлахыгаа *“улс төр хийж байна”* гэдэг болжээ.

Хэрэв Үндсэн хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах бол нэн тэргүүнд 2000 онд оруулсан 7 өөрчлөлтийг цуцалж хуучин зүйл, заалтуудыг нь сэргээх ёстой.

Өнгөрсөн 27 жилийн дотор улс орны байдал эрэгээр өөрчлөгдөж өөр болсон нь 1992 оны шинэ ардчилсан Үндсэн хуулийн үйлчилгээний үр дүн юм. Харин өнөөгийн нийгэмд шинээр гарч буй сөрөг үзэгдлийг бодолцож, түүнд нь холбогдсон нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуульд оруулж болох юм.

“Ардчилсан тогтолцоотой улс оронд өөрийн орны ард иргэддээ улс төрийн оролцоог нь хуулийн дагуу албан ёсоор олгосон байдаг” гэж иргэдийн улс төрийн оролцоог томьёолжээ. Үүнээс харвал манай орны ард иргэд улс төрийн оролцоогоор бүрэн хангагдсан мэт ойлгогдоно. Үндсэн хуулиндаа ч иргэдийн улс төрийн тэгш оролцоог тусгасан байдаг. Сонгууль гэдэг нь ямарваа нэг хувь хүн өөрийн биеэр хараат бусаар, өөрийн бодлоор тодорхой түвшний олон нийтийн удирдлагыг (жишээлбэл Улсын их хурлын сонгууль) сонгох цогц үйл явц юм. Энэ нь XVII-р зуунаас хойш төлөөллийн ардчиллыг хэрэгжүүлэх үндсэн оньс болсоор ирсэн юм. Сонгуулиар хууль тогтоох байгууллага, хааяа Засгийн газар, шүүх, орон нутгийн засаглалуудыг бүрдүүлэхэд хэрэглэнэ. Энэ үйл явц нь бас ажил хэрэгч болон олон нийтийн байгууллагуудад хэрэглэгддэг. Нэг талд ард түмний сонголт, нөгөө талд нь хууль буюу хуулийг хамгаалах механизм. Сонгууль бол хуулийн хүрээнд шударга явагдах ёстой.

Зөгнөл, ид шидийг санаандаа багтаасан цуврал роман зохиогчид адил улс төрчдийн үл биелэх мөрөөдөл өнөөгийн хуульд нууц байдлаар агуулагдсан байж болно, мөрөөдөл нь хуулийн ирээдүй байх тохиолдол бас байх аж. Тухайлбал, Өршөөл үзүүлэх тухай 2015.08.11-ний өдрийн хууль үүний тод жишээ болно. Анхны төслөөс бодит хууль нь орвонгоороо өөрчлөгдөн батлагдсан хууль тогтоогчдын «далд сэдэл санаархал” нь юу вэ? Зөвхөн энэ ч биш зарим хуулийг батлахдаа тэмдэглэлт баярын үеэр буюу олны анхаарлаас далд сэмхэн, мөн редакци нэрийдлээр өгүүлбэр, зүйл, заалтыг гээгдүүлдэг, засдаг үзэгдлүүд цөөн бус удаа гарч байв[16].

Улс төрөөр хамгаалагдаж, амьдралын баталгаа бүрдүүлнэ гэсэн сэтгэлгээ өөрчлөгдөж хуулиар хамгаалуулж, эрхээ эдэлж, үүргээ хэрэгжүүлж амьдарна гэсэн үзэл санаа бүрэлдэж байна. Улс төрийн шийдвэрийг удирдлага болгосон төрийн тогтолцооноос хууль дээдэлсэн эрх зүйт төрийн үзэл баримтлалыг Үндсэн хуулиар тунхаглаж ардчилсан төрийн тогтолцоонд шилжих нөхцлийг бий болгож, төр түүний бүтэц, бүрэлдэхүүн нь ард түмнээс эх үндэстэй, иргэнлэг шинж чанартай болсон нь хууль дээдлэх үзэл, сэтгэлгээг төлөвшүүлж байна.

IV. ДҮГНЭЛТ

Хууль боловсруулж, баталж, ойлгож, онож хэрэглэж, төгөлдөржүүлвэл улс төрийн тогтолцоо бэхжиж, төр тогтворжино. Хууль шиг хууль төрийн дээр буюу Засгийн гурван

[15] Б.Даш-Ёндон. Монголын хөгжлийн философи /асуудал, аргачлал, ашиг тус/ Уб ., 2017 он, 131 дэх тал.

[16] Р.Дворкин. Хуулийн эзэнт гүрэн.Уб., 2015 он.

салаан дээр заларч, тэдгээрийг нэгтгэн жолоодож эрх зүйд захирагдана. Төрөөс батлан гаргаж буй хууль тогтоомж нь иргэдэд төдийгүй төрд ч өөрт нь зайлшгүй хамааралтай гэдгийг хүлээн зөвшөөрсөн тэр цагт хууль, эрх зүйн ноёрхол тогтоно.

Төрийн хуулиа улсынхаа онцлогт тохируулан боловсруулж хийж байх, хууль тогтоохдоо зөвхөн мэргэшсэн шударга хуульчдын санааг авах, хууль тогтоогчид гаргаж буй хуулиа улсынхаа ашиг сонирхолын төлөө гэж батлах ёстой ингэж эрх зүй, улс төр нэгдмэлээр холбогддог. Монгол Улсад хууль ба улс төрийн харилцан хамаарлыг төлөвшүүлэн хөгжүүлэхэд эрх зүйт төрийн онолын сэтгэлгээний хөгжил, хувьсал, төгөлдөржилтийг ойлгож ухаарах нь маш чухал ач холбогдолтой. Эрх зүйт төрийн загвар, онолын үзэл баримтлал нь хэдийгээр өнөөдөр улс төр, эрх зүйн үнэт зүйлсийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөж байгаа хэдий ч төрийн хөгжлийн эцсийн зорилго, үнэмлэхүй загвар хараахан биш юм. Монгол Улсад цаашид хууль ба улс төрийн уялдаа холбоог төлөвшүүлэн хөгжүүлэхийн тулд дэлхийн улс орнуудын хөгжлийн практикаас урган гарсан онолын дүгнэлт, үзэл баримтлалыг судалж, улсынхаа онцлог нөхцөлд тохируулж төрийн бодлогод тусгаж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Платон “хууль нь засаглалын дээр, бүхний дээр байж, тэд хуулийн “боол” нь байвал энэ нь төрийн аврал, бурханаас төрд хайрлаж болох бүхий л сайн сайхан бэлэг юм” мэргэн үгээр энэхүү өгүүлэлээ жаргаая.

I. Монгол эх сурвалж

1. Б.Чимид. Үндсэн хуулийн мэдлэг. УБ.,2008
2. Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал. УБ.,2017
3. Б.Чимид. Өнөөгийн улс төр хуульчийн нүдээр. УБ.,2006
4. Б.Чимид. Сонгуульд суралцахуй. УБ., 2008
5. Б.Даш-Ёндон. Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж. Эмхтгэл III боть. УБ., 2012
6. Б.Даш-Ёндон. Монголын хөгжлийн философи /асуудал, аргачлал, ашиг тус/.УБ.,2017
7. МУИС. Улс төрийн шинжлэх ухаан. УБ., 2010
8. Б.Даш-Ёндон. Аристотель Улс төр. УБ.,2015
9. Д.Болд-эрдэнэ. Улс төрийн философи. УБ., 2015
10. Ф.Бастиа. Хууль. УБ., 2001
11. Н.Лүндэндорж. Шилжилтийн үе: улс төр, эрх зүйн асуудал.УБ.,2010
12. Р.Дворкин. Хуулийн эзэнт гүрэн. УБ., 2015

II. Гадаад эх сурвалж

13. И.Кант. Идей к всеобщей историй. Соч.в 6 томах.Т.6.,М.,1966
14. Stahl.Staats-Rechtslehre auf die Grundlage christliche weltanshaung Heidelherg.1856
15. Гнейст Р.Правовое государство и административные суды Германий. Спб.1896
16. А.Гулыга.Кант.М.,с.1981

III. Бусад эх сурвалж

17. Williams J. Political factors that affect development. https://makewealthhistory.org/2007/07/01/political-factors-that-affect-development/. July.1,2007
18. www.legalinfo.mn
19. www.judcouncil.mn

---o0o---

АНАГААХЫН САЛБАР ШИНЖЛЭХ УХААНЫ ОЮУТНУУДЫН ЭМНЭЛГИЙН ЭРХ ЗҮЙН МЭДЛЭГИЙН ТҮВШИНГ ҮНЭЛСЭН СУДАЛГАА

АШУҮИС, АУ-ны доктор, дэд профессор М.Цэрэнбат
АШУҮИС, Математикийн шинжлэх ухааны магистр М.Еркебулан
АШУҮИС, НАСС – 508 хэсгийн оюутан Б. Шүрэнцэцэг, Б.Ишханд, Э.Номингэрэл, МУИС ХЗС магистрант П.Ариунболд

ТҮЛХҮҮР ҮГ:

Эмнэлгийн эрх зүй, оюутан, мэдлэг

ТОВЧЛОЛ:

Манай улсын хувьд эмч нарын хуулийн талаарх мэдлэг дутмаг байдгаас хууль эрх зүйн зөрчлийн асуудлаас өөрсдийгөө хамгаалж чадахгүй, тухайн нөхцөлд гэм буруутай болох нь цөөнгүй байдаг. Б.Тунгалагбайгаль нарын 2011-2015 онуудыг хамарсан “Эмч, эмнэлгийн мэргэжилтний эрх зүйн зөрчил” сэдэвт судалгаанд 323 эмнэлгийн эрх зүйн зөрчил судлагдсан байна. Эдгээр зөрчлүүдэд эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн эмнэлгийн эрх зүйн мэдлэгийн түвшин чухал бөгөөд бид анагаах ухааны чиглэлээр суралцагчдын эмнэлгийн эрх зүйн мэдлэгийн түвшинг тогтоох зорилго тавьсан.

Судалгаанд нийт 153 төгсөх дамжааны оюутныг таниулсан зөвшөөрлийн дагуу хамруулсан. Эрх зүйн мэдлэгийн түвшинг тогтоохдоо анкетын аргыг ашигласан бөгөөд эрх зүйн онолын мэдлэгийг үнэлэх, эмнэлгийн эрх зүйн мэдлэгийг үнэлэх гэсэн хоёр хэсгээс бүрдсэн тест бөглүүлсэн.

Судалгаанд хамрагдагсдын эрх зүйн онолын мэдлэгийн түвшин дунджаар 10-аас 3.3 оноо, эмнэлгийн эрх зүйн мэдлэгийн түвшин дунджаар 20-оос 6.5 оноо авсан байна.

Боловсролын системийн үнэлгээгээр нь авч үзвэл эрх зүйн онолын мэдлэгийн хувьд 0.7% нь B, 2.6% нь C, 7.2% нь D, 89.5% нь F үнэлгээтэй байлаа. Эмнэлгийн эрх зүйн мэдлэгийн хувьд 0.7% нь D, 99.3% нь F үнэлгээтэй байлаа. Мэргэжлээр нь авч үзвэл хүний их эмчээр суралцаж буй оюутнууд дунджаар 9.2 оноо, шүдний их эмчээр суралцаж буй оюутнууд 12.5 оноо, уламжлалтын их эмчээр суралцаж буй оюутнууд 7 оноо тус тус авсан нь статистик ач холбогдол бүхий ялгаатай байна **(p=0.0001)**. Үүнээс 2% нь D, 98% нь F үнэлгээтэй байлаа **(p=0.061)**.

Эрх зүйн онолын мэдлэг болоод эмнэлгийн эрх зүйн мэдлэгийн түвшинг тодорхойлж үзэхэд хамгийн их хувийг (98%) F үнэлгээ эзэлж байна. Хүний их эмч, шүдний их эмч, уламжлалтын их эмчээр суралцаж буй оюутнууд

ХУУЛЬ ЗҮЙН УНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН www.nli.gov.mn

нь эрх зүйн онолын болон эмнэлгийн эрх зүйн мэдлэг хангалтгүй байгаа нь тогтоогдлоо.

УДИРТГАЛ:

Сүүлийн жилүүдэд эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн эмнэлгийн эрх зүйн мэдлэг, ёс зүйн талаарх асуудал нэлээдгүй хөндөгдөж байна. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг оюутан байх үеэс нь эрх зүйн мэдлэг, ёс зүйн төлөвшлийг бий болгох шаардлагатайг судалсан нэлээдгүй олон судалгааны ажил хийгдсэн байна. Тухайлбал, 2018 онд Энэтхэг Улсад хийгдсэн судалгаагаар оюутнуудад эмнэлгийн ёс зүйн талаар хангалттай хэмжээний сургалт, семинар, бага хурал зохион байгуулах шаардлагтай байна гэсэн дүгнэлтэд хүрсэн бол 2014 онд Банарас Хиндү Их сургуулийн (Banaras Hindu University) анагаах ухааны оюутнуудад хийгдсэн судалгаагаар мөн л оюутнуудад эмнэлгийн эрх зүйн хичээл заах шаардлагатай гэж үзжээ. Манай орны хувьд анагаах ухааны чиглэлээр сурч буй оюутнуудын эмнэлгийн эрх зүйн мэдлэгийг үнэлсэн судалгаа хомс байдаг. Бидний судалгааны ажлын зорилго нь анагаах ухааны чиглэлээр суралцагчдын эмнэлгийн эрх зүйн мэдлэгийн түвшинг тогтооход оршино. Зорилгодоо хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн тавьж хэрэгжүүллээ.

1. Хүний их эмч, шүдний их эмч, уламжлалтын их эмчийн төгсөх дамжааны оюутнуудын эрх зүйн онолын мэдлэгийн түвшинг үнэлэх

2. Хүний их эмч, шүдний их эмч, уламжлалтын их эмчийн төгсөх дамжааны оюутнуудын эмнэлгийн эрх зүйн мэдлэгийг үнэлэх

3. Судалгааны үр дүнг бусад гадаад, дотоодын анагаахын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургуулийн оюутнуудын эмнэлгийн эрх зүйн мэдлэгийн түвшинтэй харьцуулах

ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БА АРГА ЗҮЙ

Судалгаанд Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн (АШУҮИС) Хүний их эмч, шүдний их эмч, уламжлалтын их эмчийн ангийг 2017-2018 оны хичээлийн жилд суралцаж төгсөх дамжааны 115 оюутан, Шинэ Анагаах Ухааны Их Сургуулийн (ШАУИС) уламжлалтын их эмчийн ангийг мөн тухайн оны хичээлийн жилд төгсөх 38 оюутныг таниулсан зөвшөөрлийн дагуу тус тус хамруулав. Дамжаа бүрийн хэсэг тус бүрийн оюутнуудын нэрийг цагаан толгойн үсгийн дарааллаар байрлуулж 1, 4, 7, 10 дахь оюутныг сонгон аналитик судалгааны нэг агшингийн загвараар хаалттай асуумжийн хэлбэрээр хийж гүйцэтгэв. Асуумж нь 30 асуултаас бүрдэх бөгөөд эхний 10 асуулт нь эрх зүйн онолын мэдлэг буюу бүрэн дунд боловсрол эзэмшсэн хүн бүр мэдэж байхуйц суурь ойлголтыг үнэлэх, дараагийн 20 асуулт нь эмнэлгийн эрх зүйн мэдлэг буюу төгсөөд эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн өдөр тутмын үйл ажиллгааанд шаардагдахуйц ойлголтыг үнэлэх асуултаас бүрдсэн. Судалгааны үр дүнг статистикийн SPSS 23 программ хангамжийг ашиглан боловсруулалт хийсэн.

ҮР ДҮН

Судалгаанд хамрагдсан нийт оюутнуудын эрх зүйн онолын мэдлэг, эмнэлгийн эрх зүйн мэдлэгийг анкетын аргаар судлахад 2% нь D, 98% нь F үнэлгээ авлаа **(p=0.061)** (Зураг1).

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Зураг 1. Эрх зүйн онол, эмнэлгийн эрх зүйн мэдлэгийг судалсан дүн



Мэргэжил тус бүрээр нь авч үзвэл хүний их эмчээр суралцаж буй оюутнууд дунджаар 9.2 оноо, шүдний их эмчээр суралцаж буй оюутнууд 12.5 оноо, уламжлалтын их эмчээр суралцаж буй оюутнууд 7 оноо тус тус авсан ба мэргэжил хооронд статистик ач холбогдол бүхий ялгаатай байлаа **(p=0.0001)** (Зураг2).

Зураг 2. Эрх зүйн онол, эмнэлгийн эрх зүйн мэдлэгийг мэргэжил тус бүрээр нь харьцуулсан байдал



Эрх зүйн онолын мэдлэгийн хувьд 0.7% нь B, 2.6% нь C, 7.2% нь D, 89.5% нь F үнэлгээтэй байсан бол эмнэлгийн эрх зүйн мэдлэгийн хувьд 0.7% нь D, 99.3% нь F үнэлгээтэй байлаа (Зураг3).

Зураг 3. Эрх зүйн онолын мэдлэг болон эмнэлгийн эрх зүйн мэдлэгийн үнэлгээний байдал



ХЭЛЦЭМЖ

Судалгаанд хамрагдсан 153 оюутны 150 нь буюу 98% нь F үнэлгээ авсан. Бидний судалгааны үр дүн нь Энэтхэг Улсад 2014 ба 2018 онд хийгдсэн судалгааны үр дүнтэй дүйж байна. Иймд бидний судалгаанд хамрагдсан оюутнуудын эрх зүйн онолын болон эмнэлгийн эрх зүйн мэдлэгийн түвшин маш доогуур үнэлэгдэж байна. Бид асуулгадаа эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд өдөр тутам хэрэглэгдэхүйц ойлголтуудыг тусгасан бөгөөд ямар нэгэн алдаа, зөрчил гарсан тохиолдолд тухайн нөхцөл байдалд ямар арга хэмжээ авах, тухайн ойлголтыг буюу алдаа гаргасан уу? зөрчил гаргасан уу? гэдгээ ялгаж салгаж ойлгох чадвартай эсэхийг тодорхойлох боломжтой асуулгыг бэлтгэсэн. Гэвч дийлэнх хувь нь маш муу үнэлгээ авлаа. Тиймээс эмч, эмнэлгийн мэргэжилтэн болохоор бэлтгэгдэж буй оюутнуудад эмнэлгийн эрх зүйн хичээлийг зайлшгүй заах шаардлагатай ба үүнээс гадна эмнэлгийн эрх зүй, ёс зүйн сургалт, семинар, бага хурлуудыг зохион байгуулах хэрэгтэй юм.

---o0o---

Хуулийн чанарын хүрээлэн www.nlr.gov.mn

ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Хууль зүйн судалгааны төв[1]

ТҮЛХҮҮР ҮГ:

Өргөдөл, гомдол гаргах; өргөдөл, гомдлыг шийдвэрлэх; ИТБАТГӨГШтХ; ЗЕХ; төрийн байгууллага, албан тушаалтан; өргөдөл, гомдол шийдвэрлэх хугацаа.

ТОВЧЛОЛ:

ИТБАТГӨГШтХ нь 1995 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр батлагдан хэрэгжиж эхэлснээс хойш даруй 23 жилийн хугацаа өнгөрчээ. Энэ хугацаанд хуульд нийт 6 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна. “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “Тогтвортой, хариуцлагатай улс төрийн соёлыг төлөвшүүлж, хүчтэй, чадамжтай, хууль дээдэлсэн төрт ёсыг бэхжүүлэх зарчмыг баримтална” хэмээх 5.1-ийн 5.1.20-д “Төрийн захиргааны албан тушаалтан иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх хугацааг хоёр дахин бууруулж, хөнгөн шуурхай болгоно” гэсний дагуу хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 144-т “ИТБАТГӨГШтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж тодорхойлсон. Иймд хуульд заасан өргөдөл, гомдол шийдвэрлэх хугацааны зохицуулалт нь бодитой эсэх, хариу өгөхөд хангалттай хугацаа мөн эсэх, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт зааснаар хугацааг хоёр дахин бууруулах шаардлагатай эсэх зэрэг асуултад хариулт өгөх үүднээс Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6 дахь хэсэгт заасныг удирдлага болгон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын зургаадугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтлан ИТБАТГӨГШтХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийлээ. Үнэлгээ нь төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн 3 үе шатаас бүрдсэн бөгөөд энэхүү тоймд тэдгээрийг багцлан товч байдлаар хүргэх болно.

ҮНДСЭН ХЭСЭГ:

Үнэлгээ хийх хүрээг тогтоохдоо Товчлол хэсэгт дурдсан шалтгаантай уялдуулан ИТБАТГӨГШтХ-д заасан өргөдөл, гомдол шийдвэрлэх хугацааны зохицуулалт буюу хуулийн 16 дугаар зүйлийг сонгон авсан болно. Түүнчлэн үнэлгээний шалгуур үзүүлэлтээр *“практикт нийцэж байгаа байдал”*-ыг сонгож, “байх ёстой ба одоо байгаа”, “тохиолдол судлах” гэсэн хэлбэрүүдийг үндэслэн харьцуулан үзлээ. Энэхүү тоймд шалгуур үзүүлэлтийн томьёоллыг шууд дурдан үнэлгээ тус бүрийг товчлон хүргэв.

1. <u>Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхийн хуульд туссан байдал:</u>

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхийг Монгол

[1] Энэхүү судалгааг ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор П.Амаржаргал удирдаж, Эрдэм шинжилгээний ажилтан С.Цэрэндолгор, Э.Уянга нар гүйцэтгэв 2018 он.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Улс үе үеийн Үндсэн хуульдаа буюу 1940 оны Үндсэн хуулиас эхлэн тунхаглаж байсан. Гэсэн хэдий ч түүхэн эх сурвалжуудыг харахад тухайн үеийн төрийн тогтолцоо, нийгмийн байгууллаас хамааран энэ эрх нь "тунхаг"-ийн төдий байсан байна.

1992 оны Монгол Улсын "шинэ" Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 дахь хэсэгт "Төрийн байгууллага,албантушаалтандөргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй" гэж заасан.

Нэг талаас иргэд төрийн байгууллага болон түүний албан тушаалтнуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, алдаа дутагдал, зөрчил гажуудлыг арилгах, нөгөө талаас өөрсдийн зөрчигдсөн эрхийг төрөөр хамгаалуулах, эцэст нь хууль ёс, нийгмийн дэг журмыг чандлан сахиулах олон талын ач холбогдолтой иргэн төр хоёрын харилцан тэгш эрх эдэлж, үүрэг хүлээх зарчмыг хангах нэг үндсэн хэрэгсэл[2] болох бөгөөд үүнээс үзвэл уг эрх нь Үндсэн хуульд заасан бусад үндсэн эрхээс томоохон ялгаатай. "Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрхийн үндсэн зориулалт нь Үндсэн хуульд заасан бусад эрхийг эдлэх боломжийг бүрдүүлэх, процессын онцгой эрх болдог. ... Өөрөөр хэлбэл, уг эрх нь Үндсэн хуульд заасан бусад эрхүүдийг эдлэх хүрээнд өргөдөл гаргаж, тус эрхүүд зөрчигдсөн тохиолдолд гомдол гаргах байдлаар эдлэгдэх онцгой эрх болно. Энэхүү эрхийн бусад үндсэн эрхүүдээс ялгагдах онцлог нь бие даасан шинжтэй, дангаараа үл орших бөгөөд бусад эрхүүдийн суурь байж сая хэрэгжиж байдаг. Иймд тус эрх нь үндсэн эрх эдэлж болох субъектуудын хувьд амин чухал суурь процессын эрх"[3] билээ.

Үндсэн хуульд заасан тус эрхийг баталгаажуулах үүднээс УИХ-аас 1995 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр ИТБАТГӨГШтХ-ийг баталсан бөгөөд төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулдаг болсоор өдгөө 23 жилийн нүүрийг үзжээ. Иргэдийн өргөдөл, гомдлыг шударга чанд, бүрэн гүйцэд, бүх талыг хамарч шалгалт хийсний эцэст эргэлзээ төрүүлэхгүйгээр тов тодорхой хариу өгсөн[4] байх учиртай.

Мөн тийнхүү иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд тодорхой хугацаа байх нь зүй ёсны хэрэг юм. Учир нь ИТБАТГӨГШтХ-ийн 6, 7 дугаар зүйлд зааснаар иргэн нь гаргасан өргөдөл, гомдлынхоо хариуг авах эрхтэй, харин төрийн байгууллага, албан тушаалтан нь өргөдөл, гомдолд үндэслэл бүхий хариу өгөх, хугацаанд нь барагдуулах, шийдвэрлэх үүрэгтэй юм. Түүнчлэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хариу өгөх хугацаа тогтоож өгч байгаа нь төрийн байгууллага, албан тушаалтан хүнд суртал гаргахгүй, үйл ажиллагаа нь олон нийтэд ил тод, чиг үүрэг нь тодорхой байхад оршино. Иймд хуулийн 16 дугаар зүйлд өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хариу өгөх хугацааг зохицуулсан.

2. <u>ИТБАТГӨГШтХ-ийн 16 дугаар зүйл буюу өргөдөл, гомдол шийдвэрлэх ердийн хугацааны талаарх зохицуулалт:</u>

Өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэх ба шаардлагатай тохиолдолд тухайн байгууллагын удирдах албан тушаалтан 30 хүртэл хоногоор нэмж сунгасан бол өргөдөл, гомдол гаргагчид мэдэгдэхээр хуульчилжээ.

[2] Г.Совд нар, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, Уб., 2000 он, 108 дахь тал.

[3] А.Бямбажаргал, "Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрхийн хэрэгжилт, шинжилгээ" Ардчиллын хөгжил-Иргэний оролцоо, Уб., 2014 он, 68 дахь тал.

[4] Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, Ханнс-Зайделийн сан, Уб., 2009 он, 89 дэх тал.

Хуульд зааснаас үзвэл шийдвэрлэж хариу өгөх хугацаа нь тухайн өргөдөл, гомдлыг хүлээж авснаар тоологдож эхлэхээр байна. Өөрөөр хэлбэл, иргэний гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах учиртай этгээд хүлээн авснаар 30 хоногийн хугацаа тоологдож эхлэх ба хүлээж аваагүй байх үед хугацаа тоологдохгүй.

30 хоногт багтаан шийдвэрлэнэ гэдэг нь заавал тус хоногоор хязгаарлагдахгүй бөгөөд өргөдөл, гомдолд дурдсан асуудлыг шууд шийдвэрлэх боломжтой бол хуульд заасан хугацаа болохыг хүлээлгүйгээр зохих шийдвэрийг гаргаж шуурхай хариу өгнө.[5]

УИХ-аас 2015 онд захиргааны үйл ажиллагааны материаллаг хууль болох ЗЕХ-ийг баталсан нь тус салбарын хувьд томоохон дэвшил авчрах алхам болсон бөгөөд хуульд захиргааны үйл ажиллагааны үндсэн ба тусгай зарчмыг нэлээд тодорхой, нарийвчлан тусгасан.

ЗЕХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт захиргааны үйл ажиллагааны тусгай зарчмыг зааж, мөн зүйлийн 4.2.2 дахь хэсэгт "шуурхай, тасралтгүй байх" зарчмыг хуульчилжээ. Захиргааны байгууллага, албан тушаалтан нь хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд эсхүл иргэн, хуулийн этгээдийн өргөдөлд үндэслэн үйл ажиллагаагаа явуулдаг.

Ингэхдээ шуурхай, тухайн үйл ажиллагааг хойшлуулахгүйгээр хэрэгжүүлэх үүрэгтэй. Хэдийгээр хуульд "... захиргааны шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулах тодорхой хугацаа заасан хэдий ч аль болох шуурхай байхыг захиргааны байгууллага эрмэлзэнэ. Учир нь нийтийн эрх зүйн чиг үүргийг хэрэгжүүлдэг этгээдийн хувьд эдийн засгийн хэмнэлттэй үйл ажиллагаа явуулахыг зорих, нөгөө талаас хувь хүн, хуулийн этгээдэд хандсан асуудлыг хугацааны хувьд аль болох хурдан шийдвэрлэснээр ажиллагааны явц болон үүсэх үр нөлөө, үр дагавар эерэг байх"[6] юм.

Гэхдээ шаардлагатай тохиолдолд 30 хүртэл хоногоор нэмж сунгаж болохоор хуульд зохицуулсан ба сунгах шалтгаан нь зайлшгүй[7] шинжтэй буюу тухайн өргөдөл, гомдолд дурдагдсан асуудлын талаар нэмэлт баримт, мэдээлэл цуглуулах, шаардлагатай ажиллагаа хийх зэрэг нөхцөл байдал үүссэн байвал сунгана. Хуульд хугацаа сунгаж болохоор зохицуулахдаа сунгалтын давтамжийн хязгаарлалтыг хуульчлаагүй байна. Өөрөөр хэлбэл, хуулийн тус зохицуулалтыг үзвэл гагцхүү "... 30 хүртэл хоногоор нэмж сунгаж болно" гэсэн байх тул 30 хүртэл хоногоор хэдэн ч удаа нэмж сунгаж болох мэт ойлгогдож байна.

Иймд практикт ИТБАТГӨГШтХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт зааснаар тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтнаас өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмыг батлахдаа сунгалтын хязгаарыг тогтоож байна. Тухайлбал, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын даргын 2015 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн А/194 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам"[8]-ын дөрөвдүгээр зүйлийн 4.1-д "Өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш хуанлийн 30 хоногт багтаан шийдвэрлэх ба шаардлагатай тохиолдолд хугацааг Ерөнхий газар /дэд дарга/, орон нутаг дахь газар /тухайн газрын дарга/-т 30 хүртэл хоногоор *1 удаа сунгаж болно*" гэжээ.

[5] Нээлттэй нийгэм форум, Өргөдөл, гомдлоо хэрхэн гаргах вэ? /Иргэдэд зориулсан гарын авлага/, Уб., 2006 он, 36 дахь тал.

[6] Захиргааны ерөнхий хуулийн тайлбар, Ханнс-Зайделийн сан, Уб., 2017 он, 51 дэх тал.

[7] Мөн тэнд, 380 дахь тал.

[8] Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын даргын 2015 оны А/194 дүгээр тушаал, http://immigration.gov.mn/legal/2015-%D0%90194.pdf (Сүүлд үзсэн 2018.11.29)

Гагцхүү хугацаа сунгасан тохиолдолд өргөдөл, гомдол гаргагчид мэдэгдэнэ. Гэвч ИТБАТГӨГШтХ-ийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт мэдэгдэх тухай зохицуулахдаа "... мэдэгдэнэ" гэсэн үгээр хуульчилсан буюу угтаа бол энэ нь өргөдөл, гомдол гаргагчид заавал мэдэгдсэн байх утгатай заалт боловч "... нэмж сунгаж болно" гэдгийн адил заавал биелүүлэх шинжийг агуулахгүй байгаа нь энэхүү заалтын хүчийг сулруулж байна.

Хугацаа сунгасан талаар холбогдох этгээдэд мэдэгдэх нь захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд баримтлах гол зарчмын нэг болох "мэдэгдэх ба сонсгох" зарчимтай шууд хамааралтай. ЗЕХ-ийг шинэчлэн найруулахдаа 43 дугаар зүйлд "мэдэгдэх" зарчмыг хуульчилсан бөгөөд энэ нь нэг талаас өргөдөл, гомдлынхоо талаар хариу авах иргэний эрхийг хангах, нөгөө талаас өргөдөл, гомдолд дурдагдсан асуудал бүрийг хянан үзэж, үндэслэлтэй шийдвэрлэх үүргээ биелүүлэх боломжийг олгож буй хэрэг мөн. Өөрөөр хэлбэл, захиргааны байгууллагаас хандсан этгээддээ зохих ёсоор мэдэгдсэнээр[9] захиргааны шийдвэр гаргах үйл ажиллагааг "... эрх зүйн хувьд бий болсонд"[10] тооцдог.

3. <u>Холбогдох зохицуулалт нь өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хариу өгөхөд бодитой, хангалттай хугацаа мөн эсэх:</u>

Үнэлгээний хүрээгээр сонгож авсан зохицуулалт дахь хугацаа нь өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хариу өгөхөд хангалттай хугацаа мөн эсэхэд дүгнэлт өгөхийн тулд хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн тайлан, мэдээлэл болон холбогдох албан тушаалтантай хийсэн ярилцлага, иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авдаг цахим хэрэгсэл зэрэгт дүн шинжилгээ хийлээ.

ИТБАТГӨГШтХ-ийн дагуу Засгийн газраас "Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай" 2005 оны 67 дугаар[11] тогтоолыг баталсан бөгөөд өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байна. Тус тогтоолын 2 дахь хэсгийн "б"-д "Засгийн газарт иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын агуулга, бүтэц, чиг хандлага, шийдвэрлэлтэд судалгаа хийж, тойм танилцуулга, мэдээлэл бэлтгэн ... нийтэд мэдээлж байсугай" гэжээ. Гэвч Засгийн газрын хэрэг эрхлэх газрын албан ёсны цахим хуудас руу нэвтрэхэд тус хуудасны мэдээлэл 2016 оноос хойш шинэчлэгдээгүй[12], өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн талаар мэдээлэл байхгүй байв.

Иймд дурдсан мэдээллийг нийтэд мэдээлсэн байгууллагууд болох салбарын зарим яам, Нийслэлийн зарим захиргааны байгууллагуудын тайлан, мэдээг үзсэн болно. Тухайлбал, Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар /цаашид "НХТЕТГ" гэх/, МУЕТГ-ын холбогдох албан тушаалтан, өргөдөл, гомдол хүлээн авах цахим хэрэгслийг тус тус авч үзэв.

а/ НХТЕТГ нь Нийслэлийн Засаг даргын 2013 оны "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл,гомдлыг шийдвэрлэх тухай" А/1086 дугаар захирамжийг[13] өргөдөл, гомдол шийдвэрлэх үйл ажиллагаандаа мөрдлөг болгодог.

[9] П.Одгэрэл, Захиргааны эрх зүйн ерөнхий анги, 3 дахь хэвлэлт, Уб., 2016 он, 202 дахь тал.

[10] Мөн тэнд.

[11] ЗГ-ын 2005 оны 67 дугаар тогтоол "Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай", https://www.legalinfo.mn/law/details/3022 (Сүүлд үзсэн: 2018.11.30)

[12] Засгийн газрын хэрэг эрхлэх газрын албан ёсны цахим хуудас - http://cabinet.gov.mn (Сүүлд үзсэн 2018.11.30)

[13] Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1086 дугаар захирамж "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" /Тус захирамжийг нийслэлийн хэмжээний бүх нутгийн захиргааны байгууллага мөрдөн ажиллана./

Тус байгууллагын 2017 оны бүтэн жилийн[14] болон 2018 оны III улирлын[15] тайлангаас үзвэл сүүлийн 5 жилийн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа нь 12[16] хоног байх бөгөөд хугацаа хоцроосон өргөдөл, гомдол байхгүй байна. Дундаж хугацааг дор хүснэгтээр үзүүлье.

Хүснэгт *1. НХТЕТГ-ын өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн хугацааны тайлан /сүүлийн 4 жил/*

	Он	2015	2016	2017	2018
Өргөдөл, гомдол шийдвэр-лэлтийн дундаж хугацаа	Хоног	15	10	12	10
Нийт дундаж хугацаа			**12**		

Дээрхээс үзвэл өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа хуульд заасан хугацаанаас хоёр дахин бага буюу тус байгууллагын хувьд "шуурхай, тасралтгүй байх" зарчмыг ханган ажилласан гэж болохоор байна.

б/ Судалгааны хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын ахлах референттэй гүйцэтгэвэл зохих чиг үүргүүдийнх нь нэг болох өргөдөл, гомдолд хариу өгөх, шийдвэрлэх чиг үүргийн талаар болон энэ хүрээнд тулгардаг асуудлын талаар богино ярилцлага хийсэн бөгөөд товч байдлаар дор тэмдэглэвэл:

Иргэд өргөдөл, гомдол гаргах харьяаллаа сайн мэддэггүйгээс харьяаллын дагуу шилжүүлэх өргөдөл, гомдол цөөнгүй ирдэг. Түүнчлэн тодорхой албан тушаалтан хуульд заасан үндэслэлээр ажлаа хүлээлгэж өгөхдөө ирсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлээгүй чигээр нь хүлээлгэдэг тул шинэ албан хаагч ажил хүлээлцэх хооронд өргөдөл, гомдол шийдвэрлэлт хугацаа алддаг.

МУЕТГ-ын ахлах референттэй ярилцсан ярилцлагаас... 2018.11.27.

в/ Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд нь www.ub1200.mn цахим хуудас болон тус хуудасны эрхээр нэвтэрдэг "Smart UB", "Check my service" хэмээх ухаалаг утасны цахим хэрэглүүрээр иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч байна.

Эдгээрээс "Check my service" цахим хэрэглүүр дэх иргэдийн өргөдөл, гомдол олон нийтэд ил харагддаг бөгөөд өргөдөл, гомдол гаргасан болон шийдвэрлэсэн огноог мэдээллэдгээрээ онцлог ажээ. Тэдгээрээс үзвэл гомдол шийдвэрлэсэн дундаж хугацааны дээд үзүүлэлт 70 хоног, доод хугацаа 2 хоног байна.

Дээрхийг дүгнэвээс, иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хариу өгөх хугацаа нь асуудлын цар хүрээнээс хамаарч янз бүр байх боловч дийлэнх нь хугацаандаа шийдвэрлэгдсэн байх бөгөөд хугацааны зохицуулалт нь бодитой, хариу өгөхөд хангалттай гэж үзэж болох юм.

4. <u>Өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлээгүйн улмаас гарах үр дагавар буюу албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын асуудал нь практикт нийцэж байгаа эсэх:</u>

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацааны дотор шийдвэрлэх нь тодорхой эрх зүйн үр дагавар агуулдаг тул онцгой ач холбогдолтой заалт юм. Учир нь

[14] НХТЕТГ-ын өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн 2017 оны тайлан, http://mpa.ub.gov.mn/?p=1909 (Сүүлд үзсэн 2018.11.01)

[15] НХТЕТГ-ын өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн 2018 оны III улирлын тайлан, http://mpa.ub.gov.mn/?p=3600 (Сүүлд үзсэн 2018.11.01)

[16] Дунджийг тооцоолоход 11.75 гарсан тул ийнхүү ойролцоо дүнг авав.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

иргэдийн өргөдөл, гомдлыг хугацаанд нь барагдуулах үүргээ биелүүлээгүй албан тушаалтан ИТБАТГӨГШтХ-ийн 21 дүгээр зүйлд заасан хариуцлага хүлээдэг. Иймд үнэлгээний хүрээгээр сонгож авсан заалт болон үүргийн зөрчил хоёр нь хоорондоо шууд хамааралтай байна.

ИТБАТГӨГШтХ дахь хариуцлагын талаар заасан 21 дүгээр зүйлд УИХ-аас ЭХ болон ЗтХ-ийн шинэчилсэн найруулгыг баталсантай холбогдуулан өөрчлөлт[17] оруулсан бөгөөд хуулийн бичвэр дараах байдлаар өөрчлөгдсөн:

Дээрхээс үзвэл, ЭХ болон ЗтХ-тай холбогдуулан өөрчлөлт оруулахаас өмнө иргэний өргөдөл, гомдлыг хугацаанд нь барагдуулаагүй албан тушаалтанд торгох шийтгэлийг шүүгч ногдуулахаар; сахилгын шийтгэлийг түүнийг удирддаг эрх бүхий албан тушаалтан ногдуулахаар тус тус хуульчилсан байжээ.

Харин өөрчлөлт орсноор ЭХ болон ЗтХ-ийг эш татан хуульчилсан байна. Үүний дагуу ЭХ болон ЗтХ-ийг үзвэл холбогдох зохицуулалт олсонгүй. Тодруулбал, ЗтХ-д өмнө нь салбарын

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан

өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйл

Өөрчлөлт орохын өмнөх бичвэр	Өөрчлөлт орсны дараах бичвэр
21 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага	**21 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**
1. Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 4, 6 дахь заалт, мөн зүйлийн 2 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 2, 5 дахь хэсэгт заасныг зөрчсөн бол сахилгын шийтгэлийг эрх бүхий албан тушаалтан, 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, *16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг*, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг зөрчиж өргөдөл, гомдол гаргагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироосон нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч 20000-50000 төгрөгөөр торгох шийтгэлийг ногдуулна.	1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
2. Энэ хуулийн 8 дугаар зүйлийн заалтыг зөрчиж, бусдыг доромжилсон, гүтгэсэн, бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан этгээдэд Иргэний хууль, Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
3.Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаа хожимдуулан хариу өгсөн нь Төрийн албаны тухай хуулийн 26.1-д заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.	

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

[17] УИХ, “ИТБАТГӨГШтХ-д өөрчлөлт оруулах тухай” хууль (2015 оны 12 дугаар сарын 4-ний өдөр), https://www.legalinfo.mn/additional/details/2446?lawid=294 (Сүүлд үзсэн 2018.11.15)

хууль тогтоомжид байсан хариуцлагыг нэгтгэн хуульчилсан бөгөөд тус хуулийн тусгай ангид тухайн зөрчилд холбогдох хууль тогтоомжийг нэрлэн заасан. Гэтэл ИТБАТГӨГШтХ-ийг зөрчсөн талаарх зөрчил тусгагдаагүй буюу тус хуулийг эш татаагүй байна. Гагцхүү ЗтХ-ийн Арван тавдугаар бүлэгт "Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааны эсрэг зөрчил"-ийг хуульчилсан байх бөгөөд мөн бүлэгт ИТБАТГӨГШтХ-тай холбогдох зохицуулалт хэлбэрийн болоод агуулгын хувьд байхгүй байна.

> ЗтХ-иар захиргааны эрх зүйн зөрчил алга болж, ЗтХ-ийг ЭХ-ийн нэг хэсэг болгосон байна. Түүнчлэн 220, 230-аад хуульд байсан хариуцлагыг ЗӨВХӨН МЕХАНИКААР тусгасан нь хангалтгүй.
>
> *Академич С.Нарангэрэлтэй ярилцсан ярилцлагын тэмдэглэлээс... 2018.11.19.*

Ийнхүү ЗтХ-д салбарын хууль тогтоомжид байсан хариуцлагыг "механикаар" тусгаж, салбарын холбогдох хуулиудаас хариуцлагын хэсгийг "автоматаар" хасахдаа бүрэн нягтлаагүйгээс зарим хууль, тодруулбал, ИТБАТГӨГШтХ-ийн хариуцлагатай холбоотой хэсэг хуулийн зохицуулалтын гадна үлджээ. Энэ тохиолдолд өмнө нь шийдвэрлэж болоод байсан хариуцлагыг хэрхэн шийдвэрлэх талаар эргэлзээтэй асуудал урган гарч ирж байна.

5. <u>Хуульд заасан буюу өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хариу өгөх хугацааг багасгах шаардлага байгаа эсэх:</u>

Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хариу өгөх хугацааг багасгах асуудлыг өмнөх Засгийн газрын хүрээнд буюу 2012-2016 онд мөн хэлэлцэж байсан байна. Тодруулбал, 2013 онд "ИТБАТГӨГШтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийг[18] боловсруулсан байсан боловч батлагдаагүй байна. Тус төслийн танилцуулга[19] болон үзэл баримтлалыг[20] үзвэл холбогдох зохицуулалтын 1 дэх хэсэгт заасан 30 хоногийг "ажлын 14 хоног", 2 дахь хэсэгт заасан 90 хоногийг "ажлын 45 хоног" байхаар тус тус боловсруулжээ.

Төслийн үзэл баримтлалын "Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага" хэмээх нэг дэх хэсэгт "... 2009 оноос хойш өнөөдрийг хүртэл хугацаанд иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргах өргөдөл гомдлын тоо даруй 2,2 дахин нэмэгдсэн ... байна. Ачаалал ийнхүү нэмэгдсэнтэй холбогдуулан өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хугацаа удааширч түүнийг даган төрийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээ нь иргэдийн эрх ашигт нийцсэн бус эсрэгээрээ тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулах хэмжээнд хүрээд байна. ... Тиймээс ... өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн хугацааг богиносгох, холбогдох ажилтны үүрэг хариуцлагыг илүү өндөрсгөх бодит шаардлага тулгараад байгааг харгалзан энэхүү хуулийн төслийг санаачлан боловсрууллаа"[21] гэжээ. Төрийн байгууллага, албан тушаалтанд гаргах өргөдөл, гомдлын тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор байгууллагын ачаалал нэмэгдсэн байтал ачааллыг бууруулах арга хэмжээ авахаас урьтаж шийдвэрлэлтийн хугацааг бууруулахаар үзэл баримтлалдаа тусгасан нь төдийлөн үндэслэлтэй биш юм.

[18] ИТБАТГӨГШтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, 2013, http://2012.parliament.mn/law/prtoject/258/category/1 (Сүүлд үзсэн 2018.10.29)

[19] ИТБАТГӨГШтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, 2013, http://2012.parliament.mn/files/download/51988 (Сүүлд үзсэн 2018.10.29)

[20] ИТБАТГӨГШтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, 2013, http://2012.parliament.mn/files/download/51989 (Сүүлд үзсэн 2018.10.29)

[21] Мөн тэнд, 1-2 дахь тал.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Хугацааг бууруулах эсэх асуудлыг эцэслэн дүгнэхээс өмнө гадаадын хоёр орны өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн хугацааг цухас авч үзье. Гагцхүү энэ судалгааны хувьд гадаад улсын хүрээнд эрх зүйн бүл, тогтолцоог харгалзан үзсэнгүй. Учир нь төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрх нь эрх зүйн бүлээс үл хамаарах "нийтлэг" шинжтэй суурь үндсэн эрх юм. Түүнчлэн ингэхдээ монгол хэл дээр бэлэн байсан мэдээлэл буюу УИХ-ын Тамгын газраас холбогдох асуудлаар хийсэн мэдээлэл, лавлагааг ашиглах болон гадаад хэл (англи, орос) дээр буй шаардлагатай нэмэлт мэдээллийг орчуулах замаар товч байдлаар бэлтгэлээ.

а/ Оросын Холбооны Улс /ОХУ/:

ОХУ-д иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг "ОХУ-ын иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг авч хэлэлцэх журмын тухай хууль"[22] (О порядке рассмотрения обращений граждан Российской Федерации)-д зохицуулдаг бөгөөд өргөдөл, гомдол шийдвэрлэх хугацааны зохицуулалт нь манай улсын зохицуулалттай төстэй.

Хуулийн 12 дугаар зүйлд өргөдөл, гомдол шийдвэрлэх хугацааг хуульчилсан ба мөн зүйлийн 1 дэх хэсэгт "... өргөдлийг бүртгэж авснаас хойш 30 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэнэ"[23] гэжээ. Түүнчлэн сунгах хугацааг мөн зүйлийн 2 дахь хэсэгт "Энэ хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан шиг онцгой тохиолдлоос бусад тохиолдолд эрх бүхий этгээд тухайн өргөдлийг шийдвэрлэх хугацааг 30-аас дээшгүй хоногоор сунгана. Энэ тухайгаа өргөдөл гаргасан иргэнд мэдэгдэнэ"[24] гэсэн байна.

Тус хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан тохиолдол нь тусгай журмаар зохицуулсан төрийн буюу бусад нууцтай холбоотой мэдээллийг агуулсан өргөдөл, гомдлыг 15 хоногийн дотор хүргүүлэх шаардлага байгаа бүхий тохиолдол юм. Энэ мэтчилэн онцгой тохиолдлоос бусад тохиолдолд хугацааг 30-аас дээшгүй хоногоор сунгахаар байна.

б/ Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс /ИБУИНВУ/:

ИБУИНВУ-ын хувьд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг ажлын 15-20 өдөрт багтаан шийдвэрлэдэг. Хэрэв өргөдөлд дурдсан асуудлын талаар дэлгэрэнгүй судалгаа хийх шаардлагатай бөгөөд тогтоосон хугацаанд шийдвэрлэх боломжгүй бол энэ талаар гомдол гаргагчид мэдээлнэ. Иргэдээс төрийн үйлчилгээг сайжруулах талаар ирүүлсэн бүхий л саналыг хүлээн авч судлах ба боломжтойг хэрэгжүүлнэ. Хэрэв иргэний өргөдөлд дурдсан асуудлыг хүлээн авах боломжгүй бол юуны учир хүлээн авч шийдвэрлэх боломжгүй байгаа тухай хариу заавал мэдэгдэнэ.[25]

Түүнчлэн тухайлан Умард Ирландын Төрийн албаны зөвлөл / Office of the Civil Service Commissioners - OSCS/-д иргэдээс төрийн албан хаагчийн үйл ажиллагааны талаар гаргах өргөдөл, гомдлын зохицуулалтыг авч үзэхэд Зөвлөл нь өргөдөл, гомдлыг хүлээн авсан тухайгаа ажлын 3 өдрийн дотор иргэнд хариу мэдэгдэж, ажлын 20 хоногийн дотор өргөдөл, гомдлыг

[22] Федеральный закон от 02.05.2006 N 59-ФЗ (ред. от 27.11.2017) "О порядке рассмотрения обращений граждан Российской Федерации", http://legalacts.ru/doc/59_FZ-o-porjadke-rassmotrenija-obrawenij-grazhdan-rossijskoj-federacii/ (Сүүлд үзсэн: 2018.11.28)

[23] Р.Оргилмаа, "Иргэдийн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн эрх зүйн орчин, бусад орны туршлага" УИХТГ-ын судалгааны эмхэтгэл XVII боть, Уб., 2014 он, 217 дахь тал.

[24] ОХУ-ын хууль тогтоомжийн мэдээллийн цахим сан - http://legalacts.ru/doc/59_FZ-o-porjadke-rassmotrenija-obrawenij-grazhdan-rossijskoj-federacii/ (Сүүлд үзсэн: 2018.11.28)

[25] Р.Оргилмаа, "Иргэдийн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн эрх зүйн орчин, бусад орны туршлага" УИХТГ-ын судалгааны эмхэтгэл XVII боть, Уб., 2014 он, 209 дэх тал.

шийдвэрлэдэг.[26]

Гэхдээ шийдвэрлэж буй асуудлын цар хүрээнээс хамаарч шийдвэрлэх хугацаа янз бүр байх бөгөөд дундаж хугацаа нь ажлын 20 хоног[27] байдаг. Гагцхүү Монгол Улсын ИТБАТГӨГШтХ-ийн зохицуулалтаас ялгаатай нь иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авсан тухайгаа ажлын 3-5 өдрийн дотор иргэнд хариу мэдэгддэг байна.

Дээрхээс үзвэл ОХУ болон ИБУИНВУ-ын өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн хугацааны дундаж нь ажлын 20 хоног байх бөгөөд энэ хэсгийг бэлтгэх явцад уншиж судалсан ХБНГУ, Австрали, Филиппин, Бүгд Найрамдах Энэтхэг Улс зэрэг орнуудад хугацаа мөн тийм байх боловч Монгол Улсын зохицуулалтаас ялгаатай нь иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авсан тухайгаа тухайн иргэнд ажлын 2-5 өдрийн дотор заавал хариу мэдэгддэг. Ингэснээр иргэн өргөдөл, гомдлынхоо хариуг авах хугацааны хязгаарыг мэдэх, тогтоосон хугацааны дотор хариугаа аваагүй бол гомдол гаргах эрх нээгдэх боломжтой болох юм.

Дүгнэвээс, судалгааны тайланд үнэлгээний хүрээгээр тогтоосон зохицуулалт буюу ИТБАТГӨГШтХ-ийн 16 дугаар зүйлд заасан "өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хариу өгөх" хугацаа нь практикт хангалттай хэрэгжиж байгаа, мөн хариу өгөхөд хангалттай хугацаа болох бөгөөд хэдийгээр бодит байдал дээр заасан хугацаанаас өмнө шийдвэрлэж буй ч үүнийг хоёр дахин бууруулж хуульчлах шаардлага бодитоор үүсээгүй байна. Харин үүнтэй холбоотой бусад буюу иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авснаа хариу мэдэгдэх, байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах зэрэг асуудлыг шийдвэрлэсний үндсэн дээр хугацааг бууруулах боломжтой.

ДҮГНЭЛТ

ИТБАТГӨГШтХ-ийн 16 дугаар зүйлд өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хариу өгөх хугацаа тогтоож өгч байгаа нь төрийн байгууллага, албан тушаалтан хүнд суртал гаргахгүй, үйл ажиллагаа нь олон нийтэд ил тод, чиг үүрэг нь тодорхой байхад оршино. Энэхүү үнэлгээний тайлангийн хүрээнд тийнхүү хугацаатай холбогдох зохицуулалтыг сонгон авч үнэлсний үндсэн дээр дараах дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

1. Хуульд иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хариу өгөх хугацааг сунгаж болохоор зохицуулахдаа сунгалтын давтамжийн хязгаарлалтыг хуульчлаагүй байна. Өөрөөр хэлбэл, хуулийн тус зохицуулалтыг үзвэл гагцхүү "... 30 хүртэл хоногоор нэмж сунгаж болно" гэсэн байх тул 30 хүртэл хоногоор хэдэн ч удаа нэмж сунгаж болох мэт ойлгогдож байна.

2. Өргөдөл, гомдол шийдвэрлэх хугацааг сунгасан тохиолдолд өргөдөл, гомдол гаргагчид мэдэгдэх үүрэгтэй. Хугацаа сунгасан талаар холбогдох этгээдэд мэдэгдэх нь захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд баримтлах гол зарчмын нэг болох "мэдэгдэх ба сонсгох" зарчимтай шууд хамааралтай юм. Гэвч ИТБАТГӨГШтХ-д мэдэгдэх тухай зохицуулахдаа "... мэдэгдэнэ" гэсэн үгээр хуульчилсан буюу угтаа бол энэ нь өргөдөл, гомдол гаргагчид заавал мэдэгдсэн байх утгатай заалт боловч "... нэмж сунгаж болно" гэдгийн адил заавал биелүүлэх шинжийг агуулахгүй байгаа нь энэхүү заалтын хүчийг сулруулж байна.

[26] CSC-NI, Handling complaints, enquiries and complaints, Dec, 2012, p.6-7, http://www.nicscommissioners.org/wp-content/uploads/2013/01/PDF_HANDLING_COMMENTS,_ENQUIRIES_AND_COMPLAINTS.PDF (Сүүлд үзсэн 2018.11.29)

[27] Complaints procedure - https://www.gov.uk/government/organisations/cabinet-office/about/complaints-procedure (Сүүлд үзсэн 2018.11.29)

3. Өргөдөл, гомдол шийдвэрлэх, хариу өгөх хугацааны дундаж нь практикт 12 хоног байх бөгөөд хугацаа хоцроосон өргөдөл, гомдол харьцангуй цөөн байна. Өргөдөл, гомдлын хугацааг хэтрүүлж шийдвэрлэх нь дараах шалтгаантай гэж дүгнэж болно.

- Иргэд өргөдөл, гомдол гаргах харьяаллаа тодорхой мэддэггүйн улмаас харьяаллын бус байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргадаг бөгөөд ингэснээр байгууллага хооронд шилжүүлэх, өргөдөл, гомдол гаргагчтай эргэн холбогдох шаардлага ойрхон тулгарах зэргээр хугацаа алддаг. /Тухайлбал, ял эдэлж байгаа хүнд Өршөөл үзүүлэх тухай хуулиар өршөөл үзүүлж, Ерөнхийлөгчийн зарлигаар уучлал үзүүлдгийг ялгаж мэддэггүйгээс Ерөнхийлөгчид хандан "өршөөл үзүүлэх тухай" хууль гаргах өргөдөл бичдэг/;

-Захиргааны байгууллага хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагаа муу байдгаас зарим тохиолдолд байгууллагын чиг үүрэг, бүтцэд гарсан өөрчлөлтийг цаг тухайд нь мэдээгүйн улмаас хугацаа хоцордог. Мөн өргөдөл, гомдолд дурдагдсан асуудлыг анхан шатны түвшинд шийдвэрлээд орхидог, шийдвэрийн хэрэгжилтэд тавих хяналт бараг байхгүйгээс гарах үр дагавар тодорхой бус, иргэний эрх ашиг, сонирхол хангагдахгүй үлддэг;

- Өргөдөл, гомдол гаргасан иргэд холбогдох материалаа бүрдүүлж өгөөгүй, эргээд холбоо барих гэхээр утсаа авдаггүй, холбогдох эх үүсвэрээ өөрчилсөн байдаг зэрэг иргэдээс өөрсдөөс хамаарах шалтгаан;

- Албан хаагчийн хариуцлагагүй байдлаас болох зэрэг шалтгаануудыг дурдаж болно.

4. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацааны дотор шийдвэрлэх нь тодорхой эрх зүйн үр дагавар агуулдаг тул онцгой ач холбогдолтой заалт юм. Учир нь иргэдийн өргөдөл, гомдлыг хугацаанд нь барагдуулах үүргээ биелүүлээгүй албан тушаалтан ИТБАТГӨГШтХ-ийн 21 дүгээр зүйлд заасан хариуцлага хүлээдэг.

Гэтэл УИХ-аас ЗтХ-ийн шинэчилсэн найруулгыг батлахдаа салбарын хуулиудад байсан хариуцлагыг нэгтгэн хуульчилсан бөгөөд ингэхдээ тэрхүү хуулиудын хариуцлагын хэсгийг хасаж, ЗтХ-д эш татах замаар зохицуулсан. Үүний дагуу ИТБАТГӨГШтХ-ийн холбогдох заалтад мөн адил өөрчлөлт оруулсан боловч ЗтХ-д тус хуулийг эш татаагүй, өргөдөл, гомдлыг хугацаа хоцроож шийдвэрлэсэн тохиолдолд хэрхэх талаар хэлбэр болон агуулгын хувьд зохицуулаагүй үлдээсэн нь шийдвэрлэх боломжтой байсан асуудлыг одоо хэрхэн шийдвэрлэх талаар эргэлзээ, тодорхойгүй байдлыг үүсгэж байна.

5. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хариу өгөх хугацааны зохицуулалт буюу "30", "90" хоногууд нь иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хариу өгөхөд бодитой бөгөөд хангалттай хугацаа гэж үзэх үндэслэлтэй. Түүнчлэн тус зохицуулалт нь практикт хэрэгжиж байгаа бөгөөд өнөөгийн манай практикт нийцэж болох зохицуулалт юм. Харин хугацаатай холбогдох өөр бусад хүчин зүйлүүд буюу дээр дурдсан асуудлуудыг шийдвэрлэх шаардлага бодитоор тулгарч байх юм.

ЗӨВЛӨМЖ

Судалгааны хүрээнд хийсэн үнэлгээ, дүгнэлтийг үндэслэн дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- Өргөдөл, гомдолд хариу өгөх, шийдвэрлэх хугацааг нэмж сунгах асуудлын хязгаарыг тодорхой хуульчлаагүйгээс хэдэн ч удаа сунгаж болох мэт ойлгогдож байх бөгөөд

хуулийн үйлчлэлийн хүрээнд www.nlaw.mn

ингэснээр зарим тохиолдолд иргэдийн өргөдөл, гомдол шийдвэрлэгдэх хугацаа хойшлогдож болзошгүй асуудал байгаа бөгөөд практикт тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтнаас өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмыг батлахдаа сунгалтын хязгаарыг тогтоож байх тул хугацаа сунгалтын асуудлыг хуулиар тодорхой зохицуулах /Тухайлбал, 1 удаа эсхүл 2 удаа зэргээр давтамжийн тоог тодорхой тогтоох/;

- Иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авсны дараа 3-5 хоногийн дотор тухайн өргөдөл, гомдол гаргагчид мэдэгдсэнээр иргэн өргөдөл, гомдлынхоо хариуг авах хугацааны хаязгаарыг мэдэх болон хугацаандаа өргөдөл, гомдлын хариуг аваагүй тохиолдолд дээд шатны захиргааны байгууллагад гомдол гаргах эрх нь нээгдэх тул өргөдөл, гомдол гаргагчийн эрх, ашгийг хангах үүднээс энэ асуудлыг хуульчлах;

- Өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэх буюу захиргааны байгууллагын “шуурхай, тасралтгүй байх” зарчмыг хангах үүднээс байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах, иргэдэд өргөдөл, гомдол гаргах харьяаллын талаар үнэн зөв мэдээллийг сурталчлан таниулах;

- Хугацааг хэтрүүлсний улмаас албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын асуудлыг ЭХ болон ЗтХ-д тодорхой тусгах зэрэг шаардлага байгааг анхааран үзэх учиртай.

Өөрөөр хэлбэл, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хариу өгөх хугацааны одоогийн зохицуулалт нь иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хариу өгөхөд бодитой бөгөөд хангалттай хугацаа төдийгүй өнөөгийн практикт нийцэж байх тул хугацаанд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй. Гагцхүү түүнтэй холбоотой дээр дурдсан бусад хүчин зүйлүүдийг шийдвэрлэх шаардлагатай байна.

---o0o---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nlgov.mn

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХЭСЭГЧЛЭН ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТОЙМ

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төв

ТҮЛХҮҮР ҮГ:

Тэнсэх, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх, хорих ял, хорихоос өөр төрлийн ялтай гэмт хэрэг, эрх зүйн хийдэл.

ТОВЧЛОЛ:

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6 дахь хэсэгт заасныг удирдлага болгон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын зургаадугаар хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ыг баримтлан Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хэсэгчлэн үнэлгээ хийлээ. Судалгааны хүрээнд хуулийн тодорхой зүйл, заалтыг сонгох замаар хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөлөл, цаашид тухайн хуулийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлохыг зорилоо. Үнэлгээ нь төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн 3 үе шатаас бүрдсэн бөгөөд энэхүү тоймд тэдгээрийг багцлан товч байдлаар хүргэх болно.

ҮНДСЭН ХЭСЭГ

Үнэлгээ хийх хүрээг тогтоохдоо Эрүүгийн хуульд заасан хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх зохицуулалт буюу хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1, 5 дахь хэсгийг сонгон авсан болно. Түүнчлэн үнэлгээний шалгуур үзүүлэлтээр *"практикт нийцэж байгаа байдал"*-ыг сонгож, "байх ёстой ба одоо байгаа", "тохиолдол судлах" гэсэн хэлбэрүүдийг үндэслэн харьцуулан үзлээ. Энэхүү тоймд шалгуур үзүүлэлтийн томьёоллыг шууд дурдан үнэлгээ тус бүрийг товчлон хүргэв.

1.Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний суурь эрх, халдашгүй байдлыг илүү баталгаажуулсан, олон улсын нийтийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцсэн урт хугацаанд тогтвортой үйлчлэх хуулийг батлан гаргах зүй ёсны шаардлага бий болж[2] улмаар Улсын Их Хурал Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг 2015 онд баталж, 2017 оноос эхлэн дагаж мөрдөх болсон билээ.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн ялын шинэчлэлийн нэг хэсэг болох тэнсэх, албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай заалт нь хорих ял биечлэн эдлэх явдлыг багасгах, гэмт хэрэг үйлдсэн хүний гэм бурууг өөрөөр нь ухамсарлуулах, хохирол нөхөн төлүүлэх, цаашид гэмт хэргийн карьер ахиж, мэргэшсэн гэмт хэрэгтэн бий болгохгүйн тулд авч буй шинэлэг арга хэмжээ юм.[3]

Дэлхийн бусад орнуудын Эрүүгийн хуулийн ялын бодлогод энэхүү ойлголтыг "probation" /пробаци/ гэж нэрлэж, ялын уян хатан, үр нөлөөтэй байх гол шинжийг энэхүү институтээр зохицуулж ирсэн байдаг.[4]

[1] Энэхүү судалгааг ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор П.Амаржаргал удирдаж, Эрдэм шинжилгээний ажилтан Б.Ариунжаргал, Ж.Булгансүрэн нар гүйцэтгэв (2018 он).

[2] Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлал, ХЗЯ, Уб., 2013 он.

[3] Сургагч багш нарт зориулсан гарын авлага, ХЗДХЯ, Уб., 2017 он, 72 дахь тал.

[4] Мөн тэнд, 71 дэх тал.

2015 оны Эрүүгийн хуулийн тусгай анги нь 20 бүлэг, 209 төрлийн гэмт хэргийн 424 заалтаас бүрдэж байна. Үүнээс хөнгөн гэмт хэрэгт[5] 289 , хүнд гэмт хэрэгт[6] 135 заалт нь хамаарна. Хөнгөн гэмт хэрэгт хамаарах 289 заалтаас 84 заалт нь хорих ял оногдуулахаар заагаагүй буюу хорихоос өөр төрлийн ялтай гэмт хэрэг байх бөгөөд хорих ял оногдуулахаар заагаагүй 84 заалтаас хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 34 заалт байна.

Өөрөөр хэлбэл, хорих ял оногдуулахаар заагаагүй 50 хөнгөн гэмт хэрэгт Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан "тэнсэх" албадлагын арга хэмжээг хэрэглэх боломжгүй байгаа учраас "Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх" тухай заалт нь практикт маргаан дагуулж, эргэлзээтэй байдал үүсгээд байна. Тухайлбал, хорих ялтай, хөнгөн гэмт хэрэг үйлдсэн хүний ялыг хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж болох боловч хорих ял оногдуулахаар заагаагүй[7] / хорихоос өөр төрлийн ялтай/ гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага заавал хүлээлгэж, ял оногдуулж буй нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна" гэсэн заалтыг зөрчиж, Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлд заасан "Шударга ёсны зарчим"-ыг алдагдуулж байна гэж үзэж болохоор байна.

Иймд Эрүүгийн хуулийг хэрэгжүүлэх явцад зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, хэрэглэхэд хүндрэлтэй, эрх зүйн хийдэлтэй зохицуулалт нэлээдгүй байгаа учир тухайн заалтуудыг практикт нэг мөр хэрэгжүүлэхийн тулд тодорхой асуудлаар хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай[8] хэмээн практикт ажиллаж буй хуульчид болон салбарын эрдэмтэн, судлаачдын үзэж байгаа нь хуулийн хэрэгжилтийн талаар зохион байгуулагдаж буй хэд хэдэн удаагийн хэлэлцүүлэг[9], хурлын үр дүнгээс харагдаж байна. Дээрх нөхцөл байдал бий болсон тул хуулийн энэхүү зохицуулалтад үнэлгээ хийх зайлшгүй шаардлага үүссэн гэж үзлээ.

Харин Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэгт өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхтэй холбоотой асуудлыг зохицуулсан бөгөөд уг бүлгийн зарим зүйл заалт буюу 8.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "хорих ялтай хөнгөн гэмт хэрэгт оногдуулах ялыг тэнсэх боловч хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэгт оногдуулах ялыг тэнсэх боломжгүй" байдлаар хуульчилсан, мөн 8.6 дугаар зүйлд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг эрх зүйн байдлыг насанд хүрсэн хүнтэй адил зохицуулсан нь хуулийн зорилго болон уг бүлгийн ач холбогдолд хэр нийцсэн эсэхийг судлан үзэх шаардлагатай болсон.

Үүнийг УИХ-ын гишүүн О.Батнасангийн санаачилсан Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд "... олон улсын хэмжээнд "насанд хүрээгүй хүүхдийн шүүн таслах ажиллагаа" гэх нэр томьёог хэрэглэж, гэмт хэрэгт яллагдаж, сэжиглэгдэж байгаа хүүхдийн шүүн таслах ажиллагааг насанд хүрэгсдийн ерөнхий процессоос ялгаж, тусгайлсан шүүн таслах ажиллагаа

[5] Эрүүгийн хуулийн 2.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг "Энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг таван жил, түүнээс доош хугацаагаар оногдуулахаар тогтоосон, эсхүл хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэргийг хөнгөн гэмт хэрэг гэнэ".

[6] Эрүүгийн хуулийн 2.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг " Энэ хуулийн тусгай ангинд хорих ялын доод хэмжээг хоёр жил, түүнээс дээш хугацаагаар оногдуулахаар тогтоосон гэмт хэргийг хүнд гэмт хэрэг гэнэ".

[7] Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хорих ялгүй 50 хөнгөн гэмт хэрэгт Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлийн 1.1, 1.2 дахь хэсэг, мөн хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тус тус заасан "тэнсэх" албадлагын арга хэмжээг хэрэглэх боломжгүй байна.

[8] Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйл, 6.7 дугаар зүйл.

[9] Тухайлбал, УИХ-ын ХЗБХ, ХЗДХЯ-тай хамтран "Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх хэлэлцүүлэг", "Шүүхийн шийдвэр түүний хэрэглээ ач холбогдол" сэдэвт хэлэлцүүлэг, "Эрүүгийн хуулийн шинэтгэлийн үйл явц" сэдэвт хэлэлцүүлэг, "Хүний эрх, эрх чөлөөний хууль зүйн баталгаа – онол практикийн асуудал" олон улсын эрдэм шинжилгээний хурал.

ялын бодлого авч хэрэгжүүлдэг[10] хэмээн тайлбарлажээ.

Гэтэл шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг өмнөх хуулиас дордуулж зохицуулсан нь практикт нэлээдгүй маргаан дагуулж, 18 насанд хүрээгүй хүүхдийг аль болохоор хорихоос өөр ялаар шийтгэх хувилбарыг баримтлах олон улсын гэрээ, конвенц, пактын зарчимд нийцэхгүй байна. Тухайлбал, 2002 оны Эрүүгийн хуулиар насанд хүрээгүй хүүхдийн хувьд хорих ял оногдуулахдаа гэмт хэргийн ангилал харгалзахгүйгээр хорих ял оногдуулсан шийтгэлийг тэнсэх, хойшлуулах зохицуулалттай байсныг шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар зөвхөн "хөнгөн гэмт хэрэг" гэж хязгаарласан нь өсвөр насны хүний эрх зүйн байдлыг дордуулсан зохицуулалт болсон гэж хуульч, шүүгч, судлаачид үзэж байна.[11]

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн онцлог нь хорих ялыг биечлэн эдлүүлэх явдлыг багасгах, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд анхаарч, зорчих эрхийг хязгаарлах ял, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэх, гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд насанд хүрсэн хүнээс ялгамжтай байдлаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх нөхцөлийг бүрдүүлж, ялын агуулга хэлбэрийг шинэчлэн тодорхойлж, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх институтийг тусгасан явдал юм.[12]

Эрүүгийн хуулийн зорилгыг хэрэгжүүлэхэд нөлөө үзүүлэх 7.1 дүгээр зүйл "Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх", Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэг "Өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх" зохицуулалтын талаарх асуудлыг судлан үзэхээр судалгааны хүрээг тогтоон, судалгааны удирдамжаа боловсруулсан. Гэсэн хэдий ч Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэг "Өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх" зохицуулалтын хүрээнд зохих судалгааг хийж гүйцэтгэн, 2018 оны хуулиар өөрчлөлт орсон байх тул Эрүүгийн хуулийн хэрэгжилтэд хийж буй энэхүү үнэлгээгээр өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг үнэлээгүй болно.

Харин энэхүү судалгаагаар хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх зохицуулалтын хэрэгжилт, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх зохицуулалтын эерэг, сөрөг талыг судалж, хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийхээр судалгааны хүрээг тогтоосон.

2.Тус хуулийн 7.1 дүгээр зүйлд "Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх" асуудлыг зохицуулсан бөгөөд уг зохицуулалтын ач холбогдлыг "...шүүхээс хуульд заасан шинжийг хангасан хүнд хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж, албадлагын арга хэмжээ өргөнөөр авснаар хорих ял биечлэн эдлэх явдал багасна гэж үзэж байна"[13] хэмээн тайлбарлажээ.

Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Энхбаяр "Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх хэлэлцүүлэг"-т оролцохдоо "... Гэмт хэрэг үйлдсэн хүнд шүүхээс хорих ял оногдуулах, түүнийг биечлэн эдлүүлэх үзүүлэлт 3 дахин багассан нь хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж албадлагын арга хэмжээ хэрэглэх Эрүүгийн хуулийн зохицуулалттай холбоотой байна. Тодруулбал, 2016 онд анхан шатны шүүхээр 4267 хүнд хорих ял оногдуулж шийдвэрлэж байсан бол 2017 онд анхан шатны шүүх 1314 хэрэгт хорих ял оногдуулж, 639 хүнд хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж, 370

[10] УИХ-ын гишүүн О.Батнасангийн санаачилсан Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал.

[11] Мөн тэнд.

[12] Сургагч багш нарт зориулсан гарын авлага, ХЗДХЯ, Уб., 2017 он, 4 дэх тал.

[13] Мөн тэнд, 72 дахь тал.

хүний ялыг тэнсэж, албадлагын арга хэмжээ хэрэглэх шийдвэр гаргажээ. Хамгийн гол нь тэнсэж, албадлагын арга хэмжээ авагдсан этгээд дахин гэмт хэрэг үйлдэж, шүүхээр шийтгэгдсэн тохиолдол байхгүй байгаа нь хуулийн зорилго байгаа оножээ гэж үзэхэд хүргэсэн сайн мэдээ болж чадлаа"[14] хэмээн цохон тэмдэглэсэн байна.

Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх тухай зохицуулалт нь гэмт хэрэг үйлдсэн хүнд заавал хорих ял оногдуулахгүйгээр гэм буруугаа ухамсарлан, гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо нөхөн төлөх, өөрийн гэмт зан үйлийг засах боломжийг бүрдүүлж байгаа нь "шоронжуулах"[15] бодлогын эсрэг зохицуулалт болохын хувьд практикт эерэг нөлөөллийг бий болгож байгаа хэдий ч зөвхөн хорих ялтай, хөнгөн гэмт хэрэгт ял оногдуулахгүйгээр тэнсэх боломжтой харин хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэгт оногдуулах ялыг тэнсэх боломжгүй байдлаар хуульчлагдсан нь хорихоос өөр төрлийн ялтай гэмт хэрэг үйлдсэн хүний эрх зүйн байдлыг дордуулж байна.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн тусгай анги нь 20 бүлэг, 209 төрлийн гэмт хэргийн 424 заалтаас бүрдэж байна. Үүнээс хөнгөн гэмт хэрэгт 289, хүнд гэмт хэрэгт 135 заалт нь хамаарна. Хөнгөн гэмт хэрэгт хамаарах 289 заалтаас 84 заалт нь хорих ял оногдуулахаар заагаагүй, хорихоос өөр төрлийн ялтай гэмт хэрэг байх бөгөөд энэхүү 84 заалтаас хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 34 заалт байна. Өөрөөр хэлбэл хорих ял оногдуулахаар заагаагүй 50 хөнгөн гэмт хэрэгт Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар тэнсэх боломжгүй нөхцөл байдал бий болсон нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна" гэсэн заалтыг зөрчиж, Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлд заасан "Шударга ёсны зарчим"-ыг алдагдуулж буй хэрэг юм.

3. Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэгт "Өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх" талаар тусгайлан зохицуулсан бөгөөд энэ бүлгийн хэд хэдэн заалтад 2018 онд өөрчлөлт оруулсны нэг нь 8.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг найман жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан ял оногдуулахыг тэнсэж нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хянан хүмүүжүүлэхээр шийдвэрлэж болно" хэмээх заалт юм.

Уг заалтад өөрчлөлт орсноор зөвхөн хорих ялтай, хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд л Эрүүгийн хуулийн 8.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан тэнсэх боломжтой байсныг "Энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг найман жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон эсхүл энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй..."[16] хэмээн өөрчилсөн нь гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний эрх зүйн байдлыг дээрдүүлж, эрх зүйн хийдлийг арилгах эхлэл болсон гэж үзэж байна.[17]

[14] УИХ-ын ХЗБХ, ХЗДХЯ-аас 2018 оны 3 сарын 3, 4-ний өдөр зохион байгуулсан "Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх хэлэлцүүлэг".

[15] Г.Ганбаатар, Ж.Эрдэнэбулган," Эрүүгийн хуулийн шинэчлэлийн тухай цөөн үг" нийтлэлдээ "2002 оны Эрүүгийн хуулийн хуучирсан, шоронжуулахад чиглэгдсэн зарим зохицуулалтыг өөрчлөх, боловсронгуй болгох талаар ... 15 орчим жил эгэл иргэдээ "шоронжуулах"-д чиглэгдсэн ялын хатуу бодлого, харин авилга албан тушаалын хэргийн эрх мэдэлтэнд эсрэгээр зөөлөн бодлого хэрэгжүүлдэг байсан талаар дурдсан байна. Дэлгэрэнгүй http://www.judcouncil.mn/inder/6706--.html цахим хуудаснаас үзнэ үү.

[16] Мөн тэнд.

[17] Эрүүгийн хуулийг дагаж мөрдөж эхэлснээс хойш орсон анхны өөрчлөлт.

Үүний тод илрэл нь хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд ч тэнсэх боломжтой байхаар өөрчлөлт оруулсан явдал юм.

Харин Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлийн 1.1, 1.2 дахь хэсэг, 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан зохицуулалт нь хорих ял оногдуулахаар заагаагүй хэргийг тэнсэх боломжгүй байгаа нь алдаа дутагдалтай хэвээр байна. Тиймээс тэнсэх албадлагын арга хэмжээг практикт зөв хэрэглэх, тус хуулийн зорилго, ач холбогдолд нийцүүлэн өөрчлөлт оруулах шаардлагатай хэмээн үзэж байна.

Прокуроруудаас авсан судалгааны үр дүнгээр[18]:

Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлд заасан хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх тухай зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх. Хэрэв тийм бол ямар бэрхшээл тулгарч байна вэ? гэсэн асуултад:

Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйл, 7.1 дүгээр зүйлд заасныг журамлан тэнсэхэд ижил гэмт хэрэг үйлдсэн хүнд ялгамжтай байдлаар хоёр өөр шийдвэр гаргаж байна. Өөрөөр хэлбэл, ижил гэмт хэрэг үйлдсэн хоёр хүний нэгийг нь хорих ял оногдуулахгүй тэнсэж, нөгөөг нь ял оногдуулж тэнсэж байгаа нь учир дутагдалтай хэмээн судалгаанд хамрагдсан прокуроруудын 6.8 хувь нь үзсэн байна.[19]

Шүүгчдээс авсан анкетын судалгаагаар[20] шүүхээс хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх, хорих ял оногдуулж тэнсэх асуудлыг зааглаж, ямар тохиолдолд хуулийн аль заалтыг журамлаж ял оногдуулах асуудлыг нэг мөр болгож цэгцлэхгүй бол шүүх үзэмжээрээ шийдвэрлэж, хуулийн заалтыг өөр өөрөөр хэрэглэж байна хэмээн үзсэн байна.

Түүнчлэн Эрүүгийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "... хөнгөн гэмт хэрэг үйлдсэн..." гэж заасан хэрнээ хөнгөн гэмт хэрэг дотроо зөвхөн хорих ялтай гэмт хэрэгт оногдуулах ялыг тэнсэж байгаа нь эрх зүйн хийдлийг бий болгож байна. Иймд Эрүүгийн хуулийн 7.1 зүйлд заасан Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх тухай зохицуулалт нь зорилгодоо бүрэн хүрээгүй болох нь харагдаж байна.

Уг заалтын тухайд тэнссэн хугацаанд санаатай гэмт хэрэг үйлдвэл тухайн үйлдсэн гэмт хэрэгт нь ял оногдуулж, өмнө нь үйлдсэн гэмт хэрэг буюу Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлд зааснаар хорих ял оногдуулахгүй тэнссэн хэрэгт оногдуулах ялыг энэ хуулийн 6.8, 6.9 дүгээр зүйлийг журамлан нэмж нэгтгэн ял оногдуулахаар заасан боловч хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн хугацааг хэдэн жилийн хорих ялтай дүйцүүлэн тооцох, эсхүл хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн гэмт хэрэгт шүүхээс хэрхэн ял оногдуулах нь ойлгомжгүй байна.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн дээрх зохицуулалтыг 2002 оны Эрүүгийн хуулийн зохицуулалттай харьцуулан үзвэл:

[18] Дэлгэрэнгүйг үнэлгээний тайлангийн бүрэн эхээс үзнэ үү.

[19] Мөн тэнд.

[20] Дэлгэрэнгүйг үнэлгээний тайлангийн бүрэн эхээс үзнэ үү.

Хүснэгт ***1.*** *2002 болон 2015 оны Эрүүгийн хуульд заасан "Тэнсэх"-тэй* холбоотой зохицуулалтын харьцуулалт

№	2002 оны Эрүүгийн хууль	2015 оны Эрүүгийн хууль
1	61 дүгээр зүйл. Тэнсэх 3. Тэнсэгдсэн ялтан хянан харгалзах хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд энэ хуулийн 58 дугаар зүйлд заасан журмыг баримтлан ял оногдуулна.	7.1 дүгээр зүйл. Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх 5.Тэнссэн хугацаанд энэ хуулийн тусгай ангид заасан санаатай гэмт хэрэг үйлдсэн бол шүүх тэнссэн шийдвэрийг хүчингүй болгож, энэ хуулийн 6.8, 6.9 дүгээр зүйлд заасан журмаар ял оногдуулна. 6. Тэнссэн хугацаанд болгоомжгүй гэмт хэрэг үйлдсэн бол тухайн гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан хугацаанд хүлээлгэсэн үүргийг биелүүлсэн байдлыг харгалзан уг албадлагын арга хэмжээг хүчингүй болгох эсэхийг шүүх шийдвэрлэнэ.

2002 оны Эрүүгийн хуулиар тэнсэгдсэн ялтан хянан харгалзах хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдвэл түүнд ял оногдуулдаг байсныг шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар санаатай гэмт хэрэг үйлдсэн бол шүүхээс тэнссэн шийдвэрийг хүчингүй болгож ял оногдуулах, болгоомжгүй гэмт хэрэг үйлдсэн бол тухайн гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан хугацаанд хүлээлгэсэн үүргийг биелүүлсэн байдлыг харгалзан уг албадлагын арга хэмжээг хүчингүй болгох эсэхийг шүүх шийдвэрлэхээр өөрчлөн найруулсан байна.

Эрүүгийн хуулийн 6.9 дүгээр зүйл буюу хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах тухай заалт нь 2002 оны Эрүүгийн хуулийн 58 дугаар зүйлийн шинэчилсэн найруулга бөгөөд энэхүү ойлголтыг "хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах гэдэг нь шүүхийн шийтгэх тогтоолоор ял шийтгүүлж түүнийгээ бүрэн эдэлж дуусахын өмнө гэмт хэрэг шинээр үйлдсэн тохиолдолд ял оногдуулахад хэрэглэдэг хуулиар тогтоосон журам"[21] хэмээн үздэг байсан. Гэтэл шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж, улмаар тэнсэн хугацаанд санаатай гэмт хэрэг үйлдвэл өмнөх ялыг хэрхэн тооцох нь тодорхойгүй байдлыг бий болгосон.

4. Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх зохицуулалттай холбоотойгоор хорих ял шийтгүүлсэн шүүгдэгчийн тоо буурсан. Тухайлбал, 2017 оны эхний хагас жилийн байдлаар анхан шатны шүүхээс 2617 шүүгдэгчид хорих ял оногдуулж байсан бол 2017 оны сүүлийн хагас жилд 1314 шүүгдэгчид хорих ял оногдуулсан нь 49.7 хувиар буурч, 639 шүүгдэгчид хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж, 370 шүүгдэгчийн ялыг тэнсэх албадлагын арга хэмжээ хэрэглэсэн байна.[22] Энэ мэтчилэн хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх зохицуулалт нь практикт эерэг нөлөөллийг бий болгож байгаа хэдий ч хорих ял оногдуулахаар заасан хөнгөн гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах ялыг л тэнсэх боломжтой, харин хорих

[21] С.Жанцан, Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол / ялын тухай сургаал/ II боть, Уб., 2014 он, 292 дахь тал.

[22] УИХ-ын ХЗБХ, ХЗДХЯ-аас 2018 оны 3 сарын 3, 4-ний өдөр зохион байгуулсан "Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх хэлэлцүүлэг"-т Улсын Ерөнхий Прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх Б.Амгаланбаатарын хэлэлцүүлсэн илтгэлээс.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

ял оногдуулахаар заагаагүй хөнгөн гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах ялыг тэнсэх боломжгүй байгаа нь уг заалтыг эрх зүйн хийдэлтэй болохыг илэрхийлж байна.

Хэрэв энэхүү эрх зүйн хийдлийг арилгавал уг зохицуулалт практикт хэрэгжихэд асуудал үүсэхгүй бөгөөд Эрүүгийн хуулийн зорилгодоо нийцэж, нийгэмд эерэг нөлөөллийг бий болгох боломжтой заалт юм.

Хорих ял нь бусад ялын төрлөөс нийгмийн хор аюулын шинж чанараараа хамгийн их. Гэтэл хамгийн хүнд төрлийн ялтай гэмт хэрэгт оногдуулах ялыг тэнссэн атлаа хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах ялыг тэнсэх боломжгүй байгаа нь тэгш бус байдлыг бий болгож байна.

Нөгөөтээгүүр, нуухыг нь авах гээд нүдийг нь сохлов гэгчээр Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлийн гарчигт 2017 онд өөрчлөлт оруулахдаа анх "тэнсэх" хэмээн нэрийдсэн байсныг "хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх" хэмээн өөрчилснөөр хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэгт оногдуулах ялыг тэнсэх боломжгүй болгосон хэмээн дүгнэж болохоор байна.[23]

Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлийн 1.1, 1.2 дахь хэсэг, 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 8.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус тэнсэх тухай зохицуулалтыг хуульчилж өгсөн. Ийнхүү хуульчлахдаа хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэгт оногдуулах ялыг тэнсэх боломжгүй байдлаар хуульчилсан байна.

Харин 2018 онд Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлгийн хэд хэдэн заалтад өөрчлөлт орсны нэг нь 8.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тэнсэхтэй холбоотой зохицуулалтад хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэгт оногдуулах ялыг ч мөн тэнсэх боломжтойгоор өөрчлөлт оруулсан нь гэмт хэрэг үйлдсэн хүний эрх зүйн байдлыг дээрдүүлж, тэнсэхтэй холбоотой зохицуулалтын эрх зүйн хийдлийг арилгах эхлэл болсон.

Гэсэн хэдий ч Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлийн 1.1, 1.2 дахь хэсэг, мөн хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан тэнсэх тухай зохицуулалт нь одоо ч хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэгт оногдуулах ялыг тэнсэх боломжгүй хэвээр байна.

Дээр дурдсан асуудлаар Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ 3 мөрдөгч, 59 прокурор, 117 шүүгч, нийт 179 хүнээс анкетын аргаар судалгаа авсан.

Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлд заасан хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх тухай заалтыг прокурор хэрэгжүүлэх боломжтой юу? гэсэн асуултад хэрэгжих боломжгүй гэж 15,4 хувь, хэрэгжүүлэх боломжтой гэж 73,5 хувь нь үзсэн байна.[24] Дээрх үзүүлэлтээс харахад шүүгчдийн дунд хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх тухай заалтыг хэрхэн хэрэглэх талаар өнөөдрийг хүртэл тогтсон нэг ойлголт байхгүй байгаагаас хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа нь ажиглагдаж байна.

Мөн энэхүү судалгаагаар Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан заалт нь зөвхөн шүүхийн бүрэн эрхэд хамаарна тиймээс зөвхөн шүүх хэрэглэнэ гэж нийт судалгаанд хамрагдсан шүүгчдийн 82 хувь нь, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх талаар прокурор санал гаргах эрхтэй хэмээн 8,6 хувь нь, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх тухай прокурорын саналыг үндэслэн шүүх хэргийг шийдвэрлэх нь зөв гэж 3,4 хувь нь тус тус хариулжээ.[25]

Судалгааны үр дүнгээс Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлд заасан

[23] Эрүүгийн хууль 2015 онд батлагдахад 7.1 дүгээр зүйлийн гарчиг "Тэнсэх" байсныг 2017 онд "Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх" хэмээн өөрчилсөн.

[24] Мөн тэнд.

[25] Мөн тэнд.

хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх тухай зохицуулалтыг практикт нэг мөр ойлгож, хэрэглэхэд хүндрэлтэй, эрх зүйн хийдэлтэй заалт болохыг харж болохоор байна.

Нөгөөтээгүүр, шүүгчдийн дунд хуулийн энэхүү заалтыг хэрхэн ойлгох талаар нэгдсэн нэг үзэл суртал төлөвшөөгүй, өөр өөрийн дотоод итгэл үнэмшлээр ялгамжтай байдлаар хандаж байгаа нь харагдаж байна. Учир нь шүүгчдийн олонх буюу 82 хувь нь Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйл нь зөвхөн шүүхийн бүрэн эрхэд хамаарах заалт хэмээн үзсэн байхад прокурор хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх санал гаргах эрхтэй хэмээн үзэж буй шүүгчид ч байгааг дурдах нь зүйтэй. Ийнхүү хуулийн нэг заалт нь олон утга санааг агуулж, улмаар хэргийг прокурорт буцаах үндэслэл болж байна.

Прокуроруудаас авсан судалгаанд нийт 59 прокурор хамрагдсанаас хяналтын прокурор 52 буюу 88 хувь, ахлах прокурор 7 буюу 12 хувийг тус тус эзэлж байна.

Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлд заасан хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх тухай зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх? Хэрэв тийм бол ямар бэрхшээл тулгарч байна вэ? гэсэн асуултад прокуроруудын 18,6 хувь нь хэргийн хялбаршуулсан журмаар шийдвэрлэх үед прокурор Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлд заасны дагуу хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх санал гаргахад шүүх “шүүхийн эрх мэдэлд халдаж байна” гэж үзээд хүлээж авдаггүй. Улмаар хэргийг прокурорт буцаадаг. Иймд энэхүү заалтыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй хэмээн үзсэн байна.

Прокуророос хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх санал гаргахад, шүүх хэргийг шийдвэрлэхгүй прокурорт буцааж байгаа нь Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан заалтыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдлыг бий болгож байна.

Өөрөөр хэлбэл, прокуророос хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх санал гаргахад шүүх хэргийг прокурорт буцааж байгаагаас үүдэн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа зогсонги байдалд оруулж байна. Гэхдээ хуульд энэхүү заалтыг прокурор хэрэглэн, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх санал гаргах эрх, боломж бий хэмээн судалгаанд хамрагдсан прокуроруудын олонх нь үзэж байна.

Түүнчлэн хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх явцад прокурор яллагдагчтай ял наймаалцаж, улмаар Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх боломжтой нөхцөлд энэхүү заалтыг үндэслэн шүүхэд ялын саналаа гаргадаг боловч шүүхээс хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх зохицуулалт нь шүүхийн бүрэн эрхийн асуудал хэмээн хэргийг прокурорт буцааж байгаа учир хэргээ хурдан шийдвэрлүүлэхийн тулд дээрх заалтыг баримталж, ялын санал гаргаж буй тохиолдол эрс цөөрсөн тухай судалгаанд хамрагдсан прокуроруд хэлж байсан.

Шүүгч, прокуроруд Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлд заасныг үндэслэн прокурор хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх санал гаргах эрхтэй эсэх дээр өнөөдрийг хүртэл нэгдсэн нэг ойлголтод хүрээгүй байна. Түүнчлэн прокуроруудын хувьд хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх санал гаргахад шүүхээс хэргийг шийдвэрлэхгүй буцааж байгаатай холбоотойгоор энэхүү заалтыг хэрэглэхгүй байгаа тухайгаа ярилцлага болон анкетын аргаар авсан судалгааны явцад хэлж байсан.

Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх тухай зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа асуудлуудыг тоймлон авч үзвэл хорих

ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэгт оногдуулах ялыг тэнсэх боломжгүй, прокурор шүүхэд ялын саналаа гаргахдаа уг заалтыг үндэслэн хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх санал гаргах эрхтэй эсэх нь хуульд тодорхой байдлаар хуульчлагдаагүй, Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлийн 1.1, 1.2 дахь хэсэг, мөн хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан заалтын ялгааг сайтар тайлбарлан хэрэглэхгүй бол ижил төрлийн гэмт хэрэг үйлдсэн хүнд ялгамжтай байдлаар ял оногдуулж буй явдал юм.

Шүүгч, прокуроруудаас авсан судалгааны үр дүнгээс үзвэл прокуроруудын хувьд хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна хэмээн олонх нь үзсэн бол судалгаанд хамрагдсан шүүгчдийн 82 хувь нь энэхүү заалтыг хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэнээс дүгнэвэл энэхүү хоёр субъект өөр хоорондоо харилцан адилгүй байр суурьтай байгааг илэрхийлэхийн сацуу уг заалт практикт өөр өөр байдлаар ойлгогдон хэрэгжиж буйг харуулж байна.

Дээрхээс дүгнэвэл, Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөнгөн гэмт хэрэгт хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх зохицуулалт нь практикт хэрэгжихэд нэлээд хүндрэлтэй зохицуулалт болохыг прокурор, шүүгчдээс авсан судалгааны үр дүн баталж байна. Иймд Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан заалт нь практикт бүрэн нийцсэн гэж дүгнэх боломжгүй байна.

5. Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн хугацаанд гэмт хэрэг үйлдсэн хүн санаатай гэм хэрэг үйлдвэл шүүх тэнссэн шийдвэрийг хүчингүй болгож, тус хуулийн 6.8, 6.9 дүгээр зүйлд заасныг журамлан ял оногдуулахаар хуульчилсан. Гэсэн хэдий ч 6.8 дугаар зүйл, 6.9 дүгээр зүйлийг хэрхэн хэрэглэх нь практикт тодорхойгүй байдлыг бий болгож байна. Өөрөөр хэлбэл, тухайн хорих ял оногдуулахгүй тэнссэн хэрэгт хэрхэн ял оногдуулах, тухайн оногдуулсан ялыг хэрхэн нэмж нэгтгэх нь тодорхой бус байна.

Хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах гэдэг нь ялтан шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулахад хэрэглэдэг хуулиар тогтоосон журам бөгөөд хэд хэдэн шийтгэх тогтоол гэдэг нь шүүгдэгчийн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайг нотолж, улмаар түүнд оногдуулсан хоёр буюу түүнээс дээш тооны шүүхийн шийдвэр юм.[26]

Улсын Ерөнхий Прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх Б.Амгаланбаатар "... Эрүүгийн хууль тогтоомжид орсон чухал өөрчлөлтийн нэг нь үйлдсэн гэмт хэрэг тус бүрт нь эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татаж, шүүхээр шийдвэрлэх боломж бүрдсэн гэж ойлгож байсан. Гэтэл шүүх эрүүгийн хуулийн 6.9 дүгээр зүйлд зааснаар оногдуулсан ялыг эдэлж дуусахаас өмнө шинэ гэмт хэрэг үйлдсэн бол хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулж бусад тохиолдолд хэргийг прокурорт буцааж шийдвэрлэж байна. Иймд Эрүүгийн хуулийн 6.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "шинээр гэмт хэрэг үйлдсэн" гэсний дараа "эсхүл шүүхээр ял шийтгүүлэхийн өмнө өөр гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн шийтгэх тогтоол гарсаны дараа тогтоогдсон бол" гэж нэмэх шаардлагатай[27] хэмээн үзсэн байна.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн 6.9 дүгээр зүйлд хөнгөн ялыг хүндэд нь багтаах тухай ойлголт байхгүйгээс зөвхөн ялыг нэмж нэгтгэж байгаа нь гэмт хэрэг үйлдсэн хүний эрх зүйн байдлыг дордуулж байна хэмээн

[26] Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхтгэл, Уб., 2011 он, 73 дахь тал.

[27] УИХ-ын ХЗБХ, ХЗДХЯ-наас 2018 оны 3 сарын 3, 4-ний өдөр зохион байгуулсан "Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх хэлэлцүүлэг"

Хуулийн хүрээлэн www.pilsor.mn

анкетын санал асуулгад оролцсон прокурор, шүүгчид дурдсан байх бөгөөд 2002 оны Эрүүгийн хуулийн 57 дугаар зүйлийн 57.3-т заасан "Ялтан шүүхээр ял шийтгүүлэхийн өмнө өөр гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн шийтгэх тогтоол гарсны дараа тогтоогдвол түүнд энэ зүйлд заасан журмыг баримтлан ял оногдуулна. Ингэж шийдвэрлэхдээ өмнөх шүүхийн шийтгэх тогтоолоор бүрэн буюу хагас эдэлсэн ялыг оруулан тоолно" гэсэн заалтыг сэргээх нь зүйтэй хэмээн үзсэн тохиолдол цөөнгүй байна.[28]

"Ял тэнсэх институцийн үр нөлөөг сайжруулахад Академич С.Нарангэрэлийн "Хянан харгалзах хугацааг шүүхээс оногдуулсан ялын хугацаатай дүйцүүлэн тогтоох... зэрэг нэмэлтийг Эрүүгийн хуульд оруулах нь ач холбогдолтой" гэсэн саналыг дэмжүүштэй[29] гэж бичсэн байх бөгөөд Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан заалтыг практикт хэрэгжүүлэхэд энэхүү санал эерэг нөлөө үзүүлж болохуйц байна. Нэгэнт хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж байгаа учир тэнссэн хугацааг тухайн гэмт хэрэгт оногдуулж буй хорих ялын хэмжээ гэж үзвэл Эрүүгийн хуулийн 6.9 дүгээр зүйлд зааснаар ял оногдуулахад учирч буй асуудлыг зохицуулахад дөхөм болох юм.

Мөн шүүхийн шийтгэх тогтоол гарахын өмнө үйлдсэн хэрэг шийтгэх тогтоол гарсны дараа илэрсэн тохиолдолд ялыг хэрхэн нэмж нэгтгэх талаар хуульд тодорхой байдлаар заагаагүйгээс энэхүү заалтыг хэрэглэхэд хүндрэлтэй байна хэмээн үзэж байна.

Дээрхээс дүгнэвэл, Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан заалтыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна. Учир нь Эрүүгийн хуулийн 6.8, 6.9 дүгээр зүйлд заасан зохицуулалт нь дээр дурдсан эрх зүйн хийдэл, алдаа дутагдлыг агуулж буй нь 7.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан заалтын хэрэгжилтэд шууд байдлаар нөлөөлж, практикт хэрэгжихэд хүндрэлтэй байдлыг бий болгосон байна.

ДҮГНЭЛТ

Эрүүгийн хуулийг дагаж мөрдөөд жил гаруй хугацаа өнгөрч байна. Энэ хугацаанд эрх зүйн хийдэлтэй зохицуулалт болон маргаан дагуулж буй заалтуудыг хэрхэн засаж, сайжруулах талаар олон талын сургалт, хэлэлцүүлэг[30], судалгаанууд хийгдсээр байгаа билээ. Энэ хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 7.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, дараах дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

1. Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх тухай хуулийн зохицуулалтыг **шинээр** 2015 оны Эрүүгийн хуульд хуульчилж өгсөн нь 2002 оны Эрүүгийн хуулийг боловсронгуй болгож, гэмт хэрэг үйлдсэн хүнд заавал ял оногдуулсны дараа тэнсэн харгалздаг байсныг өөрчлөн, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэхээр хуульчилсан нь шинэ хуулийн давуу талыг илэрхийлж байгаа хэдий ч Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан заалт **нь** зөвхөн хорих ял оногдуулахаар заасан, хөнгөн гэмт хэрэг үйлдсэн хүнд л хамаарах бөгөөд хорих ял оногдуулахаар заагаагүй /хорихоос өөр төрлийн ялтай/ гэмт хэрэгт оногдуулах ялыг тэнсэх боломжгүй байдлаар хуульчлагдсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт

[28] Дэлгэрэнгүйг үнэлгээний тайлангийн бүрэн эхээс үзнэ үү.

[29] С.Жанцан, "Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол / Ялын тухай сургаал/ II боть", Уб., 2014 он, 315 дахь тал.

[30] Тухайлбал, УИХ-ын ХЗБХ, ХЗДХЯ-тай хамтран "Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх хэлэлцүүлэг", "Шүүхийн шийдвэр түүний хэрэглээ ач холбогдол" сэдэвт хэлэлцүүлэг, "Эрүүгийн хуулийн шинэтгэлийн үйл явц" сэдэвт хэлэлцүүлэг, "Хүний эрх, эрх чөлөөний хууль зүйн баталгаа - онол практикийн асуудал" олон улсын эрдэм шинжилгээний хурал гэх мэт.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

“Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэсэн заалтыг зөрчсөн байж болзошгүй **байна.**

Мөн хорихоос өөр төрлийн ялтай 50 хөнгөн гэмт хэрэгт[31] Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, мөн хуулийн 6.7 дугаар зүйлийн 1.1, 1.2 дахь хэсэгт заасан заалтыг хэрэглэх боломжгүй гэж үзэж байна.

Иймд 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт хорихоос өөр төрлийн ялтай гэмт хэрэгт оногдуулах ялыг тэнсэх боломжгүй байдлаар хуульчилсан нь уг заалтын хэрэгжилтэд хүндрэл үүсгэсэн гэж дүгнэж байна.

2. Эрүүгийн хуульд хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн хугацаанд санаатай гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хорих ял оногдуулахгүй тэнссэн гэмт хэргийн ялыг хэрхэн нэмж нэгтгэх талаар нарийвчлан заагаагүйгээс дээрх зохицуулалтыг хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй байдлыг бий болгож байна.

Түүнчлэн тус хуулийн 6.9 дүгээр зүйлд хөнгөн ялыг хүндэд нь багтаах талаар зохицуулалтыг тусгаагүй нь гэмт хэрэг үйлдсэн хүний эрх зүйн байдлыг дордуулж, Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн ач холбогдлыг алдагдуулж байна хэмээн үзэх тохиолдол цөөнгүй байна.

Судалгааны явцад хуулийн заалтуудын уялдаа холбоотой байдлаас шалтгаалан 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан заалт нь мөн хуулийн 6.7 дугаар зүйлийн 1.1, 1.2 дахь хэсэгт заасан заалттай холбогдож байх бөгөөд уг заалт нь ЭХХШтХ-ийн 17.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 17.5 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасан заалтуудтай уялдаж, улмаар дээрх заалтуудын алдаа, зөрчилтэй байдлыг энэхүү судалгааны явцад дурдсан болно.

ЗӨВЛӨМЖ

Судалгааны үр дүнд гарсан дүгнэлтэд тулгуурлан дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх тухай зохицуулалтыг боловсронгуй болгон хуульчлах;

Үүний тулд Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлийн гарчгийг “тэнсэх” хэмээн өөрчилж, 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “... хөнгөн гэмт хэрэг[32] /хорих ялтай болон хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэргийг хамтатган ойлгох/ үйлдсэн хүн гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлж хор уршгийг арилгасан, эсхүл гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн бол гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, хувийн байдлыг харгалзан оногдуулах ялыг тэнсэх боломжтой байдлаар” хуульчлах шаардлагатай.

2. Мөн хуулийн 6.7 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэгт өөрчлөлт оруулах.[33] Үүний тулд уг зүйл, хэсэгт “Энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг гурван жил хүртэл, түүнээс бага хугацаагаар тогтоосон эсхүл хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн хүн тухайн гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлж, эсхүл гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн бол ялаас чөлөөлөх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тэнсэж үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын

[31] Дээрх заалтуудад хорих ялтай, хөнгөн гэмт хэрэгт оногдуулах ялыг тэнсэх боломжтой боловч хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэгт оногдуулах ялыг тэнсэх боломжгүй байдлаар хуульчилсан байна.

[32] Эрүүгийн хуулийн 2.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... хорих ялын дээд хэмжээг 5 хүртэл жил, түүнээс доош хугацаагаар оногдуулахаар тогтоосон, эсхүл хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэргийг хөнгөн гэмт хэрэг гэнэ” хэмээн заажээ. Иймд Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлийн 1.1, 1.2 дахь хэсэг, 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан тэнсэх албадлагын арга хэмжээний эрх зүйн хийдлийг арилгахын тулд зөвхөн хорих ялтай хөнгөн гэмт хэрэг бус, хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэгт ч оногдуулах ялыг тэнсэх боломжтой байдлаар өөрчлөлт оруулах.

[33] Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэгт хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэгт оногдуулах ялыг тэнсэх боломжгүй байдлаар хуульчилсан.

арга хэмжээ хэрэглэх” хэмээн өөрчлөлт оруулж болох юм.

3. Шүүхийн шийтгэх тогтоол гарахын өмнө үйлдсэн гэмт хэрэг шийтгэх тогтоол гарсны дараа илэрсэн тохиолдолд ялыг хэрхэн нэмж нэгтгэх, мөн хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн хугацаанд санаатай гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд тэнссэн гэмт хэргийн ялыг хэрхэн тооцох талаар хуульд тодорхой байдлаар заагаагүйгээс Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг практик хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна. Энэхүү заалтыг хэрэгжүүлэхийн тулд Эрүүгийн хуулийн 6.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт өөрчлөлт оруулах нь зүйтэй.

4. Хуульд заасан үндэслэл журмыг нэг мөр болгох /олон салаа утгагүй/;

Тухайлбал, ЭХХШтХ-ийн 17.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан “...прокурорын санал хүрээнд”, мөн хуулийн 17.5 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасан “...прокурорын саналыг харгалзан” гэсэн заалтууд нь өөр хоорондоо ялгаатай утгыг илэрхийлж байна.

5. 2002 оны Эрүүгийн хуулийн 57 дугаар зүйлийн 57.3 дахь хэсэгт заасан “Ялтан шүүхээр ял шийтгүүлэхийн өмнө өөр гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн шийтгэх тогтоол гарсны дараа тогтоогдвол түүнд энэ зүйлд заасан журмыг баримтлан ял оногдуулна. Ингэж шийдвэрлэхдээ өмнөх шүүхийн шийтгэх тогтоолоор бүрэн буюу хагас эдэлсэн ялыг оруулан тоолно” гэсэн заалтыг сэргээн хуульчлах нь зүйтэй.

6. Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд эрх зүйн хийдэл, алдаа дутагдалтай заалтууд олон байна. Тухайлбал,Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлд заасан Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт оногдуулж буй хорих ялын доод хэмжээ 3 сар байгаа нь ерөнхий ангийн хэм хэмжээтэйгээ зөрчилдсөн, мөн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан заалт нь ялын бодлоготойгоо зөрчилдөж байгаа гэх мэт олон асуудлуудыг цаашид зайлшгүй судлан үзэх шаардлагатай байна.

---o0o---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nlj.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН НЭР ТОМЬЁОНЫ БУЛАН

Ж.Амарсанаа

“ Хууль дээдлэх ёс” сэтгүүл энэ дугаараас эхлэн хууль зүйн нэр томьёоны булан нээн ажиллуулж байна.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиудыг харахад Үндсэн хуулийн нэр томьёо, үг хэллэгтэй зөрчилдсөн, хуулиуд хоорондоо төдийгүй, нэг хууль нь дотроо зөрчилдсөн байх нь цөөнгүй.

Хуулийн нэр томьёо, үг хэллэг, утга санааг буруу ойлгох, ингэснээр бусдад буруу ойлгуулахад улс төрчид, сэтгүүлчид, төрийн албан хаагчид төдийгүй багш, судлаачид “өөрийн хувь нэмрийг” оруулсаар байгаа нь харамсалтай. Бид энэ удаа ямар хууль зүйн нэр товъёог яаж буруу хэрэглэж байгааг зарим цөөн жишээн дээр харуулахыг хичээв. Мэдээж хууль зүйн арга ажиллагааны нэг хэсэг болох хууль зүйн хэл, нэр томьёо нь нийгмийн хөгжлөө дагаад өөрчлөгдөж байдаг тул энэхүү буланд орсон нэр томьёог шүүн хэлэлцэх, шүүмжлэл, санал бодлоо илэрхийлэх боломж Танд байгааг эцэст нь ойлгон тэмдэглэж байна.

д/д	Буруу	Зөв	Тайлбар
1	Сумын Засаг даргын Тамгын газар	Сумын Захиргаа (Уг нь Сумын Засгийн газар)	Сумын (аймаг, нийслэл, дүүргийн) Тамгын газар гэдэг нь нэг л дотоод нэгж нь юм. Ингэж буруу бичиж, ярьж хэвшсэнийг засах.
2	Төрийн гурван өндөрлөг	Төрийн эрх мэдлийн хуваарилалт. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл гэсэн нэгэн цогц төрийн 3 салаа мөчир.	Төрийн гурван өндөрлөг гэж Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд гэсэн 3 хүнийг нэрлэх болжээ. Энэ бол хүн биш, субъект, институт, байгууллага. Энэ бол төрийн дээд эрх мэдлийн хөдөлмөрийн хуваарь юм.
3	Хууль, эрх зүй; Хууль эрх зүй; Хууль эрх	Хууль, эсвэл эрх, эсвэл эрх зүй гэх.	Хууль, эрх, эрх зүй бол 3 өөр ойлголт. Ийм газар, хэлтэс УИХ, ЗГ, СЗХ, АТГ зэрэг олон газар байна. Зүй нь хууль зүйн эсвэл эрх зүйн газар, хэлтэс гэх.
4	Хуулийн байгууллага	Хууль сахиулах байгууллага, Шүүх эрх мэдлийн байгууллага.	Хуулийн, дүрмийн, тогтоолын байгууллага гэж байхгүй. Хууль бол бие даасан эрх зүйн баримт бичиг.
5	Хууль хяналтын байгууллага	Хууль сахиулах байгууллага гэж бий.	Ийм байгууллага байхгүй. Хяналтын гэсэн тодотголтой тусгай байгууллага гэвэл прокурорын хяналт, мэргэжлийн хяналтын байгууллагыг хэлж болно. Олон агентлаг хяналтын чиг үүрэгтэй. Оюуны өмчийн газар зэрэг зарим байгууллага ч ийм үүрэгтэй.

Хууль зүйн нэр томьёоны хураалтын www.nlt.edu.mn

6	Төрөө дээдлэх	Хууль дээдлэх (Монгол Улсын Үндсэн хууль, Нэгдүгээр зүйл, Арван долдугаар зүйл)	Төр дээдлэх нь феодалын хийгээд коммунист, фашист үзэл юм.
7	Хууль цааз	Хууль эсвэл цааз	Хууль нь УИХ-ын баталсан акт. 1990 он хүртэл нийтлэг хэрэглэж байсан. Одоо ч хэрэглэсээр байгаа, прокурорт хэрэглэж байна, өөрчлөх хэрэгтэй. Дархан цаазтай газар гэх зэргээр хууль тогтоомжид хэрэглэж буй, буруу биш байх.
8	Төрийн эрх мэдлийг хуваах	Төрийн эрх мэдэл хуваарилах	Нэг төрийг дотор нь эрх мэдлээр нь 3 ангилж буй хөдөлмөрийн, нэг ёсондоо, чиг үүрэг, ажлын хуваарь.
9	Улс орон	Улс, эсвэл орон	Улс орон гэж хоршин хэрэглэж буй нь зөв биш. Тухайн асуудал эсвэл ойлголтоос хамаарч тус тусад нь хэрэглэх нь зүй.
10	Хуулийн сургууль	Хууль зүйн сургууль	Хуулийн, тогтоолын, зарлигийн сургууль гэж байхгүй.
11	Хууль хүчний байгууллага	Хууль сахиулах байгууллага. Төрийн тусгай алба гэж бий.	Ийм байгууллага байхгүй. Цагдаа, батлан хамгаалах зэрэг байгууллагыг, сурвалжлагч, бас бус хүн ингэж нэрлэдэг.
12	Хуульч профессор	Хуульч тусдаа. Профессор тусдаа. Яг үнэндээ ийм "гажиг" ойлголт байхгүй.	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь хэсэгт ийм нэг ойлголт бий. Дээд боловсролын хуульд дэд профессор, профессор байх болзол бий.
13	Яамны сайд	Сайд нь Засгийн газрын гишүүн, төрийн улс төрийн албан тушаалтан.	Үндсэн хууль, Засгийн газрын тухай хууль, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн ёсоор яам нь ердөө л сайдын "ажлын аппарат".
14	Төрийн бус байгууллага	Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь хэсэг "... олон нийтийн байгууллага".	УИХ-аас 1997 онд Үндсэн хуулийн заалт зөрчиж Төрийн бус байгууллагын тухай хууль баталсан. Зарим улсын NGO (Non Governmental Organization буюу Засгийн газрын бус байгууллага гэдгийг орчуулан буулгасан нь тэр).
15	Эрхийн баталгаа	Эрх зүйн баталгаа	Эрхийн, үүргийн баталгаа гэж байхгүй. Эрх, эрх зүй нь өөр ойлголт.
16	Нам төвтэй тогтолцооноос төр төвтэй тогтолцоонд шилжих	Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйл, Арван зургадугаар зүйлийн 10, Арван долдугаар зүйлийн 1.1 дэх хэсэгт хууль дээдлэх заалт бий.	Нам төвтэй гэх тогтолцоо гэх ойлголт одоо цагт байхгүй болсон.
17	Иргэн төвтэй төрийн үйлчилгээ	Төр, иргэн хоёр адил төвшинд хуулийн дор ажиллаж амьдарна.	Ямар нэгэн төв "юм" байхгүй. Иргэнд чиглэсэн, иргэнд хандсан үйлчилгээ юм.
18	Сайн засаглал	Чадварлаг буюу үр нөлөөтэй удирдлага	Англи хэлний "Good governance" гэдгийн үгчилсэн орчуулга. Төрийн олон баримт бичигт тусгагдах болсон байна.

---o0o---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГЭЭС 2018 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН СУДАЛГААНЫ ЖАГСААЛТ

ХЗДХЯ-ны захиалгаар болон ХЗҮХ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасны дагуу:

1. “Цахим орчин дахь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох эрх зүйн зохицуулалт” сэдэвт харьцуулсан судалгаа;
2. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ;
3. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ;
4. Шүүхийн захиргааны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ;
5. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ;
6. “Төр ба шашны харилцаа: Шашны байгууллагын бүртгэл, харгис болон гаж урсгалын шашныг зохицуулах эрх зүйн механизм” сэдэвт харьцуулсан судалгаа;
7. Төрийн бус байгууллагын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ;
8. Төрийн бус байгууллагын тухай хуультай холбоотой харьцуулсан судалгаа;
9. Компанийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ;
10. Мөнгөн зээлийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын талаар харьцуулсан судалгаа;
11. Зөрчлийн тухай хууль болон бусад хүчин төгөлдөр хууль тогтоомжид хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхсан заалт буй эсэхэд үнэлгээ хийх, бусад орны хууль тогтоомжийн талаар харьцуулсан судалгаа;
12. Нотариатын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ;
13. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ;
14. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ;
15. Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ;
16. Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хэсэгчлэн хийсэн үнэлгээ;
17. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ;
18. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ;
19. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ;
20. Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ;
21. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ;
22. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ;
23. Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ;

24. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ;

25. Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зардлын тооцоо;

26. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ;

27. Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ;

28. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ;

Бусад байгууллагын захиалгаар:

1. Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа;

2. Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ;

3. Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо;

4. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шүүх хуралдаан хойшлох буюу удааширч буй шалтгаан нөхцөл сэдэвт судалгаа;

5. Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ;

6. Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа;

7. Шүүхийн шинжилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ;

8. Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжууд дахь ялгаварлан гадуурхахын эсрэг зохицуулалтын хэрэгжилтийн талаарх судалгаа, үр дагаварт хйисэн үнэлгээ;

9. Төрийн албан хаагчийн хариуцлагын тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа;

10. Төрийн албан хаагчийн хариуцлагын тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ.

---o0o---

Хуулийн зөвлөлдөх хэлтэс www.mrsey.mn